

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт										
Булган аймгийн Засаг даргын Тамгын газар										
2025 оны жилийн эцэс										
Шийдвэрийн д/д	Заалтын д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллын үнэлгээ	Үнэлгээний тайлбар	Хяналтаас хасах саналтай эсэх	Хяналтаас хасах санал	
МУ-ын хууль										
1	1	Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/ 2019-03-27 Дугаар 2023_10	8.5. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн[4] 6.2-т заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг Засгийн газар, мөн хуулийн 6.3-т заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тус тус тогтооно.	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийг хэрэгжүүлэн, аймгийн ИТХ-ын 2025 оны IX/66 дугаар тогтоолоор "Орон нутгийн хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл" олгох тэмдэгтийн хураамжийн хэмжээг 3.0 сая төгрөгөөр тогтоосон.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй		
2	2	Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай 2021-07-07 Дугаар 2021.07.07	9.18. Аймаг, нийслэлийн үнэт цаасыг нийтэд санал болгон гаргах бол Санхүүгийн зохицуулах хороонд хялбаршуулсан журмаар бүртгүүлэх бөгөөд үүнтэй холбоотой журмыг Хороо батална.	Булган аймаг нь орлогоороо зардлаа санхүүжүүлдэг улсад орлого төвлөрүүлдэг, эдийн засгийн чадамж муутай аймаг тул үнэт цаас гаргах боломжгүй байна.	Хэрэгжүүлэх зардал, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй	Хэрэгжүүлэх зардал, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй		Үгүй		
УИХ-ын тогтоол										
3	3	Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2016-04-14 Дугаар 2016 №34	1.5/. Орон сууц, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга байгууламжийн чанар, газар хөдлөлтөд тэсвэрлэх байдлыг шалгаж, барилга байгууламжийг паспортжуулах ажлыг 2017 онд багтаан дуусгах, газар хөдлөлтөд тэсвэргүй барилгыг буулгаж шинээр барих, ашиглах боломжтой барилгын судалгааг гаргах, тэдгээрийг үе шаттайгаар бэхэлж хүчитгэх ажлыг зохион байгуулах;	2017 онд паспортжуулах ажлыг хэрэгжүүлж, тухайн хугацаанд тайлагнасан. 2021-2023 онуудад нийт 30 барилгыг паспортжуулж, тус барилгуудаас газар хөдлөлтөд тэсвэргүй үнэлэгдсэн Булган сумын 4 дүгээр цэцэрлэгийн барилгыг буулгаж, 280 хүүхдийн хүчин чадалтай шинэ барилга барьж ашиглалтад оруулсан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	Шийдвэрт заасан хугацаа 2017 оноор дуусгавар болсон	
4	4	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2017-06-09 Дугаар 2017 №46	1.10.. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэнийг хөгжүүлэх төвүүдийг аймаг, дүүрэгт байгуулах;	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилга барих газрын байршлын саналыг 2026 оны аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгуулахаар санал хүргүүлсэн. Барилга барих санхүүжилтийн эх үүсвэр батлагдаагүй тул тухайн ажил хийгдэж эхлээгүй байна.	Хэрэгжүүлэх зардал, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй	Хэрэгжүүлэх зардал, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй		Үгүй		
5	5	МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2022-11-11 Дугаар 2022 №72	1.2. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого", 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний бэлтгэл ажил, зураг төсөв болон техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлыг 2023 онд шуурхай зохион байгуулах;	2025 онд Сангийн яамны /https://publicinvestment.gov.mn/ цахим системд Сангийн сайдын А/264 дүгээр тушаалын дагуу Булган аймгийн 16 сум, 1 тосгон 04 дүгээр сарын 01-ээс 30-ны хооронд саналаа ирүүлсэн. Нийт ирүүлсэн төсөл арга хэмжээний саналыг 05 дугаар сарын 01-ээс 06 дугаар сарын 25-ны хооронд үнэлж, шаардлага хангасан арга хэмжээг эрэмбэлэн орууллаа. Нийтдээ 53 төсөл арга хэмжээний 364.6 тэрбум төгрөгийн ажил арга хэмжээ илгээгдсэн. Үүний үр дүнд 15 арга хэмжээний 219.4 тэрбум төгрөгийн төсөл арга хэмжээ 2026 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад орж баталгаажсан. Үүнээс 44.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт 2026 онд санхүүжигдэнэ.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	2023 онд хэрэгжиж дууссан	
	6		1.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийнх нь эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах;	2025 онд хөрөнгө оруулалтын ажлын зураг төсөв, ТЭЗҮ боловсруулах зардалд төсвийн тодотголоор 1.4 тэрбум төгрөгийн төсөв батлагдаж, 39 төсөл, арга хэмжээний гэрээг байгуулан, 12 ажлын зураг төсвийг хүлээн авч, 27 барилга, байгууламжийн зураг төсвийг он дамнан гүйцэтгэж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	2023 онд хэрэгжиж дууссан	
6	7	АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ 2023-06-30 Дугаар 2023_59	3. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагааг улсын болон аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар ханган хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Авлигатай тэмцэх газар /З.Дашдаваа/-т тус тус үүрэг болгосугай.	"Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд 2025 онд 14 арга хэмжээ бүхий төлөвлөгөө батлуулан, хэрэгжүүлж ажиллалаа. Төлөвлөгөөний хүрээнд авлигын эсрэг нэгдэхийг иргэд, төрийн албан хаагчдад уриалж, авлигын тухай ойлголт, хор уршиг, үр дагаврыг олон нийтэд сурталчлан таниулахаар 43 байгууллагын 1483 албан хаагчид Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар сургалт зохион байгуулсан. Мөн аймгийн хэмжээнд авлигын эсрэг нэгдэхийг уриалсан 7 контент бүтээж, олон нийтэд түгээж ажилласан бөгөөд төлөвлөгөөний биелэлт 92.0 хувьтай байна. 2025 онд авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдсон албан тушаалтан байхгүй байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй		
Хавсралт : 7 зураг										

7	8	МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2023-11-10 Дугаар 2023_93	1.2. хөдөөд орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээнд шаардагдах санхүүжилтийг төр, хувийн хэвшлийн түншлэл, улс, орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээл, тусламжийн эх үүсвэрээс бүрдүүлэх замаар олон талын оролцоог хамарсан хамтын санхүүжилтээр шийдвэрлэх;	2025 оны байдлаар хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Булган суманд 3 блок 146 айлын орон сууц ашиглалтад орлоо. Булган сумын 2-р баг "Түмэн-Алт" ХХК-ийн 25 айлын орон сууц, Булган сумын 6-р баг "Хишиг дулаан" ХХК-ийн "Сайхан уул-3" 20 айлын орон сууц, Булган сумын 5-р баг иргэн Ш.Баттөрийн 56 айлын орон сууц, Булган сумын 5-р баг "Эрин гүрэн" ХХК-ийн 45 айлын орон сууц тус тус ашиглалтад орсон. Улсын төсвийн 1.98 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хутаг-Өндөр сумын төрийн албан хаагчдын 8 айлын орон сууцны барилга 11 дүгээр сард ашиглалтад орж, Булган сумын төрийн албан хаагчдын 15 айлын орон сууцны энэ оны төлөвлөгөөт ажлыг 100 хувь гүйцэтгэсэн. Бүрэгхангай суманд 20 айлын орон сууцны ажлыг эхлүүлсэн ба гүйцэтгэл 60 хувьтай, Могод, Сайхан суманд 24 айлын барилга барих архитектор төлөвлөлтийн даалгавар авч, орон сууцны ажлын зургийг боловсруулж байна. Ингэснээр орон сууцны хүртээмж нэмэгдэж, иргэдийн орон сууцтай болох нөхцөл сайжирлаа. Хавсралт : 5 зураг	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	2024 онд хэрэгжиж дууссан
	9		1.10. төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, ашиглалтад хүлээн авах, өмчид хүлээн авах үйл ажиллагаанд ногоон байгууламжийн стандарт болон тусгай хэрэгцээт иргэдийн хэрэгцээнд нийцсэн стандартыг чанд мөрдөж хэрэгжүүлэх, зохион байгуулах;	2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Булган аймагт барилга байгууламжийн шилжих 13 төсөл арга хэмжээ, шинээр 20 төсөл арга хэмжээ батлагдсан. Үүнээс он дамнан хэрэгжсэн 9, шинээр тусгагдсан 8 төсөл арга хэмжээг 2025 онд улсын комисс байнгын ашиглалтад оруулсан байна. Уг 33 төсөл арга хэмжээний зураг төслийг холбогдох яам, төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэн, тендер зарлаж, явцын хяналтыг Барилгын хөгжлийн төв, аймгийн ГХБХБГ хамтран тавьж, төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас эрх шилжсэний дараа орон нутагт хөрөнгийн бүртгэлдээ авч байна. Тухайлсан барилга байгууламжийн хэсэгчилсэн төлөвлөлт хийхдээ ногоон байгууламжийг стандарт норм дүрмийн дагуу зураг төсвийг хийлгэн, хүлээн авсан. Ашиглалтад орсон 17 барилга, байгууламжийг хүлээн авах улсын комиссын бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний төлөөллийг оролцуулж, тус барилгын хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмж стандарт, зураг төсөлд нийцэж буй эсэхэд хяналт тавьж, хүлээн авав.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	2024 онд хэрэгжиж дууссан
8	10	Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2024-01-12 Дугаар 2024_05	1.6. төрийн цахим үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд операторын горимоор хүргэх цагийг аймаг, сум, нийслэл, дүүрэг, хороонд байгуулах.	2025 онд бүтээгдэхүүн үйлчилгээний баталгаажуулалтын үйл ажиллагаа, стандартын мэдээлэл, лавлагааг цахимд шилжүүлснээр аймгаас цахимаар үзүүлж буй үйлчилгээний тоо 63 болсон. Төрийн үйлчилгээг нэгдсэн системээр дамжуулан үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж, аймгийн 16 сум, 1 тосгонд ХУРДАН төвийг байгуулан үйлчилгээний ажилнуудыг сургаж бэлтгэн, ашиглагдах тоног төхөөрөмж, интернэтийн эх үүсвэрээр ханган иргэдэд үйлчилгээ үзүүлж байна. Мөн 22 киоск машиныг 16 суманд байршуулан, 24 цагийн үйлчилгээ бүхий "Цахим үйлчилгээний цэг" байгуулан, иргэдэд төрийн үйлчилгээг хүргэж байна. Төрийн үйлчилгээний цахим (ТҮЦ) машинаар иргэн, хуулийн этгээдийн 16 төрлийн 37 үйлчилгээ, E-Mongolia цахим үйлчилгээний нэгдсэн системээс иргэн, хуулийн этгээдийн 103 төрлийн үйлчилгээг, Улсын бүртгэлийн хэлтсийн киоск машинаар 9 төрлийн үйлчилгээг тус тус үзүүлж байна. Цахим шилжилт, үйлчилгээний хэлтэс болон 16 сум, 1 тосгоны ХУРДАН цэгээс операторын горимоор 8456 иргэн цахим үйлчилгээ авч, ХУРДАН киоск төхөөрөмжөөс 18968 лавлагаа тодорхойлолтыг олгосон байна. Хавсралт : 5 зураг	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

9	11	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2024-01-17 Дугаар 2024_11	1.2. төрөөс үзүүлж байгаа үйлчилгээний төлбөр, хураамж болон тэдгээрийн зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх, хууль тогтоомж зөрчсөн төлбөр, хураамжийг хүчингүй болгох арга хэмжээ авах.	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсэгт заасны дагуу "Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох" ажлыг хэрэгжүүлэн, хураамжийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэн ажиллаж байна. Тус ажлын хүрээнд төрийн үйлчилгээний https://e-business.mn/ цахим хаягаар аж ахуйн нэгж байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийг судалж, бүрдүүлэх материалын иж бүрдлийн шаардлага хангасан 31 цэгт аймгийн Засаг даргын 7 удаагийн захирамжаар согтууруулах ундаа худалдах, согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл, 1 цэгт уламжлалт технологиор согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай шинээр олгож, 7 цэгийн эзэмшигчийн нэр шилжүүлж, орон нутгийн төсөвт 22.5 сая төгрөгийн тэмдэгтийн хураамжийг төвлөрүүлсэн байна. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалтын дагуу аймгийн ИТХ-ын 2022 оны XII/26 дугаар тогтоолоор тамхи худалдаалах энгийн зөвшөөрлийг сумын Засаг дарга 3 жилийн хугацаатай олгоход 300.0 мянган төгрөг байхаар баталж, орон нутгийн төсөвт төвлөрүүлж байна. Тайлант онд хууль, тогтоомж зөрчсөн тохиолдол бүртгэгдээгүй байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	Засгийн газарт өгсөн чиглэл тул чиг үүрэгт хамаарахгүй
10	12	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай 2024-04-18 Дугаар 2024_27	2. 2.Хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагаа, арга хэмжээг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7, 6.8, 6.9 дэх хэсэгт заасны дагуу үндсэн чиглэл, хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Ес зүйн хороо, Засгийн газрын, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ес зүйн дэд хороо, бүх шатны томилох эрх бүхий албан тушаалтанд тус тус даалгасугай.	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг Төрийн албаны салбар зөвлөлийн даргаар батлуулан хэрэгжүүлэв. Нийт 2 удаагийн танхим, 5 удаагийн цахим сургалтыг 151 төрийн байгууллагын 4000 гаруй албан хаагчид зохион байгуулсан. Аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх ажиллах "Булган сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрт 1 үйл ажиллагааны 2 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын ёс зүйн дэд хороо нь 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулагдаж, аймгийн хэмжээнд төрийн албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар тогтмол сургалт зохион байгуулж, 6183 албан хаагчийг хамруулсан байна. 2025 онд төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой 5 өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэн, хуулийн хугацаанд хариу хүргүүлсэн.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	13	Монгол Улс дахь үүний эрх зүй	2.а. а/бүх шатны боловсролын сургалтын байгууллага, дотуур байрны гадаад болон дотоод орчны аюулгүй байдлын стандартыг хангуулах, боловсролын байгууллагын барилга, өргөтгөлийн ажилд төр, иргэний хамтарсан хөндлөнгийн хараат бүс хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх;	Төлөвлөгөөт хяналт шалгалт болон урьдчилан сэргийлэх шалгалтыг 9 сургуульд, Боловсролын Ерөнхий газрын даргын А/218, А/80 тушаалуудыг үндэслэн 20 сургууль, 28 дотуур байранд сургуулийн ажлын хэсэг орчны аюулгүй байдал, стандартын хэрэгжилтэд үнэлгээ өгч ажиллалаа. Тус үнэлгээнүүдийн дунджаар сургуулийн сургалтын орчны аюулгүй байдлын стандартын үзүүлэлт 24.7 хувь бага эрсдэлтэй, дотуур байрын орчны үйлчилгээний стандартын үзүүлэлт 21.5 хувь бага эрсдэлтэй, сургуулийн орчны гал тогооны аюулгүй байдлын үнэлгээ 42 хувь, дотуур байрын гал тогооны үнэлгээ 21.9 хувийн эрсдэлтэй байна. Стандартын хэрэгжилт хангалтгүй байгаа заалтуудыг үндэслэн улсын байцаагчийн 66 заалт бүхий 4 албан шаардлагыг хүргүүлж хэрэгжүүлсэн заалт 42 буюу 63.6 хувьтай биелүүлэн ажилласан байна. Ерөнхий боловсролын сургуулийн орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр Булган сумын 1-р сургуулийн дотуур байр, Хутаг-Өндөр сумын Уньт, Хантай багийн бага сургууль, Сэлэнгэ сумын Атар багийн бага сургууль зэрэг нийт 4 ариун цэврийн байгууламжийг улсын төсвийн 1.4 тэрбум төгрөгийн санхүүжилтээр байгуулсан. Мөн энэ онд хөгжлийн бэрхшээлтэй иргэн саадгүй зорчих нөхцөлийг бүрдүүлж Могод, Сайхан сумдын сургууль орох гарах хэсэгт налуу зам хийснээр аймгийн хэмжээнд 22 сургуулийн 19 сургууль буюу 86.4 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн саадгүй зорчих нөхцөлийг бүрдүүлсэн налуу замтай боллоо.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

11	14	Монгол Улсын Засгийн газрын 2024-05-02 Дугаар 2024_37	2.б. б/хөгжлийн бэрхшээлтэй сурагчийн эрхийг хангах хүрээнд тэднийг дэмжих төв ажиллуулж, тохирох орчныг бүрдүүлэх, тусгай сургалтын хэрэглэгдэхүүн бий болгох, эцэг, эхийн оролцоог хангаж, багшийн туслахаар ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, багш, багшийн туслах, ажилтанд нэмэгдэл хөлс олгох хуулиар тогтоосон арга хэрэгслийг үр дүнтэй хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын цогц арга хэмжээ авах;	2025-2026 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 11 сургуульд 32 суралцагчид 30 багш ганцаарчилсан төлөвлөгөөгөөр ажиллаж, 38.5 сая төгрөг цалинд нь зарцуулсан байна. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 7 цэцэрлэгт 12 хүүхэд суралцаж 23 багш ганцаарчилсан төлөвлөгөөгөөр ажиллаж 35.7 сая төгрөг зарцуулсан байна. "Тэгш хамран сургах боловсролын онлайн сургалтын платформ" (adina.mn)-д 3 багш суралцуулсан. Булган сумын ерөнхий боловсролын 1, 2 дугаар сургуулиудад тусгай хэрэгцээт хүүхдүүдийг хөгжүүлэх "Хөгжлийн танхим"-ыг байгуулж, давхардсан тоогоор 381 хүүхэд үйлчилгээ авсан байна. Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын дэргэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн "Өдөр өнжүүлэх" үйлчилгээ ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд 9 хүүхдийг хамруулан ажилласан байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	15		3.в. в/аймаг, дүүрэг бүрд байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд зориулсан нөхөн сэргээх, нийгэмшүүлэх, боловсрол олгох, өдөр өнжүүлэх хөгжлийн төв болон байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн төрөлжсөн асрамж халамжийн төв байгуулах, холбогдох санхүүжилт, хүний нөөцийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэх.	Булган сумын ерөнхий боловсролын 1, 2 дугаар сургуулиудад тусгай хэрэгцээт хүүхдүүдийг хөгжүүлэх "Хөгжлийн танхим"-ыг байгуулж, давхардсан тоогоор 381 хүүхэд үйлчилгээ авсан байна. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дэргэд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өдөр өнжүүлэх бүлгийг ажиллуулан тайлант хугацаанд 9 хүүхэд хамрагдсан. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа сувиллын яслиар дамжуулан орон нутгийн зорилтот өрхийн болон хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаатай хүүхдийг хүлээн авч асрах, чийрэгжүүлэх, үйлчилгээг үзүүлж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тус яслийн барилгыг 20 ороор нэмэгдүүлэн, 60 ортой барилгыг шинээр барьж, 2025-2026 оны хичээлийн жилд ашиглалтад оруулсан. Сувиллын яслийн орыг нэмэгдүүлсэнтэй холбоотой орон нутгийн төсвийн 50.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар тавилга, эд хогшил, 1, 2-р хоолны тогоо, компьютер, тоног төхөөрөмжөөр хангасан.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%		Үгүй	
12	16	Монгол Улсын Засгийн газрын 2024-08-27 Дугаар 2024_21	2.3. 3/Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг дүнд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон жил бүрийн улсын төсөвт тусган хэрэгжүүлэх;	Булган аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх "Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилттой уялдуулан, төлөвлөсөн. 2025 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа 3 төсөл арга хэмжээнд 2.8 тэрбум төгрөг, ОНТХО, ОНХС, Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр нийт 103 төсөл хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэхээр 17.6 тэрбум төгрөг батлагдсанаас 87 төсөл арга хэмжээнд 13.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож https://shilendans.gov.mn/ , https://bulgan.gov.mn/ вэб сайтаар гүйцэтгэлийг нийтэд ил тод мэдээлж ажилласан. Бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан төсөл, арга хэмжээг 2026 онд хэрэгжүүлэхэд шаардагдах нийт 53 төсөл арга хэмжээний 364.6 тэрбум төгрөгийн ажил арга хэмжээ 2026 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын саналд тусгагдан илгээгдсэн. Үүний үр дүнд 15 арга хэмжээний 219.4 тэрбум төгрөгийн төсөл арга хэмжээ 2026 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад орж баталгаажсан. Үүнээс 44.8 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалт 2026 онд санхүүжигданэ.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	17		2.4. 4/Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнахдаа энэ тогтоолын 2 дугаар хавсралтад заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн аймагт даалгасан 102 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, 2025 оны эхний хагас жилийн байдлаар 49.1 хувь, жилийн эцсийн байдлаар 80.6 хувийн гүйцэтгэлтэйгээр цахим системээр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт тайлагнасан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

13	18	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2025-06-05 Дугаар 2025 №53	1.3/. 3/агаарын бохирдлын өндөр эрсдэлтэй бүсийг тодорхойлж, тухайн бүсэд байрлах сургууль, цэцэрлэгийн дотоод орчны агаарын чанарыг тогтмол хянах, дотоод орчны агаарын чанарыг сайжруулах арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх;	Булган сумын агаарын чанарыг сайжруулах бүс, тухайн бүсэд мөрдөх журмыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Булган аймгийн Засаг даргын хамтарсан 2025 оны А/657, А/256 дугаар тушаал, захирамжаар шинэчлэн тогтоосон. Аймгийн хэмжээнд агаарын бохирдлын өндөр эрсдэлтэй бүс байхгүй байна. Булган аймгийн Булган сумын Мал эмнэлэг ариун цэврийн лабораторийн барилгад 50 гаруй жил хадгалагдаж байсан 94 нэр төрлийн 61 кг хуурай химийн бодис, 25.9 литр шингэн химийн бодисыг 2024 онд Улаанбаатар хотын химийн бодис устгах "Элемент" ХХК-д хүлээлгэж өгсөн. 2025 онд Булган сумын тухайн нөлөөллийн бүсэд нийтийн сонсгол зохион байгуулж, мал эмнэлэг ариун цэврийн лаборатори орчмын агаарын чанарыг сайжруулах зорилгоор лабораторийн химийн хорт болон аюултай хог хаягдлыг устгах, цэвэрлэх шаардлагатай хөрөнгийг 2026 онд шийдүүлэхээр ажиллаж байна	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	19		1.6/. 6/агаарын бохирдлын талаарх мэдээллийг өдөр тутам олон нийтэд тогтмол мэдээлэх тогтолцоог боловсронгуй болгох, (олон нийтийн радио, телевизийн цаг агаарын мэдээтэй хамтатган Улаанбаатар хот, аймгийн төвүүдийн агаарын бохирдлын хэмжээг мэдээлэх) зорилтот бүлэгт хүргэх мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх;	Агаарын чанарын мэдээг өдөр бүр, 7 хоног болон 10 хоногоор Bulgan.weather.gov.mn болон Agaar.gov.mn сайтуудад тогтмол байршуулан, хяналт тавин ажиллаж байна. Аймгийн хэмжээнд агаарын бохирдлын түвшин хүлцэх хэмжээнээс даваагүй байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
УИХ-ын байнгын хорооны тогтоол									
14	20	"Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл"-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018-01-31 Дугаар 2018 №02 ХЗБХ	3.8.. Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, дээрх үйл ажиллагаанд шаардагдах төсөв, хөрөнгийг шийдвэрлэх, дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бүс байгууллагыг дэмжих, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулахад анхаарах, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хамтарсан багийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах, хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, хорооны цагдаагийн алба хаагч, нийгмийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх, мэргэжлийн нийгмийн ажилтныг ажиллуулах.	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх зорилгоор "Харилцан хүндэтгэе", "Гэртээ эрт харья" 2 аян, гэр бүлийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх, гэр бүлийн боловсрол олгох 8 модуль сургалтыг зохион байгууллаа. Гэр бүлийн боловсрол олгох сургалтыг албан байгууллага, сургууль цэцэрлэгүүдийн хүүхдүүдийн асран хамгаалагчдад 67 удаа зохион байгуулж, 3896 хүнд хүргэсэн. Олон улсын гэр бүлийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд 799 хүнийг гэр бүлийн боловсрол олгох сургалтад хамруулсан байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрх хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар 2146 иргэнд мэдээлэл хийж, сурталчилсан ба нийт 6841 иргэнийг хамруулж ажилласны үр дүнд аймгийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн тоо 23 буюу өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5 нэгжээр /17.8% буурсан байна. Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, арга зүйн удирдлагаар хангах чиглэлээр 3 удаагийн үйл ажиллагаа зохион байгуулж, мэргэжлийн ТББ-тай хамтран ажлын байранд нь сургаж, давхардсан тоогоор 555 гишүүнийг хамрууллаа. Гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог нэмэгдүүлэн 21 ажилтныг шинээр томилон ажиллуулж байна. 2025 онд хамтарсан багууд 163 кейст хамгааллын үйлчилгээ үзүүлснээс 96.9 хувийг хааж, 5 кейс ажиллагаанд байна. Нийт кейсийн 39 хувь нь хүүхдийн тусламжийн 108 утасны дуудлага, 61 хувь нь хамтарсан багт шууд ирсэн дуудлага байна. Эрсдэлт нөхцөлд амьдарч буй 329 өрхөд хүрч ажиллан 460 хүүхдэд эргэлт хийн кейс хавтас нээн ажилласан. Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх сургалт.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
15	21	Чиглэл өгөх тухай 2020-12-16	1.1/. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2020 оны 07 дугаар тогтоолоор байгуулсан ажлын хэсгийн хяналт шалгалтын тайланг хэлэлцээд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /У.Хүрэлсүх/-т чиглэл болгосугай: 1/ Мах экспортлогч үндэсний аж ахуйн нэгжүүдийг бодлогоор дэмжиж, мах, махан бүтээгдэхүүнийг экспортолдог аж ахуйн нэгжүүдийн тоог нэмэгдүүлэх;	Мах, махан бүтээгдэхүүн экспортолдог аж ахуйн нэгжүүдийг нэмэгдүүлэх зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны А/240 дүгээр тушаалаар "Хангал суманд цэвэр үүлдрийн махны чиглэлийн үхэр үржүүлэх"-д дэмжлэг үзүүлэх 300.0 сая төгрөгийн эх үүсвэр бүхий хөнгөлөлттэй зээлийг журмын дагуу олгохоор сонгон шалгаруулалтыг хийж, 3 хоршоонд 290.0 сая төгрөгийн зээл олгохоор шийдвэрлэсэн. Энэ онд Хутаг-Өндөр суманд байршилтай "Булган мах маркет" ХХК 4000 тн хонь, 400 тн адууны махыг БНХАУ-д, 50 тн ямааны махыг БНБАУ-д тус тус экспортод гаргасан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	Шийдвэрийн хэрэгжих хугацаа 2021.10.01-ний өдрөөр дуусгавар болсон.

	22	Дугаар 2020 №10 БОХХААБХ	1.5/. Экспортод гаргаж байгаа мах, махан бүтээгдэхүүний тодорхой хувь нь чанар, стандартын шаардлага хангахгүй байгаа тул мэргэжлийн хяналтын үйл ажиллагааг сайжруулж, оновчтой зохион байгуулалт хийх;	Хутаг-Өндөр суманд байрлалтай "Булган мах маркет" ХХК-нд 2024 онд зохистой дадал, аюулын дүн шинжилгээ, эгзэгтэй цэгийн хяналт (НАССР), хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO 22000 стандартаар анхдагч үнэлгээг хийсэн. Тус компани нь анхдагч үнэлгээгээр илэрсэн үл тохирлыг залруулснаар баталгаажуулалтын зөвлөлийн хурлын шийдвэрээр гэрчилгээжсэн. Мөн хонь, ямааны ангилсан маханд тохирлын үнэлгээ хийж, гэрчилгээжсэнээр экспортын гэрчилгээний үнэ төлбөрийг 50 хувь хөнгөлөх боломж бүрдсэн.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	Шийдвэрийн хэрэгжих хугацаа 2021.10.01-ний өдрөөр дуусгавар болсон.
16	23	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-01-17 Дугаар 2022 №01 БОХХААБХ	1.5/. Тариалангийн талбайн хөрсний үржил шимийг хамгаалах, таримлын зохистой сэлгээг сонгон нэвтрүүлж, малын тэжээл болон бусад ашигт таримлын тариалалтыг нэмэгдүүлэх, рапсын тариалалтыг нийт тариалсан талбайн 15 хувиас хэтрүүлэхгүй байх зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Рашаант сумын "Алтан зам Рашаант" ХХК 24 км тариалангийн талбайд ойн зурвас байгуулж, хайлаас 1168 ширхэг, бургас 125 ширхэг, сөөг мод 115 ширхэг тарьсан байна. Булган суманд 12.2 км хамгаалалтын зурвас байгуулж, 6108 ширхэг мод тарьсан бөгөөд аймгийн хэмжээнд нийт 36.2 км ойн зурвас байгуулагдсан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас тэжээлийн таримал ургамлын үрийг 20 хувийн хөнгөлөлттэй нөхцөлөөр 2 иргэн, 2 аж ахуйн нэгжид олгож, тариалалт хийсэн. Мөн Рашаант сумын "Ти Эн Эс Эн Ти" ХХК 500 га талбайд шар буурцаг, Хишиг-Өндөр сумын "Баярт тал агро" ХХК 200 га талбайд судан өвс тариалсан. Аймгийн хэмжээнд 53948.6 га талбайд тариалалт хийснээс рапс 11624 га-д тарьж, 3420 га талбайн ургац ганд нэрвэгдэж, мөндөрт ургац алдаж 6258 га талбайгаас 28534 тн ургац авсан. Рапсын тариалалт нийт тариалсан талбайн 11.6 хувийг эзэлж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	Цаашид өмнөх онтой харьцуулан тайлагнаж байх	Үгүй	
	24		1.9/. Хүнсний хангамж, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор усны эх үүсвэр бүхий газарт төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, малын тэжээл, ашигт таримал тариалах, мод үржүүлгийн газар байгуулахад шинээр газар олгох асуудлыг судалж шийдвэрлэх, нийслэл хот, говийн бүсийн болон хүн ам төвлөрсөн томоохон суурин газруудыг түшиглэн өвөл, зуны хүлэмжийн цогцолбор аж ахуй, хадгалалт борлуулалтын цогцолбор төв байгуулахад урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, хүлэмжид хэрэглэсэн цахилгааны хөнгөлөлтийн цагийн хугацааг уртасгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Тайлант хугацаанд газар эзэмшүүлэх үйл ажиллагааг Монгол Улсын Газрын тухай хууль болон холбогдох бодлого, журамд нийцүүлэн хэрэгжүүлж, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, малын тэжээл, таримал ургамал тариалах, мод үржүүлгийн зориулалтаар 139 нэгж талбарын 336.4 га газрыг шинээр эзэмшүүлэв. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар БНСУ-д үйлдвэрлэсэн 6х20 метр хэмжээтэй, 120 м.кв талбай бүхий 23 ширхэг иж бүрэн хүлэмж нийлүүлэгдэж, "Хөдөө аж ахуй-хөгжлийн ирээдүй" ОНӨХХК аж ахуйн нэгж, хоршоо, иргэнд гэрээгээр олгосон. Тухайлбал: Булган аймаг дахь Политехникийн коллежийн дэргэдэх "Багш суралцагчдын агро нэгдэл" хоршоо 6 ширхэг хүлэмж авч ашиглаж байна. Булган сумын "Үржих олонлог" хоршоо 15 ширхэг хүлэмж авч, 2 агропарк байгуулагдсан байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	25		1.4/. Мал, амьтны гоц халдварт өвчний гаралт, тархалтыг таслан зогсоох зорилгоор отор, нүүдэл, шилжилт хөдөлгөөнд тавигдах мал эмнэлгийн болон бусад мэргэжлийн байгууллагуудын хяналтыг сайжруулах талаар онцгой арга хэмжээ авах, зарим эрсдэлтэй бүс нутгийн мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, мал эмнэлгийн хорио цээрийн байнгын болон түр хяналтын цэгийг нэмэгдүүлж, мал эмнэлгийн нэгдсэн бүртгэлийг сайжруулах;	Энэ оны байдлаар мал, амьтны гоц халдварт өвчингүй тайван байна. Дархлаажуулалтын ажлын хүрээнд нийт 11 нэр төрлийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1.4 сая мал, амьтан хамруулахаар төлөвлөснөөс 1.3 сая толгой мал амьтан хамруулж, 99.4 хувийн гүйцэтгэлтэй ажиллалаа. Мал эмнэлгийн салбарын чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор Хутаг-Өндөр сумын гуртын гүүрэнд 19.8 сая төгрөгийн өртөг бүхий явуулын пост худалдан авч, Мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын байнгын цэгийг байгууллаа.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	Шийдвэрт заасан хугацаа 2022.06.15-ны өдөр дууссан.

17	26	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2022-04-13 Дугаар 2022 №04 БОХХААБХ	1.5/. Мал амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээний хүрээнд Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль болон Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэгжүүлж, хуульд заасан үүргээ биелүүлэггүй тохиолдолд огцруулах хүртэл хариуцлага тооцох;	Гоц халдварт шүлхий өвчний халдвар илрүүлэх ийлдэс судлалын тандалт шинжилгээнд 16 сумын 43 багийн 60 өрх сонгогдож, сонгогдсон өрх бүрээс 4 тугал, 6 хурга, 6 ишиг буюу 16 дээж, нийт 60 өрхөөс 960 дээж цуглуулж шинжилгээ хийсэн. Адууны 4 төрлийн халдварт өвчний халдварлалтын түвшин тогтоох тандалт шинжилгээнд 16 сумын 30 багийн 32 өрх сонгогдож, өрх бүрээс 5 адууны цус авч цусны дээжийг дээж бэлтгэх арга зүйн дагуу ийлдсийг бэлтгэсэн. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2025 оны А/174 дүгээр тушаалын гуравдугаар хавсралтын дагуу Булган аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2025 оны А/76 дугаар тушаалаар аймгийн хэмжээнд 376 өрхийг эрт илрүүлэг үзлэгт хамруулахаар сумдад хуваарилсан. Одоогийн байдлаар 4 сумын 5 мал эмнэлэг 31 өрхөд эрт илрүүлэг үзлэг хийж, нэгдсэн системд бүртгэсэн. ОБЕГ, МЭЕГ-ын хамтарсан Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг зохион байгуулж, тус арга хэмжээний үед шүлхий өвчин гарсан нөхцөлд хээр мал эмнэлгийг дэлгэх үзүүлэх сургуулийг зохион байгуулж, эрсдэл бүхий нутгийн мал сүргийг дархлаажуулалтад хамруулсан. Одоогийн байдлаар гоц халдварт өвчингүй тайван байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	Шийдвэрт заасан хугацаа 2022.06.15-ны өдөр дууссан.
	27		1.6/. Малын тоо толгойн албан татварын 50-аас доошгүй хувийг малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд зарцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Могод, Бүрэгхангай сум халдваргүйтгэл ДҮК машин, Бугат сум ачааны портер машин, суудлын жижиг машин худалдан авсан. Дашинчилэн, Баяннуур, Орхон, Булган, Сэлэнгэ, Бугат сумд нь халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, сэг зэм устгах ажилд зарцуулсан байна. Могод сум нь мал эмнэлгийн үйлчилгээний нэгдсэн цэгтэй болж орон нутаг анхан шатны лабораторийн шинжилгээ хийхээр төлөвлөж багаж тоног төхөөрөмж, оношлуур худалдан авсан. Дашинчилэн сум мал угаалгын ванныг бариулах, засварлах ажлыг хийсэн. Малын тоо толгойн албан татварын орлогын бүрдүүлэлт хангалтгүй байгаатай холбогдуулан малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулалтын хувь хэмжээ хангалтгүй байна.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%		Үгүй	
	28		1.7/. Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал эмнэлгийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх ажлын хүрээнд вакцин болон халдваргүйтгэлийн бодис, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөцийг бүрэн бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусгах;	Мал эмнэлгийн газарт улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хөдөө аж ахуй, мал эмнэлгийн салбарын ажлыг эрчимжүүлэх, бүтээмжийг дээшлүүлэх зорилтын хүрээнд сүүлийн 4 жилд салбарын материаллаг баазыг нэмэгдүүлж 1 суманд дунджаар 60-100 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ариутгалын Дук автомашин, ариутгагч, мал тарилгын хашаа, угаалгын банн зэрэг нийт 10 төрлийн, 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнээр мал эмнэлгийн ажил үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, хөдөлмөрийн бүтээмж нэмэгдсэн. Өвөлжилт хүндэрч, зудын улмаас хорогдсон малын сэг, зэм устгах, булшлах болон гамшгийн үед авч хэрэгжүүлэх бэлэн байдлын төлөвлөгөөнд тодотгол хийж байгаатай холбогдуулан халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгааллын хувцас, тоног төхөөрөмжийн судалгааг гарган нэгтгэж МЭЕГ-т хүргүүлсэн. Аймгийн хэмжээнд халдвар хамгааллын хувцас 2000 ширхэг, ханкон 473 кг, хай-куф 415 кг, суперкилл 20 кг, хлорын шохой 375 кг, новасид 36 кг, трипле кен 20 кг, мананцаржуулагч 13 ширхэг, автомакс 90 ширхэг нөөцтэй байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	Шийдвэрт заасан хугацаа 2022.06.15-ны өдөр дууссан.

18	29	Чиглэл өгөх тухай 2022-06-15 Дугаар 2022 №07 ҮББХ	1.5. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор малын тэжээл тариалах газрын асуудлыг шийдвэрлэх, зуны улиралд сүүний илүүдэлтэй аймгуудад сүү цуглуулах цэг болон боловсруулах үйлдвэрийг кластерын зарчмаар хөгжүүлэх, импортын хуурай сүүг орлох, хадгалалтын хугацаа урттай сүүн бүтээгдэхүүний үйлдвэрийг байгуулах, тоног төхөөрөмжийг шинэчлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх	Баян-Агт, Гурванбулаг, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр суманд 156 нэгж талбарын 35 га талбайг тэжээлийн ургамал тариалахаар төлөвлөснөөс 17 хоршоонд 68.6 га газарт олголт хийгдсэн. АПУ дайринг ХХК Баяннуур сумын малчдаас сүү цуглуулж, Улаанбаатар хот руу татан авч байна. Аймгийн төвийн "Мээжийн сүү" үйлдвэр нь жилд дунджаар 400 гаруй тн сүүг 600 гаруй малчин өрхөөс хүлээн авч, боловсруулан малчдыг сүүний урамшуулалд хамруулж хэвшээд байна. Тэшиг суманд улсын төсвийн 3.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хоногт 6.0 тн сүү боловсруулах хүчин чадалтай сүүний үйлдвэр байгуулагдаж, улсын комисст хүлээлгэж өгөхөөр ажиллаж байна. Булган сумын "Хатан мээж хайрхан" ХХК-ийн "Мээжийн сүү" үйлдвэрт "Сүү боловсруулах үйлдвэрт бизнесийн үйл ажиллагааг дэмжиж шингэн сүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх" зорилготой эргэлтийн хөрөнгийн 500.0 сая төгрөгийн зээл олгосон.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
19	30	Мал, махны бэлтгэн нийлүүлэлт, нөөц, экспортыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-01-17 Дугаар 2023 №02 БОХХААБХ	1.2/. Итпортлогч улсын хорио үзэрийн байгууллагаас тавьж байгаа шаардлагын дагуу хяналт шалгалтыг дотооддоо зохион байгуулж, мах махан бүтээгдэхүүн экспортлох эрх бүхий үйлдвэр, бүтээгдэхүүний тоо хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх;	Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2025 оны "Мал төхөөрөх, мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хадгалалт, худалдаалалтад төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай" 08-03-03/180-04 дугаарт удирдамжийн хүрээнд 14 объектод хяналт шалгалтыг хийхэд үйлдвэрийн аргаар 300 тн, уламжлалт аргаар 86 тн мах бэлтгэсэн байна. Мал эмнэлэг хорио цэрийн хяналтын цэгээр адууны мах 120 кг, үхрийн мах 89.4 тн, хонины мах 138.0 тн, ямааны мах 12.4 тн, 44 цахим гарал үүсэлтэй, 41 тээврийн хэрэгсэл шалган нөвтэрсэн байна. Хяналт шалгалтын явцад 1 аж ахуйн нэгж, 6 иргэний 36.3 тн бүтээгдэхүүнээс 2 нэр төрлийн 12 сорьц авч, лабораторид хүргүүлж шинжилгээнд хамруулсан. Хяналт шалгалтаар 33 дутагдал илрүүлж, 20 дутагдал буюу 60.6 хувийг газар дээр нь арилгуулсан. Илэрсэн дутагдлыг арилгуулахаар 2 иргэнд 13 заалттай хугацаатай албан шаардлага, 14 аж ахуйн нэгж, иргэнд нэгдсэн зөвлөмж хүргүүлж, 57 иргэнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. "Булган мах маркет" ХХК-ийн 2024 онд экспортын явцад үл тохирол гарсантай холбоотой аж ахуйн нэгжид хамтарсан төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж илэрсэн дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн 16 заалттай хугацаатай албан шаардлага өгч, Зөрчлийн тухай хуулийн 13.9 дүгээр зүйлийн 1 дэх заалтын дагуу 2000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр шийтгэлийн арга хэмжээ ногдуулж ажилласан. МЭАЦ-ийн лабораторийн 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 25-551 шинжилгээний дүнгийн хуудсаар адуу, ямааны мах шинжилгээний стандартын зөвшөөрөгдөх хэмжээнд, арчдас E.coli, salmonella илрээгүй, нянгийн ерөнхий тоо шулааны цехийн ажилтны хормогч, хутга, адууны хаа, ариутгалын өрөөний дэвсгэр, гал тогооны ажилтны хормогч, махны мол	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	хэрэгжиж дууссан
20	31	Тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн цэсийн баталгаажуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-01-17 Дугаар 2023 №03 БОХХААБХ	1.4/. Тусгай хамгаалалттай газар нутагт Нийслэл, дүүрэг, сумын Засаг даргын захирамжаар газар эзэмших, ашиглах эрх олгосон болон Нийслэлийн нутаг дэвсгэрт Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар газар эзэмших эрх олгосон асуудлыг хуульд нийцүүлэн шийдвэрлэж, газрын эрхийг гэрчилгээ олгох, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах;	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд заасны дагуу уг асуудал нь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны чиг үүрэгт хамаарах зохицуулалт болно. Эдд Хантай Бүтээлийн нурууны Дархан цаазат газрын хамгаалалтын бүсэд Сэлэнгэ сумаас "Гацуурт" ХХК-д олгосон газар эзэмших эрхтэй 10 нэгж талбарын эрхийг сумын Засаг даргын 2025 оны А/333 дугаар захирамжаар дуусгавар болгосон байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

21	32	Чиглэл өгөх тухай 2023-03-28 Дугаар 2023№05 НББХ	1.1.9/. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхдийн эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх, хүүхдээс мэдүүлэг авахад зориулж тусгайлан бэлтгэсэн өрөө бий болгох, хүүхдийн эрхийг хамгаалсан бодлогыг хэрэгжүүлж ажиллах, бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдээс мэдүүлэг авахдаа хохирогчтой ижил хүйсийн байцаагч ажиллуулах;	Цагдаагийн газрын хүүхдээс мэдүүлэг авах өрөөг дуу чимээ тусгаарлагч ханатай болгон, өрөөнд бичлэгийг 30 хоног хадгалах багтаамжийн төхөөрөмжтэй, дуу дүрсний бичлэг хийх 2 камерыг байршуулсан. Энэ онд Цагдаагийн газарт гэмт хэрэгт өртөж хохирсон 33, холбогдсон 11 хүүхэд бүртгэгдсэн. Мөрдөн шалгах ажиллагааг мэдүүлэг авах өрөөнд явуулж хэвшсэн байна. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хохирсон 40, холбогдсон 1 хүүхэд бүртгэгдсэн байна. Цагдаагийн газар нь насанд хүрээгүй хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртөж, хохирсон гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл, хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа хохирогчийн хүйсийн онцлогийг харгалзан дагнасан эмэгтэй мөрдөгчийг ажиллуулах зорилгоор цагдаагийн эмэгтэй алба хаагчийг томилон, насанд хүрээгүй хүүхэд хохирсон гэмт хэргийг дагнуулан шалгуулж, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөрдөн шалгах тасгийн даргын зүгээс насанд хүрээгүй оролцогчийг олон дахин дуудаж мэдүүлэг авах байдлыг таслан зогсоох, анх мэдүүлэг авахдаа нэг удаа чанартай мэдүүлэг авах, дахин мэдүүлэг авах шаардлагатай тохиолдолд гэрт нь болон түүний байгаа газар, аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт очиж мэдүүлэг авч, насанд хүрээгүй оролцогч нарт хүндрэл, чирэгдэл учруулахгүй байх талаар үүрэг чиглэл өгч ажилласан. Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газрын түр хамгаалах байранд хүүхдээс мэдүүлэг авах өрөөг тохижуулан, хүүхдийн эрхийг хангасан тохиромжтой орчныг бүрдүүлсэн. 2025 онд бэлгийн хүчирхийллийн хохирогч 2 хүүхэд хохирогчтой ижил хүйсийн хууль ёсны төлөөлөгч томилон ажиллуулсан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
22	33	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2023-04-25 Дугаар 2023№05 ТБХ	6/г/. төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын бүх үе шатанд мэргэжлийн судлаачид, мэргэжлийн төрийн бус болон судалгааны байгууллагуудтай хамтран ажиллах.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээнүүд болох Гурванбулаг, Сэлэнгэ сумын төвийн хатуу хучилттай замын ажлуудад авто замын мэргэжлийн хяналтын инженер У.Эрдэнэбилэгтэй хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилласан.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%		Үгүй	
23	34	Чиглэл өгөх тухай 2024-05-24 Дугаар 2024 №07 ТББХ	1.1/. Монгол Улсын Их Хурлын тухай хууль/ шинэчисэн найруулга/ 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр батлагдсан, Монгол Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог хангах зорилгоор Улсын Их Хурлын үйл ажиллагаанд "D-Parliament" болон "D-өргөдөл" цахим системийг нэвтрүүлсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт чиглэл болгосугай: 1/Монгол Улсын Их Хурлын "D-Parliament" болон "D-өргөдөл" цахим системийг иргэд олон нийтэд тайлбарлан танилцуулж, сурталчлах ажлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаараа дамжуулан тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах	Нийтийн цахим өргөдөл, гомдлын систем (D-Өргөдөл)-ийн талаар иргэдэд мэдээ мэдээлэл хүргэн, тус системээр дамжуулан иргэн нийтийн өргөдөл санаачлах болон нийтийн өргөдлийг дэмжиж санал өгөх боломжтой болж буйг танилцуулан ажиллаж байна. Мөн аймгийн хэмжээнд "Цахим Булган" хөтөлбөрийг хэрэгжүүлж "И-Оффис" программ хангамжийг "Анар Системс" компаниар гүйцэтгүүлж, аймгийн төрийн байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагаанд нэвтрүүлэн, өргөдөл гомдлыг хүлээн авч ажиллаж байна.	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%		Үгүй	
	35		3.. Энэ тогтоолын хэрэгжилтийн тайлан мэдээг УИХТГ-т тухай бүр ирүүлж байхыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт үүрэг болгосугай.	Нийтийн цахим өргөдөл, гомдлын систем (D-Өргөдөл)-ийг танилцуулж иргэдэд мэдээлэл хүргэн ажилласан. Мөн "Цахим Булган" хөтөлбөрийг хэрэгжүүлж "И-Оффис" программ хангамжийг "Анар Системс" компаниар гүйцэтгүүлж, аймгийн төрийн байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагаанд нэвтрүүлэн өргөдөл гомдлыг хүлээн авч ажиллаж байна. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хуулийн хугацаанд хүргүүлэн ажиллаж байна.	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%		Үгүй	

24	36	Тогтоолын хэрэгжилтийг хангуулах талаар авах арга хэмжээний тухай 2024-11-06 Дугаар 2024_06 ЕЗДБХ	1.2. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр" (2024-2030)-ийн хэрэгжилтийг нэгдсэн зохицуулалтаар хангаж, жил бүр тайлагнах;	Аймгийн хэмжээнд төрийн 118 байгууллагын дэргэд ёс зүйн дэд хороо үйл ажиллагаа явуулж, төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, гомдол мэдээллийг хүлээн авч шийдвэрлэх чиглэлээр тогтмол ажиллаж байна. Монгол Улсын Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хорооноос зохион байгуулсан хойд бүсийн төрийн байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороог чадавхжуулах сургалтад 30 байгууллагын дэргэдэх ёс зүйн хорооны дарга, гишүүн 45 албан хаагч оролцож, ёс зүйн зөрчлийг шийдвэрлэх үр чадварт суралцсан. Аймгийн хэмжээнд 2025 онд 2029 өргөдөл, гомдол бүртгэгдсэнээс 63 өргөдөл төрийн албан хаагчдын ёс зүйтэй холбоотой бөгөөд нийт өргөдлийн 3.1 хувийг эзэлж байна. Бүрэгхангай, Баяннуур, Баян-Агт, Бугат, Сэлэнгэ, Дашинчилэн, Могод, Гурванбулаг, Рашаант, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр, Төшиг, Хангал сум болон Хялганат тосгоны нийт 28 байгууллагын 1680 албан хаагч төрийн албан хаагчдын ёс зүйн тухай хуулийн сургалтад хамрагдсан бөгөөд энэ нь аймгийн нийт төрийн албан хаагчдын 40.3 хувийг эзэлж байна. Тус онд зохион байгуулагдсан нийт сургалтын хамрагдалт 80.7 хувьд хүрч, шинэ албан хаагчдын чадавх 87 хувийн хамрагдалттайгаар сайжирсан. Мөн мэргэшил, боловсролын дэмжлэг бодитоор нэмэгдсэн нь хүний нөөцийн чанарын үзүүлэлтийг сайжруулж байна.	Хэрэгжсэн - 100%	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	Шийдвэрээр үүрэг болгосон "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр" (2024-2030)-ийн хэрэгжилтийг тайлагнаагүй.	Үгүй	
	37		1.3 . төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлж, төрийн албан хаагчдыг чадавхжуулах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг таниулах сургалтыг зохион байгуулж, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өргөжүүлж, үр дүнг тайлагнаж ажиллах.	Монгол Улсын Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хорооноос зохион байгуулсан хойд бүсийн төрийн байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороог чадавхжуулах сургалтад 30 байгууллагын дэргэдэх ёс зүйн хорооны дарга, гишүүн 45 албан хаагч оролцож, ёс зүйн зөрчлийг шийдвэрлэх үр чадварт суралцсан. Аймгийн хэмжээнд төрийн 118 байгууллагын дэргэд ёс зүйн дэд хороо үйл ажиллагаа явуулж, төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, гомдол мэдээллийг хүлээн авч шийдвэрлэх чиглэлээр тогтмол ажиллаж байна. Үүнд: Бүрэгхангай, Баяннуур, Баян-Агт, Бугат, Сэлэнгэ, Дашинчилэн, Могод, Гурванбулаг, Рашаант, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр, Төшиг, Хангал сум, Хялганат тосгоны нийт 28 байгууллагын 1680 албан хаагч төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн сургалтад хамрагдсан бөгөөд энэ нь аймгийн нийт төрийн албан хаагчдын 40.3 хувийг эзэлж байна. 2025 онд аймгийн хэмжээнд 2029 өргөдөл, гомдол бүртгэгдсэнээс 63 өргөдөл төрийн албан хаагчдын ёс зүйтэй холбоотой байсан бөгөөд нийт өргөдлийн 3.1 хувийг эзэлж байна. Энэ нь суурь түвшинтэй харьцуулахад 0.5 хувиар буурсан байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
25	38	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2025-01-14 Дугаар 2025_01 ИЦББХ	1.2 . Төсвийн тухай хуулийн 28Т2.4, 291.3 заалтуудын хэрэгжилтийг хангуулан Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам", Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаал "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам"-ын хэрэгжилтийг хангах, цахим орчинд байршуулж буй төсвийн талаарх мэдээллийг эдгээр журмуудын хавсралтад тусгасан загварт хууль тогтоомжийн хүрээнд нийцүүлэх, мэдээллийг тогтоосон хугацаанд нь нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар оруулах.(Энэ тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын Инноваци, цахим бодлогын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах)	Сангийн сайдын А/264 дүгээр тушаалын дагуу төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг сумдын ЗДТТ, агентлагуудаас авч, үнэлэн, шаардлага хангасан арга хэмжээг эрэмбэлэн Сангийн яамны (https://publicinvestment.gov.mn) цахим системд оруулсан. Нийт 53 төсөл арга хэмжээний 364.6 тэрбум төгрөгийн ажил арга хэмжээ илгээгдсэн. Үүний үр дүнд 15 арга хэмжээний 219.4 тэрбум төгрөгийн төсөл арга хэмжээ 2026 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад орж баталгаажсан. Үүнээс 44.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт 2026 онд санхүүжигдэнэ. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа 3 төсөл арга хэмжээнд 2.8 тэрбум төгрөг, ОНТХО, ОНХС, Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр нийт 103 төсөл хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэхээр 17.6 тэрбум төгрөг батлагдсанаас 87 төсөл арга хэмжээнд 13.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож https://shilendans.gov.mn/ , https://bulgan.gov.mn/ вэб сайтаар гүйцэтгэлийг нийтэд ил тод мэдээлж ажилласан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

26	39		1.1.1. 1/Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлыг төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын жил бүрийн төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг ханган үр дүнд хяналт тавьж ажиллах;	Монгол Улсын Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хорооноос зохион байгуулсан хойд бүсийн төрийн байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороог чадавхжуулах сургалтад 30 байгууллагын дэргэдэх ёс зүйн хорооны дарга, гишүүн 45 албан хаагч оролцож, ёс зүйн зөрчлийг шийдвэрлэх үр чадварт суралцсан. Аймгийн хэмжээнд төрийн 118 байгууллагын дэргэд ёс зүйн дэд хороо үйл ажиллагаа явуулж, төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, гомдол мэдээллийг хүлээн авч шийдвэрлэх чиглэлээр тогтмол ажиллаж байна. Үүнд: Бүрэгхангай, Баяннуур, Баян-Агт, Бугат, Сэлэнгэ, Дашинчилэн, Могод, Гурванбулаг, Рашаант, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр, Тэшиг, Хангал сум, Хялганат тосгоны нийт 28 байгууллагын 1680 албан хаагч төрийн албан хаагчдын ёс зүйн тухай хуулийн сургалтад хамрагдсан бөгөөд энэ нь аймгийн нийт төрийн албан хаагчдын 40.3 хувийг эзэлж байна. 2025 онд аймгийн хэмжээнд 2029 өргөдөл, гомдол бүртгэгдсэнээс 63 өргөдөл төрийн албан хаагчдын ёс зүйтэй холбоотой байсан бөгөөд нийт өргөдлийн 3.1 хувийг эзэлж байна. Энэ нь суурь түвшинтэй харьцуулахад 0.5 хувиар буурсан байна.	Хэрэгжсэн - 100%	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	Бүрэн хэрэгжээгүй, тайланг ЁСХ руу явуулсан албан бичгийг хавсаргах	Үгүй	
	40	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-06-10 Дугаар 2025_04 ЁЗДБХ	1.1.3. 3/Монгол Улсын ЁС зүйн хорооны гишүүдийн, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх ЁС зүйн дэд хороодын гишүүдийн хараат бус, бие даасан зарчмаар ажиллах нөхцөл, баталгааг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хангах зохицуулалт хийх.	Аймгийн хэмжээнд төрийн 118 байгууллагын дэргэд ёс зүйн дэд хороог тушаал, шийдвэрээр томилогхожүүлж, урамшууллыг тооцон олгож байна. Ёс зүйн дэд хорооны гишүүдийг хараат бус, бие даасан зарчмаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэн, хурлын өрөө тасалгаагаар хангаж, дэд хорооны нарийн бичгийн дарга нарын үйл ажиллагаа саадгүй явуулах боломжийг бүрдүүлэн компьютер, тоног төхөөрөмжөөр ханган ажилласан. Мөн ёс зүйн дэд хороо ажиллаж буй байгууллагуудын удирдлагуудад дэд хорооны гишүүд ажиллагаа явуулах нөхцөлийн бүрдүүлэн, сонсох ажиллаа явуулах, ёс зүйн зөрчлийг судлах, шийдвэрлэх явцад үндсэн хариуцаж буй албан тушаалын чиг үүрийн ажлаас чөлөөлөх чиглэлийг хүргүүлсэн. Монгол Улсын Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хорооноос зохион байгуулсан хойд бүсийн төрийн байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороог чадавхжуулах сургалтад 30 байгууллагын дэргэдэх ёс зүйн хорооны дарга, гишүүн 45 албан хаагч оролцож, ёс зүйн зөрчлийг шийдвэрлэх үр чадварт суралцсан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	41		1.3.1. 1/Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, тухайн байгууллагын ЁС зүйн дэд хорооны гишүүдэд олгох урамшууллын асуудлыг шийдвэрлэх, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэн үр дүнг тооцож ажиллах.	Аймгийн хэмжээнд төрийн 118 байгууллагад ёс зүйн дэд хороо ажиллаж, төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр тогтмол ажиллаж, сургалт нөлөөллийн ажил зохион байгуулж байна. 2025 онд 43 дэд хорооны гишүүдийн урамшууллын асуудлыг төсвийн шууд захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд шийдвэрлэн олгосон.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%		Үгүй	
Ерөнхийлөгчийн зарлиг									

27	42	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туй 2018-05-23 Дугаар 2018_46	3... Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зэр сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай.	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн 149 байгууллага нэр, хаягаа үндэсний бичгээр бичиж, хос бичгээр хаягжуулсан. Аймгийн Засаг даргын 2024 оны А/748 дугаар захирамжаар "Аймгийн хэлний бодлогын салбар зөвлөл"-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн, 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 зорилт 18 арга хэмжээтэй батлан хэрэгжүүлээ. 2025 оны 01 дүгээр сарын 01-ээс бүх албан бичгийг крилл, үндэсний бичгээр хослуулан хөтлөх арга хэмжээг хэрэгжүүлж, төрийн албан хаагчдыг чадавхжуулан 3150 төрийн албан хаагч үндэсний бичгээр албан хэрэг хөтөлж хэвшсэн. Ерөнхий боловсролын сургуулийн дунд болон ахлах бүлгийн 13361 сурагч үндэсний бичиг судалж байна. Үндэсний бичгээ сурч эзэмших, судлан сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хамгаалах зорилгоор үндэсний бичиг соёлыг сурталчлан таниулах арга хэмжээг Монголын уламжлалт сар шинийн баяр болон "Үндэсний бичиг соёлын өдрүүд-2025"-ын хүрээнд зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд 16 сум, 1 тогсоны Соёлын төв, аймгийн Нийтийн номын сангаас үндэсний бичгийн 8 сургалт, үндэсний бичгийн ном болон бүтээлийн 17 үзэсгэлэн, үндэсний бичгийн цэвэр бичигтэн, үндэсний бичиг 60 секунд, хурдан уншигч, уран бичих зэрэг 33 уралдаан, сугалаа болон танин мэдэхүйн хөтөлбөрт 27 арга хэмжээ, нийт 85 арга хэмжээг зохион байгуулж 8735 хүнд хүргэсэн. Булган сумын Соёлын ордон Булган сумын харьяа байгууллагуудын бичиг хэргийн ажилтнуудын дунд үндэсний бичгийн зөв бичих дүрэм, албан хэрэгт хэрхэн ашиглах талаар сургалтыг Монгол хэл, бичгийн багш С.Тунгалагтай хамтран зохион байгуулж 28 албан хаагчийг хамрууллаа.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
28	43	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2019-05-30 Дугаар 2019_104	1.16.. Ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулиудын ойр орчмын түргэн хоолны болон түргэн үйлчилгээний цэгт хяналт тавих	Сумдын Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг, Боловсролын газартай хамтран сумын сургууль, цэцэрлэгт хяналт шалгалтыг 2 удаа зохион байгуулж ажилласан. Хяналт шалгалтаар хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж Сайхан, Баян-Агт сумын сургууль, Булган сумын 3-р сургууль, 2-р цэцэрлэгийн хоолны амт чанарыг сайжруулах 3 удаагийн албан даалгавар хүргүүлсэн. Булган сумын 2-р сургуулийн гал тогоонд хориглосон хүнсний бүтээгдэхүүн худалдаалж байсныг илрүүлж ЭМГ-ын улсын хяналтын ахлах багцаагчтай хамтран үйл ажиллагааг зогсоосон. Хүнс, хөдөө аж ахуйн газар, Эрүүл мэндийн газартай хамтран сургуулиас 150 метрийн зайд орших худалдааны байгууллагуудын үйл ажиллагаанд 2 удаагийн хяналт шалгалт хийж, зөвлөгөө чиглэл өгч, худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүнийг худалдан борлуулахыг зогсоосон. Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/370 дугаар тушаалаар баталсан "Сургуулийн орчинд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүний жагсаалт"-ын дагуу ерөнхий боловсролын сургуулийн дотор, ойр орчинд байрласан худалдаа, үйлчилгээний 10 цэгт улсын эрүүл ахуй, халдвар судлалын улсын байцаагчтай хамтран хяналт хийж, мэргэжил арга зүйгээр ханган, зөвлөмж хүргүүлэв.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	44		1.2. Жил бүр Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын тодорхой хувийг байгальд ээлтэй, стандарт бүхий ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд зориулах эрх зүйн орчинг бүрдүүлж, холбогдох шийдвэр гаргах Тайлбар: Тайланд хийсэн ХШҮ-ний дагуу энэхүү заалтыг ирүүлэхдээ дараах зүйлийг анхаарна уу: Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах чиглэлээр төлөвлөн хэрэгжүүлж буй үйл ажиллагааг тусгах	Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний хүрээнд 2025 онд орон нутгийн төсвөөс 10.9 тэрбум төгрөгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг 48 арга хэмжээнд зарцуулан ажиллалаа. Энэ нь аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний 6.4 хувийг эзэлж байна. Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулахаар ойжуулалт, нөхөн сэргээлт, стандартын үрийн нөөцийг бүрдүүлэх, ойн хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор арчилгааны огтлолт, ойн хөнөөлт шавжийн судалгаа болон тэмцлийн ажил зэрэгт 3.5 тэрбум төгрөг зарцуулсан байна. Байгальд ээлтэй ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд 2025 оны хавар, намрын бүх нийтийн мод тарилтаар 443905 ширхэг мод, бут тарьж, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлж эхэлснээс хойш тарьсан нийт модны тоо 921105 болсон байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

29	45	Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58	1.6. Дүүрэг, сумдад ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээж бүх нийтийн үйлс болгох	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний зорилт, арга хэмжээний хүрээнд аймгийн хэмжээнд 2025 онд мод үржүүлэг, нийтийн эзэмшлийн ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлт, зүлэгжүүлэлтийн зориулалтаар 2 нэгж талбарын 8.6 га газрыг хууль тогтоомжийн дагуу эзэмшүүлэн хэрэгжүүлж байна. Мөн Монгол Улсад ойн салбар үүсэж хөгжсөний 100 жилийг тохиолдуулан Булган сумын 1-р багийн “Цэцэг толгой” гэх газарт 5 га талбайг 2024 онд хашаажуулж шинээр “Ногоон төгөл” байгуулсан. 2025 оны хавар мод бэлтгэлийн 28 аж ахуйн нэгж, байгууллага ногоон байгууламжид 1400 ширхэг шар хуайс тарьж, намар нөхөн тарилт хийлээ. Байгальд ээлтэй ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд бүх нийтээр мод тарих уриалга гарган, сургалт, арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг хэрэгжүүлж 2025 оны хавар, намрын тарилтаар 443905 ширхэг мод, бут тарьж, анчилж байна	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	46		1.7. Мод тарьж ургуулахад шаардагдах усны нөөцийг бүрдүүлэх, ялангуяа гадаргын усыг говийн бүс нутагруу шилжүүлэх, хөв цөөрөм байгуулах, усалгааны хэмнэлттэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх зэрэг арга хэмжээний төсөв, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлж, зохион байгуулах арга хэмжээ авах	Энэ онд 10 сумын 10 байршилд худаг гаргахаар “Баясах ус эрдэнэ” ХХК-тай орон нутгийн 270.0 сая төгрөгөөр гүйцэтгэх гэрээ байгуулсан хэдий ч 2025 оны орон нутгийн төсвийн тодотголоор тус ажил хасагдсан тул 2026 оны орон нутгийн төсөвт тусгуулав.	Санхүү, хөрөнгө оруулалтаас - 0%	Санхүү, хөрөнгө оруулалтаас - 0%		Үгүй	
	47		1.8. Байгалийн бүс, бүснүүрийн хөрс, цаг агаарын онцлогт тохируулан мод тарьж ургуулах арга, орчин үеийн техник технологийг нэвтрүүлж, нэгдсэн зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлэх, хот, суурин газрын ногоон байгууламжийг хот байгуулалтын нэгдсэн төлөвлөлттэй уялдуулан бие даасан салбар болгон хөгжүүлэх	Хөрс, цаг агаарын онцлогт тохируулан мод тарьж ургуулах арга, орчин үеийн техник технологийг нэвтрүүлэх зорилгоор 2024 онд 6 га талбайд зүрвэс үүсгэн, 9000 бортоготой тарьцаар ойжуулалт хийж, 2025 онд 76.0 хувийн ургалттай хүлээж авсан. Бүх нийтээр мод тарих өдрийг тохиолдуулан Булган суманд үйл ажиллагаа явуулж байгаа 32 байгууллагын 71 алба хаагчдад дэвшилтэт аргаар мод тарих ажлын талаар сургалт нөлөөллийн арга хэмжээг Булган сум дундын Ойн анги, Булган сумын ЗДТГ-тай хамтран зохион байгуулсан. Байгууллагын вэб хуудас болон албан ёсны цахим хуудсанд мод тарих заавар, зөвлөмж, бусдыг уриалах 2 удаагийн давтамжтай 1 шторк, 3 постыг оруулж 974 хүнд хүрсэн байна. Уг мэдээллийг 14 хоногийн турш сэргээн байршуулснаар давхардсан тоогоор 2820 хүнд мэдээлэл хүрсэн байна. 2026 онд гадаадын хөрөнгө оруулалттай “Номгон форест” ХХК-тай дэвшилтэт технологиор ойжуулалт хийхээр гэрээ байгуулаад байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	48		2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай.	Байгууллагын вэб хуудас болон албан ёсны цахим хуудсанд мод тарих заавар, зөвлөмж, бусдыг уриалах 2 удаагийн давтамжтай 1 шторк, 3 постыг оруулж 974 хүнд хүрсэн байна. Уг мэдээллийг 14 хоногийн турш сэргээн байршуулснаар давхардсан тоогоор 2820 хүнд мэдээлэл хүрсэн байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

30	49	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-04-05 Дугаар 2022_43	1.8. Иргэд, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд зохион байгуулалт, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагуудыг дэмжин хамтран ажиллах;	Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, иргэдэд зориулсан стандартын шаардлага хангасан спорт талбайн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Булган сумын соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнд орон нутгийн төсвийн 1.3 тэрбум төгрөгийн санхүүжилтээр явган хүний зам, хүүхэд бүрийн насны онцлогт тохирсон тоглоомын талбайн бүтээн байгуулалт хийгдлээ. Япон улсын GOOD сайн дурын байгууллагын залуучуудтай хамтран хүүхэд, өсвөр үеийнхний чөлөөт цагийг зөв зохиистой өнгөрүүлэх зорилгоор "Хүүхэд залуучуудын цэцэрлэгт хүрээлэн"-д байрлах волейболын талбайг сэргээн, задгай талбайн "Open Mic" тайзыг шинээр байгуулав. Мөн улсын төсвийн 1676.4 сая төгрөгийн санхүүжилтээр 6 суманд хүүхдийн тоглоомын талбайн барих ажилд "Өвөлжөөн булаг" ХХК шалгаран 50 хувьтай гүйцэтгээд байна. Сум бүрийг зориулалтын үндэсний бөхийн дэвжээтэй болгох зорилгоор орон нутгийн төсөв болон хандив тусламжийн 75.0 сая төгрөгийн санхүүжилтээр Рашаант, Сайхан, Могод, Хутаг-Өндөр, Баяннуур суманд бөхийн зориулалтын дэвжээ, татамын тоог нэмэгдүүлж, бэлтгэл сургуулилт хийх нөхцөлийг сайжруулсан. 2025 онд аймгийн хөнгөн атлетик, бөх, сур, шагай, волейбол, лауэрлифтинг, бокс, ахмадын отог харваа, Цогтхүү даам, уяачид, бүргэд клуб, Тэшиг ски мастер клуб зэрэг 12 холбоодтой хамтран ажиллах гэрээ байгуулж, өсвөрийн шигшээ багийн бокс, самбо, жүдо, сагсан бөмбөгийн дасгалжуулагчдын цалин хөлсөнд орон нутгийн төсвөөс 90.0 сая төгрөгийг зарцууллаа. Спортын 13 төрлөөр албан ёсны 25 секц, дугуйланд 3236 хүүхэд тогтмол хичээллэж, хамрагдалт өмнөх оноос 3.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
31	50	Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай 2022-07-11 Дугаар 2022_159	3. Монгол хүн, айл өрх бүр Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залж, дээдлэн шүтэж байхыг уриалсугай.	Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бүх шатны байгууллагууд албан өрөө тасалгаандаа Чингис хааны хөргийг хүндэтгэн залж хэвшсэн. Айл өрхүүдэд тус зарлигийн дагуу уриалгыг аймгийн вэб сайт болон бусад мэдээллийн хэрэгслээр дамжуулан сурталчлан ажиллаж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	51		4. Монгол хүн бүр Их Монгол Улсын гал голомтыг сахиж буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билэг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв зөв сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг уриалсугай.	Үндэсний бичиг соёлыг сурталчлан таниулах, уламжлалт гар урлал, ном унших соёлыг хөгжүүлэх зорилгоор Үндэсний бичгээр хэн түргэн унших вэ?, Үндэсний бичгээр хэн цэвэр бичих вэ?, "Эх хэл минь" дэвжээ тэмцээн, "Үндэсний бичиг, ном соёл мину" номын үзэсгэлэн зэрэг 121 арга хэмжээнд 10936 иргэн, хүүхэд, залуучуудыг хамрууллаа. "Эх хэлний өдөр"-ийг угтан аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын 22 сургуулийн 480 гаруй бүлгийн 11400 суралцагч, 650 багшийг хамруулан "Миний монгол хэл" сэдвээр хичээл явуулж, үндэсний бичгийн чимэг хэрэглүүрээр 100 гаруй бичвэр бүтээн олон нийтийн сүлжээнд байршуулсан. Мөн үндэсний дээл, хувцсаа сар бүрийн эхний долоо хоногийн даваа гаргт өмсөж хэвших аймгийн Засаг даргын 2025 оны А/364 дүгээр захирамжийн дагуу төрийн байгууллагын ажилтан, албан хаагчид, аж ахуйн нэгжүүд цагалбарт хугацаанд үндэсний хувцсаа өмсөж хэвшээд байна. "Соёлын бүтээлч сар"-ын аяныг өрнүүлэн, Их Эзэн Чингис хааны мэндэлсэн өдөр, анхдугаар Үндсэн хуулиа баталж, Улс тунхагласны баярын өдрийг тохиолдуулан түүхэн өдрүүдийн ач холбогдлыг тодотгосон соёл, уламжлал, түүхээ хүндэтгэх сэтгэлгээг төлөвшүүлэх, төр нийгмийн зүтгэлтнүүдийн бүтээл туурвил, үзэл санааг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан. Сарын аяны хүрээнд соёлын байгууллагууд үзэсгэлэн, сургалт, лекц, хэлэлцүүлэг, боловсролын хөтөлбөрүүд, уралдаан тэмцээн, урлагийн тоглолт зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж, 31822 хүнд хүргэлээ. Төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээх зорилгоор иргэдийн гар дээр болон сүм хийдэд хадгалагдаж буй түүхэн тодорхой он цагийг илтгэх байгаль, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

32	52	Журам шинэчлэн батлах тухай (Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам) 2024-05-27 Дугаар 2024_73	4.2.1. Энэхүү журмын 5.2.1, 5.2.2-т заасан шаардлагад нийцсэн мэдээллийг 5.3-т заасан хугацаанд Ажлын албанд ирүүлэх; (Хавсралтад заасны дагуу нийслэлд 5, аймагт 4 төрлийн мэдээлэл, ЗГХЭГ, ЗГХХГ болон яам, агентлаг тус бүрийн чиг үүрэгт хамаарах хавсралтад заасан мэдээлэл) (3.2 дахь заалт "Төрийн холбогдох байгууллагууд Зөвлөлийг энэхүү журмын хавсралтаар батлагдсан мэдээллээр тодорхой давтамжтайгаар тогтоосон хугацаанд тасралтгүй хангах үүрэг хүлээнэ")	Булган аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн XXIV/02 дугаар тогтоолоор Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд 2024-2029 онд "Булган аймгийн баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулсан. Тус төлөвлөгөөний хүрээнд Үндэсний аюулгүй байдалд хүргүүлэх мэдээллийг нэгтгэн, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлагнаж байна. 2025 оны хэрэгжилтийг хагас жилийн байдлаар 79.8 хувь, жилийн эцсийн байдлаар 91.9 хувьтай дүгнэж, жилийн эцсийн тайланг Үндэсний аюулгүй байдлын ажлын албанд Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 03/28 тоот албан бичгээр хүлгүүлсэн.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
33	53	Тэрбум мод тарих үндэсний өдөр зарлах тухай 2025-04-03 Дугаар 2025_44	1.. Жил бүрийн 5, 9 дүгээр саруудын Бямба, Ням гарагуудыг тэрбум мод тарих үндэсний өдөр болгон зарласугай. 2. Тэрбум мод үндэсний өдрийн хүрээнд бүх нийтээр мод, сөөг тарих, арчлан ургуулах үйл хэрэгт идэвхтэй оролцож, сурталчлан таниулж, түгээн дэлгэрүүлэхийг Монгол Улсын нийт ард иргэд, айл өрх, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хөгжлийн түнш байгууллагууд, хандивлагч нарт уриалсугай.	Аймгийн хэмжээнд 2025 оны хавар, намрын бүх нийтийн мод тарилтаар 443905 ширхэг мод, бут тарьж, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлж эхэлснээс хойш тарьсан нийт модны тоо 921105 болсон байна. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хот, суурин газрын ногоон байгууламжид 73808 мод бут тарьж, 325 м.кв талбайд цэцэрлэгжүүлэлт хийв. Ингэснээр нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн талбай 4 м.кв-аар нэмэгдэж 24.8 м.кв болсон үр дүнг үзүүлээ.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
ҮАБЗ-ийн зөвлөмж									
34	54	Газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх тухай 2010-03-18 Дугаар 2010_10/09	1. Хот, суурингуудад ашиглахыг хориглосон болон эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй барилга, байгууламжуудыг дахин төлөвлөж, олон улсын стандартын дагуу шинэчлэх,	Ашиглалтын шаардлага хангахгүй дүгнэлттэй Булган сумын 6-р цэцэрлэгийн барилгыг дахин төлөвлөж, 150 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн зураг төслийг "Энхийн жаргал контракшн" ХХК гүйцэтгэж, 2024 онд хүлээлгэж өгсөн. Тэшиг сумын 320 хүүхдийн сургуулийн барилгын зургийн даалгавар боловсруулж, холбогдох газруудад хүргүүлсэн. Хишиг-Өндөр сумын цэцэрлэгийн барилгын зураг төсөл хийлгэх тендер зарлаж, гүйцэтгэгчээр "Энхийн жаргал контракшн" ХХК шалгаран, гэрээ байгуулан ажиллаж байна. Өмнө хийгдсэн паспортжуулах ажлын хүрээнд ашиглалтын шаардлага хангахгүй гэж дүгнэсэн Булган сумын 280 хүүхдийн хүчин чадалтай 4 дүгээр цэцэрлэг, сувицлын ясли, Төв номын сангийн барилгуудыг дахин төлөвлөж, улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгагдаж 2024-2025 онд ашиглалтад орсон.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	55		3. Газар хөдлөлтийн аюул, гамшигтай тэмцэх мэдлэг чадвар, дадал эзэмшүүлэх иргэний хамгаалалтын сургалт, дадлагыг улсын хэмжээнд байнга, тогтмол давтамжтайгаар зохион байгуулах, үр дүнг нь тооцдог байх,	Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339, 340, 2017 оны 67 дугаар тогтоолыг сурталчлах, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын 08 дугаар тушаал "Хүн нэг бүрийн үүргэвч"-ийг бэлтгэх, ач холбогдлыг таниулах чиглэлээр Булган суманд үйл ажиллагаа явуулдаг байгууллага, аж ахуйн нэгжүүдэд ангиллын сургалт зохион байгуулах, бэлэн байдлыг хангуулах, хяналт тавин ажиллах алба хаагчдын хуваарь гарган ажилласан. Онцгой байдлын газар, Боловсролын газартай хамтран Булган сумын ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын суралцагчдад гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх мэдлэг олгох талаар ангиллын сургалтыг 9 удаа, 681 хүүхдэд танхимын хэлбэрээр зохион байгуулсан. Байгууллага, аж ахуйн нэгжүүдийн хүсэлтийн дагуу газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх таниулах, гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах сургалт зохион байгуулсан. Сургалтад 13 байгууллагын 432 ажилтан, алба хаагчид хамрагдаж газар хөдлөлтийн гамшгийн үеэр хэрхэн аврах, хохирол багатай даван туулах талаарх 520 ширхэг тараах материалыг хүргэн, бэлтгэл бэлэн байдлыг хангууллаа. Булган Онцгой байдлын газар, Засаг даргын Тамгын газар, Сайхан Монгол фэйсбүүк хуудсаар дамжуулан иргэд олон нийтэд газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, видео, постеруудыг Онцгой байдлын ерөнхий газар, Урьдчилан сэргийлэх газрын цахим хуудаснаас 6 удаа татан авч байршуулан 347 хандалт авсан байна. Сум, орон нутгийн иргэдэд мэдээ мэдээллийг хүргэх зорилгоор "Багц мессеж"-ээр 16 сумын 25400 иргэнд мэдээллийг дамжуулж ажилласан. Аймгийн хэмжээнд 16 сум, 1 тосгонд байршилтай 16 Булган сумын төвл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

35	56	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018-02-05 Дугаар 2018_06/05	1.9. Хяналтгүйгээр худалдаалж байгаа ахуйн хэрэглээний хийг тусгай зөвшөөрөл бүхий хүнсний дэлгүүр, аж ахуйн нэгжээр дамжуулан худалдаалах болон ахуйн хэрэглээний хийг насанд хүрээгүй хүүхдэд худалдаалахыг хориглох шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх.	Ахуйн хэрэглээний хийг зөвшөөрөлгүйгээр, хяналтгүй худалдаалж байгаа тохиолдол бүртгэгдээгүй. Булган аймгийн Цагдаагийн газраас хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа хүнс болон ахуйн хэрэглээний зүйл худалдан борлуулдаг аж ахуйн нэгж, зах худалдааны төвүүдээр ахуйн хэрэглээний хий худалдаалж байгаа үйл ажиллагаанд тогтмол хяналт тавин ажиллаж байна. Мөн 18 хүртэлх насны иргэнд ахуйн хийг худалдан борлуулахгүй байх 4 заалт бүхий зөвлөмжийг боловсруулан, 114 аж ахуйн нэгжид хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажилласнаар энэ оны байдлаар ахуйн хийтэй холбоотой хүний амь нас, эрүүл, мэндэд хохирол учирсан тохиолдол бүртгэгдээгүй байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	57		2.6. УБ хотын цэвэрлэх байгууламжийн шинэчлэлийн ажлыг эрчимжүүлж, гэр хороолол, аймаг сумын төвүүдэд дэвшилтэт технологи бүхий хэсэгчилсэн, зардал багатай ариун цэврийн байгууламжуудын шийдлийг туршин нэвтрүүлж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг сайжруулах, холбогдох стандартыг мөрдүүлэх	Сэлэнгэ сумын төвийн цэвэрлэх байгууламж болон саарал ус шүүрүүлэх талбайн ажлыг байгаль хамгаалах сангийн 591.5 сая төгрөгийн санхүүжилтээр "Хулдын бүлээн" ХХК гүйцэтгэж, ашиглалтад хүлээлгэн өгсөн. Тайлант хугацаанд 40 айл өрх, 22 аж ахуйн нэгж хөрс бохирдуулагч нүхэн жорлонг буулгаж, 77 айл өрх, 43 аж ахуйн нэгж нүхэн жорлон, угаадасны нүхийг MNS 5924:2015 стандартын шаардлага хангасан эко жорлонтой болгосон байна. Үүний үр дүнд 2025 оны байдлаар аймгийн хэмжээнд 16903 жорлон ашиглагдаж байгаа бөгөөд өссөн дүнгээр 1830 айл өрх, аж ахуйн нэгж буюу 10.8 хувь нь стандартын шаардлага хангасан жорлонтой болсон байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
36	58	Усны нөөцийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, усны чанар, аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай 2019-12-31 Дугаар 2019_60/40	2.7. Усны хэмнэлттэй хэрэглээг төлөвшүүлж, ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх зохистой менежментийг явуулах, үйлдвэрлэлийн хаягдал бохир усыг дэвшилтэт технологиор цэвэрлэж дахин ашиглахыг бодлогоор дэмжих	Гурванбулаг сумын ахуйн үйлчилгээний гадна бохир усны шугамын угсралтын ажлыг "Баян-Өндөр булаг" ХХК 120.0 сая төгрөгөөр гүйцэтгэн ашиглалтад оруулж 1 аж ахуйн нэгж, Сэлэнгэ сумын төвийн цэвэрлэх байгууламж саарал ус шүүрүүлэх талбайн ажлыг байгаль хамгаалах сангийн 591.5 сая төгрөгөөр "Хулдын бүлээн" ХХК гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өгч 2 аж ахуйн нэгж холбогдсон. Хангал сумын төвийн цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугамын ажлын зургийг "Нарлаг хөхий" ХХК 60 сая төгрөгөөр гүйцэтгэж байгаа бөгөөд төсөвт өртөг 1.8 тэрбум төгрөг гарч хөрөнгө оруулалтад тусгуулахаар санал хүргүүлсэн. Орхон сумын цэвэрлэх байгууламжийн зураг төсөл боловсруулах ажил даалгаврын шатандаа явж байна. Могод сумын цэвэрлэх байгууламжийн зураг төсөл хийгдэж хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхээр холбогдох газарт санал хүргүүлсэн. Баяннуур сумын цэвэрлэх байгууламжийн зураг төслийг Эдийн засаг, хөгжлийн яамнаас хийлгэхээр судалгааны ажил хийгдэж байна. Гурванбулаг сумын цэвэрлэх байгууламжийн зураг төслийг "Хатанбаатар" ХХК 81.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулах шатандаа байна. Бугат сумын цэвэрлэх байгууламжийн зураг төсөл боловсруулах даалгаврыг боловсруулан тус суманд хүргүүлээд байна. Аймгийн хэмжээнд төв, суурин болон аж ахуйн нэгж, байгууллагын 16 ариун цэврийн байгууламж хаягдал усыг дэвшилтэт технологиор цэвэрлэж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
37	59	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-09-30 Дугаар 2021_03	3.5. Байгаль орчноо хайрлан хамгаалах, зохицон амьдрах, монгол зан заншлыг дээдлэх, уур амьсгалын нөлөөллийг бууруулах, ой мод, усны нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор экологийн боловсролыг бүх шатны боловсролын байгууллага болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан бүх нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээ авах.	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Бүх нийтээр мод тарих өдрийг тохиолдуулан Булган суманд үйл ажиллагаа явуулж байгаа 32 байгууллагын 71 албан хаагчид мод тарих ажлын талаар сургалт нөлөөллийн арга хэмжээг Булган сум дундын ойн анги, Булган сумын 3ДТТ-тай хамтран зохион байгуулсан. Байгууллагын вэб болон албан ёсны цахим хуудсанд мод тарих заавар, зөвлөмж, бусдыг уриалах 2 удаагийн давтамжтай 1 шторк, 3 постыг оруулж 974 хүнд хүрсэн байна. Уг мэдээллийг 14 хоногийн турш сэргээн байршуулснаар давхардсан тоогоор 2820 хүнд мэдээлэл хүрсэн байна. ЕБС-ийн сурагчдын дунд "Миний ногоон дэлхий", "Байгалиа хэрхэн хамгаалах вэ" сэдэвт гар зургийн болон видео бичлэгийн уралдаан зарлаж, бүтээлээ ирүүлсэн хүүхдүүд, анги хамт олныг шалгаруулан, шагнаж урамшууллаа. Мөн ерөнхий боловсролын сургуулийн 371 сурагч, цэцэрлэгийн 85 сурагчид байгаль орчноо хайрлан хамгаалах сэдвийн хүрээнд явган аяллыг зохион байгуулж, экологийн боловсрол олголоо.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

38	60	Хүнсний аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-05-02 Дугаар 2022_01	3.4. Тариалангийн зориулалттай газар ашиглалтыг сайжруулах, талбайн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор шинээр 200.0 мянган га атар газар олгох ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны IX/18 дугаар тогтоолоор "Булган аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө"-г шинэчлэн баталсан. Уг төлөвлөгөөнд шинээр атар газар эзэмшүүлэхээр тусгагдаагүй бөгөөд харин олон жил атаршсан, ашиглалтгүй байгаа 33804.8 га тариалангийн талбайг эргэлтэд оруулахаар тусгасан байна. Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын дагуу тариалангийн ангилалд шилжүүлэх боломжтой атар (бэлчээр) газрын байршлын судалгааг ирүүлэх чиглэл өгөгдсөний үндсэн дээр Баян-Агт суманд 333 га, Бугат суманд 325 га, Могод суманд 1495 га, Орхон суманд 300 га, нийт 2467.5 га газрыг ангилал шилжүүлэх боломжтой байршлаар тодорхойлж, нарийвчилсан хэмжилт, зураглалын ажил болон хөрсний судалгааг Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа судалгааны хүрээлэнгийн мэргэжлийн баг гүйцэтгэсэн. Судалгааны дүгнэлт гарсны дараа уг газрын ангиллыг өөрчлөх асуудлыг сум, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, холбогдох шийдвэрийг гарган дээд шатны байгууллагад хүргүүлэхээр төлөвлөж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	61		3.8. Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг бүсчлэн, кластераар хөгжүүлэх, хот суурин, газар тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх, түүхий эд бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;	Булган аймагт 2025 оны 04 дүгээр сард зохион байгуулагдсан Монгол Улсын Засгийн газрын өргөтгөсөн хуралдаанаас "Хойд бүсэд үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийг дэмжих зарим арга хэмжээний тухай" 2025 оны 209 дүгээр тогтоол батлагдсан. Тус тогтоолд "Хойд бүсийн мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, технологийн парк"-ийг Булган аймагт байгуулах шийдвэр гарсан тул "Булган үйлдвэр технологийн парк"-ийн ажлын даалгаврыг боловсруулж, ТЭЗҮ, зураг төсөв боловсруулахад шаардагдах санхүүжилтийг улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгах, шийдвэрлүүлэх албан бичгийг ЭЗХЯ-д хүргүүлээд байна. "Шинэ хоршоо" хөдөлгөөний хүрээнд аймгийн хэмжээнд 673 хоршоо шинээр байгуулагдаж, 535 хоршооны 1895 малчинд 70.26 тэрбум төгрөгийн зээл олгож, 45 хоршооны 86 малчны 3.5 тэрбум төгрөгийн зээлд 2.0 тэрбум төгрөгийн батлан даалт гарган эрчимжсэн мал аж ахуй эрхлэлтийг дэмжин ажилласан. Дашинчилэн сум Хоршоо хөгжүүлэх сангаас "Адуун толгой хошуу" хоршоонд "Стандарт хадгалалт, хөргүүртэй зоорь" төсөлд 50.0 сая төгрөг, мах, махан бүтээгдэхүүн боловсруулах цехийн үйл ажиллагаа эрхэлдэг "Товчлох хурд" ХХК-ийн дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэн, Хутаг-Өндөр сум Хоршоо хөгжүүлэх сангаас "Хорголжин тэжээлийн үйлдвэр" өргөтгөх төсөлд 30.0 сая төгрөгийн зээл олгож, арьс шир нэхий боловсруулах цехийг 31.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэгт хамруулсан байна. Мөн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцаас 764.1 сая төгрөгийн 325 тоног төхөөрөмж нийлүүлсэн. Үүнд: Сүү, цагаан идээ 81.0 сая төгрөгөөр 35 тоног төхөөрөмж, чацаргана жимс 61.3 сая төгрөгөөр 11 тоног төхөөрөмж, хөргөлтийн 53.6 сая төгрөгийн 2 тоног төхөөрөмж	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	62		3.10.. Хоол, хүнсний зөв, зохистой, соёлтой хэрэглээний талаарх сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг улс орон даяар зохион байгуулах	Бүс, улсын хэмжээнд зохион байгуулагдсан хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарын сургалт үйл ажиллагаанд аймгийн төлөөлгүүдийг оролцоход дэмжлэг үзүүлэв. Хүнсний аюулгүй байдлын сорилтын лабораторийн чадамжийг бэхжүүлэхэд улсын төсвийн 45.1 сая төгрөгийн хөрөнгөөр автоклап, спектофотометр, био аюулгүйн кабинет, татах шүүгээгээр хангагдлаа. Хүнсний салбарын дөвхөрдсөн тоогоор 223 албан хаагч нарт Хүнсний тухай багц хуулиар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, фейсбүүк орчноор 15 мэдээлэл иргэдэд түгээж, 10 төрлийн гарын авлага материалаар хангаж ажиллав. Эрүүл хооллолтын мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор "Тэнцвэртэй хооллолт", "Эрүүл бүс хүнсний хэрэглээ" сэдвээр сургалт зохион байгуулж, боловсролын болон хүчний байгууллагын ажилтан, сурагч, нийт 10420 иргэнийг хамрууллаа. "Сахаргүй 30 хоног Challenge"-д нэгдэж, "Долоо хоногийн нэг өдрийг чихэргүй" арга хэмжээг хэрэгжүүлэн 350 гаруй хүүхдэд мэдээлэл хүргэж, 1057 сурагчид эрүүл хооллолтын зөв дадлын талаар зөвлөгөө өгч, 700 гаруй материал түгээсэн.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

39	63	Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн өнөөгийн байдал цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 2022-11-25 Дугаар 2022_03	1.3 - Үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхол Монгол Улсын хөгжлийн бодлогод ниицүүлэн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох ажлыг цахим хэлбэрээр сонгон шалгаруулалтын журмаар /нээлттэй болон хязгаарлагдмал/ зохион байгуулах тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээг тухайн сум дүүргийн нутаг дэвсгэрийн 15 хувиас хэтрүүлэхгүй байх;	Ашигт малтмал, газрын тосны газраас 2025 онд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар Бүрэгхангай суманд 2408.58 га, Хангал суманд 80.52 га талбайг "Эрх чамба", "Хонзанг", "Дэлхийн хүдэр", "Хаш болор", "Сеон зол" зэрэг 5 аж ахуйн нэгжид олгосон. Нийт аймгийн хэмжээнд 37 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Тусгай зөвшөөрлөөр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд холбогдох ууль, журмын хүрээнд хяналт тавин ажилласан. Аймгийн хэмжээнд олгосон тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээг сумын газар нутагтай харьцуулахад Баяннуур сумын 18.3, Бүрэгхангай сумын 8.6, Гурванбулаг сумын 2.3, Могод сумын 0.05, Орхон сумын 5.6, Рашаант сумын 5.19, Сайхан сумын 3.2, Хангал сумын 6.4, Хишиг-Өндөр сумын 2.4, Хутаг-Өндөр сумын 0.02 хувийг тус тус эзэлж, Булган аймгийн хэмжээнд хайгуулын тусгай зөвшөөрөл нийт газар нутгийн 3.14 хувийг эзэлж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
ЗГ-ын тогтоол									
40	64	"Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж" □ төсөл, арга хэмжээг батлах тухай 2021-06-01 Дугаар 2021_161	3. "Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж" төсөл, арга хэмжээний хүрээнд сумдын Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, инженерийн дэд бүтцийн барилга, байгууламжийн ашиглалт, үйлчилгээг нэгдсэн байдлаар зохион байгуулж ажиллахыг холбогдох аймаг, сумын Засаг дарга нарт даалгасугай.	Сумын хөгжил-Инженерийн дэд бүтцийн хангамж төсөлд Хутаг-Өндөр, Хишиг-Өндөр, Сэлэнгэ, Дашинчилэн сум хамрагдсан. Хутаг-Өндөр суманд "Илчиг хутаг" ОНӨААТҮГ дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн ашиглалт, үйлчилгээг зохион байгуулан ажиллаж байгаа ба дулаан, цэвэр усны 2642 м, бохир усны 2800 м шугам сүлжээ, 50 м.куб биологийн байгууламжтай байна. Мөн 3.8 мВт хүчин чадалтай дулааны төв, 50 м.куб цэвэр усан сан бүхий эх үүсвэртэй. Хишиг-Өндөр суманд "Хишиг дулаан" ХХК концессын гэрээгээр дулаан, цэвэр усны 790 м шугам сүлжээг барьж ашиглаж байна. Сэлэнгэ сумын дулаан, цэвэр усан хангамжийн шугам сүлжээний өргөтгөлийг "Үндсэн төсөл" ХХК-ийн зураг төслөөр "Долоон бар" ХХК концессын гэрээгээр 790 м дулаан, цэвэр усан хангамжийн шугам сүлжээг хариуцан ажиллаж байна. Ариутгах татуургын шугам сүлжээний ажлыг 2025-2026 онд "Хулдын бүлээн" ХХК гүйцэтгэж байна. Дашинчилэн суманд 1085 м дулаан, цэвэр усан хангамжийн шугам сүлжээг "Дулаан баян хайрхан" ХХК концессын гэрээгээр барьж ашиглаж байна. Тус сумын дулааны эх үүсвэр 1.8 мВт хүчин чадалтай, 25 м.куб цэвэр усан хангамжийн даралтат цамхаг, гүний худаг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан. Тус сумын төвийн инженерийн шугам сүлжээний ажлын гүйцэтгэгчээр "И жи өү" ХХК шалгарч 2024-2026 онд улсын төсвийн 2.7 тэрбум төгрөгөөр гүйцэтгэж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	"Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж" төсөл, арга хэмжээ 2021-2024 онд хэрэгжиж дууссан.

41	65	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7	5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасгай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томъёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн 149 байгууллага нэр, хаягаа үндэсний бичгээр бичиж, хос бичгээр хаягжуулсан. Үндэсний бичгээ сурч эзэмших, судлан сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хамгаалах зорилгоор үндэсний бичиг соёлыг сурталчлан таниулах арга хэмжээг Монголын уламжлалт сар шинийн баяр болон "Үндэсний бичиг соёлын өдрүүд-2025"-ын хүрээнд зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд 16 сум, 1 тосгоны Соёлын төв, аймгийн Нийтийн номын сангаас үндэсний бичгийн 8 сургалт, үндэсний бичгийн ном болон бүтээлийн 17 үзэсгэлэн, үндэсний бичгийн цэвэр бичигтэн, үндэсний бичиг 60 секунд, хурдан уншигч, уран бичих зэрэг 33 уралдаан, сугалаа болон танин мэдэхүйн хөтөлбөрт 27 арга хэмжээ, нийт 85 арга хэмжээг зохион байгуулж 8735 хүнд хүргэсэн. Ерөнхий боловсролын сургуулийн дунд болон ахлах бүлгийн 13361 сурагч үндэсний бичиг судалж байна. 2025 оны 01 дүгээр сарын 01-ээс Төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг хос бичгээр хөтлөх ажлыг туршин, архив, албан хэрэг хөтөлтийн ажилтнуудад цахим тооцоолуурт монгол бичгийн (CMs Ulaanbaatar) (CMs Uрга) (CMs Huree) фонтыг ашиглан албан бичиг хөтлөх аргад суралцах, албан бичгийг монгол бичгээр хөтлөх сургалтыг зохион байгуулснаар аймгийн төрийн албан хаагчдын унших чадварын дундаж 67-135 үг, бичих чадварын дундаж 3.5-4 оноо, зөв бичих зүйн чадвар 50.0 хувьд хүрсэн. Булган сумын Соёлын ордон Булган сумын харьяа байгууллагуудын бичиг хэргийн ажилтнуудын дунд үндэсний бичгийн зөв бичих дүрэм, албан хэрэгт хэрхэн ашиглах талаар сургалтыг Монгол хэл, бичгийн багш С.Тунгалагтай хамтран зохион байгуулж 28 бичиг хэргийн ажилтан хамрагдаж 28 байгууллага хос бичгээр албан	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
42	66	Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-09-14 Дугаар 2022_340	1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр зохих хууль журмын дагуу хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус үүрэг болгосугай.	Аймгийн хэмжээнд төр, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран хийх 32 ажлын төлөвлөгөөг гаргасан. 2025 онд аймгийн хэмжээнд 14 төрийн бус байгууллагатай хамтран ажлын байр нэмэгдүүлэх, хүүхэд, эмэгтэйчүүд, залуучууд, ахмад настны эрх хамгаалал, эрүүл амьдрах идэвхийг өрнүүлэх, эрх зүйн боловсрол олгох, мал, амьтны эрүүл мэндийг сайжруулах, тоо толгойг өсгөх, аялал жуулчлал, төрийн үйлчилгээ зэрэг 20 гаруй ажил, арга хэмжээг зохион байгуулсан байна. Булган аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх "Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд аялал жуулчлалын идэвхтэй улирал эхэлж байгаатай холбогдуулж, зочид буудал, зоогийн газар, амралт аялал жуулчлалын газруудын зочлох болон утгах үйлчилгээний стандартыг хэвшүүлэх, чанарыг сайжруулах, салбарын ажилтныг сургаж хөгжүүлэх, хэрэглэгчийн эрэлтэд нийцсэн хариуцлагатай үйлчилгээг бий болгоход чиглэсэн зочлох үйлчилгээний ажилтнуудад зориулсан мэргэжлийн сургалтыг 16 сум, 1 тосгоны 106 иргэн аж ахуйн нэгжид "Зочлох үйлчлэх салбарын сургалт үйлдвэрлэлийн төв" ГҮТББ-тай хамтран амжилттай зохион байгуулж, сертификат олгож төсвөөс 8.2 сая төгрөг зарцуулав. Сogтyуpyулax yндaаны "Хариуцлагатай үйлчилгээ эрхлэх" сертификат олгох сургалтыг аймгийн ХАҮТ-аар гэрээний дагуу гүйцэтгүүлж, 56 ажилтныг хамруулав. "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр", "Амар тайван Булган" хөтөлбөрийн хүрээнд Булганы өнгө ТББ, Ахмад хуульчдын холбоо, Цагдаагийн газрын Ахмадын зөвлөл, АА цуглааны Гэгээрэл бүлэгтэй хамтран 16 сум, 1 тосгонд 5 удаагийн арга хэмжээг хэрэгжүүлсэн. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын ажлаах асчлалын хувсгал "Ахмал	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
67			1.3. цэцэрлэгийн барилга төлөвлөөгүй орон сууцны хороолол, цогцолбор барилгын зураг төслийг баталж магадлан хийсэн, барилгын ажлын зөвшөөрөл олгосон, хүлээн авч ашиглалтад оруулсан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцуулах талаар зохих арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Булган суманд 280 хүүхдийн цэцэрлэгийн шинэ барилга ашиглалтад орж хүчин чадал нэмэгдсэн. Цэцэрлэгийн хүүхдийн багтаамж хангалттай байна. Одоогийн байдлаар сургууль, цэцэрлэг төлөвлөөгүй орон сууцны хороолол, хотхоны цогцолбор барилгын төлөвлөлт байхгүй байна. 2025 онд шинээр ашиглалтад орсон орон сууцны барилгууд аймгийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан газарт баригдсан бөгөөд цэцэрлэгийн бүсэд төлөвлөгдсөн.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	ЗГ-ын тогтоолын хэрэгжилтийг тайлагнах хугацаа 2023.01.31-ний өдрөөр дуусгавар болсон.

43	68	Орон сууцны хороолол, цогцолбор барилгад хүүхдийн цэцэрлэг байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-09 Дугаар 2022_402	1.4. орон сууцны хороолол, цогцолбор барилгын 1, 2 дугаар давхарт цэцэрлэг байгуулах зорилгоор түрээслэх, худалдан авах, салбар бүлэг ажиллуулахад норм нормативыг мөрдүүлэх чиглэлээр мэргэжлийн хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг авч, хэрэгжилтийг хангаж, хамтран ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Цэцэрлэгийн хүүхдийн багтаамж хэвийн байгаа бөгөөд орон сууцны хороолол, цогцолбор барилгад түрээсээр үйл ажиллагаа явуулж буй цэцэрлэг байхгүй.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	ЗГ-ын тогтоолын хэрэгжилтийг тайлагнах хугацаа 2023.01.31-ний өдрөөр дуусгавар болсон.
	69		2. Цаашид шинээр баригдах орон сууцны хороолол, цогцолбор барилга байгууламжийн зураг төсөлд цэцэрлэг төлөвлөх, ашиглалтад оруулах талаар дараахь арга хэмжээ авч хэрэгжилтийг хангаж ажиллахыг дор дурдсан холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгасугай: 2.1. барилга байгууламжийн газар олголт, барилгажилтын төсөл, архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг төсөлд холбогдох норм, дүрмийн дагуу цэцэрлэгийн барилгыг заавал тусган баталгаажуулж байхад хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 2.2. орон сууцны хороолол, цогцолбор барилгад төлөвлөгдсөн цэцэрлэгийн барилгыг бүрэн ашиглалтад орох хүртэл хугацаанд тухайн бүс нутгийн байршилд "түр цэцэрлэг" байгуулан ажиллуулж байх талаар хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	Булган аймгийн хэмжээнд орон сууцны хороолол хотхоны төлөвлөлт хийгдээгүй. Цэцэрлэгийн барилгыг Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм дүрэм, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын төлөвлөлт БНБД 31-24-22 норм дүрэм болон бусад стандарт норм дүрмийн дагуу үйл ажиллагааны болон үйлчилгээний хүрээг тогтоож, төлөвлөн хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллаж байна. 2025 онд Булган сумын 6-р цэцэрлэгийн шинэ 150 хүүхдийн ортой барилгын ажлын зургийн төсвийг шинэчилсэн ба 2026 оны улсын төсөвт тусгуулахаар санал хүргүүлсэн. 2024 онд Булган сумын 4-р багт бага сургуулийн газрыг тусгуулж, Боловсрол шинжлэх ухааны газарт олгосон.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	ЗГ-ын тогтоолын хэрэгжилтийг тайлагнах хугацаа 2023.01.31-ний өдрөөр дуусгавар болсон.
	70		3. Хот, тосгоны хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд хот байгуулалтын норм, дүрмийн шаардлагыг хангасан цэцэрлэгийн барилгыг тусгасан эсэхэд хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Булган аймгийн 15 сум, 1 тосгон нь хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй бөгөөд шинээр Бугат сумын ерөнхий төлөвлөгөөнд ирээдүйн хүн амын тооцоо судалгаанд үндэслэж боловсролын барилга төлөвлөлт хийгдэнэ. Булган суманд шинээр 3 цэцэрлэг, бусад суманд тус бүр цэцэрлэгийн өргөтгөл төлөвлөсөн.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	ЗГ-ын тогтоолын хэрэгжилтийг тайлагнах хугацаа 2023.01.31-ний өдрөөр дуусгавар болсон.
	71		4. Цэцэрлэгийн зориулалтаар баригдсан барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгөөр түрээслэх, худалдан авах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх, шаардгдах зардлыг жил бүрийн улс, нийслэл, орон нутгийн төсвийн төсөлд тусгахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Аймгийн хэмжээнд 22 цэцэрлэг хэвийн нөхцөл горимоор ажиллаж байгаа бөгөөд иргэн, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар стандартын шаардлага хангасан цэцэрлэгийн барилга баригдаагүй байна. Цэцэрлэгийн зориулалтаар баригдсан барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгөөр түрээслэх, худалдан авах асуудал үүсээгүй.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	ЗГ-ын тогтоолын хэрэгжилтийг тайлагнах хугацаа 2023.01.31-ний өдрөөр дуусгавар болсон.
44	72	Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-23 Дугаар 2022_419	3. Энэ тогтоолын 2-т заасан чиглэлийн хүрээнд орон нутгийн хэмжээнд Ажлын хэсэг байгуулж, тодорхой арга хэмжээ авч, шаардгдах эх үүсвэрийг батлагдсан төсөвтөө багтаан санхүүжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. /2. Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн боловсронгуй болгох арга хэмжээний цогц хөтөлбөр боловсруулж, батлуулахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт тус тус үүрэг болгосугай./	"Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих арга хэмжээний санал боловсруулах" хэлэлцүүлгийг зохион байгуулж, дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг аймгийн Засаг даргын 2022 оны А/673 дугаар захирамжаар байгуулан, "Нээлттэй аймаг" хөтөлбөрийг боловсруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны хуралдааны XIII/03 дугаар тогтоолоор батлуулсан. Шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэн 2025 оны байдлаар хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Булган суманд 3 блок 146 айлын орон сууц ашиглалтад орсон. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хутаг-Өндөр сумын төрийн албан хаагчдын 8 айлын орон сууцны барилга 11 дүгээр сард ашиглалтад орж, Булган сумын төрийн албан хаагчдын 15 айлын орон сууцны энэ оны төлөвлөгөөт ажил 100 хувь дууссан. Ингэснээр орон сууцны хүртээмж аймгийн хэмжээнд 15.3 хувиар нэмэгдэж, иргэдийн орон сууцтай болох нөхцөл сайжирлаа. Булган аймагт шилжин ирж үйл ажиллагаа явуулах боломжтой аж ахуйн нэгжүүдэд газрын зөвшөөрөл олгох ажлыг хуулийн хүрээнд шуурхай үзүүлэх боломжтой төдийгүй аймгийн ГХБХБГ-ын ажилтан албан хаагчид хүнд сурталгүйгээр түргэн шуурхай үйлчилж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

	73		4. Улаанбаатар хотын хэт төвлөрлийг бууруулах, хот, хөдөөгийн хөгжлийн зохистой тэнцвэрийг хангах зорилгоор Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Орхон, Өмнөговь, Сэлэнгэ аймаг, нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэг хүн амынхаа тоог 20 хувиар, бусад аймаг 10 хувиар тус тус нэмэгдүүлэх бодлогын чиглэлийг баримталж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн болон нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Аймгийн хүн амыг нэмэгдүүлэх зорилгоор шилжин суурьшигчдад аж ахуй эрхлэх болон амьдрах зориулалтаар газар олгох, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэн, орон сууцны хүрэлцээг нэмэгдүүлэх, таатай нөхцөлөөр зээл олгох үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Тус ажлын хүрээнд Улаанбаатар хотоос худалдааны чиглэлийн "Их Учдарга нутаг" ХХК, Орхон аймагас "Молор Очир" ХХК, "Шашир бугат" ХХК газар тариалангийн салбарт шилжин ирж үйл ажиллагаа явуулж байна. "Шашир бугат" ХХК нь ЖДҮХС-аас 100.0 сая төгрөгийн зээлд хамрагдав. Булган суманд 3 блок 146 айлын орон сууц, Хутаг-Өндөр сумын төрийн албан хаагчдын 8 айлын орон сууц ашиглалтад орж, орон сууцны хүртээмж аймгийн хэмжээнд 15.3 хувиар нэмэгдсэн. Үүний үр дүнд 2024 оны статистик мэдээгээр аймагт шилжин суурьшсан хүний тоо өмнөх оноос 317-оор өсөж, шилжин явсан хүний тоо 350-иар буурсан байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
45	74	Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-12-07 Дугаар 2022_448	1.12. . 1.12 гүйцэтгэсэн ажлын бүтээмжийг нь харгалзан аймаг, сумын засаг захиргааны байгууллагад ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдын үндсэн цалинг хоёр дахин хүртэл нэмэгдүүлсэн хэмжээгээр тооцож, орон нутгийн нэмэгдлийг батлагдсан төсөвтөө багтаан олгох арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.13.орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын арга хэмжээг төлөвлөх, батлах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавихад холбогдох хууль тогтоомжийг баримталж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.14.ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээний хүрээнд нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламжийг аймаг болон сумын орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлж, орон нутгийн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрт хууль тогтоомжид нийцүүлэн зарцуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.15.нийслэлээс орон нутагт шилжин суурьшсан иргэнд жилийн 3 хувийн хүүтэй ипотекийн зээл олгох, орон нутагт үйл ажиллагаагаа шилжүүлсэн аж ахуйн нэгжийн арилжааны банкаас авсан зээлийн хүүг 1 хувь хүртэл бууруулж олгох ажилд орон нутгийн зүгээс шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.16.нийслэлээс орон нутагт үйл ажиллагаагаа шилжүүлсэн аж ахуйн нэгжил бизнесээ эрхлэхэд нь	Орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын төрийн захиргааны албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг 40 хүртэл хувиар нэмэгдүүлэн олгохоор 1,561.4 сая, аймгийн төвийн улсын төсвийн байгууллагын төрийн захиргааны албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг 20 хувиар тооцож олгохоор 850.0 сая нийт 2,411.4 сая төгрөгийг 2025 оны төсөвт баталж, хэрэгжилтийг ханган ажилласан. 2025 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 25 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас 12 сарын эцсийн байдлаар 76 хувь нь бүрэн хэрэгжсэн, 20 хувь нь дунд шатны санхүүжилт авсан, 4 хувь нь буюу нэг төсөл арга хэмжээг 2026 онд хэрэгжүүлэхээр шилжүүлсэн байна. Хууль журмын дагуу https://shilendans.gov.mn/ сайтад болон https://onhs.mof.gov.mn/ систем, https://bulgan.gov.mn/ вэб сайтуудаар гүйцэтгэлийг нийтэд ил тод мэдээлж ажилласан. Ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу Бүрэгхангай суманд уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг 7 аж ахуйн нэгж, байгууллага аймгийн Засаг даргатай нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж, 206.5 сая төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд байршуулан аймгийн Засаг даргын нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөрт 100 хувь зарцуулсан. Хангал сумын Хялганат тосгонд "Бодь Арвин констракшин" ХХК шилжин ирж хоногт 3 тн үртсэн шахмал түлш үйлдвэрлэх хүчин чадалтай Эко харандаан түлшний үйлдвэрийг ажиллуулж, орон нутгийн 4 иргэнийг ажлын байраар хангаж байна. Орон нутаг үйлдвэрлэлийн байр болон түүхий эдийн дэмжлэг үзүүлж байна. Булган аймагт Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн 3 төсөл арга хэмжээний гадаад зээлийн 2025 оны эргэн төлөлтийн хугацааг лагцв 2328.3 сая төгрөг төлөхөөр	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	Хэрэгжиж дууссан
46	75	2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай 2023-02-08 Дугаар 2023_49	X-1.2. Шүгэл үлээх үйл ажиллагааг бүх талаар дэмжих хөдөлгөөн зохион байгуулж, авлигыг үл тэвчих, үл эвлэрэх хандлагыг төлөвшүүлэх, олон нийтийн дэмжлэг авах;	"Авлигын эсрэг хууль", "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх" тухай хуулиар 43 байгууллагын 1483 албан хаагчид сургалт зохион байгуулсан. "Авлигагүй төрийн алба" уриан дор "Авлигын эсрэг нэгдье" видео уралдааныг төрийн байгууллагуудын дунд зохион байгуулж 4 байгууллага оролцож 1-р байр Улсын бүртгэлийн хэлтэс, 2-р байр Стандарт хэмжил зүйн хэлтэс тус тус шалгарлаа. Мөн авлигаас урьдчилан сэргийлэх зорилгоор богино хэмжээний 3 видео хийж, "110" дугаарыг сурталчлан, 2 удаагийн нээлттэй хаалганы өдөрлөгт оролцож, тараах материал тарааж, мэдээлэл түгээв. Тайлант хугацаанд авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдсон хүн, хуулийн этгээд бүртгэгдээгүй байна	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	Авлигатай тэмцэх жилийн ажил хэрэгжиж дууссан.
	76		X-1.3. Төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийг багасгах, иргэд, хувийн хэвшлийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хамтран ажиллах.	Төрийн үйлчилгээний хүнд суртлыг бууруулан, иргэдэд хүргэж буй үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор "Цахим Булган" хөтөлбөрийг аймгийн ИТХ-аар батлуулан, хэрэгжүүлээ. 2025 онд төрийн цахим үйлчилгээний хэлтсээс хүн, хуулийн этгээдэд 9119 лавлагаа, тодорхойлолт болон нэг ба олон шатлалт үйлчилгээг хүргэн ажилласан байна. Мөн аймгийн төвд байрлах 6 киоск, 16 сум, 1 тосгонд байрлах 23 ХУРДАН киоск төхөөрөмж, 11 суманд байрлах 24/7 цахим үйлчилгээний төвөөр дамжуулан нийт 18368 төрийн үйлчилгээг иргэдэд хүргэв. Энэ нь нийт иргэдийн 30.4 хувийг эзэлж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	Жилийн ажлын хэрэгжих хугацаа 2024 онд дууссан.

47	77	Хүнсний хангамж, хөдөө аж ахуйн салбарын технологит ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-02-08 Дугаар 2023_63	3. Мал, малын гаралтай бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох зорилгоор нийт үхэр сүргийг ялган тэмдэглэж, Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн А/205 дугаар тушаалаар 4 сумын 28250 толгой үхэр сүргийг эзэмжүүлэхээр 70.6 сая төгрөгийн хөрөнгийг баталсан. Тус ажлын хүрээнд Сэлэнгэ суманд 8000, Хангал суманд 3500, Хутаг-Өндөр суманд 2173, Төшиг суманд 6800, Орхон суманд 196, нийт 20669 толгой үхэр сүргийг ялган тэмдэглэж, эзэмжүүлсэн.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	Хэрэгжиж дууссан
48	78	Хот, хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-02-08 Дугаар 2023_68	7. Шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, хөрөнгө оруулагчдад мэдээлэл өгөх цахим платформыг үүсгэн, төрийн үйлчилгээг цахимжуулан "Цахим аймаг" болгох арга хэмжээ авч ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны яам (Н.Учрал), аймгийн Засаг дарга нарт даалгасугай.	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 11/82 дугаар тогтоолоор Төрийн үйл ажиллагааны хурд, бүтээмжийг нэмэгдүүлэх "Цахим Булган" хөтөлбөрийг батлуулсан. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд "Цахим Булган" гар утасны аппликейшнийг нэвтрүүлэх талаар судалгааны ажил хийгдэж байна.	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%		Үгүй	
49	79	Шинжлэх ухаан, технологийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2023-04-05 Дугаар 2023_120	2.3. "Хот хөдөөгийн сэргэлт"-ийн хүрээнд нийгэм, эдийн засгийн бүсчлэл тогтоох схем, арга зүй, шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох, эдийн засгийн өсөлтийн төв боомтуудын тусгайлан орон зайн хөгжлийн төлөвлөлтийг боловсруулж, дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн дарга нарт;	Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнгээс Булган аймгийн өсөлтийн төвүүд буюу орон нутгийн хөгжлийн төвд хөдөө аж ахуйн нөөцөд тулгуурлан үйлдвэрлэл, үйлчилгээ, бирж, тээвэр логикийн цогцолбор байгуулах техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын тендер зарлагдаж, гүйцэтгэгч нь шалгарч, судалгааны ажил үргэлжилж байна. Эдийн засгийн хөгжлийн яамны захиалгаар Хилийн боомт дэд төслийн хүрээнд Бага Илэнх боомтын зөвлөх үйлчилгээний ажлыг "Ди Ди Эй Жи" ХХК гүйцэтгэж, хүлээлгэж өгсөн. Босоо тэнхлэгийн Бага-Илэнх боомт-Төшиг-Хутаг-Өндөр чиглэлийн 137 км авто замын ажлыг эхлүүлэхээр зураг төсөв, ТЭЗҮ боловсруулах нээлттэй тендер зарлаж, гүйцэтгэгч шалгарсан боловч, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд хөрөнгө оруулалтыг царцаасан. Тухайн хөрөнгө оруулалтыг Засгийн газрын 2025 оны 204 дүгээр тогтоолын 1.2.3 дахь хэсэгт заасны дагуу 2026 оны улсын төсөвт Эдийн засаг, хөгжлийн сайдын багцад тусгуулах санал хүргүүлээд байна.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%		Үгүй	
	80		3. Энэ тогтоолд заасан арга хэмжээг 2024 оноос эхлэн хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, холбогдох Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт тус тус даалгасугай.	Улсын төсвийн 500.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнгээс Булган аймгийн өсөлтийн төвүүд буюу орон нутгийн хөгжлийн төвд хөдөө аж ахуйн нөөцөд тулгуурлан үйлдвэрлэл, үйлчилгээ, бирж, тээвэр логикийн цогцолбор байгуулах техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын тендер зарлагдаж, гүйцэтгэгч нь шалгарч, судалгааны ажил үргэлжилж байна.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%		Үгүй	
50	81	Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-07-05 Дугаар 2023_266	3. Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын ашиглалттай холбогдон гарах зардлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу жил бүрийн орон нутгийн төсөвт тусган, засвар үйлчилгээг хариуцаж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай	Төрийн өмчийн цэцэрлэг, сургууль, сургуулийн дотуур байрны орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих төсөлд Хутаг-өндөр сумын Хантай багийн сургууль, цэцэрлэг, Уньт багийн цэцэрлэг, Сэлэнгэ сумын Атар багийн сургууль, цэцэрлэг, Булган сумын 1 дүгээр сургуулийн дотуур байрны ариун цэврийн байгууламжийг сонгон хэрэгжүүлж, орон нутгийн төсвийн 1.3 тэрбум төгрөгийн санхүүжилтээр шинэчлэн, ашиглалтад өгөөд байна. Ашиглалттай холбогдон гарах зардлыг хууль, тогтоомжийн дагуу бүрэн шийдвэрлэж ажилласан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

51	82	Журам шинэчлэн батлах тухай 2023-07-19 Дугаар 2023_278	2. Энэ журмыг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай.(1."Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам)	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа 3 төсөл арга хэмжээ нь эрх шилжин хэрэгжиж байгаагаас 40.8 хувь, 71.4 хувь, 22.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа 39 төсөл арга хэмжээний 20 төсөл арга хэмжээ нь бүрэн хэрэгжиж, байнгын ашиглагч байгууллага орлого, бүртгэлд авсан байна. Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа 25 төсөл арга хэмжээний 12 төсөл арга хэмжээг хууль журмын дагуу бүрэн хэрэгжүүлж, баримт бичгийн бүрдлийг бүрэн бүрдүүлж, байнгын ашиглагч байгууллагад орлого, бүртгэлд авсан байна. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа 39 төсөл арга хэмжээний 5 төсөл арга хэмжээний бүрэн санхүүжилтийг олгоходоо 278 дугаар тогтоолын 4.3.4.7, 4.3.4.8-д заасны дагуу Үнэлгээний хороо байгуулсан захирамж, Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл зэрэг мэдээлэл болон уг тогтоолын 2.1.9 дүгээр зүйлд заасны дагуу төсөл арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд бий болсон хөрөнгө, их засвар, тоног төхөөрөмжүүдийг байнгын ашиглагч байгууллагад орлогод авч, бүртгэлд тусгасны дараа эцсийн шатны санхүүжилтийг олгож ажиллаж байна. Сангийн яамны /https://publicinvestment.gov.mn/ цахим системд Сангийн сайдын А/264 дүгээр тушаал, 278 дугаар журмын дагуу 2026 онд УТХО-аар хийлгэх Булган аймгийн 16 сум, 1 тосгон 04 дүгээр сарын 01-ээс 30-ны хооронд саналаа ирүүлсэн. Нийт ирүүлсэн төсөл арга хэмжээний саналыг 05 дугаар сарын 01-ээс 06 дугаар сарын 25-ны хооронд үнэлж, шаардлага хангасан арга хэмжээг аймаг эрэмбэлэн орууллаа. Нийтдээ 53 төсөл арга хэмжээний 364.6 тэрбум төгрөгийн ажил арга хэмжээ илгээгдсэнээс 2 дахь шатны үнэлгээ хийгдсэн.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
52	83	Нийслэл Улаанбаатар хотод гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гамшгийн хор уршгийг арилгах, нийслэлийн хот төлөвлөлт, газар зохион байгуулалттай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2023-08-16 Дугаар 2023_294	3. 3. Аймаг, сум, чөлөөт бүсийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдаагүй, тусгагдсанаас өөр зориулалтаар газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахгүй байхыг аймаг, сумын Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч нарт үүрэг болгосугай.	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий болон хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй нийцүүлэн Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн дэд системийн дагуу тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдаагүй, эсхүл батлагдсан зориулалтаас өөр зориулалтаар газар эзэмшүүлэх, ашиглуулах аймаг, сумын Засаг даргын шийдвэрийг гаргаагүй болно.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
53	84	Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн зарим арга хэмжээний тухай 2023-08-30 Дугаар 2023_321	2. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг харьяалах салбар, нутаг дэвсгэртээ зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шаардагдах зардлыг төсвийн ерөнхийлөн захирагч нарын саналыг харгалзан улсын нэгдсэн төсвийн төсөлд тусган, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай.	"Эрүүл Булган" хөтөлбөрийг боловсруулан, аймгийн ИТХ-ын 2025 оны VI/32 дугаар тогтоолоор батлуулж, 75 хувьтай хэрэгжүүлсэн. Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгааны чиглэлээр нийгмийн эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүд 19, нэрэмжит сарын аяныг 9 удаа тэмдэглэн, арга хэмжээ зохион байгуулж, 153 удаагийн танхимын сургалт болон хөдөлгөөнт сургалтыг хийж, 16792 иргэнийг хамруулсан. Эрүүл мэндийн газрын албан ёсны цахим хаяг www.bu.mohs.go.mn болон эрүүл мэндийн байгууллагуудын цахим хуудсаар цаг үеийн шинжтэй 252 мэдээ, мэдээллийг түргэн шуурхай, үнэн зөв хүргэж, цахим хуудсанд байршуулсан мэдээлэлд 47684 хүн хандаж мэдээлэл авсан байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
54	85	"Эрүүл шүд" арга хэмжээг хэрэгжүүлэх тухай 2023-08-30 Дугаар 2023_322	2. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын сургуульд өдөр бүр "Шүд угаах цаг"-ийг бий болгон хэвшүүлж, эрүүл ахуйн шаардлага хангасан шүдээ угаах хэсэг бий болгох ажлыг үе шаттайгаар улс, орон нутгийн төсвийн болон гадаадын зээл тусламжийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр тусгаж, холбогдох арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	"Шүд угаах цаг" зохион байгуулах аргачлал олгох сургалтыг Сайхан Монгол телевизтэй эрүүл мэндийн байгууллагын дарга, эрхлэгч нар, нийгмийн ажилтан, ерөнхий боловсролын сургуулийн захирал, нийгмийн ажилтан, эмч нарт зохион байгуулснаар "Шүд угаах цаг"-ийг ерөнхий боловсролын сургуулийн 104 ангид бий болгоод байна. "Шүд угаах цаг" аймагийн аварга шалгаруулах" тэмцээн зохион байгуулан, 21 сургуулийн 144 хүүхэд оролцсон. "24/3-Шүдээ зөв угаа-2025 аян"-ыг аймгийн хэмжээнд зохион байгуулан, амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 6470 хүүхдийг хамруулж, 3449 хүүхдэд нэмэлт эрдэсжүүлэлт хийсэн. Шүдний эмч мэргэжилтний Булган аймаг дахь холбооноос "Амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох" мэдээллийг бэлтгэн нэгдсэн сургалтын гарын авлагаар ханган, 35 удаагийн сургалт зохион байгуулж, 3100 гаруй иргэнийг хамруулаад байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

55	86	Журам батлах тухай 2023-09-13 Дугаар 2023_344	2... 2. Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн орон нутгийн төсвийн төсөлд тусган шийдвэрлүүлж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Засгийн газрын "Стратегийн нөөц бүрдүүлэх тухай" тогтоолын дагуу аймгийн Засаг даргын 2025 оны А/192 дугаар захирамжаар Орхон аймгийн "Эрдмийт" ХХК-тай 10 тн мах нийлүүлж, 1 кг тутамд 2300 төгрөгийн урамшуулал олгохоор 1 кг үхрийн махыг 12500 төгрөг, хонины махыг 10500 төгрөг, ямааны махыг 8500 төгрөгөөр борлуулж, борлуулалт хийсэн дэлгүүрүүдэд 1 кг тутамд 200 төгрөгийн урамшуулал олгохоор гэрээ хийсэн. Аймгийн төвийн 6 багийн 9 дэлгүүрээр нөөцийн мах худалдаалагдаж, 7.5 тн мах борлуулагдаж, 17.25 сая төгрөгийн урамшуулал, худалдан борлуулсан 9 дэлгүүрт 1.06 сая төгрөгийн урамшуулал тус тус олгосон байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
56	87	Аргачлал шинэчлэн батлах тухай (Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг тооцох аргачлал) 2023-12-20 Дугаар 2023_457	2. Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 2024 оны төсвийн жилээс эхлэн энэ тогтоолын 1-д заасан аргачлалын дагуу тооцон хуваарилж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай	Аймгийн орон нутгийн хөгжлийн санд 2025 онд 11,079.7 сая төгрөг хуваарилагдсан. Орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлгийг шинэчлэгдэн батлагдсан аргачлалын дагуу орон нутгийн хөгжлийн индекс, хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамааруулан тооцсон. Аймагт 3,633.8 сая, сумдад 7,446.0 сая төгрөг хуваарилсан ба итгэлцүүрээс хамааран сумдад 188.5-1,159.2 сая төгрөг олгохоор батлагдсан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
57	88	Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-12-20 Дугаар 2023_458	2. Төлөвлөгөөнд тусгагдсан, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.(Өвлийн аялал жуулчлалын 2024 оны төлөвлөгөө) Төлөвлөгөө батлагдсанаас хойш хэрэгжилтийг тайлагнах	Засгийн газрын 2022 оны "2023-2028 оныг Монголд зочлох жил болгон зарлах тухай" 264 дүгээр тогтоолын дагуу өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр 2024 онд Булган аймагт "1 жуулчинд - 1 хонь" арга хэмжээг зохион байгуулан хэрэгжүүлээ. Аймгийн хэмжээнд 10 сум, 1 тосгоны 3798 төрийн албан хаагч, иргэн, ЕБС-ийн 3581 сурагчид мэдээлэл өгч, 16 сумын 2639 өрхийн 492 хонь бүртгэгдсэнээр БНСУ-ын 6 аялагч Булган сумын 2-р багийн малчин Б.Цогтгэрэлийн хот айлаар зочилж, жуулчин тус бүр хундан цагаан эм хоньтой боллоо. Мөн "Монголын өвлийн нутгийг үзүүлбэ" уриатайгаар Дэлхийн хамгийн олон сая дагачтай NAS DAILY-гийн студийн олон сая дагач бүхий Япон, БНСУ, БНХАУ-ын Хонг Конг мужийн нийт 9 инфлүүнсэр контент бүтээгчид 2024 оны 01 дүгээр сарын 09-14-ний өдрүүдэд Булган аймгийн Хангал сум, Хялганат тосгоноор аялж, Хангал сумын 2-р багийн малчин, сэтгүүлч Х.Эрдэнэбулганы хот айлаар зочилж нүүдэлчин ахуй соёлтой танилцаж, ирсэн инфлүүнсэрүүд хундан цагаан хоньтой болсон. Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, улирлын хамаарлыг бууруулах зорилгоор худалдаа, үйлчилгээний байгууллагуудтай хамтран үнийн хөнгөлөлттэй "Winter Sale" буюу "Хямдралын сар" аяныг зохион байгуулах, хил дамнасан болон хил орчмын аялал жуулчлалыг цаг алдалгүй нээж, хөгжүүлэх, хил залгаа улсуудын хотуудаас аймаг, орон нутаг руу шууд нислэг бий болгох, гадаадын агаарын тээврийн компаниудын захиалгат нислэг үйлдэх хүсэлтийг дэмжих, мөн өвлийн улиралд чиглэсэн төрөлжсөн арга хэмжээнүүдийг бодлогоор нэмэгдүүлэх зэрэг асуудлыг хэлэлцэн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хурлаарааар Засгийн	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	Хэрэгжиж дууссан.
58	89	Мах бэлтгэхэд зориулан олгох эзэлийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-12-20 Дугаар 2023_461	4. Мах бэлтгэн нийлүүлэлт, борлуулалт болон чанар, аюулгүй байдалд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай	Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн "Мал төхөөрөх, мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хадгалалт, худалдаалалтад төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай" 08-03-03/180-04 дугаарт удирдамжийн хүрээнд 14 объектод хяналт шалгалтыг хийхэд үйлдвэрийн аргаар 300 тн /үхрийн мах 150 тн, хонины мах 150 тн/, уламжлалт аргаар 86 тн мах бэлтгэгдсэн /үхрийн мах 31.2 тн, хонины мах 37.6 тн, ямааны мах 17.2 тн/ байна. Мал эмнэлэг хорио цээрийн хяналтын цэгээр адууны мах 120 кг, үхрийн мах 89.4 тн, хонины мах 138.0 тн, ямааны мах 12.4 тн, 44 цахим гарал үүсэлтэй 41 тээврийн хэрэгсэл шалган нэвтэрсэн байна. Хяналт шалгалтын явцад 1 аж ахуйн нэгж, 6 иргэний 36.3 тн бүтээгдэхүүнээс 2 нэр төрлийн 12 сорьц авч, лабораторид хүргүүлж шинжилгээнд хамруулсан. Хяналт шалгалтаар 33 дутагдал илрүүлж, 20 дутагдал буюу 60.6 хувийг газар дээр нь арилгуулсан. Илэрсэн дутагдлыг арилгуулахаар 2 иргэнд 13 заалттай хугацаатай албан шаардлага, 14 аж ахуйн нэгж, иргэнд нэгдсэн зөвлөмж хүргүүлж, 57 иргэнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	Хэрэгжиж дууссан.

59	90	Иргэдийг орон сууцжуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-12-27 Дугаар 2023_483	2.8.. Иргэд орон нутагт шилжин, тогтвортой суурьших орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор орон сууцны төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх бүс нутгийг тодорхойлж, шаардлагатай газрыг чөлөөлж, олгох арга хэмжээ авч ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар (А.Энхманлай), аймгийн Засаг дарга нарт;	Хутаг-Өндөр суманд 2022 онд улсын төсвийн 424.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар орон сууцны бүсийн ус, дулааны шугам сүлжээ, цахилгаан хангамжийн 250 кВА-ийн дэд станцын дэд бүтцийг шийдвэрлэсэн ба тус газарт "Инфинити пик" ХХК төрийн албан хаагчийн 8 айлын орон сууцны барилгыг улсын төсвийн 1 тэрбум төгрөгөөр барьж 2025 оны 11 дүгээр сард ашиглалтад оруулаад байна. Орон сууцны зориулалтаар газар чөлөөлөх арга хэмжээ авагдаагүй бөгөөд ерөнхий төлөвлөгөөний дагуу нийтийн орон сууцны газрын зориулалтаар Сэлэнгэ суманд 2100 м.кв газар, Дашин-чилэн суманд 1500 м.кв газрыг тус тус эзэмшүүлээд байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	91		2.9.. Нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, орон нутгийн иргэдийн амьдрах тав тухтай орчныг бий болгох зорилгоор цаашид хот суурин болж хөгжих боломжтой сумдад орон сууц барих талаар шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн болон аймгийн Засаг дарга нарт, шаардагдах санхүүжилтийг тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан судлан шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Жавхланд;	Орхон, Сэлэнгэ, Хутаг-Өндөр суманд 2023 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутгийн иргэдийн амьдрах тав тухтай орчныг бий болгох зорилгоор инженерийн дэд бүтцийг барьж ашиглалтад оруулсан. Энэ онд Могод, Сайхан суманд төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд орон сууцны гэрээ байгуулж зураг төсөл гүйцэтгэж байна. Бүрэгхангай суманд 20 айлын орон сууцны барилга угсралтын ажил 70 хувьтай явагдаж байна. Мөн энэ онд улсын төсвийн 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хутаг-Өндөр суманд 8 айлын орон сууц баригдаж, ашиглалтад орсон. Булган сумын 15 айлын орон сууцны барилга угсралтын ажил 15 хувьтай явагдаж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	92		2.10.. Орон нутаг дахь төрийн үйлчилгээг сайжруулах, төрийн албан хаагчдыг орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор төрийн албан хаагчдад зориулсан орон сууцны төсөл, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн болон аймгийн Засаг дарга нарт, шаардагдах санхүүжилтийг тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан судлан шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Жавхланд;	Улсын төсвийн 1850.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Булган суманд төрийн албан хаагчийн 15 айлын орон сууцны барилгын ажлыг "Голден ийгл стар" ХХК 2025-2027 онд барьж ашиглалтад оруулахаар ажиллаж байгаа бөгөөд гүйцэтгэл 15 хувьтай байна. Хутаг-Өндөр суманд 8 айлын орон сууцны барилгыг "Инфинити пик" ХХК улсын төсвийн 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэн 11 дүгээр сард ашиглалтад оруулсан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
60	93	Фестиваль зохион байгуулах тухай 2024-01-25 Дугаар 2024_41	3. Фестивалийг зохион байгуулахад зохих дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.(1."Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивалийг жил бүр зохион байгуулж байхаар тогтсугай.)	Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн жагсаалт болон ЮНЕСКО-ийн яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэгдсэн соёлын өвүүдээ өвлөн уламжлуулах, сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор 2025 оны 08 дугаар сарын 22-24-ний өдрүүдэд Улаанбаатар хотын Налайх дүүргийн Тайж хайрхны бэлд зохион байгуулагдсан "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивальд оролцсон. Тус арга хэмжээнд Булган аймгийн төлөөлөл 5 дахь удаагаа 49 хүний бүрэлдэхүүнтэй оролцож, эх хэл, аман уламжлал, ардын язгуур урлаг, уламжлалт арга ухаан, уламжлалт гар урлал, уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай уриа дуудлага, байгалийн болон сав шимийн ертөнцийн тухай мэдлэг, зан үйл зэрэг 6 ай савд багтах 24 өвийн төрлийг түгээн дэлгэрүүлж, үзүүлбэр, тоглолт, үзэсгэлэн, боловсролын хөтөлбөрөөр дамжуулан олон нийтэд сурталчилсан. Монгол бөхийн цол дуудлага, монгол бөхийн зодог шуудаг урлал, модон сийлбэрийн урлал өвийг өвлөн уламжлагч 3 иргэн "Шилдэг өвлөн уламжлагч"-аар шалгарсан. Нүүдэлчин фестивальд оролцоход орон нутгийн төсвөөс 8 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
				Хавсралт : 1 файл					

61	94	Морин хуурын улсын чуулгыг өргөтгөх, морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх талаар авах арга хэмжээний тухай 2024-02-14 Дугаар 2024_59	6.. Энэ тогтоолын хэрэгжилтийг шуурхай зохион байгуулахыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнг жил тутам Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Соёлын сайд Ч.Номинд тус тус даалгасугай. (5."Морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх талаар авах арга хэмжээ"-г хавсралт ёсоор баталсугай.)	Морин хуур хөгжмийг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх зорилгоор 8 арга хэмжээ бүхний төлөвлөгөөг боловсруулан батлуулсан. Морин хуур урлаач, өвлөн уламжлагчдын судалгааг бүх соёлын төвөөс авч нэгтгэн, мэдээллийн сан үүсгэсэн. Морин хуурын шавь сургалт, дугуйланг Хөгжимт жүжгийн театр, 16 сум 1 тосгоны Соёлын төвийн дэргэд хичээллүүлэн 262 хүүхэд хамрагдаж байна. Морин хуурын сургалт, дугуйлан хичээллүүлэх хөгжмийн багшийг чадавхжуулах зорилгоор Баян-Агт, Сайхан сумын Соёлын төв, Архангай, Орхон аймгийн Морин хуурын багштай хамтран 7 хоногийн сургалт, Хөгжимт жүжгийн театрын Морин хуурч Л.Бат-Эрдэнийн Морин хуурын тайлбарт тоглолт, сургалт Баяннуур сумын нум сум, морин хуурч урлаач Мөнхжаргалын бүтээлийн үзэсгэлэнг зохион байгуулсан. Гурванбулаг сумын Соёлын төв, Булган сумын Соёлын ордон өөрсдийн зохион байгуулдаг хүүхдийн урлагийн наадамд морин хуурын төрлийг оруулж байна. Хөгжимт жүжгийн театр 7.0 сая төгрөгөөр 2 ширхэг мастер морин хуур, Булган сумын Соёлын ордон 1.8 сая төгрөгөөр 1 ширхэг цахилгаан морин хуурыг тус тус худалдан авч сургалтын материаллаг баазыг нэмэгдүүлсэн. "Морин хуурыг эрхэмлэн дээдэлж түгээн дэлгэрүүлэх цахим чэллэнж" зарлаж Хөгжимт жүжгийн театр, Булган сумын 2-р сургууль, Бүрэгхангай сумын ЕБС-ийн морин хуурын дугуйлангийн сурагчид болон Булган сумын Соёлын ордны багш нар Жалам хар, Үүлэн бор, Монгол яалгуу, Цагаан суварга, Халуун элгэн нутаг зэрэг уран бүтээлийг тоглож олон нийтэд хүргэсэн. Хавсралт нийт : 4 Файл : 1 Зураг : 3	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
62	95	Өвөлжилт, хаваржилтын хүндрэлийг даван туулахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2024-02-28 Дугаар 2024_76	2 . Тариалан эрхлэгч аж ахуйн нэгжүүдээс худалдан авах тэжээлийн буудай болон малын тэжээлийн үнэ, татан авах зардлын тооцоо, аймгуудад олгох хуваарийг гаргаж, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	2024 онд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, "ХААК" ТӨХК-ийн Булган салбараас хуваарилсан 300 тн тэжээлийн буудайг Баяннуур, Дашинчилэн, Рашаант, Гурванбулаг, Могод, Хишиг-Өндөр, Бүрэгхангай, Сайхан, Баян-Агт, Хангал, Орхон, Булган суманд олгосон. Улсын онцгой комиссоос нийлүүлж буй 450 тн тэжээлийг Сэлэнгэ аймгаас татан авч, Баян-Агт, Баяннуур, Бүрэгхангай, Гурванбулаг, Дашинчилэн, Могод, Орхон, Рашаант, Сайхан, Хангал, Хишиг-Өндөр суманд тус тус нийлүүлсэн. Нийт аймгийн 750 тн тэжээлийг татан авахад 50.0 сая төгрөгийг зарцуулсан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын хүндрэлтэй холбоотой гарсан шийдвэр ба тухайн хугацаанд хэрэгжиж дууссан
63	96	Журам батлах тухай 2024-02-28 Дугаар 2024_77	3. Энэ журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй. (Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгүүлэх журам")	Суурь болон төрөлжсөн мэдээллийн сан үүсгэх журам батлагдсаны дагуу АЗДТГ-ын даргын 2024 оны 03/683 дугаар албан бичгээр 24 агентлагт хүргүүлж, уг журмын хэрэгжилтийг хэрхэн хангах талаар мэдээлэл өгөх цахим уулзалтыг зохион байгуулсан. Агентлагууд өөр өөрсдийн чиг үүргийн хүрээнд суурь мэдээллийн санд өгөгдлийг тухай бүр шинэчлэн, мэдээлэл нэгдсэн дата төвд автоматаар бүртгэгдэн дата нь тогтмол шинэчлэгдэж байна. 2025 онд мэдээлэл хариуцагч байгууллагуудаас суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах шаардлага үүсээгүй.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
64	97	Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай 2024-02-28 Дугаар 2024_82	2.. Төрийн албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг олгоход шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. /2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш тайлагнах/ (1."Журам батлах тухай" Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам"-ыг хавсралт ёсоор өөрчлөн баталсугай.)	Орон нутгийн хөгжлийн бодлого, санхүүгийн нөөц бололцоонд тулгуурлан орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын төрийн захиргааны албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг 40 хүртэл хувиар нэмэгдүүлэн олгохоор 1,561.4 сая төгрөг баталснаас 1,556.0 сая төгрөг, улсын төсвийн байгууллагын төрийн захиргааны албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг 20 хувиар тооцож олгохоор 800.0 сая төгрөг баталснаас гүйцэтгэлээр 734.8 сая төгрөг, нийт 2,361.4 сая төгрөг баталснаас 2,290.8 сая төгрөгийг зарцуулсан байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
65	98	Журам батлах, журмын хавсралтад өөрчлөлт оруулах тухай 2024-02-28 Дугаар 2024_83	3.. Мөнгөн урамшуулал олгоход 2024 онд шаардагдах хөрөнгийг тухайн төрийн захиргааны байгууллагын төсвийн захирагчийн батлагдсан төсөвт багтаан, цаашид жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг төсвийн захирагч нар, Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай. (1."Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.)	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт хамаарах орон нутгийн төсвөөс санхүүждэг аймаг, сумын 9 төсөвт байгууллагад төрийн захиргааны албан тушаалд 60 сар болон түүнээс дээш хугацаанд тасралтгүй ажилласан 13 төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулалар 113.2 сая төгрөгийг олгохоор 2025 оны төсөвт баталсан. Журмын шаардлагад заасан хугацааг хангасан төрийн захиргааны 13 албан хаагчид урамшууллыг бүрэн олгосон.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

66	99	Жагсаалт батлах тухай 2024-04-17 Дугаар 2024_162	3..Ерөнхий гэрээний аргаар зохион байгуулах тендер шалгаруулалтад шаардагдах техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, холбогдох бусад материалыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Аймгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа 60 ортой сувиллын яслийн тоног төхөөрөмжийн 9.6 сая төгрөгийн худалдан авалтыг ерөнхий гэрээ байгуулан "Цахим дэлгүүр"-ийн системд байршсан бараа, үйлчилгээнээс худалдан авсан. Мөн аймгийн Нэгдсэн эмнэлэг 42 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгслийг 226.9 сая төгрөгөөр ерөнхий гэрээний аргаар зохион байгуулж худалдан авалт хийсэн. Ерөнхий гэрээний аргаар зохион байгуулсан худалдан авах ажиллагааны холбогдох материалыг журмын дагуу бүрдүүлж, холбогдох газарт хүргүүлсэн.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
67	100	Журам шинэчлэн батлах тухай 2024-04-24 Дугаар 2024_168	1.. Энэ журмыг хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай	Булган аймаг нь орлогоороо зардлаа санхүүжүүлдэг, улсад орлого төвлөрүүлдэг, эдийн засгийн чадамж муутай аймаг тул үнэт цаас гаргах боломжгүй байна.	Хэрэгжүүлэх зардал, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй	Хэрэгжүүлэх зардал, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй		Үгүй	
68	101	Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 2024-05-01 Дугаар 2024_187	4.б.. Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан 2024 онд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд эзэмшүүлэх газрыг тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, газар эзэмшүүлэх асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэхийг аймаг, нийслэл, сумын Засаг дарга нарт, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд тухай бүр нь дүгнэлт гаргаж ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар (А.Энхманлай)-т тус тус даалгасугай	Засгийн газрын 2025 онд баталсан шинээр эзэмшүүлэх, ашиглуулах газрын хэмжээ, байршил, зориулалтын жагсаалтын дагуу малчдын хоршоонд олгохоор 35 нэгж талбарын 143.496 га газар төлөвлөгдсөнөөс, 25 нэгж талбарын 106.4 га газрыг олгож, газрын кадастрын мэдээллийн системд бүртгэн, баталгаажуулж ажиллав.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
69	102	Ариун цэврийн байгуулам бүхий түр буудаллах цаг, үйлчилгээний цогцолбор барьж байгуулах тухай 2024-05-01 Дугаар 2024_189	2.. Энэ тогтоолын хавсралтад заасан байршилд эзэмшүүлэх газрыг аймаг, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, холбогдох хууль тогтоомжийн дагуу эзэмшүүлэх ажлыг 2024 оны 2 дугаар улиралд багтаан зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар (А.Энхманлай), аймаг, сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай	Засгийн газрын 2024 оны 189 дүгээр тогтоолын хавсралтад заасан байршлыг Дашинчилэн, Рашаант сумын 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлтээр тусгуулж, Засгийн газрын 2024 оны 74 дүгээр тогтоолоор баталгаажуулан газар олголтыг холбогдох хууль журмын хүрээнд эзэмшүүлсэн.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	Хэрэгжиж дууссан.
	103		4.. Олон улс, улсын чанартай авто зам дагуу ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэгийн цэвэрлэгээ, арчлалт, хог хаягдлын асуудлыг зохион байгуулж ажиллахыг холбогдох аймаг, сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай	Улсын чанартай авто зам болох Орхон-Булган-Хөвсгөл чиглэл, УБ-Лун-Рашаант-Өвөрхангай чиглэлийн дагуу байрлаж үйл ажиллагаа явуулж буй түр буудаллах цэгийн ариун цэврийн байгууламж, хог хаягдлын асуудалд аймгийн зүгээс зохион байгуулалтын арга хэмжээг тогтмол авч харьяалах сумдын Засаг даргад үүрэг чиглэл өгч, тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Нийтийн эзэмшлийн талбайн эзэнгүй хог хаягдлыг бууруулах зорилгоор аймгийн Засаг даргын 2025 оны А/193 дугаар захирамжаар батлагдсан "Цэвэр орчин-Цэмцгэр Булган" аяныг аймгийн 16 сум, 1 тосгонд зохион байгууллаа. Аяны хүрээнд 38531.03 га талбайн 3757.3 тонн хог хаягдал, 132 гол горхины эрэг орчмоос 56.5 тонн хог хаягдлыг цэвэрлэж, 70.1 сая төгрөгийг зарцуулсан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
70	104	Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим системийн талаар авах арга хэмжээний тухай 2024-05-08 Дугаар 2024_196	3.. "Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем"-ийг ашиглан эрхлэх асуудлынхаа хүрээндээ төрийн албан хаагчийн мэдээллийн бүрдүүлэлт, үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай	Аймгийн Засаг даргын удирдамжаар харьяалах 149 байгууллагын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим системийн хөтлөлт, төрийн албан хаагчдын үндсэн мэдээлэл, цахим хувийн хэрэг хөтлөлтөд 2 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулж ажилласан. Хяналт, шалгалтаар төрийн албаны тусгай шалгалтын дүн, эрүүл мэндийн тодорхойлолт, мэргэшүүлэх сургалтын гэрчилгээ зэргийг хавсаргаагүй, үндсэн мэдээллийг бүрэн оруулаагүй нийтлэг зөрчлүүдийг засаж сайжрууллаа. Төрийн албан хаагчийн порталд хандан өөрийн мэдээллээ хянаж, баталгаажуулалт хийх ажлыг зохион байгуулж, аймгийн хэмжээнд баталгаажуулалт 55.56 хувьд хүрсэн нь өмнөх оноос 28.5 пунктээр нэмэгдсэн байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
71	105	Цахим шилжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 2024-05-15 Дугаар 2024_215	4.. Төрийн байгууллага хоорондоо төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад албан бичгийг илгээх, хүлээн авахдаа албан бичиг солилцооны дундын систем (Docx)-ийг ашиглаж байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шүүх, прокурор, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог төрийн байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй.	Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем ERP программыг аймаг, сумдын хэмжээнд үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлж, албан бичиг солилцооны дундын системийг 40 байгууллагын 510 төрийн албан хаагч албан хэрэгцээндээ ашиглаж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

72	106	Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2025 оны төсвийн хязгаарыг батлах тухай 2024-07-24 Дугаар 2024_10	2.. Энэ тогтоолоор баталсан төсвийн хязгаарт нийцүүлэн 2025 оны төсвийн төслийг боловсруулахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн хязгаар 83.2 тэрбум төгрөгөөр батлагдсан. Төсвийн ерөнхийлөн захирагчид хамаарах сум, байгууллагаас 2025 оны төсвийн төслийг хуулийн хугацаанд хүлээн авч хянаж, 82.8 тэрбум төгрөгийн төсвийн саналыг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд Сангийн яаманд нэгтгүүлсэн. Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны төсвийн хязгаар 58.8 тэрбум төгрөгөөр батлагдсан. Төсвийн ерөнхийлөн захирагчид хамаарах сум, байгууллагаас 2026 оны төсвийн төслийг хуулийн хугацаанд хүлээн авч хянаж, нэгтгэн 87.3 тэрбум төгрөгийн төсвийн саналыг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд Сангийн яаманд хүргүүлж, 70.0 тэрбум төгрөгөөр хянуулсан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2026 оны төсвийн хязгаарыг батлах тухай шийдвэр гарсан.
73	107	Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 2024-08-07 Дугаар 2024_28	3.1.. "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоол, "Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аяныг зарлах тухай" Засгийн газрын 2019 оны 476 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд атар газрыг тариаланд шилжүүлэх ажлыг орон нутгийн түвшинд зохион байгуулах;	Атаршсан талбайг ашиглалтад оруулахаар сумын ИТХ-аар батлуулж, тариалангийн атаршсан талбайн хөрсөнд хянан баталгаа хийлгүүлэх чиглэлийг сумдад өгч ажилласан. Баян-Агт, Тэшиг, Бугат, Орхон, Могод сумаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Дархан-Уул аймгийн Ургамал, газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн хөрс судлалын сектороор хөрсний шинжилгээг хийлгэхээр Тэшиг сум 14 га талбайгаас 7 дээж, Баян-Агт сум 332.2 га талбайгаас 21 дээж, Бугат сум 384.9 га талбайгаас 18 дээж, Орхон сум 104.36 га талбайгаас 6 дээж, Могод сум 1497.3 га талбайгаас 74 дээж, нийт 5 сумын 2474.33 га талбайгаас 126 дээж авч, ялзмаг, нитратын азот, хөдөлгөөнт фосфор, солилцох кали, хөрсний урвалжийн орчин РН гэсэн агро химийн таван үзүүлэлтээр задлан шинжилгээг хийлгэж, атар хөрсний үржил шимийн төлөв байдлыг тогтоолгосон. Баян-Агт, Бугат, Гурванбулаг, Дашинчилэн, Сайхан, Хангал, Хишиг-Өндөр Могод суманд 134 нэгж талбарын 556.4 га талбайг үр тариа тариалах зориулалтаар олгоод байна. Баян-Агт, Гурванбулаг, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр суманд 156 нэгж талбарын 35 га талбайг тэжээлийн ургамал тариалахаар төлөвлөснөөс 17 хоршоонд 68.69 га газар олголт хийгдэж, нийт 625.1 га газрыг үр тариа, тэжээлийн ургамал тариалах зориулалтаар олгосон.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	Хэрэгжиж дууссан
	108		3.2. Энэ тогтоолын хавсралтаар батлагдсан аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх, отор нүүдлийг тогтоосон чиглэлийн дагуу явуулах, мал эмнэлгийн хорио цээрийн хяналт шалгалтыг эрчимжүүлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;	Аймгийн аюулгүйн нөөцөд 100 тн өвс, 40 тн тэжээл бэлтгэхээс 56 тн тэжээл, 202 тн өвс бэлтгэсэн. Сумын аюулгүйн нөөцөд 640 тн өвс, 480 тн тэжээл бэлтгэхээр төлөвлөж, 709 тн өвс, 323.5 тн тэжээл бэлтгэсэн. Отор нүүдлийг дамжин өнгөрүүлэх чиглэлийг гарган, сумдад хүргүүлж, тогтоосон чиглэлийн хүрээнд отор нүүдлийг дамжин өнгөрүүлэх үүрэг чиглэлийг хүргүүлэн ажилласан. Хутаг-Өндөр сумын Гуртын гүүрэнд мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэг ажиллаж, хяналт шалгалтыг зохион байгуулсан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	Хэрэгжиж дууссан
	109		3.3.. Улсын тусгай хамгаалалттай болон хилийн зурвас газарт отроор өвөлжиж, хаваржих малчин өрх, малын тооны судалгааг урьдчилан гаргаж, холбогдох төрийн байгууллагын зөвшөөрөл, гэрээний дагуу босоо чиглэлд отроор өвөлжүүлж, хаваржуулах ажлыг зохион байгуулах;	Улсын тусгай хамгаалалттай болон хилийн зурвас газарт отроор өвөлжиж, хаваржих малчин өрх, малын тооны судалгааг гаргаж, Тайлант хугацаанд улсын тусгай хамгаалалттай бүс нутагт 133 өрхийн 86.7 мянган мал, хилийн зурвас бүс нутагт 34 өрхийн 1.3 мянган мал отор нүүдлээр өвөлжиж, хаваржсан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	Хэрэгжиж дууссан
	110		3.4.. "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий хүрээнд хэрэгжүүлэх төслийг орон нутгийн хөгжлийн болон бэлчээр ашиглалт, газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан мал аж ахуйн салбарын үндсэн хөрөнгө, бүтээн байгуулалтын чиглэлд хандуулах;	Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд аймгийн хэмжээнд 2024 онд 3 сум 20 хоршоонд 93.3 га газрыг тэжээлийн ургамал, 2 сум 2 хоршоонд мал аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалтаар 3 га газрыг олгосон. 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд мал аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалтаар 24 нэгж талбарын 77.4 га газрыг тусгасан. Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам"-ын хүрээнд сонгон шалгаруулалтыг зарлаж хоршоодод газар эзэмшүүлэх ажлыг зохион байгуулсан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	Хэрэгжиж дууссан
	111		4.. Энэхүү тогтоолд заасан арга хэмжээг батлагдсан төсөвтөө багтаан зохион байгуулж, хэрэгжилтийг ханган амжиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын холбогдох агентлагийн дарга нарт үүрэг болгосугай.	Орон нутгийн 150 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 202 тн өвс, 50 тн тэжээлийн нөөц бүрдүүлж, ашигласан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	Хэрэгжиж дууссан

74	112	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай 2024-09-18 Дугаар 2024_86-1	1.1.. Тухайн нутаг дэвсгэрийнхээ нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд суурилуулсан болон аж ахуйн нэгж, байгууллагын гадна орчны теле камерыг нэгдсэн сүлжээнд холбох, хяналт тавих чиг үүрэг бүхий "Теле камерын хяналтын дэд төв"-ийг холбогдох хууль тогтоомжийн дагуу аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэргэд байгуулах ажлыг удирдан зохион байгуулж ажиллахыг аймаг, дүүргийн Засаг дарга нарт;	Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх "Теле камерын хяналтын дэд төв"-ийг аймгийн Засаг даргын 2024 оны А/798 дугаар захирамжаар байгуулан, 4 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулахаар урсгал зардалд 201.8 сая төгрөг шийдвэрлэсэн. Тус төв нь NS болон IREX программыг нэвтрүүлэн ажиллаж Төв Мэдээлэл шуурхай удирдлагын газартай холбогдон, 8 сумыг дэд төвтэй амжилттай холбон ажиллаж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	113		1.3. Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд суурилуулсан болон аж ахуйн нэгж, байгууллагын гадна орчны теле камерыг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа теле камерын стандартад нийцүүлэх, мэдээлэл холбоо, сүлжээний үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын дэд бүтцийг ашиглан "Теле камерын хяналтын дэд төв"-д холбох боломжийг судалж, шийдвэрлэхийг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт;	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийтийн эзэмшлийн гудамж талбайг камержуулах "Ногоон сум" ажил арга хэмжээг зохион байгуулахаар 2025 оны орон нутгийн төсөвт 11 суманд 382.0 сая төгрөг, аймгийн теле хяналтын камерын дэд төвд ухаалаг программ хангамж нэвтрүүлэх, аж ахуйн нэгжийг холбох чиглэлээр аймгийн 2025 оны төсөвт 400 сая төгрөг, мөн төвийн урсгал зардалд 197.5 сая төгрөгийг тус тус шийдвэрлэсэн. Аймгийн хэмжээнд шинээр 10 цэгт 22 камер суурилуулсан бөгөөд Булган сумын төвийн 44 цэгийн 99 камераас эвдрэлтэй 51 камерыг засварласан. "Амар тайван Булган" хөтөлбөрийн хүрээнд Булган сумын 19.8 сая төгрөгийн санхүүжилтээр дугаар танигчтай 4 камер, чиглэлийн 20 камерыг засварласан. 2025 онд дэд төв нь 88 ширхэг чиглэлийн, 8 ширхэг PTZ, 4 тусгай зориулалтын камерыг хэвийн ажиллагаанд оруулж, 31 аж ахуйн нэгж, байгууллагыг дэд төвтэй холбосон байна. Булган сумын 6 багт нийт 1230 метр шилэн кабелиг татаж шинэчилсэн. Мөн Булган сумын 6 багийн хүүхдийн 8 тоглоомын талбайг дэд төвтэй холбосон бөгөөд камержуулалтын гүйцэтгэл 90 хувьтай байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	114		4.Теле камераар цуглуулсан мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд ашиглахгүй байх нөхцөлийг бүрдүүлж, эрсдэлээс хамгаалах шаардлагатай арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгож, шүүх, прокурор, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог төрийн байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй.	Теле камераар цуглуулсан мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд ашиглахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр аймгийн Засаг даргын 2025 оны А/108 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтаар "Дэд төв"-ийн ажиллах журмыг 12 зүйл 61 заалтаар батлуулж, теле камерын цагдаа нараар мөрдүүлж, бичгээр 5 заалт бүхий зааварчилгаа хүргүүлэн мэдээллийн аюулгүй байдалд хяналт тавин ажиллаж байна. Тайлант онд энэ төрлийн зөрчил, мэдээлэл бүртгэгдээгүй. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
75	115	Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбилцолыг батлах, эрх олгох тухай 2024-09-25 Дугаар 2024_100_1	2.. Энэ тогтоолын хавсралтад заасна солбилцол бүхий талбайд авто замын барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд түгээмэл тархцатай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгох, эрх олгосон хуулийн этгээдийн орон нутгийн төсөвт төвлөрүүлэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн төлөлтөд хяналт тавьж ажиллахыг Булган аймгийн Засаг дарга Б.Ариун-Эрдэнэд даалгасугай	Булган - Орхон - Хишиг-Өндөр - Гурванбулаг чиглэлийн 133.7 км хатуу хучилттай авто замын барилгын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрхийг 2024 оны 6 дугаар сараас 2025 оны 9 дүгээр сар хүртэл "Идэр ширэгү" ХХК-д олгосон. Засгийн газрын 2023 оны 463 дугаар тогтоолоор түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөр тооцох үнэлгээг 1 төгрөгөөр тооцож, орон нутгийн төсөвт төвлөрүүлж байна. Түгээмэл тархацтай ашигт малтмалын 2025 оны орлогын төлөвлөгөөний хэрэгжилт 52.8 сая буюу 58 хувийн биелэлттэй байна.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%		Үгүй	
76	116	Журам батлах тухай "Төрийн нууцад хамаарах худалдан авах ажиллагааг зохицуулах журам" 2024-10-09 Дугаар 2024_120_1	2.. Энэ тогтоолын хавсралтаар баталсан журмыг (Төрийн нууцад хамаарах худалдан авах ажиллагааг зохицуулах журам) үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг холбогдох төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагад тус тус үүрэг болгосугай. (З.Журиын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Тагнуулын ерөнхий газар (П.Одонбаатар)-т тус тус заалгасугай)	Төрийн нууцад хамаарах худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүй.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

77	117	ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ ШИЛЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2024-11-13 Дугаар 2024_163	2. 2.Төрийн захиргааны байгууллагын албан хэрэгцээнд ашиглах баримт бичиг боловсруулах программ хангамжийн лицензийг Ерөнхий гэрээгээр худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу нэгдсэн журмаар зохион байгуулахыг Монгол Улсын Шадар сайд Т.Доржжандад, холбогдох зардлыг төсвийн багцдаа тусган санхүүжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус үүрэг болгосугай.	Аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх "Булган сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд "Цахим Булган" хөтөлбөрийг аймгийн ИТХ-аар батлуулан хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд Орхон аймагтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний дагуу 100 сая төгрөгийн санхүүжилтээр "И-Оффис" программ хангамжийг "Анар Системс" компаниар гүйцэтгүүлж, аймгийн төрийн байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагаанд нэвтрүүлэн ажиллаж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
78	118		2.3.. Аялал жуулчлалын нэгдсэн цаглабрыг боловсруулж, улирлын онцлогийг харгалзан салбарын олон улсын хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн, урлаг, соёл, спортын зарим арга хэмжээг жил бүрийн 10 дугаар сараас дараа жилийн 4 дүгээр сар хүртэл хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт.	Аймгийн аялал жуулчлалын 2025 оны төлөвлөгөөг 4 зорилт 22 арга хэмжээтэйгээр боловсруулан батлуулж, 86.3 хувьтай хэрэгжүүлэв. Үүнд: Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчдийн судалгааг шинэчилж, НИТАЖ эрхлэгчдэд зориулсан зочлох үйлчилгээний сургалт, "Жуулчны хөтөч тайлбарлагч бэлтгэх" сургалтад 51 аж ахуйн нэгжийн 132 иргэнийг оролцууллаа. Мөн "Хангинахын шугуйн шагайн тойром-2025", "Айраг фестиваль" эвент арга хэмжээ зэрэг ажлуудад орон нутгийн төсвийн 230.0 сая төгрөгийг зарцуулан зохион байгуулж, гадаад дотоодын 34000 орчим жуулчид хүрэлцэн ирж үзэж сонирхлоо. Чех улсын иргэн, зураач, контент бүтээгч Peter Herel Raabenstein-тэй хамтран тусгай сонирхлын аялал жуулчлалыг сурталчлан таниулах ажлын хүрээнд 7 сумын түүх, соёлын дурсгалт газар, байгалийн үзэсгэлэнт орчин, нүүдлийн ахуй, шашин, үндэсний өв соёлын онцлогийг тусгасан түүх соёлын, байгалийн адал явдалт, рашаан сувилал, эрүүл мэндийн зэрэг 5 контентыг хэвлэл мэдээлэл, цахим сүлжээгээр дамжуулан олон нийтэд сурталчлан ажиллалаа. 2026 оны аялал жуулчлалын нэгдсэн цагалбарын жагсаалтад оруулах 2 эвент үйл ажиллагааны саналыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд хүргүүлсэн.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	119	Жуулчдын урсгалыг нэмэгдүүлж, дөрвөн улирлын турш жуулчин хүлээн авах зорилтын хүрээнд хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2024-11-27 Дугаар 2024_191_01	5.. Жуулчдад үйлчлэх стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг зохих байршилд байгуулж, байнгын ажиллагаатай байх нөхцөлийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Орон нутгийн эдийн засаг, аялал жуулчлал, үйлчилгээний салбарт түлхэц үзүүлж, зорчигчдын аюулгүй байдал, тав тухыг хангах зорилгоор орон нутгийн төсвийн 70.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Булган-Орхон аймаг чиглэлийн авто зам дагуу "Түр амрах цэг"-ийг ашиглалтад оруулсан. Мөн Дашинчилэн сумын нутаг дэвсгэрт түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор байгуулахаар орон нутгийн зүгээс газар эзэмших эрхийг бүрэн олгож, дуудлага худалдааг нээлттэй зарлан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлээд байна. Зам дагуу үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, үйлчилгээний газрууд, шатахуун түгээх станцуудын ариун цэврийн байгууламжийг стандартын шаардлагад нийцүүлж, нээлттэй үйлчлэх талаар Аймгийн засаг даргын 2025 оны "Ариун цэврийн өрөөгөөр чөлөөтэй үйлчлүүлэх нөхцөл бүрдүүлэх тухай" А/317 дугаар захирамжийг батлан, хэрэгжүүлж байна. Захирамжийн хүрээнд Орхон, Булган, Хутаг-Өндөр, Дашинчилэн суманд нийт 4 ШТС, 3 аж ахуйн нэгж стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж барьж, нүхэн жорлонг нураасан. Мөн тус захирамжийн хүрээнд 2025 онд 6 жуулчны бааз, 2 зочид буудал, 6 амралтын газар, нийт 14 аж ахуйн нэгж гадна ариун цэврийн байгууламжаа шинэчлэн, стандартын шаардлага хангасан 81 байгууламжтай болсон. Орхон сум 35.0 сая төгрөгөөр 6 ширхэг хөрсний бохирдлоос сэргийлэх стандартын шаардлага хангасан жорлонг 4 багийн төв, сумын Засаг даргын тамгын газар, улсын чанартай авто зам дагуу барьж ашиглалтад оруулсан. Байгальд ээлтэй эко нойл болон хогийн савыг стандартын дагуу байрлуулах, хог хаягдлыг ангилах, хүрээлэн буй орчны бохирдлоос сэргийлэх тухай 8 контентыг цахим хуудсанд байршуулж	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
79	120	Танилт, нэвтрэлтийн арга, хэрэгсэл батлах тухай 2024-12-18 Дугаар 2024_217	2. 2. Хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхэд танилт, нэвтрэлтийн системийг ашиглахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга нарт болон төрийн захиргааны бүх шатны байгууллагын удирдлагад тус тус үүрэг болгосугай.	Төрөөс хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхдээ тоон гарын үсэг, биометрик өгөгдөл, нэг удаагийн нууц үгээр болон цахим шуудангийн хаягаар нэвтрэх нэр, нууц үг ашиглах зэрэг танилт нэвтрэлтийн арга хэрэгсэл ашиглаж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

80	121	Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай 2024-12-20 Дугаар 2024_226	4. 4. Аймаг, нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн шинэчлэн тогтоож, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр богино, дунд, урт хугацааны хөтөлбөр, төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны дарга С.Одонтуяа, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Жил бүр агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогын ажлыг аймгийн хэмжээнд явуулж байна. Булган сумын агаарын чанарыг сайжруулах бүс, тухайн бүсэд мөрдөх журмыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Булган аймгийн Засаг даргын хамтарсан 2025 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн А/657, А/256 дугаар тушаал, захирамжаар шинэчлэн тогтоосон. Агаарын чанарыг сайжруулах бүсэд дагаж мөрдөх журмыг Булган суманд хэрэгжүүлэн ажиллаж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай тогтоол 2025.02.28-ны өдрийг хүртэл хэрэгжиж дууссан
81	122	Жагсаалт батлах тухай 2024-12-25 Дугаар 2024_233	2. 2. Энэ тогтоолын 1, 2 дугаар хавсралтад заасан төсөл, арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны газар, аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газарт 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн дотор тус тус хүргүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Төрийн худалдан авах ажиллагааны газарт Эдийн засаг хөгжлийн яам, Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнгээс ирүүлсэн албан бичгийн дагуу Бугат сумын замын ажлын даалгавар, Баян-Агт, Сайхан, Могод сумын замын ажлын даалгавар, Хүүхэд залуучуудын паркийн ажлын даалгаврыг хугацаанд нь хүргүүлсэн.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	Хэрэгжиж дууссан.
	123		3. 3.Худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.tn)-ээр зохион байгуулж, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд заасан дугаар төсөл, арга хэмжээний дугаар нэр хүчин чадал, байршил төслийн код ("УТ" код)-ыг батлагдсан хэлбэрээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд нийтэлж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч, Төрийн худалдан авах ажиллагааны газарт тус тус даалгасугай.	Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөнд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 39, харьцуулалтын аргаар 35, шууд худалдан авалтын 3 төсөл арга хэмжээ тусгагдсан. 2025 оны жилийн эцсийн байдлаар 77 төсөл арга хэмжээний тендерийн урилга, үр дүнг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn), аймгийн албан ёсны цахим хуудас (bulgan.gov.mn), Худалдан авах ажиллагааны газрын цахим хуудас (bu.spa.gov.mn)-т 149 удаа нийтэлж 100 хувь цахимаар зохион байгуулан ил тод нээлттэй байдлыг ханган ажилласан	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	Хэрэгжиж дууссан
	124		4. 4.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг баримтлан шуурхай зохион байгуулж ажиллахыг Төрийн худалдан авах ажиллагааны газар, төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д нийтлэгдсэн тендер шалгаруулалт зохион байгуулсан 77 төсөл арга хэмжээнд давхардсан тоогоор 149 тендер шалгаруулалтын урилга нийтэлж, хуулийн хугацаанд шийдвэр гаргаж, шийдвэр гарсан өдрөөр цахим системд тендерийн үр дүнг тухай бүр нийтэлсэн. Тендерт шалгарсан оролцогчийн ирүүлсэн материал, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлтэй танилцах боломжоор ханган ажилласан. Мөн үнэлгээний хорооны гишүүдээр "Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг"-ийг тухай бүрд нь гаргуулан, баталгаажуулж ажиллав.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
82	125	Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2024-12-25 Дугаар 2024_238_1	2. 2. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлж, 2025 онд орон тооны дээд хязгаарыг нэмэгдүүлэхгүй байхыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг 2025.01.01-ээс шинэчлэн тогтоосонтой холбоотой төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт хамаарах аймаг, сумын орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагуудад шаардагдах төсвийг тооцоолон, 2025 оны төсөвт тусгасан болно. Батлагдсан төсөв, орон тооны хязгаарт нийцүүлэн, орон тоог нэмэгдүүлэлгүй ажилласан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
83	126	Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2024-12-25 Дугаар 2024_246	5. 5. Орон нутгийн харьяалалтай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийслэл хотод нийтийн тээврийн хэрэгслээр 2017-2024 оны хооронд зорчсон зардал болох нийт 1.3 тэрбум (нэг тэрбум гурван зуун сая) төгрөгийн хуримтлагдсан өр төлбөрийг тооцооллын дагуу нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газарт 2025 онд багтаан шилжүүлэн барагдуулахыг холбогдох аймгийн Засаг дарга нарт даалгасугай.	Сангийн яамны орон нутгийн суурь зардалд тусгагдаагүй тул 2025 оны төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт дээрх зардал батлагдаагүй болно.	Санхүү, хөрөнгө оруулалтаас - 0%	Санхүү, хөрөнгө оруулалтаас - 0%		Үгүй	
84	127	Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн тогтоох тухай 2025-01-29 Дугаар 2025_37	5. 5."Аргачлал батлах тухай" Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан аргачлалын дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын чиг үүргийн шинжилгээгхийж, аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, Засагдаргын эрхлэх асуудлын хүрээнд ажиллах агентлагийн хооронд чиг үүргийн давхардал, хийдэл үүсгэхгүйгээр оновчтой зохицуулалт хийж ажиллахыг аймгийн Засаг дарга нарт даалгасугай.	Аймаг, сумын Засаг даргын тамгын газрын удирдах болон гүйцэтгэх 22 албан тушаалын тодорхойлолтод чиг үүргийн шинжилгээ хийж, тодорхойлолтыг Салбар зөвлөлийн хуралдаанаар хянан, хэлэлцэж, Төрийн албаны зөвлөлд хүргүүлэн, батлах зөвшөөрөл авсан. Батлах зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолтыг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр баталгаажуулж, албан тушаалын тодорхойлолтыг ХНУМТ цахим системд оруулах ажилд хяналт тавин ажиллалаа. Аймгийн хэмжээнд төрийн захиргааны 41 байгууллагын 217 албан тушаалын тодорхойлолтод шинжилгээ хийж, ХНУМТ цахим системд оруулж, төрийн албаны тусгай шалгалт, сонгон шалгаруулалтыг явуулах, томилгооны зөрчлийг цахим системээр хянах нөхцөлийг бүрдүүлээд байна	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

85	128	Хүүхдийн эрхийг хамгаалах зарим арга хэмжээний тухай 2025-01-29 Дугаар 2025_41	2. 2.Хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг таслан зогсоох арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, өвөл, хаврын улиралд зохион байгуулагдах хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээнд 18 нас хүртэлх хүүхдийг аливаа хэлбэрээр оролцуулахгүй байхад хяналт тавьж ажиллахыг бүх шатны Засаг дарга, Цагдаагийн ерөнхий газар (Т.Сүхболд), Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар (Т.Ихтамир)-т тус тус үүрэг болгосугай.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр "Хүүхэд хамгааллыг хамтдаа хөгжүүлэе" аймгийн Засаг даргаар батлуулсан удирдамжийн дагуу бүх сумдад хүүхдийн асуудлыг сонсож ажиллав. Өвөл, хаврын улиралд хурдан морины уралдаан зохион байгуулахыг хориглосон аймгийн Засаг даргын 2024 оны А/721 дүгээр захирамжийг сумдын Засаг даргын тамгын газар, уяачдын холбоонд хүргүүлж, хамтарсан багаас хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. Хориглосон хугацаанд зохион байгуулахыг оролдсон 2 уралдааныг таслан зогсоож тараасан. Булган аймгийн баяр наадам, сумдын баяр наадам, тэмдэглэлт ойн баяр наадмын нийт 42 удаагийн хурдан морины уралдаанд 412 хүүхэд бүртгэгдэж, давхардсан тоогоор 2007 хүүхэд уралдааны замд гарчээ. Уралдаан бүрт хүүхэд хамгааллын баг ажиллаж, уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг ханган ажилласан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
86	129	Ой тэмдэглэх тухай 2025-01-29 Дугаар 2025_44	2. 2.Ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээг удирдан, зохион байгуулах Ажлын хэсгийг байгуулж, арга хэмжээний төлөвлөгөө батлан, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, ойг тэмдэглэн өнгөрүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг холбогдох аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Тус заалт манай аймагт хамааралгүй байна.	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй		Тийм	Маршал Хорлоогийн Чойбалсангийн мэндэлсний 130 жилийн ойг 2025 оны 09 дүгээр сард Дорнод аймагт тэмдэглэн өнгөрүүлсэн.
87	130	Яаралтай тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-02-05 Дугаар 2025_67	3. 3.Орон нутагт яаралтай тусламжийн дуудлага, мэдээллийг нэгдсэн "112" дугаарлалтаар хүлээн авах үйл ажиллагааг Теле камерын хяналтын дэд төвүүдийн үйл ажиллагаатай уялдуулах арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, аймгийн Засаг дарга нарт даалгасугай.	Теле камерын хяналтын дэд төвийн үйл ажиллагааг жигдрүүлж, орон нутагт яаралтай тусламжийн дуудлага, мэдээллийг нэгдсэн "112" дугаарлалтаар хүлээн авах бэлтгэл ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2025 оны А/308 дугаар захирамжаар байгуулсан. Яаралтай тусламжийн дуудлага мэдээллийн нэгдсэн систем "112" дугаарлалт руу шилжүүлэхэд шаардлагатай тооцоог гаргуулахаар Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл шуурхай удирдлагын төвд хүсэлт хүргүүлж, тус төвөөс 256/1227 дугаартай албан бичгээр 404 сая төгрөгийн тооцоо ирүүлсэн. Төсөв, санхүүгийн хүндрэлтэй холбоотойгоор тус ажлыг хэрэгжүүлэх зардлыг 2026 оны хагас жилийн төсвийн тодотголоор дахин хэлэлцэхээр шийдвэрлэсэн.	Санхүү, хөрөнгө оруулалтаас - 0%	Санхүү, хөрөнгө оруулалтаас - 0%		Үгүй	
88	131	Экспортын орлогыг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай 2025-02-19 Дугаар 2025_94	2. 2. Томоохон төсөл, арга хэмжээний санхүүжилт, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэхдээ гадаад валютын улсын нөөцөд богино, дунд, урт хугацаанд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нар, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад тус тус үүрэг болгосугай.	Хэрэгжээгүй	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй		Үгүй	
	132		4. 4. Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулалт татах зорилгоор гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж болон иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэж ажиллахыг бүх шатны төрийн захиргааны байгууллагад үүрэг болгосугай.	Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж болон иргэдээс ирүүлсэн өргөдөл, хүсэлт бүртгэгдээгүй.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
89	133	Монгол Улсын иргэнд 2025 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай 2025-03-06 Дугаар 2025_119	2. 2. Энэ тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар (А.Энхманлай), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. /Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг үндэслэн "Монгол Улсын иргэнд 2025 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалт"-ыг хавсралт ёсоор баталсугай/	Засгийн газрын 2025 оны 119 дүгээр тогтоолын дагуу аймгийн хэмжээнд 225 иргэнд 43.38 га газрыг өмчлүүлэхээр төлөвлөснөөс 145 нэгж талбарын 26.25 га газрыг өмчлүүлсэн байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
90	134	Улсын хэмжээнд 2025 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай 2025-03-06 Дугаар 2025_120	2. 2.Энэ тогтоолоор баталсан жагсаалтад тусгагдсан байршилд газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахдаа холбогдох хууль тогтоомж, журмыг баримталж, газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээр дамжуулан хэрэгжүүлэх арга хэмжээ авч, жагсаалтад тусгагдаагүй байршилд газар эзэмшүүлэх, ашиглуулах аливаа шийдвэр гаргахгүй байхыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, сум, нийслэлийн Засаг дарга, Чөлөөт бүсийн захирагч нарт тус тус үүрэг болгосугай	Булган аймгийн хэмжээнд Засгийн газрын 2025 оны 119, 120, 06, 74 дүгээр тогтоолын дагуу нийт 600 нэгж талбар газраас 457 нэгж талбар газрыг иргэн, хуулийн этгээдэд өмчлүүлж, эзэмшүүлснээр төлөвлөгөөний хэрэгжилтийг 76.2 хувиар хангаж ажилласан байна. Иргэн, хуулийн этгээдэд газар өмчлүүлж, эзэмшүүлэхдээ газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн системийн жагсаалтад тусгагдаагүй байршилд газар олгосон шийдвэр гаргаагүй.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

91	135	Олон улсын худалдааны тарифын нөхцөл байдалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2025-03-12 Дугаар 2025_132	1. Олон улсад үүсэж байгаа геополитикийн болон худалдааны хурцадмал, тодорхойгүй нөхцөл байдалтай холбогдуулан хүн амд үзүүлэх үйлчилгээний зохицуулалтын уялдааг хангах, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх орчны тогтвортой байдлыг дэмжих зорилгоор төрөөс иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа бүх төрлийн үйлчилгээний төлбөр, хураамжийг 2025 оны төсвийн жилд нэмэгдүүлэхгүй байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нар, зөвлөл, хороо, комиссын дарга нар, бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу 2025 оны төсвийн жилд бүх төрлийн үйлчилгээний төлбөр хураамжийг нэмэгдүүлэхгүйгээр өмнөх түвшнийг барьж ажилласан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
92	136	Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай 2025-03-19 Дугаар 2025_141	2. 2. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, мөнгөн төлбөрийг төвлөрүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Улсын Их хурлын 2009 оны 33 дугаар тогтоол, Засгийн газрын 2025 оны 141 дүгээр тогтоолоор цэргийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн нэр бүхий 85 иргэнд цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрөөр орлуулан хаах журмын холбогдох заалтын дагуу төлбөр ноогдуулж, 181.3 сая төгрөгийг төвлөрүүлээ.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
93	137	2026 оныг "Боловсролыг дэмжих жил болгон зарлах тухай 2025-04-02 Дугаар 2025_158	3. 3. Боловсролыг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Боловсролыг дэмжих жилийн ажлын хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.	Х.Б	Х.Б		Үгүй	
94	138	Хойд бүсийн хөгжлийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 2025-04-28 Дугаар 2025_204	1.1.1.. 1.1.1."Хойд бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөө"-г төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын оролцоотойгоор боловсруулж, батлан хэрэгжүүлэхийг Хойд бүсийн зөвлөл (Д.Пүрэв-Очир)-д, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номинд;	"Хойд бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөө"-г боловсруулахаар аймгийн Аялал жуулчлалын холбоо, байгууллага, холбогдох албаныханд санал, мэдээлэл хүргүүлэн санал солилцох, судалгаа, арга зүйг нэгтгэх замаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	Зохион байгуулалтаас - 0%	Зохион байгуулалтаас - 0%		Үгүй	
	139		1.3.1.. 1.3.1.Хойд бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан Орхон, Хөвсгөл, Булган аймгийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг байгалийн аялал жуулчлал, уул уурхай, эрчим хүчний чиглэлээр төрөлжүүлж, дэд бүтцийн төслийн хүний нөөцийг богино хугацаанд бэлтгэх, давтан сургах зорилгоор Хөвсгөл аймаг дахь Политехник коллежийн дэргэд байгуулах салбар дундын дадлага, үйлдвэрлэлийн баазын техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулахад шаардагдах санхүүжилтийн асуудлыг судалж, танилцуулахыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Боловсролын сайд П.Наранбаяр, Сангийн сайд Б.Жавхлан, Хойд бүсийн зөвлөл (Д.Пүрэв-Очир)-д;	ХААИС-ийн харьяа Булган аймаг дахь Политехникийн коллежийг хөдөө аж ахуйн чиглэлээр төрөлжүүлэн, 1 жилийн ангид 352 суралцагч, 2.5 жилийн курст 49 суралцагч, нийт 401 суралцагч суралцаж төгссөн. "Чадварлаг мэргэжилтэн" хөтөлбөрийн хүрээнд Политехник коллежийн 2025-2026 оны хичээлийн жилд Мэдээллийн системийн мэргэжлийн ангийг нээлээ. Тус мэргэжлээр 15 элсэгч суралцаж байна. Энэ ангид суралцсанаар орон нутагтаа код бичдэг мэргэжилтэн бэлтгэх юм. Суурь ур чадвар олгох сургалтыг Рашаант, Хишиг-Өндөр, Орхон, Булган, Бугат сумын зорилтот бүлгийн 165 иргэнд зохион байгууллаа.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%		Үгүй	
	140		1.3.2.. 1.3.2.Хойд бүсийн цэцэрлэг, сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын Багшийн хөгжлийг дэмжих төвийг Орхон аймагт байгуулахад шаардагдах санхүүжилтийн асуудлыг судалж, танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Боловсролын сайд П.Наранбаяр, Хойд бүсийн зөвлөл (Д.Пүрэв-Очир)-д;	Орхон аймгаас тооцоо судалгааг ирүүлээгүй байна.	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй		Үгүй	
	141		1.3.4.. 1.3.4.Булган аймгийн Нэгдсэн эмнэлгийн барилгын ажлын санхүүжилтийн эх үүсвэрийг судалж, шийдвэрлүүлэхийг Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Сангийн сайд Б.Жавхлан, Булган аймгийн Засаг дарга Д.Пүрэв-Очир нарт;	Булган аймгийн Булган суманд баригдах Нэгдсэн эмнэлгийн 100 ортой өргөтгөлийн барилгын ажлын нийт төсөв 38 тэрбум бөгөөд 2026 оны улсын төсөвт 7.6 тэрбум төгрөгийн барилгын ажлыг санхүүжүүлэхээр батлагдсан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	142		1.4.2.. 1.4.2.Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд бүсийн хэмжээнд хог хаягдлын тээвэрлэлт, үйлчилгээний хураамжийн орлогын зарцуулалт, менежментийн хяналтыг сайжруулж, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, холбогдох эрх зүйн актыг батлан мөрдүүлэх ажлыг зохион байгуулахыг Хойд бүсийн аймгийн Засаг дарга нарт.	Хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 07/04 дүгээр тогтоолоор "Хог хаягдлын менежментийг сайжруулах" хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Булган сумын Тохижилт үйлчилгээний анги нь хог хаягдлын цуглуулалт, тээвэрлэлтийг хариуцан ажиллаж, гэр хорооллын өрхүүд, 82 аж ахуйн нэгж, байгууллага, сууц өмчлөгчдийн холбоотой гэрээ байгуулан, 36 байрны 697 айлын хог хаягдлыг тээвэрлэж, төвлөрсөн хогийн цэгт хүргэх ажлыг гүйцэтгэж байна. Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан 192/А243 тушаалаар батлагдсан аргачлалын дагуу Булган аймгийн 16 сум хог хаягдлын хураамжийг ИТХ-ын тогтоолоор баталсан. Үүнээс 8 сум хог хаягдлын хураамжийг өрхөөр, 8 сум иргэнээр тогтоосон. Хог хаягдлын хураамжийг эрчим хүчний үйлчилгээний төлбөртэй хамтатган хураах замаар төвлөрүүлж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

	143		1.5.1.. 1.5.1.Хөвсгөл аймгийн Мөрөн суманд Бүсийн дата төв, Орхон аймгийн Эрдэнэт хотод Мэдээллийн технологийн төрөлжсөн төв байгуулах асуудлыг судалж, холбогдох арга хэмжээ авахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Хойд бүсийн зөвлөл (Д.Пүрэв-Очир)-д;	Орхон, Хөвсгөл аймгаас тооцоо судалгааг ирүүлээгүй байна.	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй		Үгүй	
	144		1.5.2. 1.5.2."Цахим аймаг, ухаалаг хот" зөвлөмжийг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хойд бүсийн зөвлөл (Д.Пүрэв-Очир)-д, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд.	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн XI/82 дугаар тогтоолоор төрийн үйл ажиллагааны хурд, бүтээмжийг нэмэгдүүлэх "Цахим Булган" хөтөлбөрийг батлуулсан хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд Орхон аймагтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний дагуу олгогдсон 100 сая төгрөгийн санхүүжилтээр "И-Оффис" программ хангамжийг "Анар Системс" компаниар гүйцэтгүүлж, аймгийн төрийн байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр ажиллаж байна. Кибер халдлагын эрсдэлийг бууруулах, цахим орчны зөв хэрэглээг төлөвшүүлэх зорилгоор "Булганчууд залилуулахгүй", "Цахим орчны зөв, боловсон хэрэглээ" сэдвийн хүрээнд төр, төсвийн байгууллагын мэдээлэл технологийн ажилтан болон мэдээлэл зүйн багш нарын давхардсан тоогоор 100 хүн хамрагдсан сургалтуудыг зохион байгууллаа.ХУР, E-Mongolia системээр нэг болон олон шатлалт төрийн үйлчилгээг 18368 иргэдэд үзүүлж, 9119 лавлагаа, тодорхойлолт олгож ажиллалаа. Энэ нь аймгийн нийт иргэдийн 30.4 хувьд хүрсэн үзүүлэлт юм. Үйлчилгээг аймгийн төвд байрлах 6 киоск, 16 сум, 1 тосгонд байрлах 23 "ХУРДАН" киоск, 11 сумын 24/7 цахим үйлчилгээний төвүүдээр дамжуулан үзүүлсэн. Аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсээс бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалт болон стандартын мэдээлэл, лавлагааны үйлчилгээг cert.masm.gov.mn, estandard.gov.mn системээр дамжуулан цахимд бүрэн шилжүүлснээр Булган аймагт үзүүлж буй цахим үйлчилгээний төрөл 63 болж нэмэгдсэн. "Цахим Булган" хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 2025 онд 14 арга хэмжээ төлөвлөн 60.0 сая төгрөг батлуулснаас төлөвлөгөөний хэрэгжилт 95 хувьтай төсвийн гүйцэтгэл 100 хувьтай	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
95	145	Ой тэмдэглэх тухай 2025-04-28 Дугаар 2025_206	3. 3.Ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг шийдвэрлэх, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангахыг Ажлын хэсэг (Н.Учрал)-т, ойг тэмдэглэн өнгөрүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг холбогдох аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, Монгол Улсын Ерөнхий сайд асан Агданбуугийн Амарын мэндэлсний 140 жилийн ойг 2026 онд тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан аймгийн ЗДТГ-ын даргаар ахлуулсан ажлын хэсгийг Засаг даргын захирамжаар байгуулсан. А.Амар сайдын алдар гавьяаг мөнхжүүлэх, намтар, үйл хэргийг иргэд, олон нийт, залуучууд хойч үедээ сурталчлан таниулах, Булган аймаг байгуулагдсаны 90 жилийн ойн бэлтгэл хангах чиглэлээр төлөвлөгөө гарган, ажиллаж байна. А.Амар сайдын нэрэмжит аймгийн шагналыг бий болгохоор энгэрийн тэмдгийн загвар шалгаруулах уралдааныг олон нийтэд нээлттэй зарласан. Мөн "Бүгд найрамдах Монгол ард Улсын Ерөнхий сайд А.Амарын гэрэл зураг болон түүхэн ном зохиол, үзмэр, эд өлгийн үзэсгэлэнг Булган аймгийн музейд дэглэн тавьж, олны хүртээл болголоо. "Бүгд найрамдах Монгол ард Улсын Ерөнхий сайд А.Амарын түүх, баримт" сэдэвт илтгэлийг Түүхийн ухааны доктор Н.Батболд, А.Амар сангийн тэргүүн Ё.Отгонбаяр нар Булган аймгийн Хөгжимт жүжгийн театрт илтгэн, хэлэлцүүлээ. Тус илтгэлийг иргэд, олон нийт, төрийн албан хаагчид, ерөнхий боловсролын сургуулийн түүхийн багш нар, дунд болон ахлах ангийн сурагчид шимтэн сонсоо	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%		Үгүй	

96	146	Алт олборлолтыг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай 2025-04-30 Дугаар 2025_211	4. 4.Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн үндсэн дээр тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа алт олборлогч аж ахуйн нэгжид хууль тогтоомжийн хүрээнд зохих дэмжлэг үзүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга нарт, хайгуул, олборлолтын үйл ажиллагааны үлмээс байгаль орчинд учрах хор уршгийг арилгах, байгальд ээлтэй технологийн шийдлийг нэвтрүүлэх, уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд тавих хяналтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн сайжруулах арга хэмжээг үе шаттай төлөвлөн хэрэгжүүлэхийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан нарт тус тус үүрэг болгосугай.	Аймгийн хэмжээнд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдэд хууль тогтоомжийн хүрээнд шаардлага тавьж, хамтран ажиллаж байна. 2025 онд үйл ажиллагаа явуулж буй 7 компанитай нийгмийн хариуцлагын гэрээ байгуулсан. Аймгийн Засаг даргын 2024 оны А/654 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2025 оны 10 дугаар сарын 8-10-ны өдрүүдэд уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдийн тухайн жилийн нөхөн сэргээлтийн ажлыг хүлээн авч ажилласан. Бүрэгхангай сумын Дарст багийн нутаг дэвсгэрт уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч 8 аж ахуйн нэгж компани 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу техникийн нөхөн сэргээлтийг 39 га талбайд хийхээр төлөвлөснөөс 52.16 га талбайд, биологийн нөхөн сэргээлтийг 25.55 га талбайд хийхээр төлөвлөснөөс 49.86 га талбайд хийж гүйцэтгэн, хүлээлгэн өгөв.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
97	147	Тусгай зориулалтаар 2025 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай 2025-05-21 Дугаар 2025_242	2. Энэ тогтоолын 1, 2 дугаар хавсралтаар баталсан тусгай зориулалтын ангийн дуудлага худалдааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг холбогдох аймгийн Засаг дарга нарт даалгасугай.	Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн 1 халиун буга, 30 тул загас, 300 бусад төрлийн загас тусгай зориулалтаар агнах, барих дуудлага худалдааг зохион байгуулж, гэрээ байгуулах эрх олгосон. Тусгай зориулалтын ангаас орон нутгийн төсөвт 35.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
98	148	Хүн ам, орон сууцны завсрын тооллого явуулахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2025-05-28 Дугаар 2025_260	2. 2.Хүн ам, орон сууцны 2025 оны завсрын тооллогод ашиглах мэдээллийн сангийн мэдээллийн чанарыг сайжруулах, шинэчлэх, баталгаажуулах арга хэмжээг харьяа нутагт дэвсгэртээ зохион байгуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Хүн ам, орон сууцны 2025 оны завсрын тооллогыг орон нутагт зохион байгуулах аймгийн комиссыг 2025 оны 6 дугаар сард байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган тооллогын ажлыг зохион байгуулсан. Мэдээллийн санг сайжруулах, хүн ам, өрхийн бүртгэлийг тодруулах ажлыг 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс 12 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл хийж гүйцэтгэв. Мэдээлэлд дүн шинжилгээ хийх ажил хийгдэж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
99	149	Ажил, амралтын цагийн зохицуулалтын тухай 2025-06-04 Дугаар 2025_279	1. 1.Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярын 2025 оны 07 дугаар сарын 12, 13-ны өдрүүд нь Бямба, Ням гарагт тохиож байгаатай холбогдуулан 2025 оны 07 дугаар сарын 16, 17-ны өдрийн Лхагва, Пүрэв гарагт ажилтан, албан хаагчдыг амрааж, 2025 онд багтаан нөхөн ажиллуулах зохицуулалт хийхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад даалгасугай.	Аймгийн Засаг даргын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн А/495 дугаар захирамжаар ажил, амралтын зохицуулалт хийх тухай шийдвэрийг батлан хэрэгжүүлж, ажлын өдрүүдэд амраасан хугацааг 2025 онд багтаан нөхөх зохицуулалт хийж ажилласан. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	Шийдвэрт заасан хугацаанд бүрэн хэрэгжүүлж дууссан.
100	150	Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2026 оны төсвийн хязгаарыг батлах тухай 2025-06-18 Дугаар 2025_01	2. Энэ тогтоолоор баталсан төсвийн хязгаарт нийцүүлэн 2026 оны төсвийн төслийг боловсруулахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны төсвийн хязгаар 58.8 тэрбум төгрөгөөр батлагдсан. Сум, байгууллагаас 2026 оны төсвийн төслийг хуулийн хугацаанд хүлээн авч, хянаж, нэгтгэн 87.3 тэрбум төгрөгийн төсвийн саналыг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд Сангийн яаманд хүргүүлж, 70.0 тэрбум төгрөгөөр хянуулсан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

101	151	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-07-23 Дугаар 2025_29	1.6. хүүхэд, залуучуудын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэсэн соёл, спорт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийг олон нийтэд тайлбарлан ойлгуулах ажлыг тогтмол зохион байгуулахыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундрам, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Жаргалант зуслангийн зуны хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж 493 хүүхдийг амраасан. Аймгийн Засаг даргын "Амьд хөгжим", "Англи хэлтэй Булган" хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн зуслангийн гитар хөгжмийн сургалттай ээлжинд 80, англи хэлний анхан шатны сургалттай ээлжинд дунд ангийн 100, ахлах ангийн сурагчдад зориулсан ахисан түвшний сургалтад 44 хүүхэд хамрагдав. 2025 онд спортын 12 холбоодтой хамтран ажиллах гэрээ байгуулж, спортын 13 төрлөөр албан ёсны 25 секц, дугуйланг тогтмол хичээллүүлэн 3236 хүүхдийг хамруулсан нь өмнөх оноос 3.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. "365 Анхаарч Хайрлая" уриан дор зохион байгуулагдсан мэдээлэл нөлөөллийн арга хэмжээний хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн 7-9 дүгээр ангийн сурагчдын дунд 3х3 сагсан бөмбөгийн тэмцээн зохион байгуулж 14 баг тамирчид авхаалж самбаа, ур чадвараараа өрсөлдсөн. Электрон тамхи хорт зуршил сэдвээр Булган сумын 2 дугаар сургууль, спортын дунд сургууль, политехникийн сургуулийн сурагчдыг хамруулан 2 цагийн сургалтыг тус тус зохион байгууллаа. "Анхаарч Хайрлая" уриан дор хүүхдүүд эцэг эхтэйгээ ярилцаж, сонсож, ойлголцож байх нь хамгийн чухал сэдэвт зөвлөгөөнийг аймгийн Цагдаагийн газар, Булган сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран зохион байгуулж, ерөнхий боловсролын сургуулийн эцэг эхийн зөвлөлийн 100 гишүүнийг хамруулав. Тус арга хэмжээний хүрээнд 3 видео бичлэг, рийл хийж Цагдаагийн газрын цахим хуудсанд байршуулсан. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр "Анзаар-2", "Хорт зуршил ба донтолт", Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын ойлголт, хэрэглээ "Анзаарч хайрлая 365" зэрэг	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	152		3. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх арга хэмжээний хэрэгжилтийг хангах хүрээнд бүх талын дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Экологийн асуудал хариуцсан эрүүгийн ахлах мөрдөгч, цагдаагийн ахмад Ш.Мөнх-Амгалан, эдийн засгийн мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч Г.Дашням нар аймгийн төвийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах, дунд ангийн сурагчдад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийн талаар 5 удаа сургалт зохион байгуулсан ба уг сургалтад давхардсан тоогоор 439 сурагч хамрагдсан. Мөн 8 сум, 1 тосгоны ахлах ангийн 356 сурагчид Сум дундын цагдаагийн тасгийн дарга, хэсгийн төлөөлөгч нар тус бүр нэг удаа сургалт нөлөөллийн ажил арга хэмжээг зохион байгуулж ажилласан. Булган аймгийн тодорхой бусад ургадаг Каннабис ургамлыг устгах "Устгал" тусгай арга хэмжээг зохион байгуулав. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын шинжтэй зөрчил бүртгэгдээгүй байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
153	153		2.3.. мэргэжлийн байгууллагын дүгнэлтэд үндэслэн ган, зудын зураглалыг нарийвчлан гаргах, эрсдэлийн үнэлгээ хийх аргачлалыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн шинэчлэн батлахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Онцгой байдлын ерөнхий газар (Г.Ариунбуян)-т;	Зудын зураглалыг 12 дугаар сарын төлөвөөр гаргахад нийт нутгийн 2.8 хувьд нэн их, 17.4 хувьд их, 69.3 хувьд дунд зэрэг, 10.4 хувьд бага хүндрэлтэй байхаар зураглал гарсан. Тухайлбал: Рашаант, Баяннуур, Дашинчилэн, Гурванбулаг, Сайхан сумын ихэнх нутгаар их, Баян-Агт, Бүрэгхангай, Хангал, Хутаг-Өндөр, Орхон, Хишиг-Өндөр сумын нутгаар дунд болон их, Тэшиг, Сэлэнгэ, Бугат, Булган, Могод сумын ихэнх нутгаар дунд зэрэг байх төлөвтэй байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	Хамааралгүй
	154		2.4.. өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын хүрээнд зам, гүүрний засварын ажлыг дуусгах, улсын болон орон нутгийн чанартай авто зам, даваа хаагдахаас урьдчилан сэргийлэх, зам засвар, ашиглалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, аймгийн Засаг дарга нарт;	Энэ онд Булган суманд 200.0 сая төгрөгөөр орон нутгийн чанартай авто замын засвар, арчлалтын ажил, 50.0 сая төгрөгөөр үерийн далангийн засвар, цэвэрлэгээг хийж гүйцэтгэсэн. Ургац тээврийн зам засварын ажилд 70.0 сая төгрөг батлагдаж, Сэлэнгэ, Хутаг-Өндөр, Тэшиг, Хангал суманд хуваарилалт хийгдсэн. Орон нутгийн төсвийн 345 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баяннуур, Дашинчилэн суманд ковш машин худалдан авч, өвөлжилт хүндрэх эрсдэл бүхий урд сумдын зам давааг хаагдахаас сэргийлэх боломжийг бүрдүүлээ.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

102	155		2.5.. аймаг дундын отрын бүс нутгийн бэлчээрийн даацад тохируулан мал өвөлжүүлж, хаваржуулах чиглэлийг тогтоохыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт, отор нүүдлийг тогтоосон чиглэлийн дагуу явуулахыг холбогдох аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	2025-2026 оны өвөл, хаврын бэлчээрийн даацыг тодорхойлсон дүнгээс үзвэл нийт нутгийн 30.9 хувь бэлчээрийн нөөцтэй, 20.9 хувь бэлчээр хүрэлцээтэй, 34.9 хувьд даац 1-3 дахин хэтэрсэн, 5.5 хувьд даац 3-5 дахин хэтэрсэн, 7.7 хувьд даац олон дахин хэтэрсэн буюу өвөл, хаврын бэлчээрийн даац нутгийн 50 хувьд хүрэлцээтэй, 50 хувьд даац хэтэрч гарсан байна. Даац хэтэрч гарсан бэлчээр нутгийн хэмжээ өмнөх жилээс 20 хувиар нэмэгдсэн. Аймаг дундын “Чилэн” отрын бүс нутгийн орон тооны бүс зөвлөлийн хурлыг энэ оны 9 дүгээр сард зохион байгуулж, тус отрын бүсэд хонин тогойд шилжүүлснээр 45.0 мянган толгой хонь өвөлжих тооцоо судалгаа гарсан. Тооцооллын дагуу Төв, Өвөрхангай, Булган аймгаас 37 өрхийн 27.3 мянга буюу хонин толгойд шилжүүлснээр 45.7 мянган толгой мал өвөлжиж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	156		2.6.. улсын тусгай хамгаалалттай болон хилийн зурвас газарт отроор өвөлжиж, хаваржих малын тоо, малчин өрхийн судалгааг нарийвчлан гаргаж, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, орон нутгаас гаргасан судалгаанд үндэслэн отроор өвөлжүүлж, хаваржуулах боломж, нөхцөлийг бүрдүүлэхийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Хил хамгаалах ерөнхий газар (Ж.Бямбасүрэн)-т;	Тус аймгийн 36 малчин өрхийн 17.5 мянган толгой мал өөр аймгийн нутагт, 449 малчин өрхийн 80.6 мянган толгой мал өөрийн аймгийн бусад сумдын нутагт, 34 малчин өрхийн 2.1 мянган толгой мал хилийн зурвас бүс нутагт, 131 малчин өрхийн 84.1 мянган толгой мал улсын тусгай хамгаалалттай бүс нутагт, 21 малчин өрхийн 12.2 мянган толгой мал тусгай хэрэгцээний отрын бүс нутагт өвөлжиж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	157		2.7.. аймгийн болон сум дундын отрын бүс нутаг шинээр бий болгох тооцоо, судалгаа хийж, хэрэгжилтийг зохион байгуулахыг аймгийн Засаг дарга нарт;	Бэлчээрийн даацыг тооцоолж гаргасан дүнгээс үзвэл нийт нутгийн 30.9 хувь бэлчээрийн нөөцтэй, 20.9 хувь бэлчээр хүрэлцээтэй, 34.9 хувь даац 1-3 дахин хэтэрсэн, 5.5 хувь даац 3-5 дахин хэтэрсэн, 7.7 хувь даац олон дахин хэтэрсэн байна. Тухайлбал өвөл, хаврын бэлчээрийн даац нутгийн 50 хувьд хүрэлцээтэй, 50 хувьд хэтэрч гарсан. Даац хэтэрч гарсан нутгийн хэмжээ өмнөх жилээс 20 хувиар нэмэгдэж гарсан байна. Иймд манай аймаг шинээр отрын бүс нутаг байгуулах боломжгүй байна.	Х.Б	Х.Б		Үгүй	
	158		2.10.. энэ тогтоолын хавсралтаар заасан өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлж, мал эмнэлгийн хорио, цээрийн хяналт шалгалтыг эрчимжүүлэн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Аймгийн аюулгүйн нөөцөд 166.6 тн өвс, 60 тн тэжээлийг бэлтгэн, тогтоолын хэрэгжилтийг 77.6 хувиар хангасан. Мал эмнэлгийн хорио, цээрийн хяналт шалгалтыг эрчимжүүлж, Хутаг-Өндөр сумын гуртын гүүрэнд 19.8 сая төгрөгийн өртөг бүхий явуулын пост худалдан авч, байнгын хяналтын цэгийг байгуулаад байна. Тайлант онд мал, амьтны гоц халдварт өвчлөлгүй тайван байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	159	Хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 2025-08-20 Дугаар 2025_56	2.13.. ургац хураалтын ажилд их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн оюутан, сонсогч, хугацаат цэргийн алба хаагчдыг татан оролцуулах, тэдгээрийн цалин хөлс, ажлын байрны нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Боловсролын сайд П.Наранбаяр, Батлан хамгаалахын сайд Д.Батлут, Хууль зүй, дотоод хэргийн сайд Л.Мөнхбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Ургац хураалтын ажилд шаардлагатай хүн хүчний судалгааг гаргаж, холбогдох байгууллагуудад хүргүүлснээр 2025 оны ургац хураалтын ажилд 7 аж ахуйн нэгж, 5 тариаланч, 8 ногоочид, политехникийн коллежийн 90 оюутан, 30 албан хаагч, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч 33 иргэнийг ажиллуулан, ажиллах хугацаанд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг ханган, нийт 150 гаруй хүнд цалин хөлс, урамшуулал олгож ажилласан байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	160		2.14.. улсын хэмжээнд шаардлагатай улаанбуудай, төмс, хүнсний ногоо, өвс, тэжээлийн хэрэгцээ, хангамжид үндэслэн гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний экспорт, импортын зохистой харьцааг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний дотоодын нөөцийг бүрдүүлж, нийлүүлэлтийг тасалдуулахгүй байхад анхаарч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Тайлант онд төмс 373.03 га-д тарьж 3267 тн, хүнсний ногоо 209.13 га-д тарьж 2157 тн ургац хураан авсан. Өмнөх онтой харьцуулахад төмс тарьсан талбайн хэмжээ 1.1 хувиар буурч, хураан авсан ургац 9.1 хувиар нэмэгдсэн. Хүнсний ногоо тарьсан талбайн хэмжээ 1.5 хувиар буурч, хураан авсан ургац 10.3 хувиар нэмэгдсэн. Хамгаалалттай хөрсний буюу хүлэмжийн аж ахуйн үйл ажиллагааг 242 иргэн, 1 хоршоо, 8 аж ахуй нэгж эрхэлж байна. Өвлийн хүлэмжийн тариалалтыг 3400 м.кв талбайд хийж, 71.5 тн ургац хураасан нь хүнсний ногооны хангамжийн 47.8 хувийг эзэлж байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад хүлэмжийн тариалалт 0.9 га-аар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

	161		2.17.. арилжааны зориулалтаар байгалийн хадлан бэлтгэх гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгжийн гэрээний гүйцэтгэлд хяналт тавих, гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах нэгдсэн төлөвлөгөөний дагуу сумдад хадлан, тэжээл бэлтгэлийн ажлыг чанартай, шуурхай зохион байгуулах, малдаа хүрэлцэхүйц хэмжээний өвс, тэжээлийг бэлтгэж, нөөцлөх, худаг уст цэгийн эзэмшилт, ашиглалт, хашаа хорооны хангамжийг сайжруулах, эр сувай малыг зах зээлд борлуулах, зам даваа хаагдаж болзошгүй газарт өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх, малчдын хувийн бэлтгэлийг сайтар хангуулах зэрэгт тодорхой зөвлөмж чиглэл өгч ажилласан. Малчдын өвс тэжээлийн бэлтгэл 84.6 хувь, аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийн бэлтгэл 77.3 хувь, сумдын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийн бэлтгэл 72.0 хувиар тус тус хангагдсан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	162		2.19.. цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх мэдээг малчид, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд цаг алдалгүй, шуурхай хүргэх арга хэмжээ авч ажиллахыг Цаг уур, орчны шинжилгээний газар (Э.Баттулга), аймгийн Засаг дарга нарт.	"Булган аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв 2025 онд иргэд, байгууллагуудад цаг агаарын мэдээ, сэрэмжлүүлгийг тогтмол хүргэж ажиллав. Тухайлбал: Анхааруулга мэдээ 43 удаа, сэрэмжлүүлэг мэдээ 10 удаа, урьдчилан сэргийлэх мэдээ 3 удаа, нийт 72 удаагийн мэдээг 12–72 цагийн өмнө гаргаж, цаг тухайд нь багц мессежээр 66 байгууллага, 45218 хэрэглэгчдэд, нийт 229138 мэдээ хүргэв. Мөн www.bulgan.weather.gov.mn сайт болон "Булган аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв" фэйсбүүк хуудсаар шинэчилсэн мэдээг тогтмол байршуулж, аймаг, сумын удирдлагуудад өгсөн. "Булган аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв"-ийн цахим хуудсаар сард дунджаар 180,000–270,000 хэрэглэгч мэдээлэл авч, өөрийн ажил, аж ахуйдаа ашиглаж байна. Мөн утсаар холбогдсон иргэд, аж ахуйн нэгжид хүссэн цаг агаарын мэдээ, мэдээлэл болон зөвлөмж өгч үйлчиллээ. Сэрэмжлүүлэг мэдээний таарц 100 хувь, онц 100 хувь, илрүүлсэн байдал 100 хувьтай, дундаж таарц 100 хувьтай байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.7 хувиар ахиулж, цаг агаарын гаралтай аюултай болон гамшигт үзэгдлээс эртнээс сэрэмжлүүлэх үүргээ цаг тухайд нь биелүүлсэн.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	163		3.. Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, хүндрэл багатай даван туулахад шаардлагатай санхүүжилтийг батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Орон нутгийн төсвийн 150 сая төгрөгийн хөрөнгөөр аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг 77.3 хувьтай бэлтгэсэн.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
103	164	Хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай 2025-08-27 Дугаар 2025_64	1.. Хичээлийн шинэ жилийн бэлтгэл хангах зорилтын хүрээнд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр барьж шинээр ашиглалтад оруулсан хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиудад шаардлагатай тавилга, тоногтөхөөрөмж нийлүүлэх ажлыг 2025 онд батлагдсан төсөвтөө багтаан, өр үүсгэхгүй, холбогдох хууль, журамд нийцүүлэн, санхүүгийн гэрээ байгуулах замаар зохион байгуулахыг Боловсролын сайд П.Наранбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	2025 онд улсын төсвөөс 33,963.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 сургуулийн барилга, 3 цэцэрлэг, 2 дотуур байрны ажил хийгдэж байна. Тухайлбал: Сайхан, Баян-Агт, Баяннуур сумын 3 сургуулийн барилгын ажил хийгдэж байна. Булган сумын тусгай хэрэгцээт хүүхдийн яслийн барилга, Рашаант сумын 75 ортой цэцэрлэгийн өргөтгөл, Хутаг-Өндөр сумын дотуур байр ашиглалтад орсон. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 163.6 сая төгрөгийн 19 ширхэг зөөврийн компьютер, 8 ширхэг смарт телевизор, 6 ширхэг ухаалаг дэлгэц, 1 иж бүрэн физикийн кабинет, 2 биеийн тамирын хичээлийн багцыг ерөнхий боловсролын сургуульд хуваарилсан байна. Сум орон нутгийн төсвөөс нийт 677.2 сая төгрөгөөр сургууль цэцэрлэгийн иж бүрэн камер, дроз, дуу хөгжмийн тоног төхөөрөмж, бага ангийн цахим кабинет, ухаалаг самбар, системийн хэрэглэгдэхүүнээр хангасан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
104	165	Улсын хэмжээнд 2025 онд эзэмшүүлэх, ашиглуулах зарим газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай 2025-09-02 Дугаар 2025_74	3. Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн мэдээллийг бүрдүүлэх, газар эзэмших, ашиглах хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг шуурхай шийдвэрлэх хүрээнд Газрын тухай, Чөлөөт бүсийн тухай, Усны тухай, Ойн тухай, Төмөр замын тээврийн тухай, Авто замын тухай, Харилцаа холбооны тухай, Эрчим хүчний тухай болон холбогдох бусад хуульд заасан байгаль орчин, уул уурхай, зам тээвэр, харилцаа холбоо, эрчим хүчний салбарын орон зайн өгөгдөл мэдээлэл бүхий мэдээллийн санг газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системтэй бүрэн холбож дуусгах, газар ашиглалтын мэдээллийг тухай бүр зураглаж, нэгтгүүлэх ажлыг шуурхай зохион байгуулж, хэрэгжүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүс, хотын захирагч нарт тус тус даалгасугай.	Булган аймгийн хэмжээнд Засгийн газрын 2025 оны 119, 120, 06, 74 дүгээр тогтоолын дагуу нийт 600 нэгж талбар газраас, 457 нэгж талбар газрыг иргэн, хуулийн этгээдэд өмчлүүлж, эзэмшүүлснээр төлөвлөгөөний хэрэгжилтийг 76.2 хувиар хангаж ажилласан байна. Иргэн, хуулийн этгээдэд газар өмчлүүлж, эзэмшүүлсэн мэдээллийг тухай бүрд нь газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн системд бүртгэж, хянан баталгаажуулав. Дээрх хууль тогтоомжид заасан байгаль орчин, уул уурхай, зам тээвэр, харилцаа холбоо, эрчим хүчний хамгаалалтын бүс, зурвас газрыг Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд бүрэн бүртгэж, мэдээллийн санг шинэчлэн ажилласан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

105	166	Зорилт шинэчлэн батлах тухай 2025-09-10 Дугаар 2025_91	3. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, дасан зохицох салбар тус бүрийн зорилтыг эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Хялганат тосгонд шахмал түлшний үйлдвэр байгуулагдан Орхон, Булган, Хангал, Хялганат тосгонд 24 тн үртсэн шахмал түлшийг нийлүүлэн, иргэдийн хэрэгцээг хангаж нүүрсний хэрэглээг бууруулсан. Аймгийн хэмжээнд 2025 онд айл өрхүүд 85691 ширхэг мод, бут тарьж, ойжуулалт нөхөн сэргээлтийн чиглэлээр 498670 ширхэг мод, цөлжилт газрын доройтлыг бууруулах зорилгоор хамгаалалтын зурвас, ойн зурвасын ажилд 34948 ширхэг мод тарьж, нийт аймгийн хэмжээнд 619309 ширхэг мод бут тарьж, ойжуулалт хийн, хүлэмжийн хийн шингээлтийг нэмэгдүүлж байна. Булган сумын зарим айл өрх болон 10 суманд нийтийн дулааны уурын зуухтай болж түлээ болон нүүрс түлэх яндангийн тоо буураад байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
106	167	Эрүүл мэндийн даатгалын сангийн үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-11-05 Дугаар 2025_151	5. 5.Төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засварын зардлыг хуульд заасны дагуу хариуцан санхүүжүүлэхийг Батлан хамгаалахын сайд Д.Батлут, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Орон нутгийн төсвийн 1927.0 сая төгрөгийн санхүүжилтээр эрүүл мэндийн байгууллагуудын 7 барилга байгууламжид засвар үйлчилгээг хийж, ашиглалтад бүрэн хүлээн авсан. Мөн эрүүл мэндийн 19 байгууллагын 33 түргэн тусламжийн автомашин хэвийн ашиглагдаж байгаа бөгөөд засвар үйлчилгээний зардалд урсгал төсвийн санхүүжилтээр 34.0 сая төгрөгийг зарцуулаа.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
107	168	2027 оныг “Эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарлах тухай 2025-11-05 Дугаар 2025_154	4. Эрүүл мэндийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй.	Х.Б	Х.Б		Үгүй	
Ерөнхий сайдын захирамж									
108	169	Үндэсний хороо байгуулах тухай /Хүчирхийллийн эсрэг үндэсний хороо/ 2025-07-30 Дугаар 1	2. Хүчирхийллийн эсрэг үндэсний хорооны Ажлын албаны чиг үүргийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаар хариуцуулан гүйцэтгүүлэх арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Л.Мөнхбаатарт, бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. 3.Хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, хамтарч ажиллахыг иргэд, олон нийт, хэвлэл мэдээллийн байгууллагуудад уриалсугай.	Сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран 165 иргэнд “Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт”, “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-аар мэдээлэл өгч, “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх”, “Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт”, “Хүүхдийн эрх хамгаалал, гэмт хэрэг, зөрчлийн товч ойлголт, урьдчилан сэргийлэх” зэрэг сэдвээр 7 удаагийн сургалт, мэдээлэл хийж, ерөнхий боловсролын 4 сургуулийн 235, политехникийн коллежийн 75 оюутан, Баяннуур, Хутаг-Өндөр сумын 135 хүүхэд, нийт 445 хүүхдийг хамруулав. Аймгийн хэмжээнд 2025 онд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр “Харилцан хүндэтгэе”, “Гэртээ эрт харья”, “Миний хүүхэд-Монголын Ирээдүй”, “Тандалт”, “Хайрлая-Анзаарья” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулсан. Гэр бүлийн боловсрол олгох 8 модуль сургалт, 67 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээнд 6841, “Гэр бүлийн өдөр” нөлөөллийн ажилд 3452, Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх аянд 3714 иргэн, нийт 14007 иргэнийг хамруулсан. 2025 онд аймгийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн тоо 23 буюу өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5 нэгжээр /17.8%/ буурсан. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нөлөөллийн ажилд 3.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс зарцуулсан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

109	170	Нийгэмд шударга ёсыг бэхжүүлэх, авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2025-08-13 Дугаар 2025_64	5.. Авлигатай тэмцэх хүсэл зориг, хүчин чармайлтыг манлайлж, ил тод байдлыг бэхжүүлэн, бүх түвшинд шударга ёсыг эрхэмлэж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллахыг Засгийн газрын гишүүд, яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, нийт төрийн албан хаагчдад үүрэг болгосугай.	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Эрүүгийн хуулиар 696 төрийн албан хаагчид сургалт зохион байгуулсан. "Булганы өнгө" төрийн бус байгууллагатай хамтран иргэдийн төрийн үйлчилгээний чанар хүртээмжид итгэх итгэл, авлигын тухай ойлголт өгөх зорилгоор эрүүл мэндийн салбарын асуудлыг хөндсөн видео контент бэлтгэн олон нийтэд түгээж, 266 хүн үзэж сонирхсон байна. Мөн 2 удаагийн өдөрлөг зохион байгуулж, гарын авлага тараасан. Авлигагүй төрийн алба уриан дор төрийн байгууллагуудын дунд "Авлигын эсрэг нэгдье" видео уралдааныг зохион байгуулж, уралдаанд Улсын бүртгэлийн хэлтэс, Стандарт хэмжил зүйн хэлтэс шагналт байруудад шалгарлаа. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, "Гэрэлт ирээдүй оршихуй" төрийн бус байгууллагатай хамтран Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдалд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх ажлыг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс 12 дугаар сарын 20-ны өдрүүдэд зохион байгуулж, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төсвийн тухай хуульд заасан олон нийтийн оролцоог хангах, олон нийтийг хяналт тавих боломжоор хангасан эсэхэд мониторинг, дүн шинжилгээ хийж, санал боловсруулах ажлыг хэрэгжүүлээ. Энэ онд авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдсон иргэн, хуулийн этгээд бүртгэгдээгүй байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл									
110	171	2021 оны 6 дугаар сарын 8-ны өдөр 34 дүгээр тэмдэглэл 2021-06-08 Дугаар 2021_34	ҮИИ.5.2 . Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хамгаалж, холбогдох хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хангуулах, хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлийг Аймгийн Засаг даргын 2025 оны А/150 дугаар захирамжаар шинэчлэн байгуулсан. 2025 онд салбар зөвлөлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр 30.0 сая төгрөг батлуулан 28.9 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэдээллийг хүртээмжтэй, саадгүй хүргэх ажлын хүрээнд Сайхан Монгол телевизтэй хамтран Нийгмийн халамжийн тухай хуулийн өөрчлөлт, хөдөлмөр эрхлэлтийн талаар дохионы хэлний орчуулга бүхий нэвтрүүлгийг бэлтгэн орон нутгийн телевиз, байгууллагын цахим хуудсаар дамжуулан иргэдэд мэдээллийг хүргэсэн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжтэй орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор "Тусламжийн хонх" арга хэмжээг аймгийн хэмжээнд өрнүүлж, иргэдэд үйлчилгээ үзүүлэх 44 аж ахуйн нэгж байгууллага арга хэмжээнд нэгдэж, хэрэгжүүлэв. Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангуулах үзлэгийг зохион байгуулж, 11 сумын 47 байгууллага хамрагдсан. Үзлэгээр ХБИ-ний цалингийн дундаж 1.1 сая төгрөг байгаа нь одоо мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс 41 хувиар илүү байна. Барилга байгууламжийн хүртээмжийн байдлын хувьд ХБИ-нд зориулсан налуу замтай 25, шатны баруултай 2, брайл хаягтай 13 /эрүүл мэндийн төвүүд/, ариун цэврийн өрөөг тохирох хэрэглэгдэхүүнээр хангасан 29, машины зогсоолыг тусгайлан тэмдэглэсэн 13 байгууллага байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангуулж ажиллах талаар 47 байгууллагад зөвлөмж хүргүүлж 5.8 сая төгрөгийн нөхөн төлбөрийн акт тогтоосон. Тус онд 25 ба түүнээс дээш ажилтантай хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллаж байгаа 2	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

111	172	2021 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2021-11-03 Дугаар 2021_58	ХII.6.8. Дээр дурдсан арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тооцож, улс, орон нутгийн жил бүрийн төсвийн төсөлд тусгах, гадаадын зээл тусламж, төсөл хөтөлбөрт хамруулах арга хэмжээ авахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав.	Аймгийн Засаг даргын 2025 оны А/349 дүгээр захирамжийн дагуу 2025 оны 05 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд аймгийн "Аюулгүй гамшигт тэсвэртэй чадавхыг бий болгох нь" санаачилгын дагуу Монгол Улсад хэрэгжүүлж буй "Гамшгийг тэсвэрлэх чадавхын үнэлгээ"-г хийх ажлын хэсгийг 22 хүний бүрэлдэхүүнтэй томилгоожуулан үнэлгээг хийж ажилласан. Ашиглалтын шаардлага хангахгүй дүгнэлттэй Булган сумын 6-р цэцэрлэгийн барилгыг дахин төлөвлөж, 150 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн зураг төслийг 2024 онд хүлээлгэж, шинэ барилгын санхүүжилтийг 2026 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөвт тусгуулахаар санал хүргүүлсэн. Тэшиг сумын 320 хүүхдийн сургуулийн барилгын зургийн даалгавар боловсруулж, холбогдох газруудад хүргүүлсэн. Хишиг-Өндөр сумын цэцэрлэгийн барилгын зураг төсөл хийлгэх төндөр шалгаруулалт хийгдэж, зураг төсөл хийгдэж байна. Өмнө хийгдсэн паспортжуулах ажлын хүрээнд ашиглалтын шаардлага хангахгүй гэж дүгнэсэн Булган сумын 280 хүүхдийн хүчин чадалтай 4 дүгээр цэцэрлэг, сувиллын ясли, Төв номын сангийн барилгуудыг дахин төлөвлөж, улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгагдаж 2024-2025 онд ашиглалтад орсон. Аймгийн хэмжээнд 16 сум, 1 тосгонд байршилтай 16, Булган сумын төвд байрлах 3, нийт 19 дуут дохиоллын хэрэгслийн дэлгэрэнгүй судалгаа гарган тодотголоо. Нийт 22 сургууль, 22 цэцэрлэгийн байрыг иргэдийг нүүлгэн шилжүүлэх байраар томилгоожуулж, "Гамшгийн үеийн бэлэн байдлын төлөвлөгөө"-нд тусган батлуулсан. Гамшгаас хамгаалах ирж бүрэн сургуулийг 2025 оны 09 дүгээр сард аймгийн хэмжээнд зохион байгуулж, "Хангалттай" үнэлгээ авсан. Тус иж бүрэн сургуулийг зохион байгуулах нөөц материал хэрэгслийн	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
112	173	2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_28	XX.7. . Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов.	Тоон гарын үсэг олголтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд улсын бүртгэлийн байгууллагын зөвөрийн төхөөрөмжийг ашиглан ХААИС-ийн харьяа Политехникийн коллежийн 12 оюутан, "Булган Мээж" ХХК-ны 7 албан хаагч, Хялганат тосгон,Хутаг-Өндөр, Орхон сумын 57, нийт 76 иргэнд тус тус тоон гарын үсэг олгож, Улсын бүртгэлийн хэлтэс дээр ирж 720 иргэн тоон гарын үсэг авснаар 2025 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 37262 иргэн тоон гарын үсэгтэй болсон.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

113	174	2022 оны 8 дугаар сарын 3-ны өдөр 39 дүгээр тэмдэглэл 2022-08-03 Дугаар 2022_39	ХҮИИ.3.1.4. "Шинэ сэргэлтийн бодлого"-д тусгагдсан хөгжлийн төслүүдийн бүтээн байгуулалтын ажилд бүх талын дэмжлэг үзүүлж, газрын асуудал болон эрх хэмжээний хүрээнд хамаарах тусгай зөвшөөрөл олгох, төлбөр, хураамж авах, хэлцэл хийхтэй холбоотой асуудлыг тухай бүр шуурхай шийдвэрлэж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	"Шинэ сэргэлтийн бодлого"-ын зорилтын хүрээнд Хишиг-Өндөр сумын шинэ суурьшлын бүсэд цахилгаан дамжуулах агаарын шугамын, мөн Хишиг-Өндөр, Рашаант сумдын дэд станцын зориулалтаар тус бүр 2 нэгж талбар, хөдөө аж ахуйн цогцолборын зориулалтаар 4 нэгж талбарын 3.85 га газрыг эзэмшүүлсэн байна. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны XI/81 дүгээр тогтоолоор орон нутгийн зэрэглэлтэй Булган хотын эдэлбэр газрын саналыг уламжилсан тогтоолыг гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлсэн. Мөн газрын үйлчилгээний киоск төхөөрөмжийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр худалдан авч, иргэдэд газрын үйлчилгээ үзүүлэн хэвийн үйл ажиллагаа явуулж байна. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьц, суулгачын нөөцийг бүрдүүлэх, иргэн, аж ахуй нэгжүүдийг тарьц суулгацаар тогтвортой хангах зорилгоор сум дундын ойн ангиуд үрийн талбайн арчилгаа, хамгаалалтын ажлыг Хутаг-Өндөр, Орхон, Хангал сумдын нутагт гүйцэтгэлээ. Байгаль, цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалан шилмүүст болон навчит модны үрийн чанар, үр өгөх хугацаанд гарч буй хүндрэлтэй холбоотойгоор үрийн талбайд арчилгаа, хамгаалалт, бордоо хийх зэрэг арга хэмжээг авч, үрийн гарцыг хэвийн түвшинд барих нөхцөлийг бүрдүүлэв. Мөн Булган, Хялганат сум дундын ойн ангиуд ойн арчилгааны огтлолын ажлыг Орхон, Хангал, Бугат сумдын нутагт нийт 70 га талбайд хийж гүйцэтгэсэн байна. Хутаг-Өндөр, Сайхан, Орхон, Бугат, Баян-Агт сумдын нутагт "Ойн таксаци" ХХК, "Гранд форест" ХХК, "Сайхан ойн төлөө" ХХК нар хамтран 15000 га талбайд ойн хөнөөлт шавжийн эсрэг тэмцлийн ажил гүйцэтгэсэн. Уг ажлын үр дүнд аймгийн ойн сангийн нийт талбайн 0.7 хувийг хамгааралт авч, ой, экосистемийн тэнцвэрт байллыг	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
114	175	2022 оны 8 дугаар сарын 24-ний өдөр 42 дугаар тэмдэглэл 2022-08-24 Дугаар 2022_42	ХҮ.3. . Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааны явцын талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэхийг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод, уг үйл ажиллагаанд салбарын болон төрийн бүх шатны байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг хамруулах, энэ чиглэлд салбарын болон нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг уриалах ажлыг зохион байгуулж зохих арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав.	Эрүүл Булган" хөтөлбөрийг боловсруулан Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн VI/32 дугаар тогтоолоор батлуулан, орон нутгийн төсвөөс 78.7 сая төгрөгийг хөрөнгө оруулалт хийж, хэрэгжүүлээ. Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг, нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийг 9 төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоотой хамтран 15 сум, 1 тосгон, Булган сумын төвд зохион байгуулж, зорилтот бүлгийн иргэдийн 50.5 хувийг хамруулсан. "Хавдрын өвчлөлийг бууруулахад таны, миний оролцоо" сэдвээр төрийн болон төрийн бус 6 байгууллагын 136 иргэнд, эрүүл мэндийн 9 байгууллагын 63 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулж, эрт илрүүлэг үзлэг оношилгоонд 100 хувь хамруулсан байна. Элэгний В вирусийн эсрэг сайн дурын дархлаажуулалтыг эрчимжүүлэн нийт 3989 иргэнийг дархлаажуулсан. Аймгийн Засаг даргын нэрэмжит нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг Баян-Агт, Бугат, Сайхан, Сэлэнгэ, Тэшиг, Хутаг-Өндөр, Баяннуур, Гурванбулаг, Дашинчилэн, Рашаант зэрэг 10 суманд 7 чиглэлээр зохион байгуулагдсан. Нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт дотор 470, сүрьеэ 502, рентген 382, халдварт 37, мэдрэл 227, эмэгтэйчүүд 271, шүд урьдчилан сэргийлэх үзлэгт 900, С, В вирус илрүүлэг шинжилгээ 58, В вирусын дархлаажуулалт 14, ДОХ тэмбүү 24 хүнд үзлэг хийж, нийт 2885 иргэнийг хамруулж, зөвлөгөө өгч, сургалт, мэдээлэл хийж ажилласан байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	Монгол улсын Засгийн газрын 2023.03.07-ны өдрийн 2023_11 дүгээр хурлын тэмдэглэлээр дахин шийдвэр гарсан.
115	176	2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр 54 дүгээр тэмдэглэл 2022-11-09 Дугаар 2022_54	Х.12.2. "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 10 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлж төрийн өмчийн бүх шатны боловсролын сургалтын байгууллагын болон шинжлэх ухааны байгууллагын газар эзэмших, ашиглах эрхийг батлагдсан аргачлалын дагуу үнэлүүлэх талаар шаардлагатай арга хэмжээг авч, дүнг танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.	Сургууль, цэцэрлэгийн эдэлбэр, эзэмшил газарт зориулалтын бус барилга байгууламж барих, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохгүй, ашиглуулахгүй байх шаардлагыг хэрэгжүүлэн ажиллаж, газар эзэмших, ашиглах эрхийг батлагдсан аргачлалын дагуу үнэлүүлж, газрын удирдлагын цахим систем (egazgov.gov.mn)-д баталгаажуулсан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	Шийдвэрт заасан хугацаанд бүрэн хэрэгжүүлж дууссан.

116	177	2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2022-12-07 Дугаар 2022_58	XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов;	Булган аймгийн хэмжээнд ERP системийг ашиглан сум, байгууллагууд албан бичиг солилцон ажиллаж байна. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн XI/82 дугаар тогтоолоор төрийн үйл ажиллагааны хурд, бүтээмжийг нэмэгдүүлэх "Цахим Булган" хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд Орхон аймагтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний дагуу олгогдсон 100 сая төгрөгийн санхүүжилтээр "И-Оффис" программ хангамжийг нэвтрүүлэх ажлыг "Анар Системс" компаниар гүйцэтгүүлсэн. Дотоод удирдлагын нэгдсэн систем И-Оффис программын танилцуулга, заавар, зөвлөгөөг 2025 оны 12 дугаар сарын 22-25-ны өдрүүдэд хуваарийн дагуу бүх төрийн байгууллагын албан хаагчдад зохион байгуулсан	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
117	178	2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр 4 дүгээр тэмдэглэл 2023-01-18 Дугаар 2023_4	VIII.2.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд орон нутгийн өмчит байгууллагаас татан төвлөрүүлсэн автомашиныг цаашид зайлшгүй шаардлагатай байгаа орон нутгийн өмчит хуулийн этгээдэд шилжүүлэх, худалдах, актлах ажлыг зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нар.	Орон нутгийн өмчит байгууллагын 12 тээврийн хэрэгслийг 6 удаагийн нээлттэй дуудлага худалдаагаар худалдан борлуулж, аймгийн хөрөнгө борлуулсны орлогын дансанд 104.5 сая төгрөг төвлөрүүлээ. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 815 дугаар тогтоолоор Улсын драмын эрдмийн театр бүртгэлтэй 24.9 сая төгрөгийн үнэтэй Хьондай Старекс автомашин, 2024 оны 711 дүгээр тогтоолоор "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 41.3 сая төгрөгийн ЗИЛ-131 тээврийн хэрэгсэл, 2025 оны 498 дугаар тогтоолоор Булган аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 33.0 сая төгрөгийн Тобота ланд круйзер 76 тээврийн хэрэгсэл, нийт 3 тээврийн хэрэгслийг Булган аймгийн Орон нутгийн өмчийн газрын данс бүртгэлд шилжүүлэн бүртгэж авлаа. Аймгийн ХХААГ, ОБГ, ШШГГ, Авто тээврийн үндэсний төв зэрэг байгууллагуудад нийт 4 тээврийн хэрэгслийг ашиглалтын гэрээгээр ашиглуулж байна. Дуудлага худалдаагаар худалдан борлуулах 5 тээврийн хэрэгсэл, хоёрдогч түүхий эд болгон худалдан борлуулах 1 тээврийн хэрэгсэл, үнэ бууруулж худалдан борлуулах 4 тээврийн хэрэгсэл, шилжүүлэхээр 1 тээврийн хэрэгсэл, нийт 11 тээврийн хэрэгслийг аймгийн ИТХуралдаанаар шийдвэр гаргуулахаар хүргүүлээд байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
118	179	2023 оны 2 дугаар сарын 1-ний өдөр 6 дугаар тэмдэглэл 2023-02-01 Дугаар 2023_6	XIV.1.3. Төрийн байгууллагууд болон зөвлөх үйлчилгээний захиалгаар хийлгэсэн судалгааны ажлын тайланг судалгааны нэгдсэн сангийн системд байршуулах, хянах, засварлах, хэрэглэгчийн саналыг хүлээн авах ажлыг холбогдох албан тушаалтанд хариуцуулж ажиллуулахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, төрийн болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын удирдлагад;	Судалгааны ажил хийгдээгүй.	Х.Б	Х.Б		Үгүй	
119	180	2023 оны 3 дугаар сарын 1-ний өдөр 10 дугаар тэмдэглэл 2023-03-01 Дугаар 2023_10	XVI.4.2. Мал, амьтны гоц халдварт шүлхий, бог малын мялзан өвчний дэгдэлтийг таслан зогсоох мал эмнэлгийн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нар.	Энэ онд мал, амьтны 11 төрлийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1.4 сая мал, амьтан хамруулахаар төлөвлөгөө, хуваарийг Аймгийн Засаг даргын А/164 дугаар захирамжийг батлуулан, хэрэгжүүлсэн. Сумдаас ирүүлсэн захиалга, Улсын мал эмнэлгийн ерөнхий газрын хуваарийн дагуу эм биобалдмэлийг хуваарилан өгч, тархвар зүйч эмч нар цахим системд төлөвлөлтийг оруулж, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нар урьдчилан сэргийлэх арга хэмжээний гүйцэтгэлийг тайлагнасан. Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд 11 төрлийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1,409.8 мянган толгой мал хамруулаад байна. Турк улсад 2024 оны 6-р сарын 4-ний өдөр үйлдвэрлэсэн 05.LSD-N/24 серийн дугаартай 75.8 мянган тун вакциныг хүлээн авч, Сэлэнгэ, Тэшиг сумдад хуваарилан олгож, дархлаажуулалтын ажлыг зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд 6 мал эмнэлэг үйлчилгээний нэгж ажиллаж, 896 өрхийн 64.782 толгой үхэр дархлаажуулж 418 тун вакцин хэвийн хорогдолд гарч, 10.6 мянган тун вакцины үлдэгдэлтэй байна. Энэ онд малын гоц халдварт өвчин гараагүй байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

Хавсралт - 1 файл

120	181	2023 оны 3 дугаар сарын 07-ний өдөр 11 дүгээр тэмдэглэл 2023-03-07 Дугаар 2023_11	XII.5. Жөндэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон салбарын бодлого, стратегийн төлөвлөгөө, Жөндэрийн үндэсний хорооны 2023 оны ээлжит хуралдаанаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллахыг Засгийн газрын гишүүд, яамдын жөндэрийн салбар зөвлөл, орон нутгийн салбар хорооны дарга, Жөндэрийн үндэсний хорооны гишүүдэд тус тус даалгав.	Орон нутгийн түвшин дэх нийгмийн бүх харилцаанд жөндэрийн тэгш байдлыг хангах хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр 4 зорилтын хүрээнд 24 ажлыг төлөвлөн 97.0 хувьтай гүйцэтгэсэн. Тухайлбал: Жөндэрийн эрх тэгш байдлыг бий болгох, жөндөрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр 2025 онд 4 нөлөөллийн үйл ажиллагаа, 5 сургалт байгуулж нийт 3714 хүнийг хамруулсан байна. Өсвөр үеийнхний жөндэрийн мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагааг 16 сумын сургууль, дотуур байрны орчинд зохион байгуулж 2687 хүүхэд хамрагдсан. Жөндөрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх олон нийтэд чиглэсэн аянд 1027 насанд хүрэгчийг хамруулсан. 100 аав нөлөөллийн арга хэмжээнд төрийн болон тусгай хүчин, хувийн хэвшлийн байгууллагын албан хаагчид, малчин зэрэг 100 аав урилгаар оролцуулж "Сайн аав", "Гэр бүл юун дээр тогтдог вэ?" "Эр хүн гэж хэн бэ?" зэрэг сэдвээр яриа хэлэлцүүлэг өрнүүлж эрчүүдийн үүрэг оролцоо, нөлөөллийг нэмэгдүүлэх санал санаачилга гаргасан. Дээрх ажлуудын үр дүнд иргэд олон нийтэд жөндэрийн эрх тэгш байдлын талаарх ойлголт мэдэгдэхүүн өгч ажиллан орон нутгийн төсвөөс 6.5 сая төгрөгийг зарцуулаад байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	182		XII.2.1. Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдалтын явц, амны хөндийн эрүүл мэндийн өнөөгийн байдлын талаар Эрүүл мэндийн сайд С.Чинзориг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1.Хүн амыг эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэх, аймаг, нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийг дэмжих төвүүдийг ходоодны уян дурангийн аппаратаар нэмэлтээр хангахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгт аймгийн нэгдсэн эмнэлгийн дэмжих төвөөр 1111 иргэн, явуулын баг буюу нарийн мэргэжлийн эмчийн үзлэг оношилгоонд 2885 иргэн, нийт 3996 иргэнийг хамруулсан. Ингэснээр зорилтот насны хүн амын 50.5 хувийг үзлэгт хамрууллаа. Аймгийн хэмжээнд ажлын байранд суурилсан эрт илрүүлэг үзлэгт 38 байгууллагын 964 төрийн болон төрийн өмчит байгууллагын ажилтан албан хаагчид хамрагдсан байна. Хавдрын эрт илрүүлэг үзлэгт 6 байрлалын хавдрын зорилтод насны иргэдийн 15628 буюу 28.2 хувь хамрагдсан. Эдгээр илрүүлэг үзлэгүүдийн дүнгээр аймгийн хэмжээнд эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт 50.5 хувьд хүрч, өмнөх оноос 7.3 хувиар өссөн байна. Шүдний кабинетын үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийн байгууллагууд нийт 5700 хүүхдийн шүдийг эмчлэн эрүүлжүүлсэн байна. Хувийн хэвшлийн шүдний 3 эмнэлэг нүүр амны тусламж үйлчилгээг үзүүлэн, сургуульд суурилсан 6 настуудын нүд, шүд, зүрхний эмгэгийг эрт илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэгт 1057 хүүхдээс 1055 буюу 99.81 хувь нь хамрагдсан. Нүүр амны тусламж үйлчилгээний анхан үзлэг 1577, давтан үзлэг 1050, урьдчилан сэргийлэх үзлэгт 752 хүүхэд хамрагдсанаас 126 хүүхдийг эмчлэн эрүүлжүүлэв.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
121	183	2023 оны 3 дугаар сарын 22-ний өдөр 3 дугаар тэмдэглэл 2023-03-22 Дугаар 2023_13	IV.2. Нийслэл Улаанбаатар хот, аймаг, сумын төв, бусад суурин газрын хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөлт хийгдээгүй байршилд болон иргэн, аж ахуйн нэгжийн эзэмшиж байгаа газар нь улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд өмчлүүлэхээр тусгагдаагүй газарт газар өмчлүүлэх, улсын тусгай хэрэгцээний болон бусдын эзэмшиж, ашиглаж байгаа газартай давхцалтай газарт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахгүй байхыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, чөлөөт бүсийн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж, хэрэгжилтэд газрын нэгдмэл сангийн цахим системээр дамжуулан хяналт тавих, газар олголтыг нээлттэй, ил тод болгох арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт даалгав.	Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн системээр дамжуулан 2025 онд иргэн, хуулийн этгээдэд өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах газрын төлөвлөлтийг ил тод болгож, Засгийн газрын 2025 оны 119 дүгээр тогтоолоор Булган аймгийн хэмжээнд 225 иргэнд 43.38 га газрыг өмчлүүлэхээр тусгагдсанаас, 145 нэгж талбарын 26.25 га газрыг өмчлүүлж, тогтоолын хэрэгжилтийг 64.4 хувиар ханган ажиллав. Төлөвлөлтөд тусгагдсанаас өөр байршилд газар олголт хийгдээгүй байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

122	184	2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр 17 дугаар тэмдэглэл 2023-04-19 Дугаар 2023_17	XIX.2.3. Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн зөрчлийг арилгуулахаар Хүний эрхийн үндэсний комиссын гишүүнээс гаргасан шаардлага, зөвлөмжийг биелүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд болон бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгов	Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 01/05 дугаартай зөвлөмж ирсэн. Ун зөвлөмжийн хүрээнд ажлын хэсэг байгуулан зөвлөмжийн мөрөөр ажиллаж хэрэгжилтийг хүргүүлсэн бөгөөд 2025 онд өөр зөвлөмж ирээгүй байна. Аймгийн Засаг даргын 2025 оны өдрийн А/28 дугаар захирамжаар Хамтарсан ажлын хэсэг байгуулагдсан. Уг ажлын хэсэг нь Эгийн голын усан цахилгаан станц баригдаж буй төсөлтэй холбоотойгоор Хутаг-Өндөр сумын Хантай багийн иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөхөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
123	185	2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр 18 дугаар тэмдэглэл 2023-04-26 Дугаар 2023_18	XIV.7.3. Ой, хээрийн түймэр, болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл, анхааруулгыг олон нийтэд тогтмол хүргэж, бэлэн байдлыг хангуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав.	Монгол Улсын Онцгой комиссын даргын 2025 оны 01 дүгээр тушаал, 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ой, хээрийн гал түймрийн эрсдэлтэй сум, орон нутагтай хамтран урьдчилан сэргийлэх хөдөлгөөнт эргүүлийг томилгоожуулан, малчид, иргэд, тээвэрчдэд өдөр бүр урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг хүргэж ажилласан. Хөдөлгөөнт эргүүлээр аймгийн хэмжээнд 15643 иргэн, 8373 айл өрх, 6259 авто машинд үзлэг хийж заавар зөвлөмж өгч, сэрэмжлүүлэх 13337 хэвлэмэл материалыг хүргэж ажилласан. Аймгийн Онцгой комиссын даргын 2025 оны 06 дугаар тушаалаар 2025 оны 04 дүгээр сард ОБГ-аас ГТУХАБайцаагч, хошууч Х.Чинзоригоор ахлуулсан бүлгийг сумдад ажиллуулж, ой, хээрийн гал түймрийг унтраах бүлэг, дайчилгаагаар ажиллах иргэдийн бэлэн байдлыг хангуулснаар гарсан ой, хээрийн түймрийг 1-3 хоногт бүрэн унтрааж ажилласан. Мөн урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоо өмнөх оноос 11 хувиар өсөж, 21 хувьд хүрсэн. Ой, хээрийн гал түймрийн тоо өмнөх оноос өссөн боловч хохирол 50 хувиар буурсан байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
124	186	2023 оны 5 дугаар сарын 17-ны өдөр 21 дүгээр тэмдэглэл 2023-05-17 Дугаар 2023_21	XVIII.2.3. Монгол Улсын хөгжлийн бодлого, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хүний хөгжил, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд эерэг үр нөлөөтэй байхад чиглүүлэн бодитой, үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.	Булган аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050", дунд хугацааны "Шинэ сэргэлтийн бодлого" зорилтот хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон бусад бодлогын баримт бичгийг үндэслэн боловсрууллаа. Хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааг Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан тодорхойллоо. Мөн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны сонгуульд оролцсон Монгол Ардын нам, Ардчилсан намын мөрийн хөтөлбөр, төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд, иргэд, олон нийтийн саналд үндэслэсэн болно. Тухайлбал, аймгийн 16 сум, 1 тосгон, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 24 агентлагаас саналыг нэгтгэн авч нийгмийн салбарын болон Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн харьяа агентлаг, байгууллага бизнес эрхлэгчдтэй хийсэн уулзалт хэлэлцүүлэгт оролцогчдоос 114 санал, цахим хуудас, нээлттэй утсаар 74 санал, аймаг, сумын ИТХ, түүний төлөөлөгчид, Засаг даргын Тамгын газар, төрийн байгууллагуудаас 499 санал, иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагуудаас 18 санал, нийт 705 санал ирүүлснийг хөтөлбөрийн төсөлдөө тусгасан. Хөтөлбөрийн зорилгыг "Булган аймгийн сэргэлт нь ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ бий болгож, ҮЙЛЧИЛГЭЭГ сайжруулан, бизнесийн таатай орчныг бүрдүүлж, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛСЭН, иргэд нутагаа ая тухтай, амар тайван, аз жаргалтай амьдрах"-д оршино гэж тодорхойлон хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

125	187	2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 23 дугаар тэмдэглэл 2023-05-31 Дугаар 2023_23	XXII.2.. "Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай" Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгов: 1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудаст, шаардлагатай мэдээллийг нэгдсэн систем (shilen.gov.mn)-д байршуулж, тухай бүр шинэчилж ажиллах; 2.Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д мэдээллийг шууд холбох боломжтой байдлаар өөрийн байгууллагын системийн бэлэн байдлыг хангах; 3.Мэдээллийн сан, системийн хэвийн үйл ажиллагаа болон мэдээллийн үнэн зөв, алдаагүй байдлыг бүрэн хариуцах.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд байнга ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллийг аймгийн цахим хуудас (www.bulgan.gov.mn)-д тогтмол байршуулан ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 159 байгууллагыг mlapage.gov.mn, shilen.gov.mn цахим системд бүртгэсэн. Тайлант онд 103 байгууллага 86 төрлийн мэдээ мэдээллийн баяжуулалт хийж, холбогдох хуулийн дагуу мэдээ мэдээллийг https://shilen.gov.mn/ сайтад байршуулсан. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 4-р улирлын хэрэгжилт 98.0 хувьтай дүгнэгдсэн. Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д мэдээллийг шууд холбох боломжийг бүрдүүлэн төрийн цахим шилжилт үйлчилгээний хэлсээс холболт хийж, бүх байгууллагыг системд бүрэн холбосон. Мэдээллийн сангийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, 3 дугаар улирлын байдлаар 40 байгууллага цахим системд мэдээлэл байршуулж байсныг 4 дүгээр улирлын байдлаар 103 болгож нэмэгдүүлэв.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
126	188	2023 оны 6 дугаар сарын 14-ний өдөр 25 дугаар тэмдэглэл 2023-06-14 Дугаар 2023_25	XIII.5.2. 2. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг ард иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг аймаг, дүүргүүдэд зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт,	Алсын хараа 2050 бодлогын хүрээнд аймгийн хэмжээнд 2023 оны 3 дугаар сарын 2-ноос 5-ны өдрүүдэд бодлогын баримт бичгийн талаар танхимын сургалтыг нийт 221 төрийн албан хаагчдад, 03 дугаар сарын 02-оос 05 дугаар сарын 03-ны өдрийг хүртэл аймгийн 1048 төрийн албан хаагчдад цахимаар зохион байгуулж, сертификат олгосон.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	Хэрэгжиж дууссан.
	189		XIII.10.. "Цахим аймаг" бодлогын зөвлөмжийн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан "Цахим аймаг" бодлогын зөвлөмжийг аймаг, нийслэл, сум, дүүрэгт хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад, бодлогын дэмжлэг үзүүлж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт тус тус даалгав.	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн XI/82 дугаар тогтоолоор төрийн үйл ажиллагааны хурд, бүтээмжийг нэмэгдүүлэх "Цахим Булган" хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд Орхон аймагтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний дагуу олгогдсон 100 сая төгрөгийн санхүүжилтээр "И-Оффис" программ хангамжийг "Анар Системс" компаниар гүйцэтгүүлж, аймгийн төрийн байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр ажиллаж байна. Кибер халдлагын эрсдэлийг бууруулах, цахим орчны зөв хэрэглээг төлөвшүүлэх зорилгоор "Булганчууд залуулахгүй", "Цахим орчны зөв, боловсон хэрэглээ" сэдвийн хүрээнд төр, төсвийн байгууллагын мэдээлэл технологийн ажилтан болон мэдээлэл зүйн багш нарын давхардсан тоогоор 100 хүн хамрагдсан сургалтуудыг зохион байгууллаа. ХҮР, E-Mongolia системээр нэг болон олон шатлалт төрийн үйлчилгээг 18368 иргэдэд үзүүлж, 9119 лавлагаа, тодорхойлолт олгож ажиллалаа. Энэ нь аймгийн нийт иргэдийн 30.4 хувьд хүрсэн үзүүлэлт юм. Үйлчилгээг аймгийн төвд байрлах 6 киоск, 16 сум, 1 тосгонд байрлах 23 "ХҮРДАН" киоск, 11 сумын 24/7 цахим үйлчилгээний төвүүдээр дамжуулан үзүүлсэн. Аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсээс бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалт болон стандартын мэдээлэл, лавлагааны үйлчилгээг cert.masm.gov.mn, estandard.gov.mn системээр дамжуулан цахимд бүрэн шилжүүлснээр Булган аймагт үзүүлж буй цахим үйлчилгээний төрөл 63 болж нэмэгдсэн. "Цахим Булган" хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 2025 онд 14 арга хэмжээ төлөвлөн 60.0 сая төгрөг багтуулснаас төлөвлөгөөний хэрэгжилт 95 хувьтай төсвийн гүйцэтгэл 100 хувьтай	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

127	190	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 12 дугаар тэмдэглэл 2024-03-27 Дугаар 2024_12	14.8. Үүнтэй холбогдуулан Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны 06 дугаар тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын захирал, дарга нарт, үр дүнг нэгтгэж 2024 оны 06 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг зрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд тус тус даалгав." (Үндэсний судалгааны нэгдсэн платформын ажлын явцын талаар)	2025 онд судалгааны ажил хийгдээгүй.	Х.Б	Х.Б		Тийм	Монгол улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийн үр дүнг 2024 оны 06 дугаар сард Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар тусгасан. Хэрэгжиж дууссан.
128	191	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааны 13 дугаар тэмдэглэл 2024-04-03 Дугаар 2024_13	22.6.1.. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулах, эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийн талаар мэдээллийг олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу тус тус авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт;(Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн 2024 оны 1 дүгээр улирлын явц, гүйцэтгэлийн талаар)	2024 оны төсвийн жилд хамааралтай.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	Хэрэгжиж дууссан
129	192	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдааны 14 дүгээр тэмдэглэл 2024-04-10 Дугаар 2024_14	14.17.1.1. Газрын нэгдмэл сангийн өөрчлөлт, шилжилт хөдөлгөөнийг бүртгэх болон газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх олгохтой холбогдсон үйл ажиллагааг Газрын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, журмын дагуу хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.(Монгол Улсын газрын нэгдмэл сангийн 2023 оны улсын нэгдсэн тайлангийн талаар)	Газрын нэгдмэл сангийн өөрчлөлт, шилжилт хөдөлгөөнийг бүртгэх болон газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх олгохтой холбогдсон үйл ажиллагааг Газрын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, журмын дагуу хэрэгжүүлж, аймгийн Газрын нэгдмэл сангийн 2023 оны тайланг 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/34 дугаартай албан бичгээр Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт хүргүүлсэн байна. 2025 оны тайланг заасан хугацаанд хүргүүлэхээр ажиллаж байна	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	Хэрэгжиж дууссан.
	193		14.17.1.2. Бэлчээрийн газар ашиглалт, түүний даацыг тохируулах, өнжөөн сэлгэх, хүчтэй элэгдэл, эвдрэлд өртсөн тариалангийн газрыг нөхөн сэргээх, хот суурин газрын хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээг жил бүрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, холбогдох хууль тогтоомж, журмын дагуу хэрэгжилтийг зохион байгуулан ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав;	Аймгийн хэмжээнд бэлчээрийн өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх ажлын үр дүнгээр 4 дүгээр түвшинд 19 цэг, 5-р түвшинд 8 цэг хамрагдан бэлчээрийн доройтол даацыг тодорхойлон бэлчээрийг сайжруулахаар 24 байршлын 39232.26 га газрыг өнжөөж амраах, сэлгэх, тордон сайжруулахаар 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган, нийт 40,832.124 га газрыг өнжөөж, амраах, тордон сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлсэн. Мөн хот, тосгоны суурин газрын хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр нэгж талбар тус бүрд хийсэн захиалгат хянан баталгааны үр дүнг иргэн, аж ахуй нэгжийн газар эзэмших гэрээнд тусган зөвлөмж өгч ажилласан байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
130	194	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны 15 дугаар тэмдэглэл 2024-04-17 Дугаар 2024_15	20.11.1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд байнга ил тод, нээлттэй байлгахаар заасан мэдээллийг "Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)"-д байршуулах ажлыг хариуцсан салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, мэдээллийг тухай бүр шинэчилж ажиллахыг төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой байгууллагуудын удирдлага, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;(Шил" ажиллагааны хэрэгжилтийн талаар)	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд байнга ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллийг аймгийн цахим хуудас (www.bulgan.gov.mn)-д тогтмол байршуулан ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 159 байгууллагыг manage.gov.mn, shilen.gov.mn цахим системд бүртгэсэн. Тайлант онд 103 байгууллага 86 төрлийн мэдээ мэдээллийн баяжуулалт хийж, холбогдох хуулийн дагуу мэдээ мэдээллийг https://shilen.gov.mn/ сайтад байршуулсан. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 4-р улирлын хэрэгжилт 98.0 хувьтай дүгнэгдсэн. Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д мэдээллийг шууд холбох боломжийг бүрдүүлэн төрийн цахим шилжилт үйлчилгээний хэлсээс холболт хийж, бүх байгууллагыг системд бүрэн холбосон. Мэдээллийн сангийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, 3 дугаар улирлын байдлаар 40 байгууллага цахим системд мэдээлэл байршуулж байсныг 4 дүгээр улирлын байдлаар 103 болгож нэмэгдүүлэв.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	195		26.3.5. Шатахуун түгээх болон автомашин хийгээр цэнэглэх станцын аюулгүйн бүсийг зөрчиж газар олгохгүй байхыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт;	Шатахуун түгээх болон автомашин хийгээр цэнэглэх станцын аюулгүйн бүсийг зөрчиж газар олголт хийгдээгүй болно.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

131	196	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэл 2024-04-24 Дугаар 2024_16	26.3.6. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх болон автомашин хийгээр цэнэглэх станцад орчны дүрс бичлэгийн техник, хэрэгслийг байршуулж, цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбох арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр болон бүх шатны Засаг дарга нарт;	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй шатахуун түгээх 45, автомашин хийгээр цэнэглэх 6 станцдуудад Монгол улсын стандарт MNS 6423:2019 / Теле хяналтын системийн техникийн ерөнхий шаардлага -ыг хангасан 103 теле хяналтын камер байршуулсан. Шатахуун түгээх станц, аж ахуй нэгж, байгууллагын хяналтын камеруудыг цагдаагийн байгууллагын нэгдсэн сүлжээ, теле хяналтын "Дэд төв"-д холбох чиглэлээр 2025 онд батлагдсан төсвийн хүрээнд 30 аж ахуй нэгжийг холбох зардал шийдвэрлэгдэж, аймгийн хэмжээнд 11 шатахуун түгээх станцын орчмын камер дэд төвийн серверт холбогдсон. Авто зам дагасан 29 үйлчилгээний цэгийн гадна орчны хяналтын камерыг дэд төвд холболт хийсэн.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
132	197	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны 17 дугаар тэмдэглэл 2024-05-01 Дугаар 2024_17.1	28.3.1.. "Нийгмийн түншлэлийг хэрэгжүүлэх хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг хангаж аймаг, нийслэл, салбарын түвшинд ажил олгогчийн болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллагатай хэлэлцээ хийж хамтын хэлэлцээр байгуулан, ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	Ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах аймгийн "Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт салбар хороо"-г Ажил олгогч эздийн холбоо, Үйлдвэрчний эвлэл, төрийн албаны төлөөллийг оролцуулан 10 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр аймгийн Засаг даргын 2016 оны А/449 дүгээр захирамжаар байгуулсан. Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн 2025-2027 оны аймгийн хэлэлцээрт хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажлын байрыг хадгалах, хөдөлмөрийн харилцаа, ажилтны нийгмийн халамж, хамгаалал, нийгмийн түншлэлийг хөгжүүлэх, хэлэлцээрийг хэрэгжүүлэх талаар 5 бүлэг бүхий 28 заалтыг тусган, хэлэлцээрийг байгуулаад байна. Ажилтны хөдөлмөрийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангуулахад 3 талын төлөөллийг оролцуулан улсын үзлэг зохион байгуулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдээлэл, зөвлөгөө өгөх, хяналт шалгалт зохион байгуулах, хөдөлмөрийн маргаан таслах үйл ажиллагаанд тогтмол хамтран ажиллаж байна. 2025-2027 оны аймгийн хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээрийг шинэчлэн байгуулсныг баталгаажуулан, 17 сум 1 тосгонд хүргүүлэн ажилласан бөгөөд нийт 13 сум хэлэлцээрээ шинэчлэн байгуулсан байна. Аймгийн хэлэлцээр болон сумдын хэлэлцээрийг баталгаажуулан, мэдээллийн сан үүсгэн ажилласан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 10 дугаар хуралдааны тэмдэглэлээр дахин үүрэг, чиглэл өгөгдсөн.
133	198	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны 18 дугаар тэмдэглэл 2024-05-08 Дугаар 2024_18.1	19.3.2.. Уг төлөвлөгөөнд туссан үйл ажиллагааг эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэрийн хүрээнд хэрэгжилтийг зохион байгуулах, шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хүрээнд шийдвэрлэж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн холбогдох байгууллагын төсвийн шууд захирагч нарт даалгав.	Хамааралгүй заалт	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй		Үгүй	
134	199	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны 19 дүгээр тэмдэглэл 2024-05-15 Дугаар 2024_19.1	22.5.2. Хот байгуулалтын норм, стандартын дагуу цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн барилга барих зориулалтаар газар чөлөөлөх, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль бариагүй орон сууцны хотхон, хорооллыг ашиглалтад хүлээн авахгүй байх, ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд тухайн орон нутгийн боловсрол, шинжлэх ухааны газраас төлөөлөл оруулж, хяналтыг сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав	Боловсролын салбарын барилга байгууламжийн зориулалтаар газар нэмж авах шаардлага үүсээгүй байна. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын бүрэлдэхүүнд аймгийн БГ-аас холбогдох төлөөллийг оролцуулан энэ онд 19 комисс ажилласан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
135	200	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны 20 дугаар тэмдэглэл 2024-05-22 Дугаар 2024_20.1	19.1. Үүнтэй холбогдуулан зудын улмаас мал нь хорогдсон малчин өрхүүдийн судалгааг нарийвчлан гаргаж, тэднийг малжуулах хөтөлбөрт хамруулах, малчдын амьжиргааг дээшлүүлэх зорилгоор авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар Засгийн газрын хуралдаан бүрд танилцуулж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд, малчныг малжуулах хөтөлбөрт хамруулах арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх арга хэмжээ авахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, аймгийн Засаг дарга нарт даалгав.(Зудын улмаас мал нь хорогдсон малчин өрхүүдийн талаар)	"Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтээр малжуулах арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулж, 2024 онд 105 өрхийг хөтөлбөрт хамруулан, тус бүр 8.0 сая, нийт 840 сая төгрөгөөр малжуулсан. Аймгийн хэмжээнд урд бүсийн сумдад өвөлжилт хүндэрч айл өрхүүд зуданд малаа алдсантай холбогдуулан зудтай сумдаас малжуулах арга хэмжээнд хамруулах өрхийн тоог бусад сумдаас өндөр байхаар квот тогтоон, зохион байгуулалтыг хийж ажилласан. 2025 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтээр малчдыг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд цөөн малтай 60 малчин өрхийг хамруулан, 3205 толгой малыг 480 сая төгрөгөөр худалдан авч, өгч, малчдын амьжиргааг дээшлүүлэн ажиллалаа.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын хүндрэлийн үед бүрэн хэрэгжүүлж дууссан.

136	201	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэл 2024-06-06 Дугаар 2024_22	37.1.1. "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлж, малчдад зөвлөн туслах үүрэг бүхий багийг орон нутагт үргэлжлүүлэн ажиллуулж, холбогдох албан хаагчдын албан томилолтын болон замын зардал, тээврийн хэрэгслийг шуурхай шийдвэрлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, агентлагийн дарга, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга (захирал) нарт	Монгол Улсын Засгийн газрын 166 тогтоолоор батлагдсан "Шинэ хоршоо" хөдөлгөөний хүрээнд 2024 онд Улаанбаатар хотод 144 малчин, хоршооны гишүүн, Орхон аймагт шинэ хоршоо хөдөлгөөний Хойд бүсийн нээлтийн үйл ажиллагаанд 120 малчин, хоршооны гишүүнийг хамруулж, оролцогчдын томилолт, унааны зардлыг орон нутгийн төсвөөс шийдвэрлэсэн. Булган аймагт шинээр байгуулагдсан хоршоог чадавхжуулах зорилгоор 2 удаагийн зөвлөлдөх уулзалт зохион байгуулж, 280 малчин, хоршооны гишүүнийг оролцуулсан. 2025 онд "Хоршоо хөгжүүлэх сан"-аас аймгийн хэмжээнд 2219.0 сая төгрөгийг зээлийн эргэн төлөлтөөр бүрдүүлж, зээл олгохоос 12 сум төсөл сонгон шалгаруулалт зарлаж, 10 сум 22 хоршоонд 1,033.0 сая төгрөгийн зээлд хамруулав.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	Хэрэгжиж дууссан.
137	202	Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдааны 31 дүгээр тэмдэглэл 2024-09-04 Дугаар 2024_31	31.9.6. 2/ Төрийн байгууллагын "gov.mn" нэгдсэн цахим хуудаст мэдээллийг байршуулах, тухай бүр шинэчлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд байнга ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллийг аймгийн цахим хуудас (www.bulgan.gov.mn)-д тогтмол байршуулан ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 159 байгууллагыг manage.gov.mn, shilen.gov.mn цахим системд бүртгэсэн. Тайлант онд 103 байгууллага 86 төрлийн мэдээ мэдээллийн баяжуулалт хийж, холбогдох хуулийн дагуу мэдээ мэдээллийг https://shilen.gov.mn/ сайтад байршуулсан. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 4-р улирлын хэрэгжилт 98.0 хувьтай дүгнэгдсэн. Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д мэдээллийг шууд холбох боломжийг бүрдүүлэн төрийн цахим шилжилт үйлчилгээний хэлсээс холболт хийж, бүх байгууллагыг системд бүрэн холбосон. Мэдээллийн сангийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, 3 дугаар улирлын байдлаар 40 байгууллага цахим системд мэдээлэл байршуулж байсныг 4 дүгээр улирлын байдлаар 103 болгож нэмэгдүүлэв.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
138	203	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааны 32 дугаар тэмдэглэл 2024-09-11 Дугаар 2024_32	32.6.2.. 2.1.Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 50 дугаар тэмдэглэлээр өгсөн даалгаврыг хэрэгжүүлж, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгүй сумдын төлөвлөгөөг боловсруулж, батлуулах ажлыг эрчимжүүлж, шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусган шийдвэрлүүлэхийг холбогдох аймаг, сумын Засаг дарга нарт, төлөвлөгөөний харилцан уялдааг зохицуулж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурьд()	Рашаант сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө аймгийн ИТХ-р батлагдаж Газар зохион байгуулалт хот төлөвлөлтийн цахим системд оруулсан. Булган сумын төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг 150.0 сая төгрөг, гэр хорооллын суурьшлын бүс нэмэгдүүлэх хэсэгчилсэн төлөвлөгөөг 80.0 сая төгрөгөөр хийлгэхээр зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгох тендер зарлаж, гүйцэтгэгчээр "А И СИ архитектс" ХХК шалгаран, гүйцэтгэж байна. Хангал, Могод, Бүрэгхангай сумын төвийн хэсэгчилсэн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийлгэх ажлын хөрөнгийг сумын ИТХ-р батлуулахаар ажиллаж байна. Сэлэнгэ сумын төвийн хэсэгчилсэн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийлгэх ажлын хөрөнгө татагдсан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
139	204	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн хуралдааны 35 дугаар тэмдэглэл 2024-10-02 Дугаар 2024_35	14.7.2.. Газрын эрхийн давхцалтай 6206 зөрчлийг арилгах, тусгай хамгаалалттай газар нутагт олгогдсон 4953 нэгж талбар газрын эрх болон уул уурхай, ашигт малтмалын зориулалтаар олгогдсон 447 нэгж талбар газрын эрхийг баталгаажуулах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах арга хэмжээ авахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгав;	Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу газрын эрхийн давхцал байгаа эсэхэд Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэсэн ба илэрсэн зөрчилгүй. Ашигт малтмал, газрын тосны газраас ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон талбайн хэмжээгээр тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн, газар ашиглах эрхийг баталгаажуулж, мэдээллийн санд бүртгэх чиглэл хүргүүлж, бүртгэв.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

140	205	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны 39 дүгээр тэмдэглэл 2024-11-13 Дугаар 2024_39	39.29.11.3. Энэ тэмдэглэлийн 2.1, 2.2, 2.3 дахь хэсэгт зааснаас гадна захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй байгаа өөрийн салбарын бусад шийдвэрийг дараах чиглэлээр хянан үзэж, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бичгээр хариу мэдэгдэхийг бүх шатны захиргааны байгууллагын удирдлагад даалгав: (Үүнд :3.1.хүчингүй болсон тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.2.ач холбогдлоо алдсан, дагаж мөрдөгдөхгүй тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.3.нэмэлт, өөрчлөлт оруулсан буюу хөдөлгөөн хийдэггүй тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.4.хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.5.хуулиар тусгайлан эрх олгогдсон боловч батлаагүй тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.6.захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэлгүй даган мөрдөж байгаа тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.7.энэ тэмдэглэлийн 3.2, 3.4-т заасан захиргааны хэм хэмжээний актын талаарх мэдээллийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхдээ зохих албан тушаалтан тэдгээрийг хүчингүй болгох шийдвэр гаргаж, хавсаргасан байх.) заалт бүрээр бичгээр мэдэгдэх	Аймгийн хэмжээнд бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга, Тамгын даргын хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн, ач холбогдлоо алдсан, дагаж мөрдөгдөхгүй байгаа захиргааны хэм хэмжээний акт болон захирамж, тушаал байхгүй. Нэмэлт, өөрчлөлт оруулсан тушаал, захирамж, тогтоол байхгүй байна. Аймгийн хэмжээнд 2025 оны байдлаар 3 хэм хэмжээний актыг хуулийн хугацаанд Хууль зүй дотоод хэргийн яаманд хүргүүлж, Улсын нэгдсэн сан https://legalinfo.mn/mn -д бүртгүүлсэн.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	206		39.29.12.3. Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага кибер аюулгүй байдлыг хангах чиг үүргээ тодорхой албан тушаалтанд хариуцуулж, үйл ажиллагааны болон кибер аюулгүй байдлыг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн төсвийн төсөлд тусгаж байхыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт	Кибер аюулгүй байдлыг хангах зорилгоор хувийн хэвшлийн Юнивишн компанитай хамтран дэд бүтцийг байгуулан мэдээлэл технологийн ажилтан хариуцан ажиллаж байна. Хамгаалалттай сүлжээ үүсгэдэг төхөөрөмж бүхий Циско төхөөрөмжийг төрийн мэдээллийн нэгдсэн системд өнөөдрийг хүртэл ашиглаж байна. Тамгын газрын хэмжээнд нийт албан хаагчдын сүлжээг хамгаалсан циско 1 төхөөрөмж, Зөвлөлийн өрөөнд циско 2 төхөөрөмжийг тус тус суурилуулаад байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	207		39.29.11.1.2. эрхэлсэн асуудал, чиг үүргийнхээ хүрээнд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрүүдийг хууль тогтоомжийн өөрчлөлттэй уялдуулан дагаж мөрдөхгүй болсон, эрх зүйн үйлчлэлийн хугацаа дууссан, хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн, Хууль зүй, дотоод хэргийн сайдаас хүчингүй болгох дүгнэлт гаргаж хүргүүлсэн боловч хүчингүй болгоогүй, мөн хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын хүрээнд хуульд нийцүүлэхээр ажиллаж байгаа талаар хариу ирүүлсэн шийдвэрүүдийг дүгнэлтийн дагуу хүчингүй болгон, хуульд нийцүүлэх арга хэмжээг авч, 2025 оны 1 дүгээр улиралд багтаан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэх (1.1Захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үр дүнгийн тайлан, цаашид авах арга хэмжээний талаар танилцуулсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн болон бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгож, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газрын бус бие даасан агентлаг болон эрх шилжүүлэн авсан нийтийн эрх зүйн этгээдийн эрх бүхий албан тушаалтнуудад зөвлөв)	Улсын нэгдсэн санд бүртгэлтэй захиргааны хэм хэмжээний актад хууль тогтоомжийн өөрчлөлттэй холбогдуулан дагаж мөрдөхгүй болсон хэм хэмжээний акт байхгүй байна. Эрх зүйн үйлчлэлийн хугацаа дууссан байхгүй. Хууль тогтоомжтой давхардсан "Малчдын бүлэг ажиллуулах журам"-ыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын VIII хуралдааны 57 дугаар тогтоолоос хасав. Зөрчилдсөн захиргааны хэм хэмжээний акт байхгүй. Хууль зүй, дотоод хэргийн сайдаас хүчингүй болгох дүгнэлт гаргасан, хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын хүрээнд хуульд нийцүүлэхээр ирүүлсэн захиргааны хэм хэмжээний акт байхгүй байна. Хяналтад авч, тайлагнаж буй Монгол улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэрүүдэд давхардлын судалгаа хийх ажлын хэсгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны А/129 дүгээр тушаалаар томилон, судалгаа хийж, мэдээллийг АЗДТГ-ын даргын 2025 оны 03/1841 тоот албан бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	2025 оны 01 дүгээр улиралд хэрэгжүүлж, дууссан.

208			39.29.11.1.3. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хийсэн судалгаа, түүнчлэн өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дагаж мөрдөж байгаа хуулиудаас тусгайлан эрх олгосон заалтын судалгааг гаргаж, батлах зохицуулалттай боловч батлаагүй, баталсан боловч захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэлгүй даган мөрдөж байгаа шийдвэрүүдийг хянан үзэж, тэдгээрийг батлах, бүртгүүлэх арга хэмжээг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан авч хэрэгжүүлэх;(1.4.цаашид нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрт тогтмол дүн шинжилгээ хийж, шинээр батлагдсан хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох шийдвэрт тухай бүр нь нэмэлт, өөрчлөлт оруулж, санд хөдөлгөөн хийлгэх ажлыг хэвшүүлэх; 1.5.шийдвэрийг баталснаас хойш ажлын 5 өдрийн дотор хянуулж, бүртгүүлэх хугацааг баримталж ажиллах; 1.6.Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулж, бүртгүүлсэн шийдвэрүүдээр салбарын сан байгуулж, иргэдэд үйлчлэх чиг үүргээ биелүүлж ажиллах;))	Нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрт тогтмол дүн шинжилгээ хийж, шинээр батлагдсан хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох шийдвэрт тухай бүр нь нэмэлт, өөрчлөлт оруулж, санд хөдөлгөөн хийлгэх ажлыг хэрэгжүүлж хэвшсэн. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор баталсан журмыг ажлын 5 өдрийн дотор хянуулж, бүртгүүлэх хугацааг баримталж ажиллаа. Энэ онд аймгийн хэмжээнд 3 хэм хэмжээний акт баталсан бөгөөд хуулийн хугацаанд Хууль зүй дотоод хэргийн яаманд хянуулж, улсын нэгдсэн санд бүртгүүлсэн. Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулж, бүртгүүлсэн шийдвэрүүдээр салбарын сан байгуулж, иргэдэд үйлчлэх чиг үүргээ биелүүлж ажиллаа.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	2025 оны 01 дүгээр улиралд хэрэгжүүлж, дууссан.
	209		39.29.11.1.7. Захиргааны ерөнхий хуулийг үйл ажиллагаандаа дагаж мөрдөн хэвшүүлэх, цаашид уг хуультай холбоотой зөрчил гаргахгүй байх, гаргасан тохиолдолд холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцож ажиллах	Захиргааны ерөнхий хуулийг үйл ажиллагаандаа даган мөрдөж, зөрчил гаргахгүй байх тал дээр анхаарч, Хууль, эрх зүйн хэлтсийн хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд боловсруулж буй захирамж, тушаал, шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг хянан, сумдад хууль, эрх зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
141	210	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдааны 40 дүгээр тэмдэглэл 2024-11-20 Дугаар 2024_40	40.19.5.3. "Өвлийн идэш" арга хэмжээнд малчдын хоршоодын оролцоог хангахад дэмжлэг үзүүлж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт." гэжээ.	Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Жижиг дунд үйлдвэрийн газартай хамтран "Өвлийн идэш" арга хэмжээнд аймгийн малчид, хоршоологчдыг зохион байгуулан оролцуулав. Хангал сумын малчин өвлийн идэшний захиалга авч махыг ангилж, савлан бууз, банш, бөөрөнхий мах зэрэг хагас бэлэн бүтээгдэхүүн болгон үйлдвэрлэж, нийлүүлсэн сайн туршлагыг дэлгэрүүлж байна. 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрөөс 12 дугаар сарын 03-ны өдрийг дуустал "Өвлийн идэш 2025" арга хэмжээ өргөтгөсөн худалдаанд Булган аймгийн Булган сумаас 1 иргэн цагаан идээ, Могод сумын "Бумбат жорх" хоршоо болон Баян-Агт сумын 1 иргэн мах борлуулан оролцсон.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	211		40.19.7.1. Дархан-Уул аймгийн Хонгор сум, Сэлэнгэ аймгийн Ерөө сум хоорондын хилийн цэсийн эргэлтийн "Хонгорын даваа" цэг болон Архангай аймгийн Хайрхан сум, Булган аймгийн Сайхан сум хоорондын хилийн цэсийн эргэлтийн "Өргөөт" цэгийг тухайн хилийн цэсийг тогтоосон архивын баримт материал, зураглалд үндэслэн, Ажлын хэсгээс гаргасан дүгнэлтийн дагуу Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд бүртгэхийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар (А.Энхманлай)-т, тухайн сумдын хилийн цэсийн талаар иргэд, олон нийтэд үнэн зөв мэдээлэл өгч, мөрдүүлж ажиллахыг Дархан-Уул, Сэлэнгэ, Архангай, Булган аймгийн болон холбогдох сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгов	Архангай аймгийн Хайрхан сум, Булган аймгийн Сайхан сум хоорондын хилийн цэсийн эргэлтийн "Өргөөт" цэгийг ажлын хэсгээс гаргасан дүгнэлтийн дагуу Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд бүртгэсэн.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	212		40.19.7.2. Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа аймаг, сум, нийслэл, дүүргийн хилийн цэсийг тогтоосон Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг, Улсын Их Хурлын тогтоолыг сахин мөрдөж, тэдгээрээс зөрүүтэй газар зүйн нэр, зургийг үндэслэн аливаа хилийн цэстэй холбоотой маргаан үүсгэхгүй байх талаар онцгой анхаарч ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгов.	Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа аймаг, сумын хилийн цэсийг дагаж мөрдөх, сумын хилийн цэстэй холбоотой маргаан үүсгэхгүй байх, байгалийн хил зааг, хүний гараар бүтээгдсэн объектоор тогтоосон хилийн цэсийн судалгааг гаргуулах чиглэлээр сумдын Засаг дарга нарт 2025 оны 01/293 тоот бичгээр хүргүүлж, ирүүлсэн судалгааг нэгтгэн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт батлагдсан маягтын дагуу 2025 оны 01/376 тоот албан бичгээр хүргүүлэн ажиллав.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
142	213	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны 43 дугаар тэмдэглэл 2024-12-04 Дугаар 2024_43	43.6.2.. Төсвийн жилд багтаан барьцаа хөрөнгийн данснаас чөлөөлөх боломжгүй, хэрэгжилт удаашралтай, зогссон төслүүдийн гэрээг дүгнэж, эцсийн тооцоог баталгаажуулан барьцаа хөрөнгийн дан дахь санхүүжилтийн үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэхийг төсвийн холбогдох ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав	2025 оны 12 дугаар сарын байдлаар барьцаа хөрөнгийн дансанд 1.2 тэрбум төгрөг байгаагаас 361.6 сая нь үлдэгдэл санхүүжилт болон техник хяналт, зураг төсөв, зохиогчийн хяналтын зардал, 810.7 сая төгрөг нь чанарын баталгааны барьцаа хөрөнгө байна. 2025 онд барьцаа хөрөнгийн данснаас 509.9 сая төгрөгийн гүйцэтгэлийг санхүүжүүлсэн.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

143	214	Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны 47 дугаар тэмдэглэл 2024-12-30 Дугаар 2024_47	47.8.1.2. Нийслэлийн хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллагыг өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан шинэ жилийн баяр, амралтын өдрүүдэд бэлэн байдлад ажиллахыг Засгийн газрын гишүүд, нийслэлийн бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгов.	Төрийн болон нутгийн захиргааны байгууллагыг өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан шинэ жилийн баяр, амралтын өдрүүдэд аймгийн Засаг даргын захирамж гаргаж агентлаг, байгууллагын дарга, эрхлэгч, аймгийн Онцгой комиссын бие бүрэлдэхүүн бүрэн бүрэлдэхүүнээр ажилласан	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай тогтоол 2025.02.28-ны өдрийг хүртэл хэрэгжиж дууссан.
144	215	Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны 44 дүгээр тэмдэглэл 2025-01-18 Дугаар 2024_44	44.22.1.12. Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулж, холбогдох албадын үйл ажиллагааг эрчимжүүлж, хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	"Агаарын тухай" хуулийн 7.1.6, 8.1.4, 8.1.5, 27.1 дэх заалт болон Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/479 дүгээр тушаалаар батлагдсан "Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах журам"-ыг үндэслэн, жил бүр аймгийн хэмжээнд "Агаарын бохирдлын эх үүсвэрийн тооллого"-ын ажлыг зохион байгуулж байна. Булган сумын агаарын чанарыг сайжруулах бүсийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Булган аймгийн Засаг даргын хамтарсан 2025 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн А/657, А/256 дугаар тушаал, захирамжаар шинэчлэн тогтоосон. 2024 онд Булган аймгийн 16 сум, 1 тосгоны нийт 7367 айл өрхийн түлш хэрэглээний мэдээллийг бүртгэлжүүлж мэдээллийн санд оруулсан. Аймгийн хэмжээнд нийт 15894 утаа гаргадаг айл өрх байгаагаас 4617 тн нүүрс, 75901 м³ мод болон 16439 тн бусад төрлийн түлш хэрэглэсэн байна. Агаар бохирдуулах эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийн хүрээнд уурын болон усан халаалтын нийт 54 зуухыг бүртгэн, хэрэглэсэн түлшний мэдээллийг шинэчиллээ. Үүнд: 15–100 кВт хүчин чадалтай 21 зуух - 1052 тн нүүрс, 840 м³ мод, 100–4200 кВт хүчин чадалтай 31 зуух - 16565 тн нүүрс, 4200 кВт-аас дээш хүчин чадалтай 2 зуух - 21366 тн нүүрс хэрэглэсэн байна. Мөн 2024 оны агаарын бохирдлын хөдөлгөөнт эх үүсвэрийн бүртгэлийн дагуу аймгийн хэмжээнд бүртгэлтэй 13799 авто тээврийн хэрэгсэл байгаагаас 13109 нь үзлэг оношлогоонд хамрагдсан байна. Бүрэгхангай, Тэшиг, Гурванбулаг, Хутаг-Өндөр сум зэрэг сумдад агаарын бохирдлын хяналт шалгалтыг хийж ажилласан ба агаарын чанарын MNS4585-2016 үзүүлэлтийг давсан үзүүлэлт байхгүй байна. Хяналт, шалгалтын хүрээнд улсын байшаасгийн 6 заалт бүхий 3	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
145	216	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдааны 5 дугаар тэмдэглэл 2025-01-22 Дугаар 2025_05	5.24.10.1. Бүсийн хамтын ажиллагааг дэмжих, идэвхжүүлэх хөдөлгөөн өрнүүлэх хүрээнд олон талт арга хэмжээ зохион байгуулж, хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.(Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан зохион байгуулах төлөвлөгөөний талаар)	Булган аймагт Хойд бүсийн зөвлөгөөн 04 дүгээр сарын 28-ны өдөр болсон. Арга хэмжээнд Орхон аймгаас 110, Хөвсгөл аймгаас 70, Булган аймгаас 150, уран бүтээлчид болон зохион байгуулах ажилтан, албан хаагчид 150, нийслэл, яам, газраас 250 гаруй албан хаагч, иргэн, аж, ахуйн нэгжүүд оролцож, амжилттай зохион байгуулсан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	Хэрэгжиж дууссан.
146	217	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 6 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-01-29 Дугаар 2025_06	6.26.5.2.2. "Засгийн газрын үйл ажиллагааны 2024-2028 оны хөтөлбөр"-т тусгагдсан 4 бодлогын 16 чиглэлийн 620 зорилтын хэрэгжилтийг эрчимжүүлэхэд анхаарч ажиллахыг Засгийн газрын гишүүд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны 2024-2028 оны хөтөлбөрт туссан өөрийн аймагт хамаарах зорилт арга хэмжээг аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэн ажиллах "Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрт тусган, хэрэгжүүлж байна. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 77 зорилтын 102 арга хэмжээний 2025 оны хэрэгжилтийг цахим системээр 80.63 хувьтай тайлагнасан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
147	218	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 10 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-02-26 Дугаар 2025_10	10.19.4.2. Холбогдох хууль тогтоомжоор өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг богино хугацаанд шуурхай зохион байгуулан бүрэн хангахад анхаарч, эрхлэх асуудлын хүрээнд дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Булган аймгийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны үйл ажиллагаанд засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас өгсөн зөвлөмжийн дагуу эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан, Тамгын газрын даргаар батлуулж, хэрэгжүүлсэн. Хэрэгжилтийг аймгийн Засаг даргын 2025 оны 10 сарын 30-ны өдрийн 02/1806 албан тоотой хүргүүлсэн болно. Хавсралт : 2 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

148	219	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 11 дүгээр хуралдааны тэмдэглэл 2025-03-06 Дугаар 2025_11	11.6.2. Хот байгуулалтын тухай хууль тогтоомжид заасны дагуу харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээний хот, тосгон, суурин газруудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон барилгажилтын төслийг боловсруулан, тус тус батлуулж, хэрэгжүүлэх ажлыг яаралтай зохион байгуулахыг аймгийн Засаг дарга нарт даалгав." гэжээ.(1.Монгол Улсын иргэнд 2025 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай асуудлыг хэлэлцээд тогтоол гаргахаар тогтов.)	Хот, тосгон, суурин газруудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу Засгийн газрын 2025 оны 119 дүгээр тогтоолоор Булган аймгийн хэмжээнд шинээр 233 иргэнд 600 нэгж талбарыг өмчлүүлэхээр тусгагдан батлагдсан. Хэрэгжилтийг ханган ажиллах талаар 2025 оны 01/301 дүгээр албан тоотоор сумын Засаг дарга нарт хүргүүлэн, 2025 оны байдлаар 457 нэгж талбарыг олгосон. Иргэн хүсэлт гаргаагүй тул бусад нэгж талбар олгогдоогүй байна. Булган сумын төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг 150.0 сая төгрөг, гэр хорооллын суурьшлын бүс нэмэгдүүлэх хэсэгчилсэн төлөвлөгөөг 80.0 сая төгрөгөөр хийлгэхээр даалгавар боловсруулж, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгох тендер зарлаж гүйцэтгэгчээр "А И СИ архитекст" ХХК шалгар гэрээ байгуулан хэрэгжүүлж байна.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%		Үгүй	
149	220		13.23.3.1.1.. Харьяа хот, тосгон, бусад суурины газрын эдэлбэр газрын хэмжээ, байршил, заагийг Газрын тухай хуульд заасны дагуу тогтоолгох асуудлыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар шийдвэрлүүлэх арга хэмжээ авах; (1.Дараах арга хэмжээг шуурхай хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.)	Булган аймгийн 43 байршлын 38771 га бэлчээрийн газраас хот суурины эдэлбэр шилжүүлэх, Булган хотын эдэлбэр газрыг тогтоох асуудлыг Аймгийн ИТХ-ын 2024 оны III/18 болон 2025 оны XI/81 дугаар тогтоолоор шийдвэрлэсэн. Шийдвэрийг ГХБХБГ-ын даргын 2025 оны 10 дугаар сарын 13-ны 01/927 дугаар албан бичгээр холбогдох байгууллагад хүргүүлсэн.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	221		13.23.3.1.1.2. Бэлчээрийн газар ашиглалт, түүний даацыг тохируулах, өнжөөн салгах, хүчтэй элэгдэл, эвдрэлд өртсөн газрыг нөхөн сэргээх, хот, суурин газрын хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээг жил бүрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах; (1.Дараах арга хэмжээг шуурхай хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.)	Аймгийн хэмжээнд бэлчээрийн өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх ажлын үр дүнгээр 4 дүгээр түвшинд 19 цэг, 5-р түвшинд 8 цэг хамрагдан бэлчээрийн доройтол даацыг тодорхойлон бэлчээрийг сайжруулахаар 24 байршлын 39232.26 га газрыг өнжөөж амраах, сэлгэх, тордон сайжруулахаар 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган, нийт 40,832.124 га газрыг өнжөөж, амраах, тордон сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлсэн. Мөн хот, тосгоны суурин газрын хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр нэгж талбар тус бүрд хийсэн захиалгат хянан баталгааны үр дүнг иргэн, аж ахуй нэгжийн газар эзэмших гэрээнд тусган зөвлөмж өгч ажилласан байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	222	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 13 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-03-19 Дугаар 2025_13	13.23.3.1.1.3.. Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа болон Газрын тухай хуульд заасны дагуу гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан иргэнд үнэ төлбөргүй газар эзэмшүүлэх, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд 5 га хүртэлх газрыг төсөл сонгон шалгаруулалтаар олгох арга хэмжээг цахим системээр зохион байгуулж, шийдвэрлэж хэвших, иргэд, олон нийтад ойлгомжтой, хүртээмжтэй мэдээлэл өгөх;(1.Дараах арга хэмжээг шуурхай хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.)	Засгийн газрын 2025 оны 121, 74 дүгээр тогтоолоор 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээний дуудлага худалдаагаар нийт 65 нэгж талбарын 124.97 га газрыг олгохоор төлөвлөгдсөнөөс, 22 нэгж талбарыг танхим, 43 нэгж талбарыг цахим хэлбэрээр зохион байгуулж, нийт 64 нэгж талбарын 124.9 га газарт дуудлага худалдаа зохион байгуулсан байна. Үүний үр дүнд төлөвлөгдсөн 800 сая төгрөгийн орлогын 454.769 сая төгрөг аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Мөн газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журмын 11 дүгээр зүйлд заасны дагуу малчдын хоршоонд олгохоор төлөвлөгдсөн нийт 35 нэгж талбарын 143.496 га газраас, 25 нэгж талбарын 106.4 га газрын олгох шийдвэрийг гаргаж, үлдсэн 10 нэгж талбарын газарт ирсэн төсөл ирээгүй буюу шаардлага хангаагүй байна. Газрын тухай хуульд зааснаар гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан 4 иргэнд газар эзэмшүүлэхээр төлөвлөж, 0.25 га газрыг 4 иргэнд бүрэн олгосон.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	223		13.23.3.1.1.4.. Уул уурхай, ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй газрын эрхийг баталгаажуулах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах.(1.Дараах арга хэмжээг шуурхай хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.)	Уул уурхай, ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй газрын эрхийг баталгаажуулах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, аймгийн Татварын хэлтэст ГХБХБГ-ын даргын 2025 оны 01/929, 01/1022, 01/1039, 01/1179 дугаар албан бичгээр мэдээлэл хүргүүлэн, газрын төлбөрийн ногдуулалтыг үүсгэн ажилласан байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

150	224	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 14 дүгээр хуралдааны тэмдэглэл 2025-03-26 Дугаар 2025_14	14.16.7.2.. Зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох хүсэлтийг хүлээн авах, магадлан шалгах, шийдвэр гаргахад төрийн мэдээлэл солилцооны "Хур" систем, цахим төлбөрийн баримтын системийг ашиглах, шийдвэрийн талаар мэдэгдлийг "И-Монгол" цахим системээр дамжуулан иргэнд хүргэх нөхцөлийг бүрдүүлж, тусгай зөвшөөрлийн цахим систем (License), Төрийн үйлчилгээний "e-business.mn" системийг ашиглах арга хэмжээг 2025 оны II улиралд багтаан хэрэгжүүлэхийг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Цахим шилжилт үйлчилгээний хэлтсийн үйл ажиллагааны хүрээнд ХҮР, E-Mongolia системээр нэг болон олон шатлалт төрийн үйлчилгээг 18368 иргэдэд үзүүлж, 9119 лавлагаа, тодорхойлолт олгож ажиллалаа. Энэ нь аймгийн нийт иргэдийн 30.4 хувьд хүрсэн үзүүлэлт юм. Үйлчилгээг аймгийн төвд байрлах 6 киоск, 16 сум, 1 тосгонд байрлах 23 "ХҮРДАН" киоск, 11 сумын 24/7 цахим үйлчилгээний төвүүдээр дамжуулан үзүүлсэн. Аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсээс бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалт болон стандартын мэдээлэл, лавлагааны үйлчилгээг cert.masm.gov.mn, estandard.gov.mn системээр дамжуулан цахимд бүрэн шилжүүлснээр Булган аймагт үзүүлж буй цахим үйлчилгээний төрөл 63 болж нэмэгдсэн. И-Бизнес" цахим платформыг сурталчлах зорилгоор Булган аймгийн Цахим шилжилт, үйлчилгээний хэлтэстэй хамтран "Нээлттэй засгийн түншлэлийн долоо хоног –2025" арга хэмжээний хүрээнд өдөрлөг зохион байгуулж, 28 аж ахуйн нэгжийн 32 бизнес эрхлэгчдийг платформтой танилцуулан мэдээлэл өглөө. Булган аймагт хувиараа бизнес эрхлэгчдэд "И-Бизнес" платформ болон төрийн үйлчилгээний талаарх мэдээллийг 41 бизнес эрхлэгчдэд зөвлөгөө, мэдээллээр ханган ажилласан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
151	225	Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 15 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-04-02 Дугаар 2025_15	15.13.4.2.. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулах хүрээнд жилийн эцсийн тайлан, мэдээнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж, чиглэл хүргүүлж, хэрэгжилт, үр дүнг тооцон ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	Аймгийн хэмжээнд 2025 онд нийт 2470 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирүүлснийг хүлээн авч, шийдвэрлэсэн байдалд хяналт-шинжилгээ хийж ажиллалаа. Нийт ирсэн өргөдөл гомдлын 92 нь буюу 3.7 хувь нь Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төвийн 11-11 дугаараас шилжүүлсэн, 76.8 хувь нь аймгийн ИТХ-ын ажлын алба, аймаг, сумдын ЗДТГ, агентлагуудад утсаар, цахимаар, болон өөрийн биеэр ирж бичгээр гаргасан өргөдөл, 19.5 хувь нь ААНБ, хуулийн этгээдээс албан бичгээр ирүүлсэн өргөдөл байна. Өргөдөл, гомдлыг төрлөөр авч үзвэл Үндсэн хуул, бусад хууль тогтоомжид заасан хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэдээс гаргасан мэдэгдлийн шинжтэй өргөдөл 14.8 хувь, иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж, сэргээлгэхээр гаргасан гомдол 8.4 хувь, төрийн ба нутгийн удирдлагын байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах талаар гарсан хүсэлт 2.9 хувь, байгууллагын дотоод үйл ажиллагаатай холбоотой, үйлчилгээ авах хүсэлтээс бусад өргөдөл 73.9 хувийг тус тус эзэлж байна. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэн, 1179 өргөдлийн хариуг албан бичгээр хүргүүлэн, 131 өргөдлийг харьяаллын дагуу шилжүүлж, 140 иргэнд цахимаар, 495 иргэнд утсаар, 506 иргэнтэй биечлэн уулзаж шийдвэрлэлтийн талаар мэдэгдэв. Хугацаа болоогүй, шийдвэрлэх шатанд байгаа өргөдөл нийт өргөдлийн 1.4 хувийг эзэлж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	226		15.13.5.1.. Нийслэлийн Шуурхай штабын хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг тогтоосон хугацаанд бүрэн хэрэгжүүлж, Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 7 дугаар хуралдааны тэмдэглэлээр даалгасны дагуу биелэлтийг тухай бүр ERP системээр тайлагнаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар, "Эрдэнэс Монгол" ХХК (С.Наранцогт)-д тус тус;	Хамааралгүй заалт	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй		Тийм	Хамааралгүй заалт

152	227	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 19 дүгээр хуралдааны тэмдэглэл 2025-04-23 Дугаар 2025_19	19.24.6.1.. Хуралдаанд оролцогчдын болон тэврийн хэрэгслийн тоог зохистой хэмжээнд байхаар хуваарилах, оролцогчдыг аймаг хооронд зорчиход авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авахыг Засгийн газрын холбогдох гишүүд, Булган аймгийн Засаг дарга Д.Пүрэв-Очир, Хөвсгөл аймгийн Засаг дарга Л.Төмөрбаатар, Орхон аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр нарт; (Хангайн бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдааны дүн болон Хойд бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдааны бэлтгэл ажлын талаар)	Энэ оны 04 дүгээр сарын 27, 28, 29 өдрүүдэд Булган аймагт Хангайн бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдаан, Монгол Улсын Засгийн газрын хуралдаан зохион байгуулагдсан. Тус арга хэмжээнд Монгол Улсын Ерөнхий Сайд болон Засгийн газрын гишүүд, хангайн бүсийн аймгуудын бүх шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, төлөөлөгчид, Засаг дарга нар оролцсон. Цагдаагийн газраас тус арга хэмжээг зохион байгуулагдахтай холбогдуулан хамгаалалтын төлөвлөгөө, ажил үүргийн хуваарийг гарган зураглал төлөвлөгөөний дагуу алба хаагчдыг хамгаалалт зохицуулалтад ажиллуулсан. Хангайн бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдаан, Монгол Улсын Засгийн газрын хуралдаанд оролцохоор Булган аймагт ирэх Чиглэл-3 болон Засгийн газрын гишүүд, аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, төлөөлөгч, Засаг дарга нарын аймаг хооронд зорчих үеийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Цагдаагийн газраас хөтөч автомашин, замын хөдөлгөөн зохицуулах хөдөлгөөнт эргүүлийн алба хаагч, автомашиныг гарган ажиллуулснаар тус арга хэмжээг зөрчил дутагдалгүй зохион байгуулан ажиллаж, дүнг илтгэх хуудсаар холбогдох газарт хүргүүлэн ажилласан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	Хэрэгжиж дууссан
	228		19.24.6.2. Харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд замын хөдөлгөөний аюулгүй байдал, олон нийтийн аюулгүй байдал, нийтийн хэв журмыг хангах арга хэмжээг зохих журмын дагуу иргэд, оршин суугчдад хүндрэл учруулахгүйгээр зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Булган аймгийн Засаг дарга Д.Пүрэв-Очирт;	Аймгийн нутаг дэвсгэрт Хангайн бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдаан, Монгол Улсын Засгийн газрын хуралдаан болохтой холбогдуулан Цагдаагийн газрын даргын баталсан хуваарийн дагуу замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, МУ-ын ерөнхий сайд, бусад сайд нар зорчих үеийн хамгаалалтад ажиллах 24 алба хаагч, 3-н автомашиныг томилон ажиллуулж, зөрчил дутагдалгүй зохион байгуулсан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	Хэрэгжиж дууссан
	229		19.24.6.3.. Засгийн газрын хуралдааны зохион байгуулалт, аюулгүй байдал, бусад шаардлагатай бэлэн байдлыг хангах чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг зэрхлэх газрын дарга Н.Учрал, Булган аймгийн Засаг дарга Д.Пүрэв-Очир, Төрийн тусгай хамгаалалтын газар (Л.Алтангэрэл), Тагнуулын ерөнхий газар (П.Одонбаатар)-т	Засгийн газрын өргөтгөсөн хуралдаан өнгөрөгч 04 дүгээр сард Булган аймагт зохион байгуулагдаж аймгийн Засаг даргын Тамгын газар болон хэлтэс, агентлагийн төрийн албан хаагчид бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллав. Хуралдааныг аймгийн Биеийн тамир, спортын газрын зааланд зохион байгуулалтын өндөр түвшинд зохион байгуулахад анхаарч ажилласан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	Хэрэгжиж дууссан
	230		19.24.5.2.. Улаанбурхан өвчний тандалт, дархлаажуулалт, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах, бүх шатлалын эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжлийн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав	Улаанбурхан өвчнөөс сэргийлэх, тандалт судалгааг аймгийн нэгдсэн эмнэлгийн түргэн тусламж, хүлээн авах тасаг, сум, өрхийн ЭМТ-үүдийн амбулаториор үйлчлүүлэгч, хэвтэн эмчлүүлэгч нийт 3230 хүний дунд зохион байгуулж, эмчийн зөвлөгөө заавар өгч ажилласан. Улаанбурхан өвчний 9 тохиолдол бүртгэгдэж, ойрын хавьтал болсон 96 хүнд тандалт судалгааг хийж, нөхөн дархлаажуулалтад 48 хүнийг хамруулсан. Аймгийн хэмжээний ЭМБ-уудад улаанбурхан өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх, нөхөн дархлаажуулах, эргэмжээр программд шивэлт хийх , өвчлөлийг эрт илрүүлэх, оношлох, сорьц тэвээрлэх, эмчлэх сургалтыг цахимаар 5 удаа, танхимаар 2 удаа зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө зөвлөмжийг 4 удаа албан бичгээр ЭМБ-уудад хүргүүлэн ажилласан	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
153	231	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 21 дүгээр хуралдааны тэмдэглэл 2025-04-30 Дугаар 2025_21	21.11.10.1.. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг эрчимжүүлж, иргэдэд хүргэх сэрэмжлүүлгийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол үр дүнтэй явуулахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгов.	Улсын онцгой комиссын 2025 оны "Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний удирдамж" 01 дүгээр тушаалыг үндэслэн аймгийн Засаг даргын 2025 оны А/195 дугаар захирамжийн дагуу ой, ойн сан бүхий газарт аялах, ан агнах, бутын эвэр түүх, мод бэлтгэх, ойн дагалт баялаг ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахыг хориглосон. Дээрх хугацаанд түймрийн аюулын зэрэглэл, I-II зэрэглэлд хүрч буурсан. Иргэн, хуулийн этгээдүүд ой, хээрийн гал түймрээс хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж, мод бэлтгэл, ойн арчилгаа, цэвэрлэгээний үед түймрийн аюулгүй байдлыг хангахад шаардлага тавьж, ой бүхий сумдад морин эргүүл ажиллуулан, хяналтын цэг гаргасан. Ой, хээрийн гал түймрийн эрсдэлтэй сум, орон нутагтай хамтран урьдчилан сэргийлэх хөдөлгөөнт эргүүлийг томилгоожуулан малчид, иргэд, тээвэрчдэд өдөр бүр урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг хүргэж ажилласан. Хөдөлгөөнт эргүүлээр аймгийн хэмжээнд 15643 иргэн, 8373 айл өрх, 6259 авто машинд үзлэг хийж заавар зөвлөмж өгч сэрэмжлүүлэх 13337 хэвлэмэл материалыг хүргэв.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

154	232	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 25 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-05-28 Дугаар 2025_25	25.31.1.1. 2024 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнд үндэслэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь өөрийн үйл ажиллагаанд дүгнэлт хийж, хэрэгжээгүй болон хэрэгжилт хангалтгүй байгаа арга хэмжээг эрчимжүүлэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлж, дүнг 2025 оны 4 дүгээр улиралд багтаан Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт ирүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Булган аймгийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны үйл ажиллагаанд засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас өгсөн зөвлөмжийн дагуу эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан, Тамгын газрын даргаар батлуулж, хэрэгжүүлсэн. Хэрэгжилтийг аймгийн Засаг даргын 2025 оны 10 сарын 30-ны өдрийн 02/1806 албан тоотоор хүргүүлсэн болно. Хавсралт : 2 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
155	233	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 26 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-06-04 Дугаар 2025_26	26.27.6.2.. Улаанбурхан өвчний тандалт, дархлаажуулалт, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангахад шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэх, үндэсний товллын дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн бүх шатлалын байгууллагад дэмжлэг үзүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/249, Булган аймгийн ЭМГ-ын даргын 2025 оны А/47 дугаар тушаалаар Эрүүл мэндийн салбарыг 2025 оны 5 дугаар сараас 7 дугаар сарын хугацаанд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн ажиллалаа. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Сум, өрхийн ЭМТ-үүд, аймгийн ЭМГ, Эм ханган нийлүүлэх байгууллагууд өөрийн хөрөнгөөр шаардлагатай эм тариа, вакцин, дагалдах хэрэгсэл, сорьц тээвэрлэх тэжээлт орчны нөөц бүрдүүлэн 21.3 сая төгрөгийг зарцуулсан. Эрүүл мэндийн байгууллагууд иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг шуурхай үзүүлэх, халдвартын эмнэлэг дэлгэн ажиллуулах төлөвлөлтийг хийж, амбулаторийн тусламж үйлчилгээ, хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээ авсан 18930 иргэнд халууралт, тууралттай хам шинжийн тандалтыг хийж, өвчлөлийн тархалтыг таслан зогсоосон. Улаанбурхан өвчнөөс сэргийлэх Нөхөн дархлаажуулалтад 811 хүүхдийг хамруулж, 2453 хүүхдийн дархлаажуулалтын мэдээллийг анхан шатны бичиг баримтыг үндэслэн нөхөн шивж E-Mongolia платформд орууллаа. Эрүүл мэндийн статистик мэдээллээр нөхөн дархлаажуулалт 91 хувьд, товлотт дархлаажуулалт 98.6 хувьд хүрсэн байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
156	234	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 10 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-07-30 Дугаар 2025_10	14.4.. Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт 2023-2025 оны улсын хэлэлцээрийн талаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт 2023-2025 оны улсын хэлэлцээрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, шинээр байгуулах хэлэлцээрийн төслийг боловсруулан 2025 оны 9 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир "Нийгмийн түншлэлийг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2013 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 370 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, үйл ажиллагаагаа эрчимжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.	Ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах аймгийн "Хөдөлмөр, нийгмийн зөвшилцөн гурван талт салбар хороо"-г Ажил олгогч эздийн холбоо, Үйлдвэрчний эвлэл, төрийн албаны төлөөллийг оролцуулан 10 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр аймгийн Засаг даргын 2016 оны А/449 дүгээр захирамжаар байгуулсан. Хөдөлмөр, нийгмийн зөвшилцөн 2025-2027 оны аймгийн хэлэлцээрт хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажлын байрыг хадгалах, хөдөлмөрийн харилцаа, ажилтны нийгмийн халамж, хамгаалал, нийгмийн түншлэлийг хөгжүүлэх, хэлэлцээрийг хэрэгжүүлэх талаар 5 бүлэг бүхий 28 заалтыг тусган, хэлэлцээрийг байгуулаад байна. Ажилтны хөдөлмөрийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангуулахад 3 талын төлөөллийг оролцуулан улсын үзлэг зохион байгуулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдээлэл, зөвлөгөө өгөх, хяналт шалгалт зохион байгуулах, хөдөлмөрийн маргаан таслах үйл ажиллагаанд тогтмол хамтран ажиллаж байна. 2025-2027 оны аймгийн хөдөлмөр, нийгмийн зөвшилцөн гурван талт хэлэлцээрийг шинэчлэн байгуулсныг баталгаажуулан, 17 сум 1 тосгонд хүргүүлэн ажилласан бөгөөд нийт 13 сум хэлэлцээрээ шинэчлэн байгуулсан байна. Аймгийн хэлэлцээр болон сумдын хэлэлцээрийг баталгаажуулан, мэдээллийн сан үүсгэн ажилласан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
157	235	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 11 дүгээр хуралдааны	9.7. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1 дэх хэсгийн хэрэгжилтийн талаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулахад цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар зөвлөмж, дүгнэлт гаргуулж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад даалгав.	Энэ онд нийтийн мэдээллийн систем шинээр үүсгэх хэрэгцээ шаардлага үүсээгүй. Цаашид аймгийн хэмжээнд нийтийн мэдээллийн систем нэвтрүүлэх тохиолдолд цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар зөвлөмж, дүгнэлт гаргуулж ажиллана.	Х.Б	Х.Б		Үгүй	

158	236	тэмдэглэл 2025-08-06 Дугаар 2025_11	9.7.1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1 дэх хэсгийн хэрэгжилтийн талаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулахад цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар зөвлөмж, дүгнэлт гаргуулж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад даалгав.	Энэ онд нийтийн мэдээллийн систем шинээр үүсгэх хэрэгцээ шаардлага үүсээгүй. Цаашид аймгийн хэмжээнд нийтийн мэдээллийн систем нэвтрүүлэх тохиолдолд цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар зөвлөмж, дүгнэлт гаргуулж ажиллана.	Х.Б	Х.Б		Үгүй	
	237	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 13 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-08-20 Дугаар 2025_13	12.3.2.2.. нийслэл, төвлөрсөн суурин газрын агаарын чанарыг 3 жилийн дотор Монгол Улсын стандартын жилийн дундаж үзүүлэлтэд бүрэн нийцүүлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Булган сумын агаарын чанарыг сайжруулах бүс, тухайн бүсэд мөрдөх журмыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Булган аймгийн Засаг даргын хамтарсан 2025 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн А/657, А/256 дугаар тушаал, захирамжаар шинэчлэн тогтоосон. Агаарын чанарыг сайжруулах бүсэд дагаж мөрдөх журмыг Булган сум хэрэгжүүлэн ажиллаж байна. 2023, 2024, 2025 оны байдлаар агаар бохирдуулагч бодисууд болох Хүхэрлэг хийн жилийн дундаж агууламж 9 мкг/м.куб буюу агаарын чанарын MNS4585:2016 стандарттай харьцуулахад /А4С- 450мкг/м.куб/ бохирдлын хэмжээ маш бага буюу бохирдолгүй, азотын давхар ислийн хувьд бохирдлын хэмжээ бага жилийн дундаж агууламж 22 мкг/м.куб буюу агаарын чанарын MNS4585:2016 стандарттай харьцуулахад /А4С- 200 мкг/м.куб/ бохирдлын хэмжээ бага буюу бохирдолгүй байна. Булган аймгийн ус цаг уур орчны шинжилгээний газрын мэдээгээр Булган суманд агаар бохирдуулагч эх үүсвэр стандартаас давсан үзүүлэлтгүй байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	238		12.3.2.4.. дотоод орчны агаарын чанарын стандартыг 2025 оны 3 дугаар улиралд багтаан батлуулж, агаарын бохирдлын өндөр эрсдэлтэй бүсэд байрлах сургууль, цэцэрлэгийн дотоод орчны агаарын чанарыг тогтмол хянах, дотоод орчны агаарын чанарыг сайжруулах нэгдсэн төлөвлөгөө батлан хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Боловсролын сайд П.Наранбаяр, Стандарт, хэмжил зүйн газар (С.Батбаатар), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, шаардлагатай санхүүжилтийг орон нутгийн төсвийн хөрөнгөөс гаргахыг холбогдох Засаг дарга нарт тус тус;	Агаарын чанарын техникийн шаардлага MNS 4585:2025 стандарт 2025 оны 06 дугаар сарын 19 -ний өдрөөс шинэчлэгдэн батлагдаж, агаарын чанарын өдөр тутмын хяналт шинжилгээнд ашиглагдаж байна. Булган аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвд агаарын чанарын 24 цагийн автомат станцыг БНСУ-ын 900 сая төгрөгийн буцалтгүй тусламжаар суурилуулж, суурилагдсан агаарын чанарын автомат харуулын тасралтгүй ажиллагааг явуулахад шаардагдах төсвийг батлуулан, сар бүр 765500 төгрөгийг урсгал болон шаардагдах материалын зардалд зарцуулж ажилласан. Булган сумын агаарын чанарын бохирдлыг 24 цагийн тасралтгүй ажиллагаатай хянаж байна. Булган аймгийн ус цаг уур орчны шинжилгээний газрын мэдээгээр Булган суманд агаар бохирдуулагч эх үүсвэр стандартаас давсан үзүүлэлтгүй байна	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	239		12.3.2.6.. угаарын хий мэдрэгч төхөөрөмжийг аймаг, нийслэл, сум, дүүргийн гэр хорооллын өрх бүрд байршуулж, хяналт тавин, мэдрэгч ажилласан тохиолдолд шуурхай арга хэмжээ авах төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	хэрэгжээгүй.	Санхүү, хөрөнгө оруулалтаас - 0%	Санхүү, хөрөнгө оруулалтаас - 0%		Үгүй	
	240		12.3.2.7.. агаарын бохирдлын талаарх мэдээллийг өдөр тутам олон нийтэд тогтмол мэдээлэх тогтолцоог боловсронгуй болгож, зорилготой бүлэгт хүргэх мэдээллийн сувгийн хүртээмжийг нэмэгдүүлэхийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Агаарын чанарын мэдээг өдөр бүр, 7 хоног болон 10 хоногоор Bulgan.weather.gov.mn болон Agaar.gov.mn сайтуудад тогтмол байршуулж, иргэдийг мэдээллээр хангаж ажилласан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	241		12.3.2.9.. гэр, барилга байгууламжийн дулаан алдагдлыг бууруулах технологи нэвтрүүлж байгаа аж ахуйн нэгжүүдийн дунд чөлөөт өрсөлдөөн бий болгох чиглэлээр үе шаттай арга хэмжээг авч, агаарын бохирдлыг бууруулах, дулаан алдагдлыг багасгах нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Булган аймгийн хэмжээнд 2024 онд нийт 7367 айл өрхийн түлш хэрэглээний мэдээллийг бүртгэлжүүлж, мэдээллийн санд оруулсан. Аймгийн хэмжээнд 15894 утаа гаргадаг айл өрх байгаагаас 4617 тн нүүрс, 75901 м.куб мод болон 16439 тн бусад төрлийн түлш хэрэглэсэн байна. Хангал сумын Хялангат тосгонд "Бодь Арвин констракшин" ХХК шилжин ирж хоногт 3 тн үртсэн шахмал түлш үйлдвэрлэх хүчин чадалтай Эко харагдан түлшний үйлдвэрийг ажиллуулан Хангал, Орхон, Булган сум, Хялангат тосгоны айл өрхийн хэрэгцээнд 24 тн шахмал түлш нийлүүлсэн.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%		Үгүй	

	242		12.3.2.10.. шахмал түлшний стандартыг шинэчлэх ажлыг зохион байгуулж, стандартын шаардлага хангасан түлшийг хэрэглээнд нэвтрүүлэх, шахмал түлшний хэрэглээний гадаад, дотоод орчны агаарын чанар, стандартад үзүүлж байгаа нөлөөллийг тогтмол хянах арга хэмжээ зохион байгуулахыг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Булган аймгийн хэмжээнд Хялганат тосгонд шахмал түлшний үйлдвэр 2025 оны 03 дугаар сард байгуулагдан Орхон, Булган, Хангал, Хялганат тосгонд 24 тн үртсэн шахмал түлшийг нийлүүлэн, иргэдийн хэрэгцээг хангаж байна. Аймгийн хэмжээнд шахмал түлшний хэрэглээ харьцангуй бага байгаатай холбоотойгоор агаарын чанарт үзүүлэх нөлөө нь бага байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
159	243	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 15 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-09-02 Дугаар 2025_15	10.4.1.. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авахыг доор дурдсан албан тушаалтнуудад даалгав: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллийг үнэн зөв, иргэдэд ойлгомжтой байдлаар цахим хуудсандаа болон нээлттэй мэдээллийн системд 2025 оны 10 дугаар сарын 01-ний дотор бүрэн байршуулахыг яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд байнга ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллийг аймгийн цахим хуудас (www.bulgan.gov.mn)-д тогтмол байршуулан ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 159 байгууллагыг manage.gov.mn, shilen.gov.mn цахим системд бүртгэсэн. Тайлант онд 103 байгууллага 86 төрлийн мэдээ мэдээллийн баяжуулалт хийж, холбогдох хуулийн дагуу мэдээ мэдээллийг https://shilen.gov.mn/ сайтад байршуулсан. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 4-р улирлын хэрэгжилт 98.0 хувьтай дүнгэгдсэн. Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д мэдээллийг шууд холбох боломжийг бүрдүүлэн төрийн цахим шилжилт үйлчилгээний хэлсээс холболт хийж, бүх байгууллагыг системд бүрэн холбосон. Мэдээллийн сангийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, 3 дугаар улирлын байдлаар 40 байгууллага цахим системд мэдээлэл байршуулж байсныг 4 дүгээр улирлын байдлаар 103 болгож нэмэгдүүлэв.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	244		10.4.4.. Эрхлэх асуудлын хүрээнд харьяа яам, Засгийн газрын агентлаг, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээд буюу мэдээлэл хариуцагчдын хууль биелүүлэх үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Хууль зүй дотоод хэргийн яамны харьяа Улсын бүртгэлийн хэлтэс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Шүүхийн шинжилгээний хэлтэс, Цагдаагийн газартай аймгийн Засаг дарга 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулан хэрэгжилтийг хангаж ажиллаа. Мөн аймгийн тойргийн нотариат, Булган аймаг дахь хуульчдын холбоотой хамтарч ажилласан. Жилийн эцсийн байдлаар гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт Улсын бүртгэлийн хэлтэс 87.6, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 24.7, Шүүхийн шинжилгээний хэлтэс 88.9, Цагдаагийн газар 90.6 хувьтай үнэлэгдсэн.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	245		28.1.3.. иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын бүртгэл, ангилал, шийдвэрлэлтийг нэгдсэн мэдээллийн санд тухай бүр бүртгүүлж байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	Иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэн хариу өгч, тайлан мэдээг хуулийн хугацаанд нь илгээж байна. Аймгийн хэмжээнд 2025 онд нийт 2470 өргөдөл, гомдол, хүлээн авч шийдвэрлэсний 92 нь буюу 3.7 хувь нь Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төвийн 11-11 дугаараас шилжүүлсэн, 76.8 хувь нь аймгийн ИТХ-ын ажлын алба, аймаг, сумдын ЗДТГ, агентлагуудад утсаар, цахимаар, болон өөрийн биеэр ирж бичгээр гаргасан өргөдөл, 19.5 хувь нь ААНБ, хуулийн этгээдээс албан бичгээр ирүүлсэн өргөдөл байна. Өргөдөл, гомдлыг төрлөөр авч үзвэл Үндсэн хуул, бусад хууль тогтоомжид заасан хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэдээс гаргасан мэдэгдлийн шинжтэй өргөдөл 14.8 хувь, иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж, сэргээлгэхээр гаргасан гомдол 8.4 хувь, төрийн ба нутгийн удирдлагын байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах талаар гарсан хүсэлт 2.9 хувь, байгууллагын дотоод үйл ажиллагаатай холбоотой, үйлчилгээ авах хүсэлтээс бусад өргөдөл 73.9 хувийг тус тус эзэлж байна. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэн, 1179 өргөдлийн хариуг албан бичгээр хүргүүлэн, 131 өргөдлийг харьяаллын дагуу шилжүүлж, 140 иргэнд цахимаар, 495 иргэнд утсаар, 506 иргэнтэй биечлэн уулзаж шийдвэрлэлтийн талаар мэдэгдэв. Хугацаа болоогүй, шийдвэрлэх шатанд байгаа өргөдөл нийт өргөдлийн 1.4 хувийг эзэлж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

246	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 16 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-09-10 Дугаар 2025_16	28.2.1.. 1.Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт дараах арга хэмжээ авахыг даалгав: 1.1.хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн төслийг боловсруулахдаа тухайн асуудлаар өмнө нь гарсан шийдвэртэй утга агуулгын хувьд давхардуулан гаргахгүй байх, санхүү, төсвийн асуудлыг тусгасан, шалгуур үзүүлэлттэй, хэрэгжихүйц байхад анхаарах; 1.2.хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг өмнөх тайлант хугацааны биелэлттэй харьцуулж, салбарын хэмжээнд нэгтгэн, хүрсэн үр дүнг товч тодорхой, үнэн, зөв тайлагнах; 1.3.хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны зохицуулалтад шаардагдах төсөв хөрөнгийг шийдвэрлэх; 1.4.хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтийг тайлагнахдаа салбар хоорондын уялдаа холбоог сайжруулж, хэрэгжилтийг тогтвортой хамгааж, чар гүйц нэмэгдүүлж, амьдрал	Хууль, эрх зүйн хэлтсийн хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд боловсруулж буй захирамж, тушаал, шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг хянан, сумдад хууль, эрх зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. 2025 онд шинээр баталж гарсан захирамж, тушаал шийдвэрүүдэд хийсэн хяналт, шалгалтаар хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн тушаал, захирамж, тогтоол байхгүй байна. Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнахдаа хяналтад авах заалтыг холбогдох байгууллагуудад хуваарилан, нийт 17 сумын ЗДТГ, 14 агентлагаас хэрэгжилтийг авч, нэгтгэн дүгнэж, хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн цахим системд тайлагнаж байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар цахим системээр хуваарилсан 331 заалтыг хяналтад авч, хэрэгжүүлсэн ажлын үр дүнг нэгтгэн дүгнэж, тайлагнав.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
247		28.4.2... Атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх, тариалангийн талбайн ашиглалтыг сайжруулах асуудлыг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн, орон нутгийн түвшинд удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга нарт;	Бэлчээрийн талбайгаас тариалангийн ангилалд шилжүүлэхээр санал ирүүлсэн Баян-Агт, Бугат, Могод, Орхон, Төшиг сумын нийт 2467.5 га талбайг эргэлтэд оруулахаар хөрсний шинжилгээнд хамруулахад 3-аас дээш хувийн ялзмагтай талбай 46.5 га, 26 хувь буюу 607.1 га нь дунд хангалттай, 72 хувь буюу 1679.2 га нь 2 хувиас бага буюу хангалтгүй ангилалд хамаарсан байна. Тус ялзмагтай газруудыг бордож, органик бодисын агууламжийг нэмэгдүүлснээр тариалангийн ангилалд шилжүүлэхээр төлөвлөсөн.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%		Үгүй	
248		28.4.3.. Ургац хураалтын үед тариалангийн талбайд мал оруулахгүй байх талаар нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг тариалан бүхий аймгийн Засаг дарга нарт, тариалангийн талбайг хашиж хамгаалах, ойн зурвас байгуулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт тус тус	Ургац хураалтын үед тариалангийн талбайд мал оруулахгүй байх ургацыг малын хөлөөс хамгаалж алдагдалгүй хураах талаар бодлогын бичиг баримтуудыг боловсруулж, хэрэгжилтийг хангуулахаар нийт 48 удаа сурталчилж, 870 гаруй тариаланч, ногоочдыг хамруулсан. Мөн 16 сумын мэргэжилтнүүдэд 2 удаа цахим сургалт хийж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж мэдээлэл өгсөн. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/263 дугаар тушаалаар тариалангийн талбайг хамгаалж ойн зурвас байгуулах зориулалтаар балансаас балансад шилжүүлсэн 51000 ширхэг энгийн шон, 550 ширхэг булангийн шон хүлээн авч, 38 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан 45591 ширхэг энгийн шон, 550 ширхэг булан шонг олгосноор 3248 талбайг хашаажуулж, хамгааллаа.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
249		28.4.5.. Төмс, хүнсний ногооны хадгалалт, борлуулалтын нэгдсэн сүлжээг бий болгоход дундын хоршоодыг түшиглэн стандартын шаардлага хангасан зоорь, агуулах барих асуудлыг орон нутгийн түвшинд зохион байгуулахыг холбогдох аймгийн Засаг дарга нарт, дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт тус тус	Судалгаагаар төмс, хүнсний ногооны 208 ширхэг буюу 23364,2 тн багтаамжтай агуулах, зоорьтой байна. 2025 онд Хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих хөрөнгө оруулалтын зээлд Бугат, Булган сумд тус бүр 500 тн зоорины төсөл хэрэгжүүлэх хүсэлтийг ХХААХҮЯ-нд уламжлаад байна. Орхон суманд "Бүрэн луу" ХХК нь өөрийн хөрөнгө оруулалтаар 150 тн багтаамжтай энгийн чулуун зоорийг 20.0 сая төгрөгөөр нөхөн сэргээж, засварлан ашиглалтад оруулаад байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

250			28.14.1.3.. шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд цахим хуудсанд байршуулж ажиллаагүй байгууллага, албан тушаалтанд хууль, гэрээнд заасны дагуу хариуцлага тооцож ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд байнга ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллийг аймгийн цахим хуудас (www.bulgan.gov.mn)-д тогтмол байршуулан ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 159 байгууллагыг mapage.gov.mn , shilen.gov.mn цахим системд бүртгэсэн. Тайлант онд 103 байгууллага 86 төрлийн мэдээ мэдээллийн баяжуулалт хийж, холбогдох хуулийн дагуу мэдээ мэдээллийг https://shilen.gov.mn/ сайтад байршуулсан. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 4-р улирлын хэрэгжилт 98.0 хувьтай дүгнэгдсэн. Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д мэдээллийг шууд холбох боломжийг бүрдүүлэн төрийн цахим шилжилт үйлчилгээний хэлтсээс холболт хийж, бүх байгууллагыг системд бүрэн холбосон. Мэдээллийн сангийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, 3 дугаар улирлын байдлаар 40 байгууллага цахим системд мэдээлэл байршуулж байсныг 4 дүгээр улирлын байдлаар 103 болгож нэмэгдүүлэв. Тайлант хугацаанд (shilen.gov.mn) цахим системд мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй 56 байгууллагын дарга нарт үйл ажиллагааг эрчимжүүлэн, цахим системд мэдээллийг хугацаанд нь байршуулж, ил тод нээлттэй мэдээлэх тухай чиглэлийг хүргүүлж, чиглэл өгөгдсөнөөс хойш үүрэг даалгаврыг биелүүлээгүй тохиолдолд хариуцлага тооцох тухай албан бичиг хүрүүлсэн.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
			28.18.5.. тарваган тахал өвчний хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг ханган, оношилгоо, эмчилгээний чадавхыг сайжруулж, авто тээврийн шалган нэвтрүүлэх цэгүүдэд тавьж байгаа хяналтыг чангатгахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	Эрүүл мэндийн сайдын 2025 оны "Тарваган тахал өвчний хяналт сэргийлэлтийн арга хэмжээг эрчимжүүлэх тухай" 04 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Хутаг-Өндөр сумын Гуртын гүүр, Баян- Агт сумын Хануй голын гүүр, Тэшиг сумын Эгийн голын гүүрэнд хяналтын пост ажиллуулж, нийт 953 автомашин, 2193 том хүн, 234 хүүхдийг бүртгэлжүүлэн, зөвлөмж өгч, дамжин өнгөрүүлсэн. Эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудыг хамруулсан цахим зөвлөгөө, зааварчилгааг 2 удаа зохион байгуулж, 780 хүнийг хамруулан, шаардлагатай эм, тариа, хамгаалах хувцас хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодисын 2 сарын нөөцийг бүрдүүлсэн. Иргэд олон нийтэд чиглэсэн тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх постер – 7, тодруулга, ярилцлага – 1 удаа, зөвлөмжит видео мэдээлэл нийт 11 төрлийг боловсруулан цахим, танхимаар дамжуулан мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулж ажилласан байна. Хутаг-Өндөр сумын 1 дүгээр багийн нутаг Гуртын гүүрэнд 24 цагийн хяналтын постыг 2025 оны 9 дүгээр сараас 4 ээлжээр ажиллуулж, 3.4 сая төгрөг зарцуулсан. Халдварт өвчний дэгдэлтийн үеийн хамгаалах хувцас хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодисын 1 сарын нөөцийг бүрдүүлсэн. Нэн шаардлагатай эм эмнэлгийн хэрэгслийн хангалт 84 хувьтай байв. Хяналт шалгалтын хүрээнд 14 зөрчил илрүүлж, 3.3 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ, 14.7 сая төгрөгийн нөхөн төлбөр, 18 ширхэг тарваг хураан авч холбогдох газарт шилүүлж, устгасан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
252		Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 24-ны өдрийн 18 дугаар хууллааны	11.1.1. 1.хяналт-шинжилгээний тайлангийн дүнгийн мөрөөр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгов.	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнөөс аймагт даалгасан арга хэмжээнүүдийг хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн системээр сум, байгууллагуудад хуваарилж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. ЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс аймагт даалгасан 102 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, 2025 оны эхний хагас жилийн байдлаар 49.1 хувьтайгаар, жилийн эцсийн байдлаар 80.6 хувьтайгаар Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт цахимаар тайлагнав.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

161	253	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 20 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-09-24 Дугаар 2025_18	11.2. . 11.2."Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний эхний хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээний дүнгийн талаар Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг төлөвлөсөн зорилтот түвшинд хүргэх, эрчимжүүлэх, нөөцийг оновчтой хуваарилах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд болон аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох төрийн захиргааны байгууллагын дарга нарт даалгав.	Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр Булган аймгийн хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын 2024 оны IV/24 дүгээр тогтоолоор тодотгон баталж хэрэгжүүлэв. Булган аймгийн хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлант оны 3-р улиралд тооцож, 78.0 хувьтай дүгнэсэн. Хангалтгүй хэрэгжиж байгаа зорилт, арга хэмжээг эрчимжүүлэх чиглэлийг холбогдох сум, байгууллагуудад хүргүүлж ажилласан. 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтийг 2026 оны 01 дүгээр сард багтаан аймгийн ИТХ-д танилцуулахаар ажиллаж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
162	254	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 20 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-10-08 Дугаар 2025_20	16.4.1.. Үүнтэй холбогдуулан 2025 онд багтаан дараах арга хэмжээг авахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга болон мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад даалгав: 1.эрхлэх асуудлын хүрээнд бүрдүүлсэн төрөлжсөн мэдээллийн сангийн мета-өгөгдлийг "Төрийн мета-өгөгдлийн нэгдсэн сан"-д бүртгүүлэх;	Хэрэгжиж эхлээгүй	Х.Б	Х.Б		Үгүй	
	255		16.4.3.. 2.төрийн байгууллагуудын ашиглаж байгаа цахим систем болон мэдээллийн санг цахим систем (system.gov.mn)-д бүртгүүлэх;	Хэрэгжүүлж эхлээгүй.	Х.Б	Х.Б		Үгүй	
	256		16.4.3.. 3.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасны дагуу цахим хэлбэрээр үзүүлэх төрийн үйлчилгээг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia.mn)-ээр үзүүлэх.	ХҮР, E-Mongolia системээр нэг болон олон шатлалт төрийн үйлчилгээг 18368 иргэдэд үзүүлж, 9119 лавлагаа, тодорхойлолт олгож ажиллалаа. Энэ нь аймгийн нийт иргэдийн 30.4 хувьд хүрсэн үзүүлэлт юм. Үйлчилгээг аймгийн төвд байрлах 6 киоск, 16 сум, 1 тосгонд байрлах 23 "ХҮРДАН" киоск, 11 сумын 24/7 цахим үйлчилгээний төвүүдээр дамжуулан үзүүлсэн. Аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсээс бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалт болон стандартын мэдээлэл, лавлагааны үйлчилгээг cert.masm.gov.mn, estandard.gov.mn системээр дамжуулан цахимд бүрэн шилжүүлснээр Булган аймагт үзүүлж буй цахим үйлчилгээний төрөл 63 болж нэмэгдсэн.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
163	257	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 22 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-10-22 Дугаар 2025_22	8.2.3.. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага, сургалтын төвүүдэд мэргэжил эзэмшүүлэхэд дэмжлэг үзүүлж, мэргэжил эзэмшин хугацаат цэргийн албанаас халагдаж байгаа залуусын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг авахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Боловсролын сайд П.Наранбаяр, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн IX/70 дугаар тогтоолоор "Чадварлаг мэргэжилтэн" хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд ОХУ, БНСУ, БНХАУ зэрэг улсад 29 багш, 11 суралцагчийг сургалтад хамруулсан. ХААИС-ийн харьяа Булган аймаг дахь Политехникийн коллежийн 1 жилийн ангид 352 суралцагч, 2.5 жилийн курст 49 суралцагч, нийт 401 суралцагч суралцаж төгссөн. Политехник коллежийн 2025-2026 оны хичээлийн жилд Мэдээллийн системийн мэргэжлийн ангийг нээлээ. Тус мэргэжлээр 15 элсэгч суралцаж байна. Хөдөлмөр халамж үйлчилгээний газартай хамтран 2025 оны 1, 2 дугаар ээлжээр цэргээс халагдаж буй 220 залууст хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжүүлж буй хамрагдах боломжтой төсөл хөтөлбөр, санхүүгийн дэмжлэгийн талаар болон хөдөлмөр зуучлах үйлчилгээний талаар мэдээлэл өгч, 2 хүнийг Цагдаагийн газарт, 2 хүнийг цэргийн ангид зуучлан, ажилтай болгосон.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	258		13.3.1.1.. 1.Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт дараах арга хэмжээг авахыг даалгав: 1.1.Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны "Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай" 01 дүгээр, "Нийгмийн шударга ёсыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай" 02 дугаар, "Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай" 03 дугаар, "Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 04 дүгээр албан даалгавраар хугацаатай өгсөн үүргийн хэрэгжилтийг эрчимжүүлэх;	Монгол Улсын Ерөнхий сайдын албан даалгавруудыг хяналтад авч, холбогдох сум, байгууллагуудад хүргүүлэн, хэрэгжүүлж, хэрэгжилтийг сар бүр хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим системд тайлагнав. Албан даалгаврын 8 дугаар сарын хэрэгжилтийг 96.0, 9 дүгээр сарын хэрэгжилтийг 97.0, 10 дугаар сарын хэрэгжилтийг 92.0, 11 дүгээр сарын хэрэгжилтийг 95.0 хувьтай тус тус нэгтгэн, дүгнэж, цахим системд байршуулсан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

164	259		13.3.1.2. 1.2.эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хангалтгүй дүгнэгдсэн заалтын хэрэгжилтийг эрчимжүүлж, хэмжигдэхүйц шалгуур үзүүлэлт бүхий төлөвлөгөө боловсруулах, салбарын хэмжээнд бодит үр дүнг сар бүр нэгтгэн дүгнэж, товч, тодорхой тайлагнах, өмнөх сард тайлагнасан албан даалгаврын хэрэгжилтийг давтан тайлагнахгүй байх.	Булган аймгийн ЗДТГ-ын 2024 оны үйл ажиллагаанд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас өгсөн зөвлөмжийн дагуу хангалгүй дүгнэгдсэн, эрчимжүүлэх шаардлагатай заалтуудыг хяналтад авч, төлөвлөгөө боловсруулан, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан, сум байгууллагуудад хүргүүлж, хэрэгжүүлсэн. Зөвлөмжийн хэрэгжилтийг тооцон Булган аймгийн Засаг даргын 2025 оны 02/1806 тоот албан бичгээр Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт тайланг хүргүүлсэн. Хяналт хэрэгжүүлэх газраас хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим системээр сараар болон улирлаар авч буй албан даалгавар, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг 17 сумдын ЗДТГ, 14 агентлагаас авч, нэгтгэн дүгнэж, цахим системээр тайлагнаж байна. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг тооцохдоо өмнөх сарын хэрэгжилттэй харгалзуулан дүгнэж, бүрэн хэрэгжиж дууссанаас бусад ажил арга хэмжээг өссөн дүнгээр тайлагнахад анхаарч, хэрэгжүүлэгч байгууллагуудад мөн тайланг өссөн дүнгээр үнэн зөв тайлагнах тухай зөвлөмж, чиглэл өгч ажиллаж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	260	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 26 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-11-05 Дугаар 2025_26	13.3.4.. Иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх ажлын хүрээнд яам, Засгийн газрын агентлагууд иргэдийг хүлээн авч уулздаг өдөр, хуваарийг гарган мөрдүүлж, иргэдээс тавьсан өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, үйлчилгээний соёл, чанарыг төлөвшүүлэх арга хэмжээг 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов;	Төрийн байгууллагын бодлого, шийдвэрийн хэрэгжилт, үйл ажиллагааг иргэдэд нээлттэй мэдээлэх, олон нийтийн санал хүсэлтийг сонсож, бодлого, шийдвэрт тусгах зорилгоор 14 хоног тутам "Иргэдийн индэр" нэвтрүүлгийг хийх хуваарийг баталж, албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хүргүүлсэн. Тус нэвтрүүлгийг "Сайхан Монгол" хойд бүсийн телевиз болон Булган аймгийн Засаг даргын тамгын газрын цахим хуудсаар төрийн болон орон нутгийн өмчит 13 байгууллага, 1 салбар зөвлөл, 1 ажлын хэсэг оролцсон 11 удаагийн дугаарыг шууд дамжуулан хүргэж, давхардсан тоогоор 120 мянган хүн үзсэн байна. Аймгийн хэмжээнд 2025 онд нийт 2470 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирүүлснийг хүлээн авч, шийдвэрлэсэн байдалд хяналт-шинжилгээ хийж ажиллалаа. Нийт ирсэн өргөдөл гомдлын 92 нь буюу 3.7 хувь нь Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төвийн 11-11 дугаараас шилжүүлсэн, 76.8 хувь нь аймгийн ИТХ-ын ажлын алба, аймаг, сумдын ЗДТГ, агентлагуудад утсаар, цахимаар, болон өөрийн биеэр ирж бичгээр гаргасан өргөдөл, 19.5 хувь нь ААНБ, хуулийн этгээдээс албан бичгээр ирүүлсэн өргөдөл байна. Өргөдөл, гомдлыг төрлөөр авч үзвэл Үндсэн хуул, бусад хууль тогтоомжид заасан хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэдээс гаргасан мэдэгдлийн шинжтэй өргөдөл 14.8 хувь, иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж, сэргээлгэхээр гаргасан гомдол 8.4 хувь, төрийн ба нутгийн удирдлагын байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах талаар гарсан хүсэлт 2.9 хувь, байгууллагын дотоод үйл ажиллагаатай холбоотой, үйлчилгээ авах хүсэлтээс бусад өргөдөл 73.9 хувийг тус тус эзэлж байна. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэн, 1179 өргөдлийн хариуг	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	261		13.3.7. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад, дотоод томилолт, өндөр өртөгтэй автомашин, тавилга хэрэгсэл, бэлэг дурсгалын зүйлсийг хязгаарлаж, уулзалт, сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж ажиллахыг төрийн байгууллагын удирдлага, албан тушаалтнуудад даалгав;	Орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагуудын төсвийг цалин хөлс, тогтмол зардлаас бусад зардлыг 2025 оны 11 дүгээр сараас эхлэн Сангийн яамнаас бүрэн хязгаарласан. Үүнтэй холбоотой сумын санхүүгийн албаны дарга, төсвийн шууд захирагч нарт мэдээллийг цахимаар хүргүүлж, тодорхой үүрэг чиглэлийг өгч, төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
ЗГ-ын албан даалгавар									
165	262	Цахим шилжилтийг эрчимжүүлэх тухай 2022-07-04 Дугаар 2022_3	2. Энэ албан даалгаврын 1-д заасан төлөвлөгөөнд тусгах нийтийн мэдээллийн дэд бүтцэд хамаарах төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөхдөө Цахим хөгжил, харилцаа холбооны яамны санал, зөвлөмжийг заавал авч байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Цахим аймаг байгуулах бодлогын зөвлөмжийн хүрээнд "Цахим Булган" хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж, төлөвлөгөө боловсруулан, нийт төрийн болон төрийн өмчит байгууллагуудаас 2 удаагийн судалгаа авч, хөтөлбөрийн төсөлд саналуудыг тусгаж ажилласан. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 11/82 дугаар тогтоолоор Төрийн үйл ажиллагааны хурд, бүтээмжийг нэмэгдүүлэх "Цахим Булган" хөтөлбөрийг батлуулсан. Хөтөлбөрийн хүрээнд 2025 онд 14 арга хэмжээг төлөвлөн ажиллаж, төлөвлөгөөний дундаж 95 хувьтайгаар үнэлэгдэв	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

166	263	Цаг үеийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх тухай 2022-07-05 Дугаар 2022_5	5. Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, аймаг, сумдын Засаг дарга нарт: 1.1.Улаанбаатар хот, аймаг, сумдад гэр хорооллыг хөгжүүлэх бодлогын санал боловсруулах; 1.2.Гэр хороололд сургууль, цэцэрлэг байгуулах судалгаа, төлөвлөлт, хийх, гэр хорооллын иргэдэд түргэн тусламж, гал унтраах зэрэг тусламж үйлчилгээг шуурхайг хүргэх зорилгоор гудамжны орц гарцыг сайжруулах санал боловсруулах; 1.3.Гэр хорооллын хог хаягдал, хөрсний бохирдол, жорлонгийн асуудлыг шийдвэрлэх, ногоон байгууламж барих, төлөвлөгөө, шийдлийг танилцуулах.	Рашаант сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө аймгийн ИТХ-р батлагдаж, Газар зохион байгуулалт хот төлөвлөлтийн цахим системд оруулсан. Булган сумын төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг 150.0 сая төгрөг, гэр хорооллын суурьшлын бүс нэмэгдүүлэх хэсэгчилсэн төлөвлөгөөг 80.0 сая төгрөгөөр хийлгэхээр зөвлөх үйлчилгээний гүйцэтгэчийг сонгох төндөр зарлаж, гүйцэтгэгчээр "А И СИ архитектур" ХХК шалгаран, гүйцэтгэж байна. Хангал, Могод, Бүрэгхангай сумын төвийн хэсэгчилсэн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийлгэх ажлын хөрөнгийг сумын ИТХ-р батлуулж байна. Стандартын бус жорлонг сайжруулан 2025 онд шинээр 77 айл өрх, 43 аж ахуйн нэгж стандартын шаардлага хангасан жорлонтой болсон. Хөрс усны бохирдол үүсэхээс сэргийлж, 3 сумыг бохир соруулах техникээр хангах ажлыг хэрэгжүүлэн, Байгаль хамгаалах, нөхөн сэргээх сангаас 174.3 сая төгрөгийг зарцуулсан. Аймгийн хэмжээнд нийт 9 сум бохир соруулах техникээр хангагдаад байна. Хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор био жорлон худалдан авах ажлын гүйцэтгэгчээр "Дансран Дүвчин" ХХК шалгарч, захиалагчийн техникийн шаардлагад нийцсэн 14 зөөврийн жорлонг нийлүүлж, Хутаг-Өндөр сумын Засаг даргын Тамгын газарт хүлээлгэн өгсөн. Ингэснээр Булган аймагт нийт 84 зөөврийн био жорлонг ашиглаж наадам, үйл ажиллагааг орчны бохирдолгүй тэмдэглэн өнгөрөөж байна. 2025 онд сумдын наадам болон, "Айраг" наадмыг бохир соруулах машин, зөөврийн био жорлонгийн тусламжтай хөрсний бохирдолгүй тэмдэглэж, 12 тонн ялгадсаар хөрс бохирдохоос урьдчилан сэргийлж ажилласан. Аймгийн хэмжээнд 2025 онд айл өрхүүд 85691 ширхэг мол. бүт. ойжуулалт нөхөн сэргээлтийн	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
167	264	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан 2024 онд багтаан хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухай 2024-09-18 Дугаар 2024_01_1	1.14.. Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэх, эрсдэлийн удирдлагын реформыг хэрэгжүүлэхийг Шадар сайд (бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал хариуцсан) С.Амарсайхан, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	Үндэсний аюулгүй байдлын зөлвөлийн ажлын албанаас аймгийн 16 сумдад Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх, ойлголт, хэрэглээ, чиг хандлага сэдэвт номыг хүргүүлсэн. Булган аймгийн төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын албан хаагчдад Монгол улсын Ерөнхийлөгчийн аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх хошууч генерал Д.Баасандамба "Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх" сэдвээр илтгэл лекц уншсан.	Зохион байгуулалтаас - 0%	Зохион байгуулалтаас - 0%		Үгүй	
168	265	ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ТУХАЙ 2025-03-06 Дугаар 2025_02	1.2.13. 1.2.13.хот, суурин газарт үерийн болон бусад гамшгийн эрсдэлийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээг хийж, инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэхийг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Аймгийн Засаг даргын "Эрсдэлийн ерөнхий үнэлгээний ажлын хэсэг томилох тухай" А/116 дугаар захирамаар бүх төрлийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсгийг байгуулж, "Зудын эрсдэл", "Шар усны үерийн эрсдэл", "Ой, хээрийн гал түймрийн эрсдэл", "Үерийн эрсдэл"-ийн ерөнхий үнэлгээг ХХААГ, УЦУОШТ, ГХБХБГ, ХХҮГ-тай хамтран хийж, дүгнэлт, зөвлөмж, гаргаж сумдад хүргүүлсэн. Булган аймагт 2024-2028 онд хэрэгжүүлэх "Дэд бүтцийн сэргэлт" дэд хөтөлбөрийн хүрээнд мастер төлөвлөгөө боловсруулах ажлыг тусган, Булган аймгийн инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөний төслийг боловсруулж ХББОСЯ-д хянуулахаар хүргүүлсэн.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%		Үгүй	
	266		1.2.14. 1.2.14.ус хангамж, ариутгах татуурга, орон сууц, нийтийн аж ахуйн салбарын мастер төлөвлөгөөг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж аймаг, нийслэл бүрээр гаргаж, бодлогын түвшинд хэрэгжүүлэхийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны "Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрийн "Дэд бүтцийн сэргэлт" дэд хөтөлбөрийн хүрээнд Булган аймгийн инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөний төслийг боловсруулж ХББОСЯ-д хянуулахаар хүргүүлсэн. Орон сууц, нийтийн аж ахуйн чиглэлээр Рашаант сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг баталж, газар зохион байгуулалт хот төлөвлөлтийн цахим системд оруулсан. Булган сумын төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг 150.0 сая төгрөг, гэр хорооллын суурьшлын бүс нэмэгдүүлэх хэсэгчилсэн төлөвлөгөөг 80.0 сая төгрөгөөр хийлгэхээр даалгавар боловсруулж, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулж, "А И СИ архитектур" ХХК гүйцэтгэж байна. Хангал, Могод, Бүрэгхангай сумын төвийн хэсэгчилсэн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийлгэх ажлын хөрөнгийг сумын ИТХ-аар батлуулахаар өргөн барьсан.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%		Үгүй	

267	1.1. 1.1."Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлого, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан аймаг, нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх;	Булган аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050", дунд хугацааны "Шинэ сэргэлтийн бодлого" зорилтот хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон бусад бодлогын баримт бичгийг үндэслэн боловсруулаа. Хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааг Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан тодорхойлсон. Мөн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны сонгуульд оролцсон Монгол Ардын нам, Ардчилсан намын мөрийн хөтөлбөр, төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд, иргэд, олон нийтийн саналд үндэслэсэн болно. Тухайлбал, аймгийн 16 сум, 1 тосгон, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 24 агентлагаас саналыг нэгтгэн авч нийгмийн салбарын болон Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн харьяа агентлаг, байгууллага бизнес эрхлэгчидтэй хийсэн уулзалт хэлэлцүүлэгт оролцогчдоос 114 санал, цахим хуудас, нээлттэй утсаар 74 санал, аймаг, сумын ИТХ, түүний төлөөлөгчид, Засаг даргын Тамгын газар, төрийн байгууллагуудаас 499 санал, иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагуудаас 18 санал, нийт 705 санал ирүүлснийг хөтөлбөрийн төсөлдөө тусгасан. Хөтөлбөрийн зорилгыг "Булган аймгийн сэргэлт нь ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ бий болгож, ҮЙЛЧИЛГЭЭГ сайжруулан, бизнесийн таатай орчныг бүрдүүлж, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛСЭН, иргэд нутагтаа ая тухтай, амар тайван, аз жаргалтай амьдрах"-д оршино гэж тодорхойлон, аймгийн ИТХ-ын 2024 оны IV/23 тогтоолоор батлуулсан "Булганы сэргэлт"	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
268	1.2. 1.2.Орон нутгийн 2026 оны төсвийн төслийг хүний хөгжлийг дэмжсэн байхаар төлөвлөх, төсвийн төсөлд тусгах төсөл, арга хэмжээний саналыг урьдчилан тооцоолж, бэлтгэх;	Орон нутгийн 2026 оны төсвийн төслийг төлөвлөхдөө хүний хөгжлийг дэмжих төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх, өмнөх оны хүний хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийн хувь, хэмжээг бууруулахгүй байх, нэмэгдүүлэн тооцох чиглэлийг барьж Нийгмийн салбарын байгууллагуудын (Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, биеийн тамир спорт) 11 арга хэмжээнд 2.9 тэрбум төгрөгөөр тооцож бэлтгэсэн.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
269	1.3. 1.3.Бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдааныг бүс бүрд зохион байгуулж, бүсүүдийн 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, бүс бүрд хэрэгжүүлэх шаардлагатай 5 мега төслийн жагсаалт гаргах;	Энэ оны 04 дүгээр сарын 27, 28, 29-ний өдрүүдэд Булган аймагт Хангайн бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдаан, Монгол Улсын Засгийн газрын хуралдаан зохион байгуулагдсан. Тус хуралдаанд 9 төсөл арга хэмжээний саналыг хүргүүлснээс Булган аймагт 5 төсөл арга хэмжээ, бүсийн хэмжээнд 17 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр Засгийн газрын тогтоолоор батлагдсан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Тийм	Хэрэгжиж дууссан
270	1.4. 1.4.Бүс, орон нутгийнхаа сайн туршлага, шинэ санаачилга, инновац нэвтрүүлсэн туршлагыг олон нийтэд таниулах, түгээх, бусад аймаг, нийслэлтэй туршлага солилцох;	Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Монгол Улсын Төрийн албаны зөвлөл үүсэн байгуулагдсаны 30 жилийн ойг тохиолдуулан Монгол улсын нийслэл, 21 аймгийн Нутгийн захиргааны байгууллагуудын төрийн үйлчилгээнд нэвтрүүлсэн бүтээлч санаачлалыг тодорхойлох, түгээн дэлгэрүүлэх, төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулсан "Бүтээмж ба инноваци-UB 2025" болзолт уралдаанд Худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээ, хоршооны бодлого хариуцсан мэргэжилтэн амжилттай оролцож, "Булган аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулах нь" Шилдэг сайн туршлагаараа манлайлан, Гутгаар байрт шалгарсан. Мөн аймаг, нийслэлийн сайн туршлагуудаас суралцаж мэдээлэл солилцож ажиллав.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
271	1.5. 1.5."Шинэ сэргэлтийн бодлого"-ын Хөдөөгийн сэргэлт зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг эрчимжүүлэх, үр дүнтэй зохион байгуулах;	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/263 дугаар тушаалаар Тариалангийн талбайг хамгаалж ойн зурвас байгуулах зориулалтаар балансаас балансад шилжүүлсэн 51000 ширхэг энгийн шон, 550 ширхэг булангийн шон хүлээн авч, 38 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан, 45591 ширхэг энгийн шон, 550 ширхэг булан шонг олгосноор 227.9 мянган га талбайг хашаажуулсан.	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%		Үгүй	

272	1.6. 1.6.Аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх агентлаг, сум, дүүргийн удирдлагын үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангаж, иргэд, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч шуурхай шийдвэрлэх, үйл ажиллагааг цахимжуулж, олон нийтэд нээлттэй, ил тод тайлагнаж, хяналтыг бий болгох;	Иргэдээс төрийн байгууллага болон албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл гомдлыг бичгээр, биеэр, цахимаар, нээлттэй утас гм хэлбэрээр хүлээн авч ажиллаж байна. 16 сум 1 тосгон, 24 байгууллага нь албан ёсны вэб сайттай бөгөөд өөрийн вэб сайтаа иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг хүлээж авах цэсийг бий болгосон. Аймгийн хэмжээнд 2025 онд нийт 2470 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирүүлснийг хүлээн авч, шийдвэрлэсэн. Нийт ирсэн өргөдөл гомдлын 92 нь буюу 3.7 хувь нь Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төвийн 11-11 дугаараас шилжүүлсэн, 76.8 хувь нь аймгийн ИТХ-ын ажлын алба, аймаг, сумдын ЗДТГ, агентлагуудад утсаар, цахимаар, болон өөрийн биеэр ирж бичгээр гаргасан өргөдөл, 19.5 хувь нь ААНБ, хуулийн этгээдээс албан бичгээр ирүүлсэн өргөдөл байна. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэн, 1179 өргөдлийн хариуг албан бичгээр хүргүүлэн, 131 өргөдлийг харьяаллын дагуу шилжүүлж, 140 иргэнд цахимаар, 495 иргэнд утсаар, 506 иргэнтэй биечлэн уулзаж шийдвэрлэлтийн талаар мэдэгдэв. Хугацаа болоогүй, шийдвэрлэх шатанд байгаа өргөдөл нийт өргөдлийн 1.4 хувийг эзэлж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
273	1.7. 1.7.Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглал, менежментийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнд хяналт тавих;	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн менежментийг сайжруулах зорилгоор 2025 онд БУЛГАН-МЭЭЖ, Хөдөө аж ахуй-Хөгжлийг ирээдүй ОНӨХХК-д баримтын иж бүрэн шалгалт хийж, үр дүнг Аймгийн Засаг даргад танилцуулсан. Компанийн засаглалын чиглэлээр дээрх 2 компанийн ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх захирлыг Худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран 16 цагийн танхимын сургалтад хамруулж, 15 хүнд гэрчилгээ олголоо. Аймгийн ИТХ-ын тогтоолоор батлагдсан орон нутгийн өмчит компанийн ТУЗ-ын гишүүд "БУЛГАН МЭЭЖ-ийн ТУЗ хуралд 3 удаа оролцож, 2025 оны санхүүгийн төлөвлөгөө, "Энэржи плас" ХХК-тай үүссэн өр төлбөр, түүнийг хэрхэн барагдуулах, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, түүнд нэмэлт өөрчлөлт талаар хэлэлцэж, шийдвэрлэх саналыг аймгийн ИТХ-д уламжилсан. "ХААХИ" ОНӨХХК, "Илчит Хутаг" ОНӨХХК-ны ТУЗ-ийн хуралд 3 удаа оролцож 2024 оны тайлан, 2025 оны төлөвлөгөө, төсөвт хяналт тавьж үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр тус бүр 3 удаа мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй ОНӨХХК-ны 2025 оны Санхүү, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Аймгийн ИТХ-ын 2025 оны VIII/59 дүгээр тогтоолоор 634.3 сая төгрөгийн орлоготой, 606.3 сая төгрөгийн зарлагатай, 25.3 сая төгрөгийн ашигтай, "Булган Мээж" ОНӨХХК-ийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 2025 оны VII/42 дугаар тогтоолоор 582.1 сая төгрөгөөр, "Тэшиг-Ус" ОНӨААТҮГ-ын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг ТУЗ-ийн 2025 оны 01 дүгээр тогтоолоор 511.8 сая төгрөгөөр, "Илчит Хутаг" ОНӨХХК-ний 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг ТУЗ-ийн 2025	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

274	1.8. 1.8.Бус, орон нутгийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, халамжаас хөдөлмөрт шилжүүлэх зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ хэрэгжүүлэх;	Арга хэмжээнд хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн ажлын байрыг хадгалах, шинээр ажлын байр бий болгох зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас иргэн, аж ахуй эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 62 иргэнд 600 сая төгрөг, малжуулах арга хэмжээнд 60 өрхөд 480 сая төгрөг, ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 30 ахмад настанд 250 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих арга хэмжээнд 20 иргэнд 160 сая төгрөг буюу нийт 1.5 тэрбум төгрөгийг зарцуулж, 236 иргэнийг хамруулан, 201 иргэний ажлын байрыг хадгалж, 32 иргэнд шинээр ажлын байр бий болгосон байна. Халамжаас-Хөдөлмөрт дэвших зорилтын хүрээнд "Зөв өрх-20" арга хэмжээг хэрэгжүүлэхээр сум тус бүрээс 20, Булган сумын баг тус бүрээс 10, нийт 380 өрхийг сонгон авч, тус өрхүүдийн хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн нөхцөлд үнэлгээ хийж, өрхийн хөгжлийг дэмжих төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна. Жилийн эцсийн байдлаар байнгын ажлын байранд 101 иргэн, түр ажлын байранд 66 иргэн, төсөл хөтөлбөрт 45 өрхийг тус тус хамруулж, ажил орлоготой болгосон. Сургалт нөлөөллийн ажилд 209 иргэнийг хамруулан, 84 өрхийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулж, нийт сонгогдсон өрхийн 319 өрх буюу 84 хувьд хүрч ажилласан байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
275	1.9. 1.9.Бус, орон нутагт шилжин суурьшиж буй өрх, иргэн, бизнесийн салбараа нээж буй аж ахуйн нэгжийг дэмжих төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах;	"Премиум нексус" ХК-ийн "SU" сүлжээ дэлгүүр, "Сайн электроникс", "Арина электроникс" цахилгаан барааны дэлгүүрүүд Булган аймагт салбараа нээж шинээр үйл ажиллагаа явуулж, орон нутгийн иргэдийг ажлын байраар хангаж байна. Дээрх аж ахуйн нэгжүүдэд орон нутгаас хамааралтай зөвшөөрөл олгож, дэмжлэг үзүүлж байна. Аймгийн Засаг даргын захирамжаар "Хөдөөгийн сэргэлт"-ийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх ажлын хэсэг томилогдож, нэгдсэн төлөвлөгөө боловсруулж, батлуулан ажиллаж байна. Бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулж, эдийн засгийн өсөлтийн төвүүд буюу сум дундын үйлдвэрлэлийн төвүүдэд бүтээн байгуулах үйлдвэрлэл худалдаа, тээвэр логистикийн ТЭЗҮ боловсруулах ажил Бүсчилсэн хөгжлийн газрын захиалгаар Системийн динамик загварчлал ТББ гүйцэтгэж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
276	1.10. 1.10.Бус, орон нутгийн эдийн засгийн тэргүүлэх салбарын бүтээн байгуулалтад шаардлагатай ажиллах хүчний хэрэгцээг салбар дундын хөдөлмөр эрхлэлтийн бодлого, төсөл, арга хэмжээтэй уялдуулж, хэрэгжүүлэх чиглэлээр төрийн захиргааны төв болон холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;	Аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх "Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн тэргүүлэх салбаруудад нэн хэрэгцээтэй байгаа мэргэжилтэй ажилтнуудыг орон нутагтаа бэлтгэн, хөдөлмөрийн зах зээлд нийлүүлэх зорилгоор ХААИС-ийн харьяа Булган аймаг дахь Политехникийн коллежийн багш суралцагчдад чиглэсэн "Чадварлаг мэргэжилтэн" хөтөлбөрийг аймгийн ИТХ-ын 2025 оны IX/70 дугаар тогтоолоор батлууллаа. Тус хөтөлбөрийн хүрээнд 2025 онд ОХУ, БНСУ, БНХАУ зэрэг улсад 29 багш, 11 суралцагчийг сургалтад хамруулсан. 2025-2026 оны хичээлийн жилд политехникийн коллежид мэдээллийн технологийн ангийг шинээр нээж, 15 оюутан суралцаж байн. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт 2025 онд иргэн, аж ахуйн нэгжээс давхардсан тоогоор 1918 ажлын байрны захиалга ирж, 1053 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучлан ажилласан. Үүнээс байнгын ажлын байранд 517, түр ажлын байранд 304, улирлын ажлын байранд 232 иргэн тус тус зуучлуулсан байна. Ажилд зуучлагдсан 444 иргэнийг хөдөлмөр эрхлэх үр чадварын үнэлгээнд хамруулж, ажиллах хүчний хэрэгцээ шаардлагыг тодорхойлж ажиллав. Мөн шинээр бий болсон 1110 ажлын байрыг бүртгэлжүүлж ажилласнаас байнгын ажлын байр 471, улирлын ажлын байр 360, түр ажлын байр 279 байна. Эдийн засгийн үйл ажиллагааны чиглэлээр авч үзвэл ажилд зуучлагдсан иргэдийн 474 буюу нийт зуучлагдсан иргэдийн 45 хувь нь хөдөө аж ахуй, ойн аж ахуйн салбарт ажиллаж байгаа бол шинээр бий болсон ажлын байрны 628 буюу 47 хувь нь мөн л хөдөө аж ахуй, ойн аж ахуйн салбарт бий болсон байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

277		1.11. 1.11. Зорилтот өрх, иргэнийг хөгжүүлэх, чадавхжуулах, бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээг шинээр нэвтрүүлж, бага орлоготой өрхийн тогтвортой амьжиргааг дэмжих төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх;	"Халамжаас хөдөлмөрт" арга хэмжээний хүрээнд нийгмийн халамжийн дэмжлэг зайлшгүй шаардлагатай 101 иргэнийг байнгын, 66 иргэнийг түр ажлын байранд зуучилж, хүнс тэжээлийн дэмжлэгт 325 өрхийг хамруулан 187.0 сая төгрөг, хувиараа хөдөлмөр эрхлэгч 44 иргэнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 350.8 сая төгрөг тус тус олгож өрхийн орлогыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгууллаа. Зорилтот бүлгийн хөдөлмөрийн насны, хөдөлмөр эрхлэх чадвартай иргэдэд суурь ур чадвар олгох сургалтыг Рашаант, Хишиг-Өндөр, Орхон, Булган, Бугат сумын 165 зорилтот бүлгийн иргэнд зохион байгуулав. Аймгийн хэмжээнд "Зөв өрх-20" арга хэмжээг хэрэгжүүлж, сум тус бүрээс 20, Булган сумын баг тус бүрээс 10 өрхийг сонгон, нийт 380 өрхийн гишүүдийг нийгмийн суурь үйлчилгээнд бүрэн хамруулж, хөгжүүлэн, бие даан амьдрах боломжийг нэмэгдүүлэхээр ажиллаж байна. 2025 онд дээрх өрхүүдээс 316 өрхийг эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын арга хэмжээнд хамруулан, хөдөлмөр эрхлэх боломжтой 71 иргэнийг байнгын, 231 иргэнийг түр ажлын байранд зуучиллаа. Мөн Хангал суманд тогоочийн мэргэжил олгох сургалтыг 17 иргэнд зохион байгуулах гэрээг Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Политехникийн коллежтой байгуулж, холбогдох материалыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сургалт, судалгааны хүрээлэнд хүргүүлсэн. Сумдад хийх нарийн мэргэжлийн эмч нарын явуулын үзлэгийг 10 суманд зохион байгуулж, тус үзлэгт "Зөв өрх 20" арга хэмжээнд хамрагдаж буй 149 өрхийн 496 иргэн, 101 хүүхдийг хамруулсан байна. "Зөв өрх 20" арга хэмжээг 4 жилийн хугацаанд сонгогдсон өрхийг өөрчлөхгүйгээр, дэмжлэгт арга хэмжээнүүдэд хамруулан, хэрэгжүүлсэн ажлын үр дүнд нийт өрхийн 80-аас лоплогий	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
278	ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДУУЛАН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАСТ ОРОН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2025-03-07 Дугаар 2025_03	1.12. 1.12. Аймаг, нийслэлийн хэмжээнд оюутан, залуучуудын чөлөөт цагаараа ажил, хөдөлмөр эрхлэх, гарааны бизнес эрхлэх, нийгмийн идэвх, оролцоог дэмжих чиглэлээр төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх	Аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх "Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрийг "Хүний хөгжлийн сэргэлт"-ийн хүрээнд нийгмийн халамж, хамгааллын чиглэлээр ТЭЗ-ын 1 зорилт, Хөтөлбөрийн 1 зорилт, үйл ажиллагааны 3 зорилтыг боловсруулан аймгийн ИТХ-аар батлуулан хэрэгжүүлж байна. "Булганы сэргэлт" хөтөлбөрийн хүрээнд залуусуудыг нийгмийн оролцооны бүх талаас нь дэмжиж, хөгжүүлэх "Залуусын хөгжил", мэргэжилтэй ажилтнуудыг орон нутагтаа бэлтгэж, ажлын байрны эрэлт ихтэй салбаруудын хүний нөөцийг хангах зорилгоор ХААИС-ын харьяа политехник коллежийн багш, сурагчдыг хөгжүүлэх "Чадварлаг мэргэжилтэн" хөтөлбөрийг тус тус аймгийн ИТХ-аар батлуулан хэрэгжүүлэв. "Залуусын хөгжил" хөтөлбөрийн хүрээнд энэ онд Япон улсын Good сайн дурын байгууллагатай хамтран ажиллаж, 20 оюутан, залуусыг Япон улсад 7 хоногийн хугацаатай сайн дурын ажилд оролцуулж, орон нутгийн төсвөөс 9.9 сая төгрөг зарцуулсан. "Чадварлаг мэргэжилтэн" хөтөлбөрийн хүрээнд ОХУ, БНСУ, БНХАУ зэрэг улсад 29 багш, 11 суралцагчийг сургалтад хамруулсан. Политехник коллежийн 2025-2026 оны хичээлийн жилд Мэдээллийн системийн мэргэжлийн ангийг шинээр нээж, тус мэргэжлээр 15 элсэгч суралцаж байна. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих "Старт-ап" арга хэмжээг энэ онд бүсийн хэмжээнд болон аймгийн хэмжээнд 2 удаа зохион байгуулсан. Орхон аймагт зохион байгуулсан бүсийн арга хэмжээнд Булган аймгийн баг 1 дүгээр байранд шалгарч 20.0 сая төгрөгийн санхүүжилт авсан бол аймгийн "Старт ап" арга хэмжээнд 5 сумын 10 багийн 35 залуус өрсөлдсөнөөс Булган, Хишиг-Өндөр сумдын 2 баг тус бүр 15.0 сая төгрөгийн санхүүжилт олгон, нийт 3	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

279

1.13. 1.13. Аймаг, нийслэлийн хэмжээнд идэвхтэй хөдөлгөөн, эрүүл хооллолтыг хэвшүүлэх, биеийн тамирын дасгал сургуулилтаар хичээллэх боломж, хүртээмжийг нэмэгдүүлэх;	Аймгийн хэмжээнд хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдрыг хөгжүүлэх, спортын олон төрөлд сонирхолтой иргэдийг тогтмол хамруулах зорилгоор волейбол, сагсан бөмбөг, бокс, жүдо, ширээний теннис, шатар, таеквондо, үндэсний бөх, буудлага, цана, тэшүүр, хөнгөн атлетик, үндэсний сур зэрэг спортын 13 төрлөөр албан ёсны 25 секц, дугуйланд 3236 хүүхэд тогтмол хичээллэж байна. Хамрагдалт өмнөх оноос 3.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх, иргэдийн идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагад спортын 40 хамтлагийг шинээр байгуулж, "Идэвхтэй алхалтад – Цаг гаргая" аяны хүрээнд байгууллагын ажилтан, албан хаагчид өдөр бүр 30 минут идэвхтэй алхах, ажлын байрны дасгал хөдөлгөөн хийх дадлыг төлөвшүүлэн, өөрсдийн цахим хуудсаар олон нийтэд уриалан сурталчилсан.Ахмадын шугаман бүжгийн 5 хамтлаг тогтмол үйл ажиллагаа явуулж байна. Тухайлбал: Булган суманд ахмадын 4 шугаман бүжгийн хамтлаг, Дашинчилэн суманд "Ахмадын золбоо" шугаман бүжгийн хамтлагууд амжилттай үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эдгээр хамтлагуудад орон нутгийн төсвөөс 5.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн нийт 72 ахмад настан идэвхтэй хичээллэж байна.Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, иргэдэд зориулсан стандартын шаардлага хангасан спорт талбайн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Булган сумын соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнд орон нутгийн төсвийн 1.3 тэрбум төгрөгийн санхүүжилтээр явган хүний зам, хүүхэд бүрийн насны онцлогт тохирсон тоглоомын талбайн бүтээн байгуулалт хийгдлээ. Мөн улсын төсвийн 1676.4 сая төгрөгийн санхүүжилтээр 6 сумдал хүүхдийн тоглоомын талбайн	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
1.14. 1.14. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих, арчилж ургуулах ажлыг эрчимжүүлэх;	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний зорилт, арга хэмжээний хүрээнд аймгийн хэмжээнд 2025 онд мод үржүүлэг, нийтийн эзэмшлийн ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлт, зүлэгжүүлэлтийн зориулалтаар 2 нэгж талбарын 8.6 га газрыг хууль тогтоомжийн дагуу эзэмшүүлэн, хэрэгжүүлж байна. Мөн Монгол Улсад ойн салбар үүсэж хөгжсөний 100 жилийг тохиолдуулан Булган сумын 1-р багийн "Цэцэг толгой" гэх газарт 5 га талбайг 2024 онд хашаажуулж шинээр "Ногоон төгөл" байгуулсан. 2025 оны хавар мод бэлтгэлийн 28 аж ахуйн нэгж, байгууллага ногоон байгууламжид 1400 ширхэг шар хуайс тарьж, намар нөхөн тарилт хийлээ. "Бүх нийтээр мод тарих өдөр"-ийг тохиолдуулан Булган суманд үйл ажиллагаа явуулж байгаа 32 байгууллагын 71 алба хаагчдад мод тарих ажлын талаар сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгууллаа. Байгууллагын вэб хуудас болон албан ёсны цахим хуудсанд мод тарих заавар, зөвлөмж, бусдыг уриалах 2 удаагийн давтамжтай 1 шторк, 3 постыг оруулж 974 хүнд хүрсэн байна. Уг мэдээллийг 14 хоногийн турш сэргээн байршуулснаар давхардсан тоогоор 2820 хүнд мэдээлэл авчээ. Хавар, намрын тарилтаар 443905 ширхэг мод, бут тарьж, арчилж байна. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлж эхэлснээс хойш тарьсан нийт модны тоо 921105 болсон байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

280

281	1.15. 1.15. Хот, суурин газрын хог хаягдлын менежментийг төр-хувийн хэвшлийн оролцоотой сайжруулах, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх;	Хог цуглуулах, тээвэрлэх байгууллагуудыг хувийн хэвшилд шилжүүлэх талаар чиглэлийг сумдын Засаг дарга нарт хүргүүлсэн. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх ажлыг Хутаг-Өндөр сум "Илчит-Хутаг Эв"ХХК, Тэшиг сум "Тэшиг ус" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна. Хишиг-өндөр сум хувиараа үйл ажиллагаа явуулдаг 2 иргэнтэй хөлсөөр ажиллуулах гэрээ байгуулан, хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх ажлыг гүйцэтгүүлсэн байна. Уг гэрээгээр дээрх иргэд хог хаягдал зохицуулах төвийн техникчээр ажиллаж, хог боловсруулах техникийн үйл ажиллагааг хариуцах болон ачих үйлчилгээ үзүүлэх ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, төвийн үйл ажиллагааг тогтвортой явуулж байна. Аймгийн төв Булган сумын хог хаягдал тээвэрлэлтийн ажлыг Булган сумын Тохижилт үйлчилгээний анги гүйцэтгэж байна.Нийтийн эзэмшлийн талбайн эзэнгүй хог хаягдлыг бууруулах зорилгоор аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/193 дугаар захирамжаар батлагдсан "Цэвэр орчин-Цэмцэгэр Булган" аяныг аймгийн 16 сум, 1 тосгонд зохион байгууллаа. Аяны хүрээнд нийт 38531.03 га талбайн 3757.3 тонн хог хаягдал, мөн 132 гол горхины эрэг орчмоос 56.5 тонн хог хаягдлыг цэвэрлэж нийт 70.1 сая төгрөгийг зарцуулсан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
282	1.16. 1.16. Саарал усны хэрэглээ, усны дахин ашиглалтыг нэмэгдүүлэх;	Гурванбулаг сумын ахуйн үйлчилгээний гадна бохир усны шугамын угсралтын ажлыг "Баян-Өндөр булаг" ХХК 120.0 сая төгрөгөөр гүйцэтгэн ашиглалтад оруулсан. Сэлэнгэ сумын төвийн цэвэрлэх байгууламж саарал ус шүүрүүлэх талбайн ажлыг байгаль хамгаалах сангийн 591.5 сая төгрөгөөр "Хулдын бүлэн ХХК гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өгсөн. Хангал сумын төвийн цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугамын ажлын зургийг "Нарлаг хөхий" ХХК 60 сая төгрөгөөр гүйцэтгэж байгаа бөгөөд төсөвт өртөг 1.8 тэрбум төгрөг гарч хөрөнгө оруулалтад тусгуулахаар санал хүргэгдсэн. Орхон сумын цэвэрлэх байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын даалгавар хийгдэж байна. Могод сумын цэвэрлэх байгууламжийн зураг төсөл хийгдэж хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхээр холбогдох газарт санал хүргүүлсэн. Баяннуур сумын цэвэрлэх байгууламжийн зураг төслийг Эдийн засгийн хөгжлийн яамнаас хийлгэхээр судалгааны ажил хийгдэж байна. Гурванбулаг сумын цэвэрлэх байгууламжийн зураг төслийг "Хатанбаатар" ХХК 81.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулах шатандаа байна. Бугат сумын цэвэрлэх байгууламжийн зураг төсөл боловсруулах даалгаврыг боловсруулан тус суманд хүргүүлсэн. .Булган аймгийн хэмжээнд төв, суурин болон аж ахуйн нэгж, байгууллагын нийт 16 ариун цэврийн байгууламж хаягдал усыг дэвшилтэт технологиор цэвэрлэж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
283	1.17. 1.17. Гэр хорооллын айл өрхүүдийн дулаан алдагдлыг бууруулж, эрчим хүчний хэмнэлт бий болгох төсөл хэрэгжүүлэх;	Хэрэгжээгүй	Хэрэгжүүлэх зардал, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй	Хэрэгжүүлэх зардал, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй		Үгүй	

284	1.18. 1.18. Хот, суурин газарт үер ус зэрэг гамшгийн эрсдэлийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээг хийж, гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;	Аймгийн Засаг даргын 2024.03.04-ний өдрийн "Эрсдэлийн ерөнхий үнэлгээний ажлын хэсэг томилох тухай" А/116 дугаар захирамжийн хавсралтаар бүх төрлийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсгийг байгуулж, "Зудын эрсдэл", "Шар усны үерийн эрсдэл", "Ой, хээрийн гал түймрийн эрсдэл", "Үерийн эрсдэл" ерөнхий үнэлгээг ХХААГазар, УЦУОШГазар, ГХБХБГазар, ХХҮГазруудтай хамтран хийж дүгнэлт, зөвлөмж, гаргаж сумдын Засаг дарга нарт хүргүүлсэн. Үерийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийж ажиллахад Булган, Сайхан, Хутаг-Өндөр, Тэшиг, Сэлэнгэ, Хангал, Хялганат тосгон, Орхон, Баян-Агт сумдад үерийн эрсдэл ИХ эрсдэлтэй. Могод, Баяннуур, Бугат, Бүрэгхангай, Хишиг-Өндөр, Дашинчилэн, Гурванбулаг, Рашаант сумдад үерийн эрсдэл ДУНД эрсдэлтэй үнэлэгдсэн. 2025 онд аймгийн хэмжээнд үер усны аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр аймгийн Засаг даргын захиражаар томилогдсон ажлын хэсэг 4 удаа үзлэг хийж, дүгнэлт гарган, ажлын хэсгээс 2 удаа зөвлөмж гаргаж, холбогдох байгууллага, сумдад хүргүүлж Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, ажилласан. Үүний үр дүнд хот суурин газарт томоохон үерийн эрсдэлд өртсөн байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх байхгүй байна. Энэ онд Булган суманд орон нутгийн төсвийн 50.0 сая төгрөгөөр үерийн далангийн засвар, цэвэрлэгээг хийж гүйцэтгэсэн.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
285	1.19. 1.19. Хот, суурин газарт авто машингүй гудамж бий болгох, явган хүний болон дугуйн зам, байгууламж, авто зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлэх;	Иргэдэд зориулсан стандартын шаардлага хангасан заал, талбайг нэмэгдүүлэх зорилгоор Булган сумын соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнд орон нутгийн төсвийн 1.3 тэрбум төгрөгийн санхүүжилтээр явган хүний зам, хүүхэд бүрийн насны онцлогт тохирсон тоглоомын талбайн бүтээн байгуулалт хийгдлээ. Булган сумын нийтийн 2000 м2 зогсоол шинээр барих ажлыг 3 багц болгон тендер зарлаж, орон нутгийн төсвийн 59.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж, байнгын ашиглалтад оруулсан. Аймгийн хэмжээнд авто машингүй гудамж бий болгох хэрэгцээ, шаардлага үүсээгүй байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
286	1.20. 1.20. Малчдад өвөлжөө, хаваржааны газрыг урт хугацаатай ашиглах боломж бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх нөхцөлөөр хангах;	Малчдын өвөлжөө хаваржааны газрыг аймгийн хэмжээнд 15-40 жилийн хугацаатай газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх нөхцөлөөр ханган ажиллаж байна. Өвөлжөө, хаваржааны газрын зориулалтаар 2025 онд мал аж ахуй эрхлэгч аж ахуйн нэгж болон малчин иргэдэд 51 нэгж талбар газрыг эзэмшүүлж, газрын кадастрын мэдээллийн санд бүртгэж баталгаажуулсан. Мөн "Шинэ хоршоо" хөдөлгөөний хүрээнд 17 хоршоонд 68.69 га газрын олголт хийгдсэн.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
287	1.21. 1.21.Бүс, орон нутгийн онцлогт тохирсон үржлийн цөм сүрэг бий болгох, сүргийн шилэн сонголт хийж өсвөр хээлтүүлэгч бойжуулах арга хэмжээг хэрэгжүүлж, мэргэжлийн байгууллагын хяналтад авах ажлыг зохион байгуулах;	Аймгийн Засаг даргын 2025 оны А/373 дугаар захирамжаар Тэшиг, Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Хангал сумдын Сэлэнгэ үүлдрийн 850 толгой хээлтүүлэгч, 27.4 мянган толгой хээлтэгч, нийт 28.2 мянган толгой үхэр сүрэгт үзлэг ангилалт хийж, 68 толгой өсвөр хээлтүүлэгч, 285 толгой хээлтэгчийг нөхөн тавилаа. Аймгийн хэмжээнд үржилд ашиглагдаж байгаа бог малын хээлтүүлэгчийг ялган суурилж, малчны хариулгатай байна. Бүрэгхангай, Сэлэнгэ, Бугат, Хангал, Гурванбулаг сумын мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжийн хяналтад 720 толгой хуц, ухныг ялган төвлөрүүлж, 12 малчин өрхөд түрээсийн гэрээгээр ашиглуулан 2000 толгой эм хонь, 2600 толгой эм ямааг хээлтүүлэн, 86 хувийн төл хүлээн авч, малын чанарыг сайжруулах ажлыг зохион байгуулсан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

288	1.22. 1.22. Иргэд малчид, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээлийн талаарх мэдээллийг хүргэж, зээлийг үр дүнтэй ашиглах чадавхыг сайжруулах;	"Шинэ хоршоо" хөдөлгөөний хүрээнд Булган аймгийн хэмжээнд 673 хоршоо шинээр байгуулагдаж, 535 хоршооны 1895 малчинд 70.26 тэрбум төгрөгийн зээл олгож, 45 хоршооны 86 малчны 3.5 тэрбум төгрөгийн зээлд 2.0 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан. ХХААХУ-ийн сайдын 2025 оны А/240 дүгээр тушаалаар хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах хүрээнд цэвэр үүлдрийн махны чиглэлийн үхэр үржүүлэх загвар хоршоог шинээр болон шинэчлэн байгуулахаар Хангал сум сонгогдож 300 сая төгрөг баталсан. Холбогдох журмын дагуу сонгон шалгаруулалт хийгдсэн. "Шинэ хоршоо – Чинээлэг малчин" арга хэмжээний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Хойд бүсийн малчид, хоршоологчдод мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, чадавхжуулах зорилгоор "Хоршоологчдын зөвлөгөөн", "Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн худалдаа, арга хэмжээ"-г 2025 оны 04 дүгээр сарын 27,28-ны өдрүүдэд Булган аймагт зохион байгууллаа.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
289	1.23. 1.23. Салбарын хяналт шалгалт давхардаж байгаагаас шалтгаалж аж ахуйн нэгж, байгууллагад учирч буй хүндрэл, чирэгдлийг арилгах, давхардлыг бууруулах;	Булган аймгийн Засаг даргын Тамгын газрын Салбарын хяналт, зохицуулалтын хэлтэс нь 2025 оны байдлаар аймгийн хэмжээнд 33 объектод төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн. Хяналт шалгалтын давхардлыг бууруулах зорилгоор 12 объектод байгаль орчин, хөдөлмөр, газрын тос, хий, эрчим хүч, эрүүл ахуй, эрүүл мэндийн хяналтын байцаагч нартай хамтарсан хяналт, шалгалт хийж, давхардал үүсгэлгүй ажиллалаа.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
290	1.24. 1.24. Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах;	Хот, суурин газарт үеийн болон бусад гамшгийн эрсдэлийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийж, инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөг боловсруулах, ус хангамж, ариутгах татуурга, орон сууц, нийтийн аж ахуйн салбарын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах тухай арга хэмжээг хяналтад авч ажиллав. Тус арга хэмжээний хүрээнд Аймгийн Засаг даргын "Эрсдэлийн ерөнхий үнэлгээний ажлын хэсэг томилох тухай" А/116 дугаар захирамжийн хавсралтаар бүх төрлийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсгийг байгуулж, "Зудын эрсдэл", "Шар усны үерийн эрсдэл", "Ой, хээрийн гал түймрийн эрсдэл", "Үерийн эрсдэл" ерөнхий үнэлгээг ХХААГ, УЦҮОШТ, ГХБХБГ, ХХҮҮ-тай хамтран хийж дүгнэлт, зөвлөмж, гаргаж сумуудад хүргүүлсэн. "Дэд бүтцийн сэргэлт" хөтөлбөрийн хүрээнд мастер төлөвлөгөө боловсруулах ажлыг тусган, Булган аймгийн инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөний төслийг боловсруулж ХББОСЯ-д хянуулахаар хүргүүлсэн. Орон сууц, нийтийн аж ахуйн чиглэлээр Рашаант сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө аймгийн ИТХ-аар батлагдаж Газар зохион байгуулалт хот төлөвлөлтийн цахим системд оруулсан. Булган сумын төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг 150.0 сая төгрөг, гэр хорооллын суурьшлын бүс нэмэгдүүлэх хэсэгчилсэн төлөвлөгөөг 80.0 сая төгрөгөөр хийлгэхээр даалгавар боловсруулж, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, "А И СИ архитектур" ХХК гүйцэтгэж байна. Хангал, Могод, Бүрэгхангай сумын төвийн хэсэгчилсэн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийлгэх ажлын хөрөнгийг сумын ИТХ батлуулахаар өргөн барьсан.	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%		Үгүй	
291	1.25. 1.25. Албан даалгаврын хэрэгжилтийн явцыг сар бүр дүгнэж, мэдээллийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэх.	Албан даалгаврын хэрэгжилтийг 8 дугаар сард 96.0, 9 дүгээр сард 97.0, 10 дугаар сард 92.0, 11 дүгээр сард 95.0 хувийн гүйцэтгэлтэйгээр хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим системд тайлагнасан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

292	1.1.. Шинжлэх ухааны судалгаа, нотолгоонд суурилсан шийдвэр гаргаж, ард иргэдээ сонсон, итгэл, хүлээлт, шаардлагад нь нийцэж ажиллах;	Булган аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа аймгийн 16 сум, 1 тосгон, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 24 агентлагаас саналыг нэгтгэн авч, нийгмийн салбарын болон Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн харьяа агентлаг, байгууллага бизнес эрхлэгчидтэй хийсэн уулзалт хэлэлцүүлэгт оролцогчдоос 114 санал, цахим хуудас, нээлттэй утсаар 74 санал, аймаг, сумын ИТХ, түүний төлөөлөгчид, Засаг даргын Тамгын газар, төрийн байгууллагуудаас 499 санал, иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагуудаас 18 санал, нийт 705 санал ирүүлснийг хүлээн авч, хөтөлбөрийн төсөлдөө тусгасан.Төрийн байгууллагын бодлого, шийдвэрийн хэрэгжилт, үйл ажиллагааг иргэдэд нээлттэй мэдээлэх, олон нийтийн санал хүсэлтийг сонсож, бодлого, шийдвэрт тусгах зорилгоор 14 хоног тутам "Иргэдийн индэр" нэвтрүүлгийг хийж байна. Тус нэвтрүүлгийг "Сайхан Монгол" хойд бүсийн телевиз болон Булган аймгийн Засаг даргын тамгын газрын цахим хуудсаар төрийн болон орон нутгийн өмчит 13 байгууллага, 1 салбар зөвлөл, 1 ажлын хэсэг оролцсон 11 удаагийн дугаарыг шууд дамжуулан хүргэж, давхардсан тоогоор 120 мянган хүн үзсэн байна. "Либерал Эмэгтэйчүүдийн Оюун Сан" ТББ-ын санаачилгаар "Эрүүл амьдрал-идэвхтэй оролцоо" сэдэвт мал эмнэлгийн аюултай хог хаягдлын хор нөлөөг бууруулах асуудлаар зөвшилцөх нийтийн сонсолыг Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Аймгийн Засаг даргын тамгын газар, Мал эмнэлгийн газар, Байгаль орчны газар, Хөдөө аж ахуйн газар хамтран зохион байгуулж, холбогдох төлөөлүүдийг оролцууллаа. Булган аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
293	1.2.. Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг ханган, салбарын удирдлагын манлайллыг мэргэжлийн түвшинд хариуцлагатай хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж ажиллах;	Төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг бэхжүүлэн, төрийн байгууллагын залгамж чанарыг хадгалах зорилгоор "Шинэ, залуу мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт", "Төрийн албаны шинэчлэл, үе шат, сургамж" 3 үеийн уулзалт, арга хэмжээг зохион байгууллаа. Залуу мэргэжилтнүүдийг чадавхжуулах зорилгоор зохион байгуулсан 3 үеийн уулзалтын үеэр төрийн албанд 10 болон түүнээс дээш жил ажиллаж буй туршлагатай төрийн албан хаагчид анх томилогдон ажиллаж буй төрийн албан хаагчдад зориулан тулгамдсан асуудлыг хэрхэн шийдвэрлэх, төрийн албанд ажиллахын бахархал болон давуу талуудыг таниулж, тогтвор суурьшилтай ажиллахыг уриалсан. Тус сургалт, арга хэмжээг 8 суманд байгуулж, 32 байгууллагын 400 гаруй ажилтан, албан хаагч оролцлоо. Төрийн 118 байгууллагын дэргэд ёс зүйн дэд хороо үйл ажиллагаа явуулж, төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, гомдол мэдээллийг хүлээн авч шийдвэрлэх чиглэлээр тогтмол ажиллаж байна. Аймгийн 13 сум, 1 тосгоны 28 байгууллагын 1680 албан хаагч Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн сургалтад хамрагдсан бөгөөд энэ нь аймгийн нийт төрийн албан хаагчдын 40.3 хувийг эзэлж байна. Аймгийн хэмжээнд 2025 онд 2029 өргөдөл, гомдол бүртгэгдсэнээс 63 нь төрийн албан хаагчдын ёс зүйтэй холбоотой байсныг хүлээн авч, хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэсэн. Төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой өргөдөл гомдлын тоо өмнөх оны мөн үеэс 0.5 хувиар буурсан байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

170	294	Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай 2025-06-18 Дугаар 2025_01	1.3.. Яам, харьяа байгууллага, салбарын хэмжээнд сахилга, хариуцлагыг өндөржүүлж, бүх шатанд төсвийн хэмнэлтийн горимыг сахин, үр ашиггүй зардлыг танах, төрийн байгууллагын бүтэц, чиг үүргийн давхардлыг арилгаж, орон тоог үе шаттай цөөлөх;	Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны батлагдсан төсөвт өөрчлөлт оруулан, аймгийн ИТХ-аар батлуулахдаа тэвчиж болох зардлыг 50 хүртэл хувиар бууруулж, төсвийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулахыг үүрэг болгосон. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт хамаарах орон нутгийн төсвөөс санхүүждэг 43 байгууллагын 57 ажлын байрыг цомхотгож, төрийн байгууллагын үр ашиггүй зардлыг танасан. Албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, орон тоог Засгийн газрын тогтоолоор батлагдсан хязгаарт багтаан ажиллахыг чиглэл болгож, сумын Засаг даргын тамгын газрын удирдах болон гүйцэтгэх 22 албан тушаалын тодорхойлолтыг Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн, Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, батлах зөвшөөрөл авсан. Батлах зөвшөөрөл олгосон албан тушаалын тодоорхойлолтыг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр баталгаажуулан ажиллалаа. Аймгийн хэмжээнд төрийн захиргааны 41 байгууллагын 217 албан тушаалын тодорхойлолтыг ХНУМТ цахим системд оруулж, төрийн албаны тусгай шалгалт, сонгон шалгаруулалтыг явуулах, томилгооны зөрчлийг цахим системээр хянах нөхцөлийг бүрдүүлээд байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	295		1.5.. Улс төрөөс ангид, чадахуйн зарчимд суурилсан, хүртээмжтэй, шуурхай, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлж, хүнд суртал, шат дамжлагыг эрс бууруулах бодитой ажлыг зохион байгуулан, тодорхой ахиц гаргаж, үр дүнг тайлагнах;	Булган аймагт төрийн байгууллагын хүний нөөцийг хөгжүүлэх, төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадвар, ажлын туршлагыг нэмэгдүүлэх чиглэлээр 2025 онд олон талт арга хэмжээг зохион байгууллаа. Нийт 86 удаагийн дотоод сургалт, зөвлөгөөн, семинарыг зохион байгуулж, давхардсан тоогоор 5375 төрийн албан хаагч хамрагдсан байна. Мөн төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх иргэдийн санал хүсэлтийг сонсох, төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор "Иргэдийн индэр" уулзалт, шууд нэвтрүүлгийг 14 хоног тутам зохион байгуулж, төрийн албаны үйл ажиллагааг сурталчлах, таниулах, иргэдийн санал, хүсэлтийг бодлого, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх ажлыг хэвшүүлээд байна. Аймгийн хэмжээнд төрийн 118 байгууллагад ёс зүйн дэд хороо ажиллаж, төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр тогтмол ажилласан бөгөөд сургалт нөлөөллийн ажилд 1680 төрийн албан хаагч хамрагдсан нийт төрийн албан хаагчдын 40.3 хувийг эзэлж байна. Булган аймагт үзүүлж буй цахим үйлчилгээний төрөл 63 болж нэмэгдсэн. Цахим шилжилт, үйлчилгээний хэлтэс болон 16 сум, 1 тосгоны ХУРДАН цэгээс операторын горимоор нийт 8456 иргэн цахим үйлчилгээ авч, ХУРДАН киоск төхөөрөмжөөс 18968 лавлагаа тодорхойлолтыг олгосон байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	296		1.6.. Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх бодитой арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Төр, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхэд онцгойлон анхаарч сум, байгууллагууд оны эхэнд "Төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэх ажлын жагсаалт"-ыг батлан гаргаж, иргэд, олон нийтэд мэдээлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд төрийн бус байгууллагуудтай хамтран сургалт зохион байгуулж, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд ажлын байр нэмэгдүүлэх, хүүхэд, эмэгтэйчүүд, залуучууд, ахмад настны эрх хамгаалал, эрүүл амьдрах идэвхийг өрнүүлэх, эрх зүйн боловсрол олгох, мал, амьтны эрүүл мэндийг сайжруулах, тоо толгойг өсгөх, аялал жуулчлал, төрийн үйлчилгээ, спортын чиглэлээрх 66 төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагууд хамтран 107 ажил, арга хэмжээг зохион байгууллаа. Арга хэмжээг зохион байгуулахад орон нутгийн төсвөөс 38.0 сая төгрөгийг зарцуулж, давхардсан тоогоор 1000 гаруй иргэн хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээнд хамрагдсан байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
	297		1.7.. Салбарын хэмжээнд нэн тулгамдсан, шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай асуудлыг Засгийн газрын 100 хоногийн төлөвлөгөөнд тусгуулан, шуурхай шийдвэрлэх;	Хамааралгүй заалт	Хэрэгжүүлэх хугацаа тодорхойгүй	Хэрэгжүүлэх хугацаа тодорхойгүй		Тийм	Хэрэгжилтийн хугацаа дууссан.
	298		1.8.. Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаанд оролцох журмыг чанд мөрdej, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгүүдтэй нягт уялдаатай ажиллах, хүндэтгэлтэй хандах.	Хамааралгүй заалт	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй		Тийм	Хамааралгүй заалт

299	2.1.. Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал болон бусад хууль тогтоомжийг чанд мөрдөж, зөрчсөн үйлдэл гаргахгүй байх;	Аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх "Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрт гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлээр 6 үйл ажиллагааг тусган хэрэгжүүлэв. Тус үйл ажиллагааны хүрээнд 2025 онд гадаад харилцааны чиглэлээр хэрэгжүүлэх 8 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг батлан, Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн. Мөн төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах зорилгоор Гадаад харилцааны сайдтай байгуулсан гэрээний холбогдох зүйл, заалт болон бусад хэрэгжүүлэх арга хэмжээг Аймгийн Засаг даргын сум, агентлагийн дарга нартай 2025 онд хамтран ажиллах гэрээнд тусган хяналтад авч, хэрэгжүүлээ. Сумдын Засаг дарга, байгууллагын дарга нарт Засгийн газрын 2013 оны 169 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам"-ын 4.6 дахь заалтыг мөрдөж ажиллах чиглэлийг 2025 оны 01/1869 дугаартай албан бичгээр хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Энэ онд манай аймаг БНСУ-ын 4 орон нутаг, 6 байгууллага, БНХАУ-ын 2 орон нутаг, 1 байгууллага, ОХУ-ын 2 орон нутаг, 1 байгууллага, Япон улсын 1 орон нутаг, 3 байгууллага, 3 олон улсын байгууллага буюу нийт 4 улсын 9 орон нутаг, 14 байгууллагатай гадаад харилцаа, хамтын ажиллагаагаа хөгжүүлэн гадаад бодлогын үзэл баримтлал, бусад хууль, тогтоомжийн хүрээнд хамтран ажилласан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
300	2.2.. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу нууцад хамааруулах шаардлагагүй мэдээллийг зохих журмын дагуу ил болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу нууцад хамааруулах шаардлагагүй мэдээ, мэдээллийг аймгийн ЗДТГ-ын болон сум, агентлагийн цахим хуудас, нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-д мэдээлж хэвшсэн. "Нээлттэй мэдээллийн систем"-д тайлан илгээх 159 байгууллагыг бүрэн бүртгэж, жилийн эцсийн байдлаар 103 байгууллага шилэн shilen.gov.mn-д нууцад хамааралгүй мэдээллийг тайлагнасан байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын шилэн дансны мэдээлэл байршуулалт 4-р улирлын байдлаар 98 хувьтай дүгнэгдсэн.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
301	2.3.. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах үүргийн биелэлтэд харьяа байгууллага, хуулийн этгээдийн хэмжээнд тогтмол хяналт тавьж, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцох;	Булган аймгийн Цахим шилжилт, үйлчилгээний хэлтсээс байгууллагуудын систем хариуцсан албан хаагчид, сумдын Засаг даргын тамгын газар, сургууль, цэцэрлэг, эрүүл мэнд, соёлын төвийн холбогдох ажилтнуудад танхимаар 7 удаа, цахимаар 3 удаа сургалт, зөвлөгөө өгч ажилласан. Мөн www.bulgan.gov.mn сайтын ашиглалтыг сайжруулж https://shilen.gov.mn/ баяжилтыг хийх чиглэлээр 5 удаагийн сургалтыг зохион байгуулсан байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд байнга ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллийг аймгийн цахим хуудас (www.bulgan.gov.mn)-д тогтмол байршуулан ажиллаж байна. Үүний дагуу аймгийн хэмжээнд 171 байгууллага бүртгүүлэхээс татан буугдсан 9 байгууллагыг хасаж, 159 байгууллагыг manage.gov.mn, shilen.gov.mn цахим хуудсанд бүртгэсэн. Тайлант онд 87 байгууллага 86 төрлийн мэдээ мэдээллийн баяжуулалт хийж, холбогдох хуулийн дагуу мэдээ мэдээллийг https://shilen.gov.mn/ сайтад байршуулсан. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 4-р улирлын хэрэгжилт 98.0 хувьтай дүгнэгдсэн. Нээлттэй мэдээллийн системд бүртгүүлсэн боловч 72 байгууллага тайлангаа илгээгүй байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

302	2.4.. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллаж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, хүнд суртал, шударга бус байдалтай тууштай тэмцэх, таслан зогсоох, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглахгүй байх, төрийн байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлэх;	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Эрүүгийн хуулиар 696 төрийн албан хаагчид сургалт зохион байгуулсан. "Булганы өнгө" төрийн бус байгууллагатай хамтран иргэдийн төрийн үйлчилгээний чанар хүртээмжид итгэх итгэл, авлигын тухай ойлголт өгөх зорилгоор эрүүл мэндийн салбарын асуудлыг хөндсөн видео контент бэлтгэн олон нийтэд түгээж, 266 хүн үзэж сонирхсон байна. Мөн 2 удаагийн өдөрлөг зохион байгуулж тараах материал, гарын авлага тараав. Авлигагүй төрийн алба уриан дор төрийн байгууллагуудын дунд "Авлигын эсрэг нэгдье" видео уралдааныг зохион байгуулж, уралдаанд Улсын бүртгэлийн хэлтэс, Стандарт хэмжил зүйн хэлтэс шагналт байруудад шалгарлаа. Энэ онд авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдсон иргэн, хуулийн этгээд бүртгэгдээгүй байна. Аймгийн хэмжээнд төрийн 118 байгууллагын дэргэд ёс зүйн дэд хороо ажиллаж, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, ёс зүйн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
303	2.5.. Төрийн албан хаагчийг хууль бусаар томилж, чөлөөлөх, аливаа хэлбэрээр дарамт, шахалт үзүүлэхгүй байх;	Төрийн жинхэнэ албаны нөөцийг бүрдүүлэх ерөнхий шалгалтыг 4 удаа зохион байгуулж, шалгалтад 337 иргэн бүртгүүлснээс 238 иргэн оролцож, 94 иргэн тэнцэн нөөцөд бүртгэгдсэн. Шалгалтын нэгдсэн дүнгээр нийт оролцсон иргэдийн 39.4 хувь нь тэнцсэн байна. 2025 онд төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагч 4, төрийн захиргааны төсвийн шууд захирагч 2, нэгжийн удирдах 2, дэс түшмэлийн 32, нийт 40 албан тушаалын сул орон тоог сонгон шалгаруулалт, тусгай шалгалтын дүнгээр нөхөж, чадварлаг, мэргэшсэн албан хаагчаар төрийн байгууллагуудын хүний нөөцийг бүрдүүлсэн. 2025 оны байдлаар төрийн захиргааны төсвийн шууд захирагч 2, нэгжийн удирдах 2, дэс түшмэлийн гүйцэтгэх 81, төрийн үйлчилгээний 156, нийт 241 ажлын байр сул байна. Төрийн албан хаагчийг төрийн албанаас чөлөөлөх, сул орон тоог нөхөх үйл ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд зохион байгуулж байна.Төрийн албаны зөвлөлийн Булган аймаг дахь салбар зөвлөлд хууль бус томилоотой холбоотой 5 өргөдлийг хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэн хариуг хүргүүлсэн.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
304	2.6.. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, тасалгалыг таслан зогсоох талаар харьяа байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг өгч, үр дүнг тооцож ажиллах.	Орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагуудын төсвийг цалин хөлс, тогтмол зардлаас бусад зардлыг 2025 оны 11 дүгээр сараас эхлэн Сангийн яамнаас бүрэн хязгаарласан. Үүнтэй холбоотой сумын санхүүгийн албаны дарга, төсвийн шууд захирагч нарт мэдээллийг цахимаар хүргүүлж, тодорхой үүрэг чиглэлийг өгч ажилласан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
305	3.2.. Ерөнхий сайдын өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хангаж, үр дүнг тухай бүр тайлагнах, биелүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцох;	Ерөнхий сайдын албан даалгаврын хэрэгжилтийг хяналтад авч, харьяа бодлогын хэлтсүүдэд хуваарилан, хэрэгжилтийг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим мэдээллийн системээр сар бүр хугацаанд нь тайлагнаж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
306	3.3.. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн, танилцуулсан, эрхлэх ажлын хүрээнд хамаарах асуудлыг бүрэн хариуцаж, гарсан шийдвэр, үр дүнгийн талаар олон нийтэд үнэн зөв, бодитой мэдээлэл өгч байх.	Хамааралгүй заалт	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй		Үгүй	

307	1.1. Улс төрөөс ангид, чадахуйн зарчимд суурилсан хүртээмжтэй, шуурхай, хариуцлагатай төрийн үйлчилгээг хүргэх, хүнд суртал, шат дамжлагыг бууруулах үр дүнтэй ажлыг зохион байгуулан, ажлын бүтээмжийг нэмэгдүүлж, цахим шилжилтийг эрчимжүүлэх	Булган аймагт төрийн байгууллагын хүний нөөцийг хөгжүүлэх, төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадвар, ажлын туршлагыг нэмэгдүүлэх чиглэлээр 2025 онд олон талт арга хэмжээг зохион байгууллаа. Нийт 86 удаагийн дотоод сургалт, зөвлөгөөн, семинарыг зохион байгуулж, давхардсан тоогоор 5375 төрийн албан хаагч хамрагдсан байна. Мөн төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх иргэдийн санал хүсэлтийг сонсох, төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор "Иргэдийн индэр" уулзалт, шууд нэвтрүүлгийг 14 хоног тутам зохион байгуулж, төрийн албаны үйл ажиллагааг сурталчлах, таниулах, иргэдийн санал, хүсэлтийг бодлого, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх ажлыг хэвшүүлээд байна. Аймгийн хэмжээнд төрийн 118 байгууллагад ёс зүйн дэд хороо ажиллаж, төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр тогтмол ажилласан бөгөөд сургалт нөлөөллийн ажилд 1680 төрийн албан хаагч хамрагдсан нийт төрийн албан хаагчдын 40.3 хувийг эзэлж байна. Булган аймагт үзүүлж буй цахим үйлчилгээний төрөл 63 болж нэмэгдсэн. Цахим шилжилт, үйлчилгээний хэлтэс болон 16 сум, 1 тосгоны ХУРДАН цэгээс операторын горимоор нийт 8456 иргэн цахим үйлчилгээ авч, ХУРДАН киоск төхөөрөмжөөс 18968 лавлагаа тодорхойлолтыг олгосон байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
308	1.2. харьяа байгууллага, хуулийн этгээдийн хэмжээнд сахилга, хариуцлагыг чангатгаж, төсвийн үр ашиггүй зардлыг танан, хэмнэлтийн горимыг чанд мөрдөх, бүтэц, чиг үүргийн давхардлыг арилган, орон тоог үе шаттай цөөлөх	Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны батлагдсан төсөвт өөрчлөлт оруулан, аймгийн ИТХ-аар батлуулахдаа тэвчиж болох зардлыг 50 хүртэл хувиар бууруулж, төсвийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулахыг үүрэг болгосон. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт хамаарах орон нутгийн төсвөөс санхүүждэг 43 байгууллагын 57 ажлын байрыг цомхотгож, төрийн байгууллагын үр ашиггүй зардлыг танасан. Албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, орон тоог Засгийн газрын тогтоолоор батлагдсан хязгаарт багтаан ажиллахыг чиглэл болгож, сумын Засаг даргын тамгын газрын удирдах болон гүйцэтгэх 22 албан тушаалын тодорхойлолтыг Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн, Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, батлах зөвшөөрөл авсан. Батлах зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолтыг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр баталгаажуулан ажиллалаа. Аймгийн хэмжээнд төрийн захиргааны 41 байгууллагын 217 албан тушаалын тодорхойлолтыг ХНУМТ цахим системд оруулж, төрийн албаны тусгай шалгалт, сонгон шалгаруулалтыг явуулах, томилгооны зөрчлийг цахим системээр хянах нөхцөлийг бүрдүүлээд байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
309	1.3. Зарим чиг үүрэг, ажил, үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх талаар бодитой арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Төр, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхэд онцгойлон анхаарч сум, байгууллагууд оны эхэнд "Төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэх ажлын жагсаалт"-ыг батлан гаргаж, иргэд, олон нийтэд мэдээлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд төрийн бус байгууллагуудтай хамтран сургалт зохион байгуулж, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд ажлын байр нэмэгдүүлэх, хүүхэд, эмэгтэйчүүд, залуучууд, ахмад настны эрх хамгаалал, эрүүл амьдрах идэвхийг өрнүүлэх, эрх зүйн боловсрол олгох, мал, амьтны эрүүл мэндийг сайжруулах, тоо толгойг өсгөх, аялал жуулчлал, төрийн үйлчилгээ, спортын чиглэлээрх 66 төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагууд хамтран 107 ажил, арга хэмжээг зохион байгууллаа. Арга хэмжээг зохион байгуулахад орон нутгийн төсвөөс 38.0 сая төгрөгийг зарцуулж, давхардсан тоогоор 1000 гаруй иргэн хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээнд хамрагдсан байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

310	1.4. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг ханган, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх	Төрийн байгууллагын хүний нөөцийг хөгжүүлэх, төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадвар, ажлын туршлагыг нэмэгдүүлэх зорилгоор 86 удаагийн дотоод сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулж, давхардсан тоогоор 5375 төрийн албан хаагчийг хамруулав. 2024-2025 онд төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 23, дунд хугацааны давтан сургалтад 18, ахлах түшмэлийн мэргэшүүлэх сургалтад 10, эрхэлсэн түшмэлийн сургалтад 1 албан хаагч, нийт төрийн захиргааны 52 албан хаагч мэргэшүүлэх сургалтад хамрагдсан. Удирдлагын академийн төрийн албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад Бүрэгхангай, Сэлэнгэ, Могод, Орхон, Дашинчилэн, Баяннуур, Төшиг сум, Хялганат тосгоны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны 195 албан хаагч хамрагдсан байна. Төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, төрийн албанд чиглүүлэх болон мэргэшүүлэх сургалтад нийт төрийн захиргааны албан хаагчдын 43.4 хувийг хамруулав.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
311	1.5. Төрийн албан хаагчийг хууль бусаар томилж, чөлөөлөх аливаа хэлбэрээр дарамт, шахалт үзүүлэхгүй байх	Төрийн жинхэнэ албаны нөөцийг бүрдүүлэх ерөнхий шалгалтыг 4 удаа зохион байгуулж, шалгалтад 337 иргэн бүртгүүлснээс 238 иргэн оролцож, 94 иргэн тэнцэн нөөцөд бүртгэгдсэн. Шалгалтын нэгдсэн дүнгээр нийт оролцсон иргэдийн 39.4 хувь нь тэнцсэн байна. 2025 онд төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагч 4, төрийн захиргааны төсвийн шууд захирагч 2, нэгжийн удирдах 2, дэс түшмэлийн 32, нийт 40 албан тушаалын сул орон тоог сонгон шалгаруулалт, тусгай шалгалтын дүнгээр нөхөж, чадварлаг, мэргэшсэн албан хаагчдаар төрийн байгууллагуудын хүний нөөцийг бүрдүүлсэн. 2025 оны байдлаар төрийн захиргааны төсвийн шууд захирагч 2, нэгжийн удирдах 2, дэс түшмэлийн гүйцэтгэх 81, төрийн үйлчилгээний 156, нийт 241 ажлын байр сул байна. Төрийн албан хаагчийг төрийн албанаас чөлөөлөх, сул орон тоог нөхөх үйл ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд зохион байгуулж байна.Төрийн албаны зөвлөлийн Булган аймаг дахь салбар зөвлөлд хууль бус томилоготой холбоотой 5 өргөдлийг хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэн хариуг хүргүүлсэн.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
312	1.6. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, төсвийн хөрөнгөөр олон нийтийн арга хэмжээг зохион байгуулахгүй байх талаар харьяа байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг өгч, үр дүнг тооцож ажиллах	Сангийн яамнаас энэ оны 7 дугаар сараас эхлэн орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагуудын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглалтын зардал болон бичиг хэрэг, шуудан холбооны зардлаас бусад зардлыг, 11 дүгээр сараас эхлэн цалин хөлс, тогтмол зардлаас бусад зардлыг бүрэн хязгаарлаж ажилласан. Дээрх арга хэмжээнүүдтэй холбогдуулан тухай бүрд нь сум, байгууллагуудын санхүүгийн албаны дарга болон төсвийн шууд захирагч нарт 2 удаагийн чиглэл, мэдээллийг өгч, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллав.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
313	2.1. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу албаны нууцад хамааруулах шаардлагагүй мэдээллийг зохих журмын дагуу ил болгох	Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу нууцад хамааруулах шаардлагагүй мэдээ, мэдээллийг аймгийн ЗДТГ-ын болон сум, агентлагийн цахим хуудас, нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-д мэдээлж хэвшсэн. "Нээлттэй мэдээллийн систем"-д тайлан илгээх 159 байгууллагыг бүрэн бүртгэж, жилийн эцсийн байдлаар 87 байгууллага шилэн shilen.gov.mn-д нууцад хамааралгүй мэдээллийг тайлагнасан байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын шилэн дансны мэдээлэл байршуулалт 4-р улирлын байдлаар 98 хувьтай дүгнэгдсэн.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

314		2.2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах үүргийн биелэлтэд харьяа байгууллага, хуулийн этгээдийн хэмжээнд тогтмол хяналт тавьж, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцож ажиллах	Булган аймгийн Цахим шилжилт, үйлчилгээний хэлтсээс байгууллагуудын систем хариуцсан албан хаагчид, сумдын Засаг даргын тамгын газар, сургууль, цэцэрлэг, эрүүл мэнд, соёлын төвийн холбогдох ажилтнуудад танхимаар 7 удаа, цахимаар 3 удаа сургалт, зөвлөгөө өгч ажилласан. Мөн www.bulgan.gov.mn сайтын ашиглалтыг сайжруулж https://shilen.gov.mn/ баяжилтыг хийх чиглэлээр 5 удаагийн сургалтыг зохион байгуулсан байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд байнга ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллийг аймгийн цахим хуудас (www.bulgan.gov.mn)-д тогтмол байршуулан ажиллаж байна. Үүний дагуу аймгийн хэмжээнд 171 байгууллага бүртгүүлэхээс татан буугдсан 9 байгууллагыг хасаж, 159 байгууллагыг manage.gov.mn, shilen.gov.mn цахим хуудсанд бүртгэсэн. Тайлант онд 103 байгууллага 86 төрлийн мэдээ мэдээллийн баяжуулалт хийж, холбогдох хуулийн дагуу мэдээ мэдээллийг https://shilen.gov.mn/ сайтад байршуулсан. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 4-р улирлын хэрэгжилт 98.0 хувьтай дүгнэгдсэн. Нээлттэй мэдээллийн системд бүртгүүлсэн боловч 56 байгууллага тайлангаа илгээгүй байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
315	Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай албан газраар	2.3. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллаж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, хүнд суртал, шударга бус байдалтай тууштай тэмцэх, таслан зогсоох, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглахгүй байх, бүх шатанд Ёс зүйн дэд хороодыг байгуулж үйл ажиллагааг нь идэвхжүүлэх	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Эрүүгийн хуулиар 696 төрийн албан хаагчид сургалт зохион байгуулсан. "Булганы өнгө" төрийн бус байгууллагатай хамтран иргэдийн төрийн үйлчилгээний чанар хүртээмжид итгэх итгэл, авлигын тухай ойлголт өгөх зорилгоор эрүүл мэндийн салбарын асуудлыг хөндсөн видео контент бэлтгэн олон нийтэд түгээж, 266 хүн үзэж сонирхсон байна. Мөн 2 удаагийн өдөрлөг зохион байгуулж тараах материал, гарын авлага тараав. Авлигагүй төрийн алба уриан дор төрийн байгууллагуудын дунд "Авлигын эсрэг нэгдье" видео уралдааныг зохион байгуулж, уралдаанд Улсын бүртгэлийн хэлтэс, Стандарт хэмжил зүйн хэлтэс шагналт байруудад шалгарлаа. Энэ онд авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдсон иргэн, хуулийн этгээд бүртгэгдээгүй байна. Аймгийн хэмжээнд төрийн 118 байгууллагын дэргэд ёс зүйн дэд хороо ажиллаж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр", Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ыг байгууллагын түвшинд сурталчлан, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлж байна. 2025 онд давхардсан тоогоор 141 байгууллагын 3100 албан хаагчид танхим болон цахим хэлбэрээр 12 удаагийн сургалтыг зохион байгуулав. Үүнээс 3 удаагийн сургалтыг төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдад зориулан зохион байгуулсан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

тулаан аюулан даалгавар
2025-07-08
Дугаар 2025_03

316	3.1. Улс, аймаг, сумын баяр наадам, тэмдэглэлт ой, бүх нийтийн амралтын улирал эхэлж байгаатай холбогдуулан ой, хээрийн түймэр, хүн, малын гоц халдварт өвчин, зам тээврийн осол аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, бүх төрлийн гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн цогц арга хэмжээг мэргэжлийн байгууллагын удирдлага, зохицуулалт, иргэдийн идэвхтэй оролцоо, дэмжлэг, туслалцаатайгаар хэрэгжүүлэх	Гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангах зорилгоор аймгийн Онцгой комисс, Онцгой комиссын шуурхай штабаас "Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай" 04 дүгээр албан даалгаврыг гарган томоохон гол, мөрөнтэй, үер усны эрсдэл өндөртэй 8 сумын Засаг дарга, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хүргүүлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлв. Үндэсний их баяр, наадмын өдрүүдэд үер, усны осол тохиолдсон үед ажиллах шуурхай 3 бүлэг, автомашин, техник, багаж хэрэгслийг томилгоожуулж, Хутаг-Өндөр сумын Сэлэнгэ мөрний эрэг дагуу Хутаг-өндөр сум дахь Эрэн хайх аврах салбарын 24 алба хаагч 6 автомашин, Сэлэнгэ, Хангал сумын Сэлэнгэ голуудад ГТУА-50 дугаар ангийн 42 алба хаагч, 6 автомашин ажиллаж, 180 автомашин, 1368 том хүн, 855 хүүхдэд сэрэмжлүүлэг, анхааруулга өгсөн. Иргэд олноор цугларах наадмын талбай, хурдан морь барианы газарт иргэдийн хоол үйлдвэрлэл эрхлэх гэр, объектод гал, гамшгаас хамгаалах хяналт шалгалтыг зохион байгуулж, 44 объектыг хамруулан, 158 иргэнд галын аюулгүй байдлыг хангуулах зөвлөмж өгч ажиллалаа. Аймгийн хэмжээнд малын галзуу өвчний 1 тохиолдол бүртгэгдэж өвчилсөн малыг устгалд оруулан ариутгал халдваргүйжүүлэлт, тандалтыг хийв. Хөрш зэргэлдээх Хөвсгөл аймагт тарваган тахал өвчний тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан иргэд, олон нийтэд урьдчилсан сэргийлэх мэдээ мэдээллийг тогтмол хүргэн, урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах ажлын хэсэг байгуулагдан ажилласан. "Устгал" , "Орон нутгийн зам соёл", "Эрүүл аюулгүй аялал" , "Дүрмээ мөрлөх" зэрэг нагдсан болон тусгай арга	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
317	3.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх, намрын ургац хураалтын бэлтгэлийг хангах, бусад аймаг, сумдаас ирэх отор нүүдлийг Засгийн газраас тогтоосон маршрутын дагуу мэргэжлийн байгууллагын хорио цээр, хяналт шалгалтын дор хэрэгжүүлэх, отроор өвөлжүүлэх, хаваржуулах ажлыг гэрээний үндсэн дээр зохион байгуулахад анхаарч ажиллах	Аймгийн аюулгүйн нөөцөд 386 тн өвс, 120 тн тэжээл бэлтгэж, нийт дүнгээр 77.6 хувь, сумдын аюулгүйн нөөцөд өвс 1381.7 тн буюу 84.6 хувь, тэжээл 548.3 тн буюу 46.8 хувь, эрдэс тэжээл 1.4 тн буюу 85.0 хувь тус тус бэлтгэсэн байна. Энэ онд аймгийн хэмжээнд 53.9 мянган га талбайд тариалалт хийж, үр тариа 2.5 мянган тн, улаан буудай 34.8 мянган тн, төмс 2.2 мянган тн, хүнсний ногоо 7.0 мянган тн, тэжээлийн ургамал 28.5 мянган тн, тосны ургамал 3.4 мянган тн, нийт 73.4 мянган тн ургац хураан авч, төлөвлөгөөг бүрэн биелүүлсэн. Отор нүүдлээр Төв, Өвөрхангай, Булган аймгуудаас 37 өрхийн 131 ам бүлтэй, 27.3 мянган толгой мал буюу хонин толгойд шилжүүлснээр 45.7 мянган мал өвөлжиж байна. Отор нүүдлийн чиглэлээр Өвөрхангай аймгийн 24 өрхийн 9.7 мянган толгой малыг өвөлжүүлэх гэрээний саналыг тус аймгаас хүлээн авч, отрын өрх, мал хүлээн авах сумдуудад гэрээний саналыг хүргүүлсэн боловч төсвийн жил дуусгавар болсонтой холбоотой гэрээ байгуулагдаагүй.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
318	3.3. аймгийн төв, хүн ам төвлөрсөн томоохон сум, суурин газрын иргэдийн орон сууц төрийн болон хувийн аж ахуйн нэгж байгууллагуудыг цахилгаан, эрчим хүч, % дулаан усаар найдвартай хангах, иргэдийг ая, тухтай өвөлжүүлэх, 2025-2026 оны өвөлжилтийн үеэр гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх	Булган аймгийн төв суурингийн өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу Булган аймгийн Засаг даргын удирдамжаар баталсан ажлын хэсэг Булган сумын төв суурин, мал аж ахуйн өвөлжилттэй 09 сарын 02-ны өдөр танилцав. Булган сумын Засаг даргын А/282 захирамжаар ажлын хэсэг байгуулагдан 2025-2026 оны оны төв суурингийн өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлын төлөвлөгөөг 07 сард батлуулан 6 бүлэг 45 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн албан байгууллагууд, ААН-д хүргүүлсэн байна. "Булган Мээж" ОНӨХХК төв суурингийн 2025 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын явц 93.5%-тай хэрэгжсэн, "Энержи плас" ХХК-ийн хуримтлагдсан их хэмжээний өр төлбөрөөс үүдэн компанийн бүх дансыг татварын байгууллагаас хаасан. Нүүрс нийлүүлэгч "Шивээ-Овоо" ХХК-д өмнөх жилүүдэд 1.3 тэрбум төгрөгийн өр төлбөр үүссэн. Нүүрсний төлбөрөө бүрэн төлөөгүй тохиолдолд нүүрс нийлүүлэхгүй гэсэн шаардлагыг ирүүлээд байна. Дулааны станцад энэ жил их засвар хийгдсэн ба урсгал засварын ажлаа 50 гаруй хувьтай гүйцэтгэж, талбай дээрээ 5 хоногийн нүүрсний нөөцтэй байна. Эрдэнэтийн дулааны станцын хүмүүсийг урьж цахилгааны үзлэг шалгалт хийлгэсэн. Металлын шинжилгээ хийлгэж илэрсэн жижиг гэмтлүүдийг засварлаж байна. Химийн шинжилгээ хийлгэж дүгнэлт гаргуулсан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

319	3.4. Өсвөр насны хүүхдүүдийн дунд гарч байгаа улаанбурхан өвчний дэгдэлтийг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд бууруулах, хяналтад авах өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулах арга хэмжээг шуурхай зохион байгуулах	Аймгийн хэмжээнд улаанбурханы эсрэг нөхөн дархлаажуулалтад 811 хүүхдийг хамруулж, 2453 хүүхдийн дархлаажуулалтын мэдээллийг цахим бүртгэлд нөхөн шивж оруулсан. Үүний үр дүнд эрүүл мэндийн статистик мэдээллээр нөхөн дархлаажуулалт 91 хувьд, товлотт дархлаажуулалт 98.6 хувьд хүрсэн байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
320	3.5. Хичээлийн шинэ жилийн бэлтгэл, сургууль, цэцэрлэгийн бэлэн байдлыг хангах, засварыг цаг тухайд нь хийж дуусгах, багшлах боловсон хүчний хангалтыг хэвийн болгох	2025-2026 оны хичээлийн жилийн бэлтгэл ажлыг бүрэн хангаж, хичээлийн шинэ жилийн үйл ажиллагааг эхлүүлсэн. Аймгийн хэмжээнд 22 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж, 273 багшийн орон тоотой ажиллаж байгаагаас жилийн эцсийн байдлаар 5 багшийн дутагдалтай, мэргэжлийн багшийн нөхөн хангалтын хувь 98.2 хувь, ерөнхий боловсролын сургуулийн мэргэжлийн багшийн орон тоонд 654 багш ажиллаж байгаа бөгөөд 28 багшийн дутагдалтай, багшийн нөхөн хангалт 95.8 хувьтай байна. Энэ оны 3-р улиралд Дашинчилэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 150 хүүхдийн ортой дотуур байр, Рашаант сумын 75 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөлийн барилга ашиглалтад орж, Булган сумын 1-р сугуулийн биеийн тамирын заалны засварын ажил дуусаж, хэвийн үйл ажиллагаа явуулж эхэлсэн.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
321	4.1. Ажлын байр шинээр бий болгоход шаардлагатай гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг бүх талаар дэмжиж, хүнд суртал, шат дамжлагыг халах, хөрөнгө оруулагчдад саад, дарамт, учруулж байгаа этгэдүүдэд хууль, журмын дагуу хариуцлага тооцож ажиглах	Тайлант хугацаанд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар хэрэгжиж, төсөл, хөтөлбөрийн санал ирээгүй. Ажлын байр шинээр бий болгох гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын санал ирсэн тохиолдолд шуурхай шийдвэрлэн ажиллана.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
322	4.2. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэхдээ бус нутгийн эдийн засгийн хөгжлийн онцлог, нөөц боломж, давуу талыг харгалзан үзэх	"Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-д Булган аймгийн орон нутгийн хөгжлийн төв, тэдгээрт таталцах сумдыг тогтоосон. Булган, Дашинчилэн, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сум орон нутгийн хөгжлийн төвүүдээр тодорхойлогдож, үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр, логистикийн цогцолборыг кластераар хөгжүүлэх, хувийн хэвшил, хоршоодыг тэргүүн ээлжид дэмжихээр тусгагдсан. Тус бодлогын баримт бичигт үндэслэн, орон нутгийн онцлогт тохируулан Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2026 оны төлөвлөлтийг боловсруулж, 62 төсөл арга хэмжээг үнэлж, эрэмбэлэн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн. Мөн Булган аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн батлууллаа. Үүнд бүс нутагтай холбоотой "Бүсийн хөгжил" зорилтыг хэрэгжүүлэхээр тусгасан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
323	4.3. Түүх, соёлын дурсгалт газруудыг хамгаалах, аялал жуулчлалын үйлчилгээг хөгжүүлэх замаар орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах	Аймгийн нутаг дэвсгэрт орших улсын болон аймгийн хамгаалалтад байх 53 дурсгалаас 50 түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах гурвалсан гэрээг байгуулан хамтын ажиллагааг хэрэгжүүлж байна. Мөн иргэдийн гар дээр болон сүм, хийдэд хадгалагдаж буй түүхэн, соёлын үнэ цэн бүхий баримтат өвийг бүртгэн баримтжуулах ажлын хүрээнд 7 сумаас 10 баримтат өвийг шинээр бүртгэж, мэдээллийн санд орууллаа. Соёлын өвийг таниулах, соёлын боловсрол олгох зорилгоор аймгийн музей болон 10 сумын соёлын төвөөс түүх, соёлын дурсгалт газартай танилцах 12 удаагийн өртөөчилсөн явган аяллыг зохион байгуулж, 953 сурагчийг хамруулсан. Орон нутгийн аялал жуулчлалын өрсөлдөх чадвар, үйлчилгээний чанар, стандартыг сайжруулах, хүний нөөцийг бэлтгэх зорилгоор 51 аж ахуйн нэгжийн 132 иргэнийг хамруулсан зочлох үйлчилгээ, жуулчны хөтөч бэлтгэх сургалтуудыг зохион байгуулж, сертификат олголоо. Мөн НИТАЖ үйл ажиллагааг 6 суманд 52 өрх эрхлэн явуулж, Gerbook платформын танилцуулга, зочлох үйлчилгээний сургалтад 20 өрхийг хамруулав.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

324	4.4. Ажилтны мэдлэг, боловсролын түвшин мэргэжлийн ур чадварыг хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэхэд байнга анхаарч, давтан сургах, мэргэшүүлэх, шинэ мэргэжил эзэмшүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	Орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн тэргүүлэх салбаруудад нэн хэрэгцээтэй байгаа мэргэжилтэй ажилтнуудыг орон нутагтаа бэлтгэн, хөдөлмөрийн зах зээлд нийлүүлэх зорилгоор ХААИС-ийн харьяа Булган аймаг дахь Политехникийн коллежийн багш суралцагчдад чиглэсэн "Чадварлаг мэргэжилтэн" хөтөлбөрийг аймгийн ИТХ-ын 2025 оны IX/70 дугаар тогтоолоор батлууллаа. Тус хөтөлбөрийн хүрээнд ОХУ, БНСУ, БНХАУ зэрэг улсад 29 багш, 11 суралцагчийг сургалтад хамруулсан байна. Суурь ур чадвар олгох сургалтыг Рашаант, Хишиг-Өндөр, Орхон, Булган, Бугат сумын зорилтот бүлгийн 165 иргэнд зохион байгууллаа.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
325	4.5. Хөдөлмөр эрхлээгүй иргэд, албан бус хөдөлмөр эрхлэлтийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн сүлжээнд хамруулах арга хэмжээ авч, хөдөлмөрийн статистикийн тогтолцоог бүрдүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн чанарыг сайжруулж, ажиллах хүчний болон ажлын байрны судалгааг боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах	Ахмадын холбоо, Залуучуудын холбоо, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллага болон хамтран ажиллах боломжтой 30 гаруй иргэнд job center байгуулах талаар мэдээлэл зөвлөгөө өгч, сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж ажиллалаа. Мэдээлэл авсан иргэдээс Хөдөлмөр зуучлалын бирж байгуулах, байр, байрны түрээсийн зардал, тоног төхөөрөмж шийдвэрлэх санхүүжилт, төсөв хүрэлцэхгүй байгаа талаар хүсэлтээ илэрхийлээд байна. Мөн байгууллагын 5 албан хаагч Улаанбаатар хотод ажиллаж, 4 "job center"-ийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судалсан. Төрийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 1110 ажлын байр шинээр бий болсныг хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн санд бүртгэлжүүлэв. Үүнд: байнгын ажлын байр 471, түр ажлын байр 279, улирлын ажлын байр 360 тус тус бий болсон байна. Хөдөлмөр эрхлэлтийн "ЕJOB" цахим системд 2025 онд 2217 ажлын байрны захиалга бүртгэгдэж, ажил хайгч 2336 иргэний мэдээллийг шивж оруулсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн дэлгэрэнгүй мэдээллийн баазыг улсын хэмжээнд бий болгох зорилгоор 18 болон түүнээс дээш насны бүх иргэдийг хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдлын судалгаанд хамруулах ажлыг хэрэгжүүлсэн. Аймгийн хэмжээнд тус судалгаанд 1923 иргэн хамрагдах ёстойгоос 72.5 хувь нь буюу 1396 иргэн хамрагдсан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
326	5. Энэ албан даалгаврын хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээллийг сар бүр Засгийн газрын Хэрэг газарт ирүүлж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, биелэлтэд нь хяналт тавьж явц үр дүнг нэгтгэн Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогтод тус тус үүрэг болгосгонд.	Ерөнхий сайдын албан даалгаврын хэрэгжилтийг хяналтад авч, харьяа бодлогын хэлтсүүдэд хуваарилан, хэрэгжилтийг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим мэдээллийн системээр сар бүр хугацаанд нь тайлагнаж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	
327	1.2. төрийн албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, удирдах албан тушаалтны тоог бууруулах арга хэмжээ авч, байгууллагын орон тоог нэмэгдүүлэхтэй холбоотой аливаа шийдвэр гаргахгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоо болон сул орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүй байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад;	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт хамаарах орон нутгийн төсвөөс санхүүждэг 43 байгууллагын 57 ажлын байрыг цомхотгож, төрийн байгууллагын үр ашиггүй зардлыг танасан. Албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, орон тоог Засгийн газрын тогтоолоор батлагдсан хязгаарт багтаан ажиллахыг чиглэл болгож, сумын Засаг даргын тамгын газрын удирдах болон гүйцэтгэх 22 албан тушаалын тодорхойлолтыг Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн, Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, батлах зөвшөөрөл авсан. Зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолтыг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр баталгаажуулан ажиллаж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%		Үгүй	

